



НЭЭЛТГЭЙ НИЙГЭМ ФОРУМ

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ БИЧИХҮЙ

Эрчим хүч
ба хөгжлийн асуудлаар
сэтгүүлчдэд зориулсан
гарын авлага

Орчуулсан: Г. Батбаяр
Хянан тохиолдуулсан: Ц. Гомбосүрэн
Б. Мөнхсоёл

DDC 333.8

Ц - 14

Хаяг:

Жамъян Гүний гудамж-5/1

Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар-48

Монгол Улс

Утас: 976-11-313207

Факс: 976-11-324857

Вэб хуудас: <http://www.forum.mn>

Энэхүү номыг хэсэгчлэн болон бүтнээр нь дахин хэвлэхийг хүсвэл
Нээлттэй Нийгэм Форумын хаягаар хандаж, зохих зөвшөөрөл авна уу.

ISBN 99929-83-31-0

ГАЗРЫН ТОСНЫ ТУХАЙ БИЧИХҮЙ

Эрчим хүч
ба хөгжлийн асуудлаар
сэтгүүлчдэд зориулсан
гарын авлага

Светлана Цалик, Аня Шиффрин нар хянан тохиолдуулав.

Орлогын Ажиглагч
Нээлттэй Нийгэм Хүрээлэн

Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ
ХҮРЭЭЛЭН

Нью Йорк

Монгол орчуулгын өмнөх үг

Монгол Улсын хөгжилд чухал үүрэг бүхий уул уурхайн салбарын асуудал олны анхаарлыг ихэд татаж, бодлого боловсруулагчид, иргэний нийгмийнхэн болон тухайн салбарт ажиллаж буй бизнесийнхний дунд уг салбарын өгөөж тал бүрт ашигтай байхаар хэрхэн зөв зохицуулах талаар нэлээдгүй ярилцлага, хэлэлцүүлэг өрнүүлж байгаа билээ. Нээлтэй Нийгэм Форум нь нэг талаар сэтгүүлчдийг энэ талын мэдээллийг олон нийтэд ил тод, нээлтэй байдлаар хүргэхэд нь дэмжлэг үзүүлэх, нөгөө талаар иргэд, иргэний нийгмийн байгууллагуудад мэдлэг, мэдээлэл олгох зорилгоор Нээлтэй Нийгэм Хүрээлэн, Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга байгууллагуудаас хамтран боловсруулсан энэхүү гарын авлагыг монгол хэлнээ хөрвүүлэн уншигч Танд өргөн барьж байна.

Байгалийн баялагтай олон орны туршлага нь анхнаасаа зөв бодлого баримталж, ил тод байдлыг хангаагүйгээс тухайн улс “нөөц баялгийн хяслан” хэмээх үзэгдэлд автаж уул уурхайн салбараас олж буй орлого цөөн хэдэн хүний ашиг сонирхолд үйлчилж ард түмний ихэнх нь ядуурал хоосролд автдаг болохыг гэрчилж байгаа юм.

Энэхүү гарын авлага нь уул уурхайн үйлдвэрлэлийн салбарыг газрын тосны үйлдвэрлэлээр жишээлэн, түүний үйлдвэрлэгч оронд үзүүлэх нөлөөний талаар хялбар ойлгомжтой хэлээр бичсэн практик мэдээллээр Та бүхнийг хангах болно.

Гарчиг

Өмнөх үг

Талархал	11
1. Байгалийн нөөц баялгийг хяслан биш хишиг болгох нь <i>Жозеф Е. Штиглиц</i>	13
2. Нөөцийн хясланг ойлгохуй <i>Терри Линн Карл</i>	21
3. Газрын тосны цагаан толгой <i>Жонн Робертс</i>	33
4. Газрын тосны компаниуд ба олон улсын газрын тосны зах зээл <i>Катерин Стефан</i>	53
5. Газрын тосны гэрээний цагаан толгой: Лиценз-хөнгөлөлтийн гэрээ, хамтарсан үйлдвэр, бүтээгдэхүүн хуваах гэрээ <i>Женик Радон</i>	73
6. Хөгжиж байгаа орны эдийн засгийг үнийн цочирдлоос хамгаалах нь <i>Рандалл Додд</i>	103
7. Газрын тосны үйлдвэрлэлийн байгаль орчин, нийгэм, хүний эрхийн үр дагавар <i>Дэвид Васкоу, Карол Уелч</i>	121
Хавсралт Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга Төлснөө Нийтэл	157
Тэмдэглэл	163
Нэр томъёоны тайлбар	171
Эх сурвалжууд	179
Зохиогчдын тухай	187

Нээлтгэй Нийгэм Хүрээлэн нь Нью Йоркт байрладаг, хувийн хэвшлийн, тэтгэлэг олгогч сан бөгөөд ардчилсан засаглал, хүний эрх болон эдийн засаг, эрх зүй, нийгмийн шинэтгэлийг хөхиүлэн дэмжих чиглэлд төр засгийн бодлогыг төлөвшүүлэх зорилготой. ННХ нь дотоодын түвшинд эрх зүйт төр, боловсрол, нийтийн эрүүл мэнд, хараат бус хэвлэл мэдээллийг дэмжих янз бүрийн санаачилгыг хэрэгжүүлж байна. Үүний зэрэгцээ авилгал, эрхийн зөрчилтэй тэмцэх зэрэг асуудлаар хил хязгаар, тив дэлхий дамнасан холбоотнууд бий болгохыг зорин ажиллаж байна.

ННХ-г хүмүүнлэгийн зүтгэлтэн, хөрөнгө оруулагч Жорж Сорос Төв болон Зүүн Европ, түүнчлэн хуучин Зөвлөлт Холбоот Улс дахь өөрийн сангуудын үйл ажиллагааг дэмжих зорилгоор 1993 онд үүсгэн байгуулжээ. Дээр дурдсан сангууд нь хуучин социалист орнуудын коммунизмаас ардчилалд шилжих үйл явцад туслах зорилгоор 1984 оноос эхлэн байгуулагдсан юм. Мөн ННХ нь ардчилалд шилжих үйл явц чухлаар тавигдаж байгаа дэлхийн бусад газар ч Соросын сангийн сүлжээний үйл ажиллагааг өргөжүүлэн явуулж байна. Соросын сангийн сүлжээнд АНУ зэрэг дэлхийн 50 гаруй орон хамрагддаг юм.

ННХ-ийн **Орлогын Ажиглагч** хөтөлбөр нь байгалийн нөөц баялгийн борлуулалт, тээвэрлэлтээс олох орлогыг ил тод ашиглах явдал бол бүс нутгийн хөгжил болон иргэний нийгмийг хөхиүлэн дэмжихэд асар их ач холбогдолтой асуудал гэж үздэг. Тус хөтөлбөр нь орлогыг хэрхэн хөрөнгө оруулж, зарцуулж байгаа болон энэ талаар хүлээх хариуцлагын төлөөх иргэний нийгмийн тавьсан шаардлагад засгийн газар, олборлох компаниуд хэрхэн хариу үйлдэл хийж байгаа талаар судалгаа, мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагаа явуулах, хэвлэн нийтлэх зорилготой. Мөн засгийн газрын газрын тосны орлогын удирдлагыг хянах, одоо байгаа болон ирээдүйд олох байгалийн баялгийн орлогыг ард түмний тусын тулд хөрөнгө оруулж, зарцуулах нөхцлийг хангах зорилго бүхий дотоодын бүлгүүдийн чадавхийг бэхжүүлэхийг зорьж байна.

www.revenuewatch.org

Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилгыг (БХДС) хөгжиж байгаа орнуудад бодлогын хувилбаруудыг судалж шинжлэхэд нь туслах, эдийн засгийн бодлого боловсруулахад иргэний өргөн хүрээтэй оролцоог хангах зорилгоор Нобелийн шагналт эдийн засагч Жозеф Штиглиц 2000 оны 7 дугаар сард үүсгэн байгуулжээ. Эдийн засгийн бүхий л бодлогод зарим нэг бүлэгт бусдаас нь илүү ашигтай тусах нөхцөл агуулагдаж байдаг. Гэтэл эдийн засгийн шийдлүүдийг бүрэн дүүрэн судалж шинжлэхийн оронд явцуу хүрээний цөөн бодлогын хувилбарууд тойрсон олон улсын маргаан мэтгэлцээн өрнөх явдал олонтаа байна. БХДС бол эдгээр асуудлуудад өгөх нэг нааштай хариулт болж байна. БХДС нь янз бүрийн бодлогуудтай холбоотой тэнцвэрт харьцаануудыг задлан шинжилж, эдийн засгийн чухал хувилбаруудыг гаргаж өгөхийн зэрэгцээ бодлогын сонголтыг тухайн улс орны улс төрийн үйл явцаар шийдэх боломж олгодог. БХДС нь Өмнөд болон Умардыг төлөөлсөн янз бүрийн намтар, үзэл бодолтой 200 гаруй тэргүүлэх эдийн засагчид, улс төр судлаачид, мэргэжилтнүүдийг хамруулсан дэлхий нийтийн сүлжээ юм. Уг санаачилга АНУ-ын Нью Йорк хот дахь Колумбийн их сургууль дээр байрладаг.

www.gsb.columbia.edu/ipd/

ӨМНӨХ ҮГ

Байгалийн нөөц баялгаар баян олон оронд авилгал, хээл хахууль, зохисгүй удирдлагаас болж хүн амын олонхи нь ядууран хоосорч байхад уг баялгийг цөөнх нь баяжих үүднээс ашиглан үрэн таран хийж байна.

Энэхүү хэвшмэл байдлыг эвдэх хэцүү. Ийм нөөц баялагтай орнууд тэднээс төсвийн ил тод байдал, төсвийн практик сайтай байхыг хариу шаарддаг олон талт зээлдүүлэгч байгууллагуудаас мөнгө зээлээд байх шаардлагагүй болдог. Газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын импортоос хамааралтай дэлхийн тэргүүлэх ардчилсан улсууд ч нөөц баялаг ихтэй орнуудад төсвийн практикаа сайжруулахыг шаардсан дипломат шахалт үзүүлэх сонирхол багатай байх нь олонтаа. Түүнчлэн байгалийн баялгийг нь үргэлжлүүлэн олборлохыг зөвшөөрснийх нь төлөө хүлээн авагч засгийн газартай сайн харилцаатай байхгүй бол болдоггүй үндэстэн дамнасан эрчим хүчний компаниудын зүгээс тухайн засгийн газрыг эдийн засгийн удирдлагаа сайжруул гэж шахах нь юу л бол.

Иймээс, засгийн газраа ил тод байж, уг орлогыг ард түмний эрэлт хэрэгцээнд нийцүүлэн зарцуулахыг шаардах онцгой үүрэг хариуцлага нөөц баялаг ихтэй орнуудын иргэдэд буюу тухайн орны байгалийн баялгийн жинхэнэ эздэд өөрсдөд нь ноогдож байна. Мөн иргэдийг мэдээллээр хангах үүднээс тухайн улсын байгалийн баялгийн олборлолтыг засгийн газар нь хэрхэн удирдаж байгаа тухай найдвартай, үнэн зөв мэдээллийг дамжуулах ажил сэтгүүлчдээс хамаарна. Үүний тулд сэтгүүлчид өөрсдөө мэдээлэл сайтай байж, чөлөөтэй бичиж, сурвалжлах ёстой.

Сүүлийн хоёр жилийн турш Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга болон Орлогын Ажиглалт байгууллагууд дотоодын түншүүд болон бусад ивээн тэтгэгчидтэй хамтран, Азербайжан, Казакстан, Нигери зэрэг газрын тос экспортлогч орнуудын сэтгүүлч нарт зориулж “Нөөц баялгийн талаар сурвалжлах нь” сэдэвт семинарууд зохион байгуулж байна. Энэ ном бол эдгээр семинарын нэг үр дүн бөгөөд газрын тосны үйлдвэрлэлийн салбар болон түүнийг боловсруулж, экспортлосноор тухайн улсад ямар нөлөө үзүүлэх талаар ойлгож мэдэхэд нь тустай мэдээллийн хэрэгцээ асар их байгааг уг семинарууд дээр сэтгүүлчид илэрхийлсэн юм.

Засгийн газрын хэрэгжүүлж буй газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын орлогын удирдлагын тухай мэдээлэх ямар хэцүү байдгийг дэлхийн эргэн тойронд буй сэтгүүлчид бидэнд өгүүлж байсан. Олон оронд олборлох салбарын төслүүдийн тухай мэдээлэл хомс байдаг, техник чадавхи дутагддаг, хугацаа богино байдаг, засгийн газар чөлөөт хэвлэлийг нухчин дардаг зэрэг нь эдгээр асуудлаарх мэдээ сурвалжлагын чанарыг муутгадаг. Сэтгүүлчид ихэвчлэн эдийн засагч, инженерийн чиглэлээр сурч боловсорсон хүмүүс байдаггүй, мөн эрчим хүчний салбар, нөөц баялгийн үр нөлөөг ойлгоход тустай эдийн засаг, инженерчлэл, геологи, бизнесийн санхүү болон бусад чиглэлийн мэдлэг боловсрол тэдэнд байхгүй. Ийнхүү мэдлэг, мэдээлэл авах боломж дутагдсанаас болж сэтгүүлчид байгалийн баялгийн тухай үйл явдлыг утга төгөлдөр бичиж мэдээлж чадахгүй байх нь олонтаа. Түүнээс гадна, голдуу цалин багатай зарим сэтгүүлч маань компаниудаас өгсөн гарын бэлэг, хөлс мөнгөнд хууртан сэтгүүлчийн шударга, бодитой хандлагаасаа няцаад зогсохгүй хэзээ ч шударга, үнэн зөвөөр мэдээлж байх чадвараа алддаг.

Хэвлэл мэдээллийг ийнхүү нухчин дарж, буруугаар ашиглаж байгаа явдал бол энэхүү гарын авлагын даван туулж эс чадах саад тотгор мөн боловч мэдлэг бол түүгээр зэвсэглэсэн зоригтой, ёс зүйтэй сэтгүүлч нарт тусалж чадах хүчирхэг хэрэгсэл мөн.

Газрын тосны тухай бичихүй: Эрчим хүч ба хөгжлийн асуудлаар сэтгүүлчдэд зориулсан гарын авлага нь газрын тос үйлдвэрлэлийн салбар, түүний үйлдвэрлэгч оронд үзүүлэх нөлөөний талаар хялбар ойлгомжтой хэлээр бичсэн практик мэдээллийг сэтгүүлчдэд өгөх болно. Энд сэтгүүлчдийн бичиж сурвалжлах үйл явдлууд болон асуух асуултууд бүхий хуудас байгаа. Ийм үйл явдлын жишээг ч мөн оруулсан. Эх сурвалжийн хэсэгт цаашид унших материалуудыг санал болгож байна. Нэр томъёоны тайлбарт нефть боловсруулалтын талаар бичсэн ном, сурах бичгүүдийг уншиж ойлгохыг хүссэн сэтгүүлчдийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхүйц санхүү, геологи, хуулийн нэр томъёонуудыг тодорхойлж өглөө. Дэлхий дахины сая сая уншигчдад нөлөөлж буй эрчим хүч ба хөгжлийн асуудлаар гүн гүнзгий, задлан шинжилгээ, шүүмжлэл, танин мэдэхүйн чанартай нийтлэл бичихэд шаардлагатай суурь мэдээллийг энэ ном сэтгүүлчдэд өгнө гэдэгт бид итгэж байна.

“Байгалийн нөөц баялгийг хяслан биш хишиг болгох нь” гарчигтай 1 дүгээр бүлэгт нөөц баялгаас авах үр өгөөжийг дээд цэгт нь хүртэл ашиглахыг эрмэлзэж байгаа нөөц баялаг ихтэй орнуудын засгийн газарт тулгарч буй бодлогын гол тулгамдсан сонголтуудын заримыг авч үзэж байна. Үүнд: Олсон мөнгөө хэр хурдан, бас юунд зарцуулах ёстой вэ? Тухайн улсад урсан орж ирж буй мөнгөн санг удирдан зохицуулахын тулд нягтлан бодох бүртгэлийн хүрээгээ хэрхэн

өөрчилж шинэчлэх шаардлагатай вэ? Нөөц баялгийн хуваарилалтын үр дагавар ямар байх вэ?

“Нөөц баялгийн хясланг ойлгохуй” нэртэй 2 дугаар бүлэгт байгалийн нөөц баялаг ихтэй олон орон тийм нөөц хомс орнуудаа бодвол эдийн засгийн хувьд илүү бэрхшээлтэй, зөрчил ихтэй, засаглал муутай байдаг хачин бодит байдал буюу “нөөц баялгийн хяслан” хэмээх гаж асуудлын талаар тайлбарласан болно. Энэ бүлэгт газрын тосны үнийн хэлбэлзэл, үйлдвэрлэлийн болон хөдөө аж ахуйн салбарт үзүүлэх дарамт, өсөн нэмэгдэж буй тэгш бус байдал, татварын дарамт, сул дорой институциуд зэрэг нь нийлснээр бодлогын дампуурал, эдийн засгийн уналтад хэрхэн хүргэдгийг тайлбарлалаа.

“Газрын тосны үндэс” хэмээх 3 дугаар бүлэгт нефть, шатахууны тухай суурь мэдээлэл өгнө. Энэ бүлэгт нефть, шатахууныг тойрсон геополитикийн гол гол асуултын заримыг хөнджээ. Бид шатахууны хомсдолд орж байна уу? Газрын тосноос хамааралтай байхын аюулгүй байдлын утга агуулга юу вэ? Бас газрын тосноос хамааралтай байх нь байгаль орчинд ямар сөрөг үр дагавартай вэ?

“Газрын тосны компаниуд ба олон улсын газрын тосны зах зээл” гэсэн 4 дүгээр бүлэг нь газрын тосны салбарын тухай суурь ойлголт өгнө. Нефть үйлдвэрлэгч хамгийн том ямар компаниуд байна вэ, тэд энэхүү зонхилох байр сууринд хэрхэн хүрсэн бэ? Ирэх арван жилд эдгээр аваргуудад ямар сорилтууд тулгарах вэ? Олон улсын зах зээл дээр шатахууныг хэрхэн худалдан авч, борлуулдаг вэ? Мөн энэ бүлэгт корпорацийн нийгмийн хариуцлагын практик, түүний дотор хүлээн авагч засгийн газарт төлж буй төлбөрөө улам бүр ил тод болгох арга хэмжээ авч буй компаниудад улам их дарамт шахалт ирж байгаа тухай ярилцана.

“Газрын тосны гэрээ, хэлэлцээрүүдийн цагаан толгой” хэмээх 5 дугаар бүлэгт газрын тосны үйлдвэрлэлийн хамгийн чухал бөгөөд хамгийн бага мэдээлэгддэг асуудал болох газрын тос үйлдвэрлэгч орнуудын газрын тосны компаниудтай байгуулдаг гэрээ, хэлэлцээрүүдийн тухай авч үзнэ. Тухайн улсын байгалийн баялгийн үйлдвэрлэлээс засгийн газар нь хэр их орлого олохыг тодорхойлдог эдгээр гэрээ нь 20, 30 буюу түүнээс дээш жилийн хугацаанд хатуу мөрдөгдөхөөр хийгдсэн байж болно. Засгийн газар нь шударга тохиролцоо хийж байгаа эсэхийг сэтгүүлчид хүмүүст хэрхэн хүргэх вэ? Энэ бүлэгт үйлдвэрлэгч орны засгийн газрын гарын үсэг зурдаг төрөл бүрийн гэрээ, эдгээр гэрээний гол бүрэлдэхүүн хэсгүүд, мөн засгийн газар болон олон нийтийн хувьд мэдэж байвал зохих эрсдлүүдийн талаар тайлбарлана.

“Хөгжиж буй орнуудын эдийн засгийг үнийн почирдлоос хамгаалах нь” гарчигтай 6 дугаар бүлэгт газрын тос экспортлогч орнуудад тулгардаг томоохон асуудлын нэг болох олон улсын газрын тосны үнийн огцом хэлбэлзлээс эдийн

засгаа хэрхэн хамгаалах вэ гэдэг асуудлыг хөндөж авч үзнэ. Газрын тосны үнэ маш тогтворгүй байдаг учраас түүний орлогоос ихээхэн хамааралтай байдаг засгийн газрууд асар их тогтворгүй байдалтай тулгардаг. Төсвийн төлөвлөлт хийхэд ч хүндрэлтэй болдог. Засгийн газрууд газрын тосны үнэ өндөр байх үед илүү их зарцуулж, үнэ нь унамагц гэнэт зарцуулалтаа хасах нь олонтаа. Иймэрхүү гэнэтийн өөрчлөлтүүд нь макро эдийн засгийн хямрал, улс төрийн тогтворгүй байдалд хүргэж болдог. 6 дугаар бүлэгт засгийн газрууд үнийн хэлбэлзэлд өртөмтгий байдлаа багасгахад хэрэглэж болох зарим арга хэрэгсэл, түүний дотор тогтворжуулалт, хуримтлалын сан, эрсдлээс хамгаалах арга зэргийн тухай авч үзсэн болно.

7 дугаар бүлэгт “Газрын тосны үйлдвэрлэлийн байгаль орчин, нийгэм, хүний эрхийн үр дагавар” гэсэн сэдвийг авч үзнэ. Газрын тос бол хэрэв ил тод, эрх тэгшээр удирдан зарцуулвал нутгийн ард иргэдэд санхүүгийн үр шимээ өгч чадах баялаг боловч түүний эдгээр боломжит ашиг тусыг тухайн ард иргэдэд учрах нийгмийн болон байгаль орчны болзошгүй сөрөг үр дагаварын талаас нь авч үзэх хэрэгтэй. 7 дугаар бүлэгт газрын тос үйлдвэрлэлийн олон төсөлд гардаг эрсдлүүд, түүний дотор хорт бодис алдах, нутгийн иргэдийг нүүлгэн шилжүүлэх, хүний эрхийн зөрчил, орчны экосистемийн сүйрэл, дэлхийн цаг уурын дулааралд үзүүлэх нөлөө гэх мэт үр дагаварын талаар ярилцана. Энэ бүлэгт уншигчдад дээрх боломжит ашиг тусыг болзошгүй өртөг зардалтай нь харьцуулж ойлгох боломж олгох үүднээс газрын тос үйлдвэрлэлийн төслүүдийн талаар сэтгүүлчдийн асуух ёстой төрөл бүрийн асуултуудыг тодорхойлж өгсөн байна.

Газрын тосны тухай бичихүй: Эрчим хүч ба хөгжлийн асуудлаар сэтгүүлчдэд зориулсан гарын авлага бол Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Орлогын Ажиглагч төслөөс янз бүрийн уншигчдад “нөөц баялгийн хяслан” гэж юу болохыг ялган салгаж ойлгуулахад туслах зорилгоор хэвлэн гаргасан цуврал гарын авлагын хоёр дахь нь юм. Байгалийн нөөц баялгийн үйлдвэрлэлээс засгийн газарт орж буй орлогод хяналт тавьж буй төрийн бус байгууллагуудад зориулсан гарын авлага болох *Мөнгийг мөшиг* ном www.revenuewatch.org хаяг дээр байгаа.

Аня Шиффрин,
Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих
Санаачилгын Сэтгүүл зүйн
хөтөлбөрийн захирал

Светлана Цалик,
Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн
Орлогын Ажиглагч
төслийн захирал

Талархал

Газрын тосны тухай бичихүй ном нэр бүхий олон хүмүүс туслаагүй бол бүтэх боломжгүй байлаа. Юуны өмнө уг номыг редакторлах ажлыг нугалж өгсөн Карен Матюстикт бид талархаж байна. Түүнчлэн редакторлах ажилд тусалцаа үзүүлсэн Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Харилцааны газрын Ари Корпиваара, Уилл Крамер нар болон номын загвар, эхийг бэлтгэсэн Жэнн Крисколад талархал илэрхийлэхийг хүсч байна.

Энэхүү гарын авлага нь ННХ-ийн Орлогын Ажиглагч төсөл, Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга (БХДС) хөтөлбөрөөс сэтгүүлчдэд зориулан Баку, Алматы, Лагост зохион байгуулсан цуврал семинаруудаас төрөн гарсан юм. Үүнд Азербайжаны Нээлттэй Нийгэм Хүрээлэнгийн Тусалцаа Үзүүлэх Сангийн Фарда Асадов, Ровшан Багиров, Баку дахь Төрийн Санхүүгийн Хяналт Шинжилгээний Төвийн Инглав Ахмедов, Назим Иманов, Сабит Багиров нар болон Казакстан дахь Соросын Сангийн Антон Артимерев, Дариус Зийтек, Казакстаны Хэвлэлийн Клубын Асел Караулова нар үнэлж баршгүй тусалцаа үзүүлсэн. Мөн Винцент Нванмагийн хүчин чармайлт болон манай ивээн тэтгэгчид болох Лагос дахь НҮБХХ-ийн газрын Энтони Дайока, Алматы дахь ЕАБХАБ/OSCE-ын газар, АНУ-ын Элчин сайдын яаманд бид талархаж байна. Энэхүү номыг ННХ-ээс Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилгад олгосон даргын буцалтгүй тусламжаар болон Орлогын Ажиглагч хөтөлбөрөөс санхүүжүүлэв. БХДС-ын Шана Хофштеттер, Акбар Номан, Шэри Шпийгел нарт бид талархлаа илэрхийлэх учиртай. Мөн Орлогын Ажиглагчийн Жюлий Маккарти, Морган Мандвелле нар энэ номын төгсгөлийн шатны турш удирдаж, мэргэжлийн болон бүхий л сайн сайхан дэмжлэгээр хангасан.

1. Байгалийн нөөц баялгийг хяслан биш хишиг болгох нь

Жозеф Е. Штиглиц

Эдийн засагчид “нөөц баялгийн хяслан” гэж нэрлэдэг нэгэн сонин үзэгдэл байдаг. Дунджаар авч үзэхэд нөөц баялаг ихтэй орнууд багатайгаа бодвол тааруу хөгжилтэй харагдаж байгаа нь төсөөлж болохоос нэлээд эсрэг үр дүн юм. Гэвч нөөц баялаг ихтэй бүх улсууд тийм биш ажээ. 30 орчим жилийн өмнө Индонези, Нигери улсууд нэг хүнд ноогдох орлогын хэмжээ ойролцоо, мөн хоёулаа газрын тосны орлогоос гүнзгий хамааралтай улс байлаа. Харин өнөөдөр, Индонезийн нэг хүнд ноогдох орлого Нигерийнхаас дөрөв дахин их болжээ. Үнэн хэрэгтээ Нигерийн нэг хүнд ноогдох орлого 1973 онд 302.75 ам.доллар байсан бол 2002 онд 254.26 ам. доллар болтол буурсан байна¹. Сиерра Леоне, Ботсвани улсууд хоёулаа алмааз эрдэнээр баян. Ботсвани улс 1974-2002 оны хугацаанд жилд дунджаар 5.2 хувийн өсөлттэй байсан² бол Сиерра Леоне улсад алмаазын баялагтаа хяналт тогтоохын төлөө иргэний тэмцэл маргаан өрнөсөн юм. Газрын тосоор баян Ойрхи Дорнодод ч нийгэм, эдийн засгийн уналт өдий төдий гарчээ.

Дэлхийн улс орнууд бүхэлдээ нэлээн сайн явж байгаа үед ч гэсэн нөөц баялаг

ихтэй орнууд ихээхэн тэгш бус байдалтайд тооцогдож, ядуу ард түмэнтэй баян орнууд гэгдэх нь олонтаа байдаг. ОПЕК-ийн гишүүн Венесуэл улсын ард түмний гуравны хоёр нь ядуурлын байдалд амьдарч байгаа нь тус улсын газрын тосны үр өгөөж цөөнхөд зориулагдаж байгаагийн үр дагавар юм. Газрын тос үйлдвэрлэгчдээс авах татварын орлогыг илүү эрх тэгш нийгэм байгуулахад ашиглаж болох учраас улс орон Латин Америкийн газрын тос хамгийн их экспортлогч Венесуэл шиг биш, арай илүү тэгш байдалтай байх ёстой гэж найдах үндэстэй.

Энэхүү оньсого мэт байдал нь улс орнууд нөөц баялгийн хясланг зогсоохын төлөө ямар нэг зүйл хийх боломж олгохуйц тайлбар өгөхийг нэхэн шаардаж байна. Сүүлийн арван жилийн турш уг асуудлын тухай бидний ойлголтыг өргөтгөхөд чиглэсэн олон судалгааг эдийн засагчид, улс төр судлаачид хийгээд байна. Ялангуяа, уг асуудлын ихэнх нь улс төрийн шинж чанартай гэдгийг бид ойлгож байна. Үүний цаана ямар хүч буйг өргөн хүрээтэй ойлгох нь ирээдүйд илүү нааштай үр дүн гарахуйц байдлаар улс төрийн үйл явцыг төлөвшүүлэхэд тустай; ийм ойлголт нь нөөц баялгийг тухайн улсын бүх ард түмний тусын тулд ашиглах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн институцийн шинэчлэл хийхэд дэмжлэг үзүүлэх болно; бас сэтгүүлчид энэ талаар гүнзгий судалж, тэнцвэртэй мэдээлэх нь зарим нэг муу муухай зөрчлийг хязгаарлахад тусална гэсэн итгэл үнэмшилд тулгуурлан бид энэхүү номыг бүтээсэн юм.

Түүнчлэн тухайн улс орон нөөц баялгийнхаа ихэнхийг өөрөө авдаг байх, тэр нөөц баялаг нь тухайн улсын өсөлт хөгжлийг нэмэгдүүлдэг байх, үр өгөөжийг нь өргөн олноор хуваан хүртдэг байхад чиглэсэн макро болон микро эдийн засгийн бодлогын аль алиныг нь бий болгосон байх шаардлагатай.

Макро эдийн засгийн бодлого

Аливаа үйлдвэрлэгч оронд тулгардаг хамгийн хэцүү асуултууд гэвэл: Тухайн нөөц баялгийг хэр хурдан олборлож, олсон орлогыг хэрхэн ашиглах ёстой вэ? Тухайн орон зээл авах замаар бэлэн мөнгөний урсгалаа нэмэгдүүлэх ёстой юу? Макро эдийн засгийн зохих шийдвэрүүд хэрэгжих нөхцлийг хангахад чиглэсэн институцийн ямар шинэчлэлүүд хийх ёстой вэ?

Олборлох хурд

Өнөөдөр олборлоогүй нөөц баялаг маргааш байж л байна, тэр алга болчихгүй. Энэ нь үнэндээ байгалийн нөөц баялгийг аль болох хурдан олборлох сэтгэл төрүүлэхгүй байж болно. Аливаа орон олсон орлогынхоо мөнгөн санг сайтар

ашиглаж чадахааргүй бол нөөц хомсдох тусам үнэ нь өсдөг³ жамтай учраас нөөц баялгаа хөрсөнд нь үлдээж, үнэ цэнийг нь өсгөж байсан нь дээр байж болно. Цэргийн дарангуйлагч этгээд бол тухайн улсын нөөц баялгийг хүн амаа нухчин дарах, дуртай дайн байлдааныг санхүүжүүлэн зэр зэвсэг худалдан авахад ашиглаж болох учраас үнэн хэрэгтээ ард түмнээ нөөц баялаг огт байхгүй байснаас ч долоон дор байдалд оруулж болно.

Цаашилбал, нөөц баялгаа олборлож олсон орлогоо өөр байдлаар хөрөнгө оруулж чадаагүй тохиолдолд аливаа орны баялгийн хэмжээ багассаар байдаг. Газрын тос, байгалийн хий, ашигт малтмал зэрэг нөөц баялаг дахиж нөхөн сэргээгдэхгүй учраас тэдгээрийг олборлох нь тухайн орныг улам ядууруулдаг. Нэгэнт газрын хөрснөөс гаргаж аваад, зарж борлуулчихсан бол тэр ашигт малтмалыг юугаар ч орлуулж чадахгүй. Энэхүү байгалийн баялгийн алдагдлыг нөхөж, тухайн орныг улам баяжуулж чадах цорын ганц зүйл бол капиталд (биет буюу байгалийн) оруулсан хөрөнгө оруулалт юм.

Байгалийн баялаг бол хөрөнгө учраас түүнийг олборлоно гэдэг бол түүнээс олсон зарим хөрөнгийн эх үүсвэрээ өөр хэлбэрт шилжүүлж байгаа жирийн нэг портфелийн дахин хуваарилалт гэж үзэх хэрэгтэй. Бангладеш шиг байгалийн хийн хязгаарлагдмал нөөцтэй орон яваандаа эрчим хүчний үнийн өсөлтөөс урт удаан хугацаанд өөрийгөө хамгаалах үр нөлөөтэй арга зам байхгүй учраас байгалийн хийгээ зарж борлуулахдаа анхаарал болгоомжтой хандахыг хүсч байж болох юм.

Зээллэг: сэрэмжлүүлэг

Газрын тос экспортлогч орнууд байгаагаасаа илүү ихийг зарцуулах хандлагад олон улсын банкууд нөлөөлөх нь олонтаа. Газрын тосны үнэ өндөр байхад тэдгээр банк тийм орнуудад мөнгө зээлдүүлж зарцуулалтын хувийг нь нэмэгдүүлэхэд бэлэн байдаг. Гэвч капиталын зах зээл бол цаг агаар шиг хувьсамтгай найз нөхөр юм. Газрын тосны үнэ буурах буюу хүүгийн хувь өсөхөд зээлдүүлэгчид өгсөн зээлээ хурдхан шиг эргүүлж авахыг боддог. Банкныхны ерөнхий араншин бол тэд мөнгө хэрэггүй хүмүүст зээл өгөхийг илүүд үздэг явдал юм. Газрын тосны үнэ унахад тухайн оронд мөнгө хэрэгтэй болно, гэтэл яг тэр мөчид зээлдүүлэгчид мөнгөө эргүүлж авахыг хүсдэг. Ийм учраас капиталын урсгал, ялангуяа богино хугацаат капиталын урсгал нь дахин давтагдах мөчлөгийг дэмжих хандлагатай байж, байгалийн баялгийн үнийн уналтаас үүссэн тогтворгүй байдлыг ямар нэг байдлаар хурцатгадаг.

Хэрэв засгийн газрууд зээлсэн мөнгөө өндөр үр ашигтай зүйлд хөрөнгө оруулж, төлөх ёстой хүүгийн төлбөрөөсөө нэлээд их ашиг олоод байдагсан бол энэ бүхэн хэвийн сайхан байхсан билээ. Гэвч тэгэхгүй байх нь олонтаа. Зээлээр

бүтээсэн хөрөнгө оруулалтаас олох цэвэр ашиг голдуу зээлсэн дүнгээсээ хамаагүй бага байдаг. Түүнээс гадна зээлийн санг дотоод зарлагаа санхүүжүүлэхэд ашигласан тохиолдолд эдгээр зарлага нь валютын ханш хэт өсөхөд хүргэж, үнэн хэрэгтээ Голланд өвчин⁴ хэмээх нөлөөллөөр дамжин дотоодын экспортлогчид, нийлүүлэгчдэд хүнд цохилт өгөх болно.

Нягтлан бодох бүртгэлийн хүрээ

Засгийн газрууд олсон орлогоо тун муу захиран зарцуулдгийн нэг шалтгаан бол өргөн хэрэглэгдэж буй нягтлан бодох бүртгэлийн стандарт хүрээтэй холбоотой. Засгийн газрууд эдийн засгаа яаж сайн удирдан зохицуулахаа мэдэж байгаагаа харуулахыг хүсдэг нь зүйн хэрэг. Тэд эдийн засгийн өсөлтийн хувиа дээшлүүлж чадсан л бол байдал сайжирлаа гэж үздэг. Гэвч дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) бол эдийн засгийн сайн сайхан байдлын жинхэнэ бодит хэмжүүр биш. Дээр дурдсанчлан, хэрвээ тухайн орон байгалийн баялгаа ихээр олборлосон ч олсон орлогоороо сайн хөрөнгө оруулалт хийж чадаагүй бол тэр улс улам баян биш, харин улам ядуу болж байна гэсэн үг.

Харин заримдаа “ногоон ДНБ” гэж нэрлэдэг өөр нэг хувилбар нь тогтвортой сайн сайхан байдлыг илүү үнэн зөв хэмжих оролдлого болдог⁵. Аливаа аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн хүрээнд үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол тооцдог шиг улс орны нягтлан бодох бүртгэлийн хүрээнд байгалийн баялгийн хорогдол, байгаль орчны доройтлыг тооцдог байх ёстой. Мөн аж ахуйн нэгжийн нягтлан бодох бүртгэлийн хүрээнд хөрөнгө ба өр төлбөрийг тооцдог шиг улс орны бүртгэл тооцоонд хөрөнгө, өр төлбөр (зээлийн өр) хоёр нэмэгдэж байгаа эсэхийг тооцож бүртгэдэг байх ёстой. Байгалийн баялгаа зарж борлуулдаг, газрын тосны компаниа хувьчилдаг, ирээдүйд олох орлогын төлөө зээл авдаг улс оронд ДНБ-ийг нэмэгдүүлсэн хэт их хэрэглээ үүсч байж болох боловч нягтлан бодох бүртгэлийн хүрээндээ тухайн орон үнэн хэрэгтээ улам ядуурч байгааг харуулдаг байх ёстой.

Институцийн шинэчлэл-тогтворжуулалтын сангууд

Бараа, түүхий эдийн олон улсын үнэ асар их хэлбэлзэж байдаг нь зарцуулалтыг тэгшитгэхэд зориулсан тогтворжуулалтын сангууд (“бороотой өдрийн сан”) байгуулах гол шалтгаан болдог. Гэхдээ ийм тогтворжуулалтын санг өөр зорилгоор ч ашиглаж болох юм. Тухайлбал, Голланд өвчний ноцтой асуудал үүсгэхгүйгээр зарцуулалтын хэв маягийг хянахад тусалж болно. Тогтворжуулалтын санг тусдаа дансанд нөөц сан үүсгэж хадгалснаар засгийн газар төрөлх зангаараа байгаа бүх нөөцөө зарцуулахаас сэргийлэх нэг хяналт болно. Мөн уг санг хөрөнгө оруулалтад

зарцуулж, улмаар байгалийн баялгийн хорогдлыг хүний болон биет капиталын өсөлтөөр нөхөх нөхцлийг хангаж өгөхөд тустай байж болох юм.

Түүнчлэн тогтворжуулалтын сангуудыг хариу төлөөс нэхэх буюу ашиг хонжоо хайх явдлыг багасгахад ашиглаж болно. Уг сангуудыг хэрхэн ашиглаж байгааг харуулах нээлттэй, ил тод үйл явцаар хангаснаар нөөц баялаг ихтэй орнуудад олонтаа гардаг бусармаг зөрчлүүдээс сэргийлэх, тэдгээрийг багасгахад тусалж болно.

Микро эдийн засгийн бодлого

Илүү их орлого олох магадлалыг нэмэгдүүлэх, олсон орлогоо сайтар зарцуулсан эсэхийг хянахад чиглэсэн янз бүрийн бодлогыг засгийн газар авч хэрэгжүүлж болно.

Ил тод байдал

Магадгүй хамгийн чухал ач холбогдолтой багц бодлого бол ил тод байдлыг дээшлүүлэхтэй холбоотой бодлого мөн. Энэ нь, байгалийн баялгийг олборлоход гэрээнд оролцогчидтой засгийн газар хэрхэн харьцаж байгаа тухай, гарын үсэг зурсан гэрээнүүдийн тухай, засгийн газрын хүлээж авсан орлогын хэмжээний тухай, үйлдвэрлэн гаргасан байгалийн баялгийн хэмжээний тухай, мөн орлогын сангуудын ашиглалтын тухай илүү их мэдээлэлтэй байна гэсэн үг. Иймэрхүү ил тод байдал нь авилгалд хамрагдах хүрээг хумиж байдаг. Эцсийн эцэст, компаниудын хувьд газрын тосны нөөцийг ашиглах эрхийн төлөө үйлдвэрлэгч орны засгийн газарт зах зээлийн үнээр төлбөр төлснөөс, засгийн газрыг нь хахуульдсан нь хамаагүй хямд байх явдал элбэг байдаг. Авилгал, хээл хахуулийн энэ боломжийг ил тод байдал хязгаарлаж байдаг. Энд хамгийн наад зах нь, засгийн газар яагаад улс орныхоо баялгийн үнийг бүрэн авахгүй байна вэ гэх мэт асуулт тавигддаг.

Газрын тос үйлдвэрлэгч БиПи компани анх Анголийн засгийн газарт төлж байгаа төлбөрөө нийтэд ил болгон зарлах санал дэвшүүлсэн боловч засгийн газар нь татгалзаж байжээ⁶. Гэтэл Нигери гэх мэт газрын тос үйлдвэрлэгч бусад олон орон газрын тосны бүх компаниудаасаа “төлснөө нийтэл” хэмээн шаардаж, мөн засгийн газрын албан тушаалтнуудаа тэр мөнгө хаашаа орсныг нийтэд мэдэгдэхийг шаардаж эхэлсэн байна⁷.

Дуудлага худалдааны хэлбэр

Байгалийн баялаг үйлдвэрлэгч улс орон уг баялгаа боловсруулан гаргахын тулд үндэстэн дамнасан компаниудтай ямар гэрээ байгуулах нь түүнээс тухайн засгийн

газар хэр их орлого олоход асар их нөлөө үзүүлж болно. Гэрээ, хэлэлцээрийн асуудал бол тун ярвигтай зүйл бөгөөд энэ тухай 5 дугаар бүлэгт илүү дэлгэрэнгүй авч үзнэ.

Гадаадын компаниудтай харилцах зарим арга өрсөлдөөнийг илт бууруулж, улмаар засгийн газарт орох орлогыг багасгахад хүргэдэг. Тухайлбал, засгийн газрууд газрын тосны орд газрын томоохон хэмжээний талбайг арилжааны олборлолт явуулах зорилгоор ойр ойрхон дараалан худалддаг “талт худалдаа”-арга нь үнийг бууруулах талтай байдаг⁸. Томоохон газрын тосны компанид хүртэл эрсдэл амсах сонирхол бага байдаг нь мэдээж бөгөөд тэд зөвхөн хямруулсан үнээр хайгуулын эрхийн бичгийг (урьд нь авсан түрээсийн эрхийнхээ үр ашгийг мэдэхээсээ өмнө) нэмж худалдан авахад бэлэн байдаг.

Аливаа улсад нэг компани бусдаасаа түрүүлж орж ирэхийг зөвшөөрөх нь дараа дараагийн өрсөлдөөнийг боогдуулж болно. Анх хайгуул хийлгэхээр урьсан компани мэдээллийн тэнцвэргүй байдлаас үүдэн хожих болно. Өөрөөр хэлбэл, тэр компани зөвхөн тухайн хайгуул хийсэн талбайнхаа мэдээллийг төдийгүй түүний ойр орчмын талбайнуудын нөөцийн тухай мэдэж авна гэсэн үг⁹. Хэдийгээр тухайн засгийн газар бусад талбайг өрсөлдөөнт дуудлага худалдаанд оруулсан ч гэсэн дээр дурдсан мэдээллийн тэнцвэргүй байдал (төдийгүй анхны компаний албан тушаалтнуудтай тогтоосон харилцаа) нь өрсөлдөөнийг багасгахад хүргэж, улмаар засгийн газарт орох орлогыг бууруулна. Тэдэнтэй өрсөлдөгчид бүгд л мэдээллийн хувьд сул талтай байгаагаа мэдрэх болно: хэрэв тэд дуудлага худалдаанд ялбал хэт их буюу тухайн талбайн бодит нөөц бололцоог мэдэж байгаа мэдээлэлтэй өрсөлдөгчөөсөө илүү их үнийн санал тавьжээ гэсэн үг. Ийм учраас шинэ компаниуд дуудлага худалдаанд идэвхтэй оролцохгүй.

Засгийн газар газрын тосны талбайд дуудлага худалдаа явуулах ажлыг өөр аргаар зохион байгуулж болно. Шагналт дуудлага худалдаа нь ялсан компани гэрээний эхэнд хүлээн авагч засгийн газарт хэр их шагнал урамшуулал төлөх вэ гэдгээр нь компаниудыг өрсөлдүүлдэг. Энэ дуудлага худалдаа нь үйлдвэрлэгч компани тухайн байгалийн баялгийн нөөцийн хэмжээ, олборлолтын зардлыг аль алиныг нь огт мэдэхгүйгээр их хэмжээний мөнгө төлөхийг шаарддаг. Шагналт дуудлага худалдааны эдгээр эрсдэл нь компаниудын өрсөлдөх урам зоригийг хугалж болно. Харин өрсөлдөгч талууд тухайн засгийн газарт нөөц ашигласны төлбөр болгон төлөх орлогынхоо хувиар өрсөлдөгч нөөцийн төлбөрт дуудлага худалдаа нь шагналт дуудлага худалдааг бодвол эрсдэл багатай, өрсөлдөөн ихтэй байдаг. Шагналт дуудлага худалдаа бол эзэмших эрхийг албадан хураах эсвэл дараа дараагийн засгийн газрууд гэрээний нөхцлийг өөрчлөх¹⁰ эрсдэл бүхий хөгжиж байгаа орнуудад хөндөгддөг арга юм. Иймд үйл ажиллагаа явуулахад

шаардлагатай их хэмжээний гарааны хөрөнгө оруулалт дутагдсан болон хожим засгийн газар гэрээний үүргээ биелүүлээгүйгээс компаниудын алдагдлыг нөхөн төлөх эрсдлийг багасгана гэдэг үүднээсээ аливаа засгийн газрын хувьд нөөцийн төлбөрт дуудлага худалдаа нь шагналт дуудлага худалдаанаас илүү их орлого бүрдүүлж байж болно.

Зарим газар, түүний дотор АНУ-д, түрээсийн гэрээний заалтууд нь цооногуудыг дутуу ашиглаад хаах, эсвэл маш эрчимтэй олборлож дуусахад хүргэж байна гэсэн асуудал тавигдаж байна. Аливаа нөөц ашигласны төлбөр нь олсон цэвэр ашгийг бууруулж байгаагаас болж газрын тосны компаниуд цооногийг шаардлагатай хугацаанаас нь өмнө хаах шийдвэр гаргахад нөлөөлсөн байж болно¹¹. Ийм учраас газрын тосыг олборлож эхлэн, олборлолтын зардал нэмэгдэж эхэлмэгц нөөц ашигласны төлбөрийг тодорхой хэмжээнд тогтмол болгох (буюу болж өгвөл бүр байхгүй болгох) нөхцөл сайтар боловсруулсан гэрээнд байж болох юм.

Энэ талаар дэлгэрэнгүй авч үзэхэд ярвигтай боловч үндсэн санаа нь аливаа орны үйлдвэрлэгчидтэй харилцах харилцаанаас асар их зүйл хамаардаг гэсэн энгийн дүгнэлт юм. АНУ болон Европт радио, телевиз, гар утас гэх мэт долгионы хуваарьт үйл ажиллагаанд зориулан ашиглаж буй агаарын долгионы дуудлага худалдаа зохион байгуулалт нь засгийн газрын орлогыг нэмэгдүүлэхэд томоохон нөлөө үзүүлж байна¹². Улс орнууд байгалийн баялгийн нийт орлогоос өөрсдийн авах тодорхой хувьдаа анхаарч, түүнийгээ олборлолтын зардал, хүлээх эрсдлийн хувьд ижил төстэй бусад орнуудынхтай харьцуулах замаар дуудлага худалдааны үйл явцаа үнэлэх ёстой.

Хөгжингүй орнуудын гүйцэтгэх үүрэг

Нөөц баялаг ихтэй орнууд байгалийн баялгаасаа аль болох чадах чинээгээрээ ихийг авч, түүнийгээ урт хугацааны сайн сайхан байдлаа дээшлүүлэхэд ашиглах нөхцлийг засгийн газартаа бүрдүүлэх эн тэргүүний үүрэгтэй. Гэвч тийм ололт амжилтад хүрэх боломжийг нь дээшлүүлэх талаар хөгжингүй орнууд, олон улсын байгууллагуудын зүгээс авч болох арга хэмжээнүүд байдаг. Үүнд дараахь арга хэмжээний жагсаалтыг санал болгож байгаа бөгөөд энэ бол бүрэн дүүрэн жагсаалт хараахан биш юм шүү.

Нэгдүгээрт, хөгжингүй орнууд газрын тос, байгалийн баялаг олборлогч компаниудыг ил тод байж, “гөлснөө нийтэл” гэсэн шахалт үзүүлж болно. Ихээхэн үр нөлөөтэй нэг энгийн шаардлага бол зөвхөн илээр нийтлэгдсэн төлбөрүүдийг татвараас чөлөөлөх явдал юм.

Хоёрдугаарт, улс орнууд авилгал, хээл хахуулийн эсрэг хатуу хууль гарган мөрдүүлж болно.

Гуравдугаарт, банкны нууц дансууд хээл хахуулийг нуух аюулгүй байр болж түүнийг хөхиүлэн дэмжиж байдаг. Олон улсын санхүүгийн хамтын нийгэмлэг террористууд банкны нууц данс ашиглах явдлыг зогсоох талаар ихээхэн амжилт олсон. Харин ийм нууц дансанд тавих хязгаарлалтыг өргөтгөн газрын тосны орлого тухайн хөгжиж буй орны төрийн санд шууд орохын оронд олон улсын банкны тогтолцоогоор дамжин өөр тийш шилжихийг төвөгтэй болгох ёстой.

Эцэст нь, Олон Улсын Валютын сангаас хөгжиж байгаа орнуудад тогтворжуулалтын сан байгуулах явдлыг дэмжих ёстой. Энэ нь түүнийг нягтлан бодох бүртгэлийн хүрээгээ өөрчлөхийг шаардах бөгөөд ингэснээр эдийн засгийн уналтын үед тогтворжуулалтын сангаасаа илүү ихээр зарцуулах явдлыг гол ашиг орлогоо алдан нөөцийн хомсдолд орж, хатуу шүүмжлэлд өртөж байдаг бусад сангууд, зардлуудын нэг адил үзэх ёстой. Түүнчлэн, ОУВС-аас олборлох салбарын үйлдвэрүүдээ хувьчлах зохисгүй дарамтыг улс орнуудад үзүүлэх ёсгүй. (Хөгжиж байгаа олон оронд олборлолтын ажлыг гардан явуулахад шаардлагатай хөрөнгө, ур чадвар бүхий дотоодын компани байхгүй учраас ийм хувьчлал нь байгалийн баялгаа гадаадын компаниудад худалд гэсэнтэй адил тусч байна.) Өмч хувьчлал бол байгалийн баялгийг олборлоход гадаадын компаниудыг оролцуулах ганц арга болоод байна. Хөгжиж байгаа оронд илүү их орлого оруулах үүнээс өөр боломжит арга (гэрээний зохицуулалтууд) байж болно¹³.

Нөөцийн хясланг бий болгодог нэг шалтгаан бол хариу төлбөр нэхэх буюу ашиг хонжоо хайх явдалаас үүсдэг зөрчил юм гэдгийг бид дурдсан. Өрнөдийн орны засгийн газрууд ардчилсан оролцооны үйл явцыг дэмжих замаар энэ зөрчлийг багасгахыг оролдож байна.

Магадгүй бүр илүү чухал байж болох зүйл бол зөрчилдөөнөөс үүсч буй “ашиг хонжоо”-г хязгаарлаж өгөх, тухайлбал “зөрчилт алмааз”-ны эсрэг кампанит ажлыг бусад газар дэлгэрүүлэх арга хэмжээг хөгжингүй орнуудын зүгээс авч болох юм. Ийм орлогын нэлээд хэсэг нь зэр зэвсэг худалдан авахад зарцуулагддаг учраас зэвсгийн худалдаанд хязгаарлалт тавих нь мөн л чухал хувь нэмэр болох нь маргаангүй.

Өсөлт, хөгжлийг хангадаг бүгдэд тохирох эм тан, анагаах шидтэй жор гэж байхгүй. Гэвч хэрвээ нөөц баялаг ихтэй орнууд болон олон улсын хамтын нийгэмлэгийн зүгээс шинэчлэл хийж чадвал нөөц баялгийн хясланг арилгаж, түүнийг улирч өнгөрсөн зүйл болгох ирээдүй бий. Байгалийн баялаг газар дэлхийн хайр хишиг байж чадна, байх ч ёстой.

2. Нөөц баялгийн хясланг ойлгохуй

Терри Линн Карл

Газрын тос экспортлох явдал өөрөө ядуу буурай орнуудыг бүхэл бүтэн нэг үеийн турш хөгжил цэцэглэлтэд хүргэж чадаагүйг дөчин жилийн туршлага харуулж байна. Урьд өмнө нь газрын тосны “хар алт” эд баялаг, эдийн засгийн хөгжил авчирна гэж олон мэргэжилтэн үздэг байлаа. Өнөөдөр тэдний ийм горьдлого найдвар хамаагүй багасчээ.

Газрын тос экспортлогч орнуудыг “элбэг дэлбэгийн гаж үзэгдэл”, “Кинг Мидасийн асуудал”, эсвэл Газрын тос Экспортлогч Орнуудын Байгууллага (ОПЕК)-ыг үндэслэн байгуулагч Хуан Пабло Перез Алфонзогийн нэгэнтээ нэрлэсэнчлэн “чөтгөрийн баас”-наас болж зовж шаналж байгаагаар илүүтэй дүрслэх нь байдаг. Тэдний бодит байдал ч ноцтой байна: амьжиргаа нь газрын тосноос хараат улс орнууд эдийн засгийн хувьд дэлхий дээр хамгийн хүндрэл бэрхшээлтэй, мөн хамгийн дарангуйлагч дэглэмтэй, хамгийн их зөрчил мөргөлдөөнтэй байдаг.

Нөөц баялгийн хяслан гэж юуг хэлэх... бас юуг хэлэхгүй вэ?

Сүүлийн дөчин жилийн турш газрын тосны экспортод тулгуурласан хөгжлийн үр дагаварууд сөрөг тал руугаа чиглэх хандлагатай байна. Сөрөг үр нөлөөний тоонд хүлээгдэж байснаас удаан эдийн засгийн өсөлт, эдийн засгийн ядмаг бүтэц, нийгмийн халамжийн дорой үзүүлэлтүүд, ядуурал, тэгш бус байдлын өндөр түвшин, орон нутгийн түвшин дэх байгаль орчны сүйрэл, туйлын сул дорой засаглал, авилгал газар авах, зөрчил харгалдаан, дайн мөргөлдөөн олон гарах зэрэг үр дагавар орно.

Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспортоос хараат улс орнуудтай харьцуулахад ашигт малтмал, газрын тос экспортлогч орнуудад ер бусын өндөр түвшний ядуурал, эрүүл мэндийн ядмаг үйлчилгээ, хаа сайгүй хүнс тэжээлийн дутагдал, хүүхдийн эндэгдлийн өндөр хувь, доогуур дундаж наслалт, боловсролын үр өгөөж муу байдаг зэрэг нь эдгээр нөөц баялаг ихтэй орнуудад орж байгаа орлогын урсгалтай харьцуулахад тун гайхалтай үр дүн юм.

Газрын тосны зах зээлийн асар тогтворгүй шинж чанараас болж газрын тос экспортлогч улс үндэстнүүд нэг хүнд ноогдох орлогын гэнэтийн бууралт, их хэмжээний өсөлтийн алдагдалд орж хохирох явдал элбэг байдаг. Статистик тоо баримтууд нь ч аймшигтай: Дэлхийд хамгийн их түүхий нефтийн батлагдсан нөөцтэй Саудын Араб улсад нэг хүнд ноогдох орлого 1981 онд 28.600 ам. доллар байсан бол 2001 онд 6.800 ам. доллар болж навс унажээ¹. Нигери, Венесуэл зэрэг оронд нэг хүнд ноогдох бодит орлогын хэмжээ 1960 оны түвшинд хүртэл буурсан байхад Алжир, Ангол, Конго, Эквадор, Габон, Иран, Ирак, Кувейт, Ливи, Катар, Тринадад Тобаго зэрэг олон оронд 1970-аад он, 1980-аад оны эхэн үеийн түвшинд хүртлээ буурчээ².

Газрын тос, ашигт малтмалаас хараат орнууд дахь энэхүү хачирхалтай сөрөг үр дүнг “нөөц баялгийн хяслан” гэж нэрлэдэг. Гэхдээ нөөц баялгийн хяслан гэж ярилцахын өмнө үүнд юуг хамааруулахгүйг тодруулах нь зүйтэй. Нөөц баялгийн хяслан гэдэг бол зарим хүний итгэдэг шиг байгалийн баялаг элбэг байх нь эдийн засгийн өсөлт, хөгжилтөд дандаа эсвэл заавал муу байна гэсэн үг биш юм. Хэдийгээр газрын тосны экспортод тулгуурлан амжилттай хөгжсөн улсын жишээ бараг байхгүй боловч, нөгөө талаас АНУ (үйлдвэрлэлээрээ дэлхийд тэргүүлэгч орон болж ирэх үедээ ашигт малтмалын эдийн засгаараа дэлхийд тэргүүлэгч улс байсан), Канад, Австрали, Чили, Норвеги зэрэг орны нөөц баялагт тулгуурлан амжилттай хөгжсөн түүхэн маргашгүй жишээнүүд байдаг.

Нөөц баялгийн хяслан гэдэг бол нефть болон бусад ашигт малтмалын

нөөцтэй төдий улсад биш, харин газрын тосны орлогоос хэт хараат улсад хамаатай асуудал. Энэхүү хараат байдлыг ерөнхийдөө нийт экспортод газрын тосны орлого зонхилох байдлаар (ихэвчлэн нийт экспортын 60-95 хувь) эсвэл газрын тос, байгалийн хийн экспортын дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувиар хэмждэг. Энэ хувь доод тал нь 4.9 хувиас (газрын тосны нөөц хомсдож байгаа Камерунд) 86 хувь (шинэхэн экспортлогчдын нэг Экваторын Гвинейд) хүртэл янз янз байдаг.

Мөн нөөц баялгийн хяслан нь газрын тос, ашигт малтмал экспортлогч орнууд байгалийн баялаг багатай байх тусам сайн, өөрөөр хэлбэл, Венесуэлд байснаас Гайтид байсан нь дээр гэсэн үг биш. Газрын тос бол нэг бол ашигтай эсвэл хор нөлөөтэй байж болох жирийн нэг өтгөн хар бодис юм: хамгийн гол асуудал уг баялгийн өөрийн шинж чанарт бус харин түүнээс бий болсон баялгийг хэрхэн хуваарилж, ашиглаж байгаад оршино.

Явцуу утгаар авч үзвэл нөөц баялгийн хяслан гэдэг бол байгалийн баялгаас ихээхэн хараат байдал ба эдийн засгийн өсөлт хоёрын урвуу хамаарал юм. Нөөц баялаг ихтэй хөгжиж буй орнууд нөөц баялаг муутайгаасаа хөгжлөөр хоцорч байгааг сүүлийн үеийн олон судалгаа харуулаад байна. Гэвч бүх нөөц баялаг адилхан байдаггүй. “Цэгт үүсвэрийн” байгалийн баялгийн (газрын тос, ашигт малтмал гэх мэт газар зүйн буюу эдийн засгийн явцуу бааз сууринаас олборлодог гэсэн үг) экспортоос хараат улсуудын эдийн засгийн өсөлт удаан байх нь элбэг. Үнэн хэрэгтээ, газрын тос, ашигт малтмалд тулгуурласан нөөц баялаг ихтэй орнууд хөрөнгө оруулалт ба импортын өндөр чадавхитай байдгийг эс тооцвол хамгийн сул дорой өсөлттэй орнуудын тоонд ордог.

ОПЕК-ийн гишүүн орнуудын 1965-1998 оны судалгааг үзэхэд нэг хүнд ноогдох үндэсний нийт бүтээгдэхүүн нь жилд дунджаар 1.3 хувиар *буурсан* байхад, тэр хооронд газрын тосны баялаггүй хөгжиж байгаа орнууд нийтээрээ жилд дунджаар 2.2 хувийн өсөлттэй гарсан байна³. Газрын тос, ашигт малтмалын нөөцөөс хэдий чинээ их хамааралтай байна төдий чинээ өсөлт муутай байдгийг судалгаанууд харуулж байна. Газрын тосны экспортын орлогоос хараат орнууд тийм нөөц баялаг муутай орнуудаас дор байгаад зогсохгүй орлогын урсгалынхаа дагуу байвал зохихоосоо хамаагүй дорой буурай явж байна.

Нөөц баялгийн хяслангийн тайлбар

Энэхүү эдийн засгийн ядмаг үр дүнг янз бүрээр тайлбарладаг бөгөөд тайлбарууд нь маргаантай байдаг. Гэвч ялангуяа дараахь хүчин зүйлс харилцан хавсарваас газрын тос экспортлогчид бодлогын алдаа, уналтад амархан нэрвэгддэг.

- ▶ **Газрын тосны үнийн тогтворгүй байдал:** Дэлхий дээр хамгийн тогтворгүй нь дэлхийн газрын тосны зах зээл гэж хэлэх үндэслэлтэй бөгөөд бодлого боловсруулагчдын хувьд үнийн гэнэтийн хөөрөгдөлт, дараа дараагийн оргил ба уналтын үеийн эдийн засгийн мөчлөгийг үр нөлөөтэй удирдах хэцүү байдаг. Үнийн тогтворгүй байдал нь төсвийн сахилга бат, төр засгийн санхүүгийн хяналт, бодлого төлөвлөлтийн хүчин чармайлтад хүчтэй сөрөг нөлөө үзүүлж байдаг. Мөн энэ нь үр нөлөөтэй хөрөнгө оруулалт хийх, орлогыг оновчтой хуваарилах, ядуурлыг бууруулахад сөргөөр нөлөөлдөг.
- ▶ **Голланд өвчин:** Газрын тосноос хараат улс орнууд Голланд өвчин хэмээх асуудал буюу газрын тосны салбар дотоодын валютын ханшийг чангаруулснаар бусад экспортоо өрсөлдөх чадваргүй болгодог үзэгдлээс болж зовж шаналах явдал элбэг байдаг. Үүний үр дүнд газрын тосны экспорт нь экспортын бусад ирээдүйтэй салбарыг, ялангуяа хөдөө аж ахуй, үйлдвэрлэлийн салбарыг түрэн гаргаж, эдийн засгийн бүтцийг олон салбарт төрөлжүүлэн хөгжүүлэхэд хүнд болгодог. Бодлого боловсруулагчид үүний хариуд улам бүр өрсөлдөх чадваргүй болж байгаа эдийн засгийн үйл ажиллагааг тогтоон барих үүднээс газрын тосны салбартаа санхүүжилтийн ачаа үүрүүлэх замаар хамгаалалтын хүчтэй бодлого баримталдаг. Гэтэл хөдөө аж ахуйн болон үйлдвэрлэлийн салбарууд газрын тосны эдгээр шилжүүлгээс хамааралтай болж эхэлмэгц, газрын тосноос хараат байдал улам даамжирч, хөрөнгийг илүү үр ашигтай ашиглах сонирхолгүй болгодог. Энэ нь яваандаа өрсөлдөх чадвараа бүрмөсөн алдахад хүргэж болно.
- ▶ **Хоцрогдсон арга туршлагын хуримтлал ба тэгш бус байдлын даамжрал:** Капитал ба технологийн дэлхийн хамгийн нягтралтай салбарын хувьд газрын тосны аж үйлдвэр нь цөөн тооны ажлын байр бий болгохын зэрэгцээ эдгээр ажлыг хийхэд шаардагдах ур чадвар нь газрын тос экспортлогч орнууд дахь ажилгүйчүүдийн мэргэжил туршлагад ерөнхийдөө тохирдоггүй. Харин тэднийг ажлаар хангахын оронд, өндөр ур чадвартай ажилтнуудыг гадаадад сургагчаар явуулах эсвэл гадаадаас ажилчид авчирч ажиллуулах зэргээр газрын тос экспортлогч орнуудыг “хийж үзэж байж суралцах”-ын асар их ашиг тусаас салгаж байгаа нь эдийн засгийн хөгжлийн хамгийн гол бэрхшээл юм. Харин нөөц баялаг хомс орнуудад байдал үүний

эсрэгээр буюу боловсролын эрэлт хэрэгцээ, ялангуяа үйлдвэрлэлийн салбарт, өндөр байдаг. Эдгээр оронд арга туршлагын хуримтлал илүү хурдан явагдаж, баян ядуугийн ялгаа бага гарах хандлагатай байдаг. Энд дан ганц газрын тосны орлогын санхүүжилтээр бус, харин хөдөлмөрийн бүтээмж нэмэгдсэний үр дүнд эдийн засгийн өсөлт ерөнхийдөө нэмэгдэж байдаг. Үүний цэвэр үр нөлөө ойлгомжтой: 2003 онд НҮБ-аас гаргасан Арабын Хүний Хөгжлийн Хоёрдугаар Тайланд Ойрхи Дорнодын зарим хэсгийн газрын тосноос ихээхэн хамааралтай байдал нь “баялаг цөөн хүний гарт хэт төвлөрч”, “эдийн засгийн өсөлтийг доголдуулан”, “мэдлэг чадварын эрэлт хэрэгцээг судруулсан” гэжээ⁴.

- ▶ **Зожигрол ба татварын асуудал:** Газрын тосны төслүүд олон оронд томоохон цар хүрээтэй, капиталын нягтрал ихтэй, гадаад эзэнтэй байдаг учраас эдгээр орны эдийн засгийн бусад хэсэгтэй холбогдох бүтээлч холбоо бага байдаг. Ерөнхийдөө, газрын тос олборлолтын орлого нэг бол гадаадын газрын тосны компаниудын төлсөн нөөцийн төлбөр эсвэл улсын үйлдвэрийн газруудын олсон татвар, ашиг хэлбэрээр шууд тухайн орны засгийн газарт очдог. Энэ байдал нь газрын тосныхоос тусдаа татварын тогтолцоо бий болгох сонирхолгүй болгож, улмаар газрын тосноос хараат байдлыг хурцатгадаг. Төрийн мөнгөн санг хянаж байдаг эрх баригчдын хувьд өөрийн хүмүүст татвар ногдуулах шаардлагагүй учраас татвар ногдуулалт, төлөөлөл, төр засгийн хариуцлагатай байдлын хоорондох чухал уялдаа холбоог алдагдуулдаг байна. Иймд газрын тосноос хараат байдал нь илүү үр бүтээлтэй үйл ажиллагаанд саад тотгор болохын зэрэгцээ татвар төлөгчдийн эрэлт хэрэгцээ, судалгаа шинжилгээнд зайлшгүй шаардагдах хариуцлагатай байдлыг алдагдуулдаг.

Асуудлын мөн чанар: Сулхан институциуд ба бэлэнчлэгч төр

Нөөц баялгийн хяслангаас зайлсхийхийн тулд үнийн хэлбэлзлийг тэгшитгэж чадахуйц бараа, түүхий эдийн тогтворжуулалтын сан байгуулах, Голланд өвчнийг намдаахын тулд эдийн засгаа улам нээлттэй болгож гадаад валютын боловсронгуй бодлого баримтлах, хүний нөөцөд, ялангуяа боловсрол, ур чадвар олгоход илүү үр нөлөөтэй хөрөнгө оруулалт хийх, илүү ил тод байдал бий болгож татварын шинэ бодлого хэрэглэх зэрэг төрийн бодлогыг санал болгож болно. Гэвч газрын тосны баялгийг үр нөлөөтэй ашиглах амаргүй. Эдгээр бодлогыг амжилттай

хэрэгжүүлэхийн тулд чадварлаг төр засаг, харьцангуй өндөр засаглалын түвшин зайлшгүй шаардлагатай. Өндөр хөгжилтэй орны боловсронгуй засгийн газар хөндлөнгийн оролцооны (интервэншенист) далайцтай бодлого хэрэгжүүлж чадахгүй байхад тэднээс буурай хөгжилтэй орны засгийн газрууд түүнээс бүр ч илүү нарийн түвэгтэй, далайцтай бодлогыг хэрхэн зохиож хэрэгжүүлэх вэ?

Газрын тосны экспортоос хэт хамааралтай байх явдал нь ерөнхийдөө газрын тосонд тулгуурласан хөгжлийн сорилтуудыг удирдан зохицуулах чадавхи дутагддаг сул дорой институциудтэй ихээхэн холбоотой. Зарим талаар энэ нь цаг хугацааны асуудал юм: хэрвээ хуучин байсан институциуд нь сул дорой буюу төр засгийн тогтолцоо бүрэн бүрдээгүй тохиолдолд газрын тосны орлого цутган орж ирэх нь түүнээс олох ашгаар амьдардаг, бусдын гар харж бэлэнчлэгч төр засаг бий болгох хандлагатай байдаг. Ийм бэлэнчлэгч төрд эдийн засгийн нөлөө ба улс төрийн эрх мэдэл нэг дор онцгой төвлөрч, улсын ба хувийн ажлын зохих холбоо алдагдан, баялаг бүтээх нэг стратеги болсон хариу төлбөр нэхэж гар харах явдал газар авдаг. Эрх баригчид орж ирж буй орлогыг өөрсөддөө болон дэмжигчиддээ татаас, хамгаалалт, төрийн албан тушаал болгон олгох, зардал хэтрүүлэх зэргээр нааш цааш болгон эрх мэдлээ бэхжүүлэн, хэвээр хадгалах хандлагатай байдаг. Ийм учраас газрын тос үйлдвэрлэгч орны төр засаг хэт томорч тэлэхийн зэрэгцээ хүн амынх нь дунд гар харах ёс дэлгэрэх ужиг хандлагатай байдаг.

Харин нөөц баялаг багатай орнуудад тэрхүү хомс нөөцийн ашиглалтад бүх нийтийн хатуу хяналт, шахалт шаардлага тавигддаг нь үр ашиггүй байдал, идэж завших явдлыг үл хүлцэхэд хүргэдэг бөгөөд тийм эдийн засагтай улс өргөн хүрээтэй хамгаалалт, хэт газар авсан хүнд суртлыг удаан тэвчиж чадахгүй. Гэвч газрын тостой улсын төр засагт орсон газрын тосны баялаг нь ийм шахалт үзүүлэх байгууллагуудаа сулруулж байдаг. Үүний цэвэр үр дүнд төр засаг нь хүчирхэг мэт харагдавч дотроо хөндий хоосон болдог. Энэхүү завшигч төрийн өөр нэг хохирогч нь ардчилал байж болох юм: дарангуйлагч дэглэмийн эрх баригчид өөрсдийн засгийн эрхийг хэвээр хадгалах, сөрөг хүчний бүлэглэлүүд үүсэхээс сэргийлэх, асар том цэргийн арми, нухчин дарах аппаратуудыг бий болгох зорилгод газрын тосны мөнгийг ашиглаж байдаг. Ийм дэглэм урт удаан оршин тогтнох хандлагатай байж, ардчилалд саад тотгор учруулдаг гайхах зүйлгүй билээ.

Бусад улс төрийн шинжтэй хүндрэл бэрхшээлүүд ч газрын тосонд суурилсан төрийг бодлогын алдаа эндэгдэлд онцгой өртөмтгий болгож байдаг. Ийм төр засаг бол “балтай таваг” учраас хүчирхэг ашиг сонирхлууд, өргөн хүрээтэй авилгалын нөлөөнд автагдах нь амархан байдаг. Газрын тос экспортлогч орнуудыг нэг бүлэг болгон авч үзвэл тэдний авилгалд автсан байдал нь дэлхийн дунджаас (Канад, Норвеги хоёрыг оруулсан ч гэсэн) нэлээд их байдаг. Засгийн газар болон

олон улсын бизнес дэх авилгалын практиктай тэмцэх зорилгоор байгуулагдсан төрийн бус байгууллага болох Транспаренси Интернэшнл буюу Олон улсын ил тод байдлын байгууллагаас жил бүр гаргадаг зэрэглэлээр Нигери, Ангол, Азербайжан, Конго, Камерун, Индонези улсууд “хамгийн их авилгалтай” гэсэн байр эзлэхийн төлөө өрсөлдөж байна⁵. Авилгал өндөр түвшинд байх нь бодлогын сонголтуудыг алдагдуулах замаар нөөц баялгийн хясланг дэвэргэдэг. Тухайлбал, газрын тос экспортлогч орны бодлого боловсруулагчид асар том хэмжээний мега төслүүдийг илүүд үзэж, тэнд орлогоо нууж, хээл хахуулийг дамжуулахад илүү хялбар болгохын зэрэгцээ илүү ил тод байдаг урт хугацааны бүтээлч хөрөнгө оруулалтаас зайлсхийх хандлагатай байдаг. Энэ нь эргээд өсөлт болон орлогын түвшинг бууруулж байдаг.

Газрын тосноос хараат орнууд бодлогын алдаа эндэгдэлд онцгой өртөмтгий байдаг. Институцийн орчин нь ерөнхийдөө нөөц баялгийн хяслангийн эдийн засгийн үр дагаваруудыг шийдвэрлэх чадваргүй учраас тэдгээрийг улам хүндрүүлж, “үндсэн бүтээгдэхүүний хамаарлын занганд” орсноор дуусдаг. Тухайн дэглэм өөрсдийгөө засгийн эрхэнд байлгахын тулд нөөц баялгийг хуваарилж, ашиглаж байгаа учраас улс төрийн ийм хуваарилалт нь эдийн засгийн хөгжлийг гажуудуулж, хөрөнгө оруулалтын үр ашгийг муутган, эдийн засгийн шинэчлэлийг эсэргүүцэхээс гадна хамгаалалтын нуувчны ард далд завхруулга гаргахыг зөвшөөрдөг. Гадаадын зээл ч энэхүү занганд орсон байдлыг удаашруулж болно, гэхдээ эцсийн эцэст өсөлтийн сүйрэлд оруулах магадлалтай. Ингээд хүчирхийлэл гарч эхэлнэ. Баяжих ирээдүй ийм их байгаа тохиолдолд үүсдэг иргэний дайн, мөргөлдөөнүүд нь өөр бусад ямар ч бараанаас илүү газрын тостой холбоотой байдагт гайхах зүйлгүй. Газрын тосноос хараат улсуудад нөөц баялаг хомс орнуудыг бодвол иргэний дайн дэгдэх, тийм дайн нь салан тусгаарлах шинжтэй байх илүү их магадлалтай бөгөөд тэр ч байтугай газрын тосгүй газар болж буй дайнаас ч илүү удаан, эрчимтэй үргэлжлэх талтай байдаг. Газрын тос аливаа дайны эхлэлийг өдөөн түргэтгэгч байж, газрын тосноос олсон мөнгө ба дамжуулах хоолойнууд нь сөргөлдөгч талуудын аль алиныг санхүүжүүлж, зөрчлийг даамжруулахад ашиглагдаж болно. Мэдээжийн хэрэг, энэ бол нөөц баялгийн хамгийн том хяслан мөн.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Газрын тосны эдийн засгийн тухай асуултууд

- ▶ Энэ хугацаанд танай оронд газрын тосны үйлдвэрлэл хэр нөлөөлсөн бэ? Газрын тосны орлогыг ядуурлыг бууруулахад туслах зорилгоор ашиглаж байна уу? Ядуурлын үзүүлэлтүүд сайжирсан уу? Энэ хугацаанд цэвэр усны хангамж, сайн сургуульд сурах боломж, эмнэлгийн үйлчилгээ сайжирсан уу? Газрын тосны үйлдвэрлэл эхэлснээс хойш илүү олон хүн дээд боловсрол эзэмшсэн үү? Газрын тосны орлогыг ашиглан ядууралтай тэмцэхэд чиглэсэн санал, төсөл хэлэлцэгдэж байна уу?
- ▶ Танай улс газрын тос үйлдвэрлэн борлуулж эхэлснээс хойш авилгалын асуудал даамжирсан уу эсвэл сайжирсан уу?
- ▶ Танай улс газрын тосны үйлдвэрлэл эрхлэх болсноос хойш илүү олон ажлын байр бий болсон уу?
- ▶ Газрын тосны бус салбаруудад нөлөө үзүүлж байна уу? Аж үйлдвэр болон хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл өссөн үү, зогсонги байгаа юу эсвэл буурсан уу?
- ▶ Газрын тосны үйлдвэрлэл, экспорт эхэлснээс хойш засаглалын байдал сайжирсан уу? Танай оронд чөлөөт, тэгш шударга сонгууль явагддаг гэж үздэг үү? Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хүндэтгэдэг үү? Сөрөг хүчний намууд байгуулагдаж, сонгуульд чөлөөтэй өрсөлдөх боломжтой юу?
- ▶ Энэ мөнгө хаашаа явж байгааг ажигла: Газрын тосны орлого юунд ашиглагдаж байгааг мэдэхийн тулд засгийн газрынхаа төсвийг үзэж судал. Засгийн газрынхаа төсвийг тухайн бүс нутаг, дэлхийн өөр хэсэгт байгаа бусад орнынхтой харьцуул.
- ▶ Газрын тосны орлогыг зэвсэгт мөргөлдөөнийг санхүүжүүлэхэд ашиглаж байна уу? Газрын тос үйлдвэрлэж буй бүс нутагт ямар нэг зөрчил мөргөлдөөн эсвэл ажилчдын үймээн самуун гарсан уу?

ҮЙЛ ЯВДЛЫН ЖИШЭЭ

Газрын тосоор тэжээгдсэн Венесуэлийн эдийн засгийн чинээлэг гэхээсээ илүү ядуурлын байдал

Сан Франциско Хроникл сонины Роберт Коллиер

КАБИМАС, Венесуэл, 2000 оны 9 дүгээр сарын 27- Фреди Валеро ууж байсан пивоо тавиад, уурлан газар дэвслээ.

“Энэ газар шорооноос хэр их баялаг гарч ирдгийг та нар мэдэх үү?” гэж тэр асуугаад, “Хаа ч хамаагүй нүх ухахад л газрын тос гарч ирж байна. Энэ нь хэр их мөнгө болохыг би ч мэдэхгүй. Гэтэл надад хэд байна вэ? Эсвэл энд байгаа хэн нэгэнд нь?” хэмээн уурсав.

Тэр баруун гараа занган эргэн тойрондоо байгаа ноорхой ажилчин ангийнхан руу зааснаа “Бараг л юу ч үгүй хоосон” гэлээ.

Венесуэл маягийн газрын тосны оронд тавтай морилно уу.

Кабимас хот Маракайбо нуурын бүс нутгийн төвд орших бөгөөд жил бүр 13 тэрбум ам. доллар орчим өртөгтэй газрын тос олборлон гаргадаг ажээ. Гэвч энэ газрын түүх ОПЕК-ийн гишүүн бусад орны олон газарт давтагдаж болох юм гэж эдийн засагчид хэлж байна.

Валеро бол энэхүү ядуу, бүгчим жижиг хотын эргэн тойронд олноор

хөлхөх ажилгүй болсон газрын тосны ажилчдын нэг юм. Энэ газраас асар их баялгийг бий болгосныг эс тооцвол эндэхийн ард түмэнд үлдсэн зүйл, ашиг тус бага ажээ. Амьжиргааны өртөг тэнгэрт тулам өндөр, хэрэглээний бараг бүх бараагаа импортоор оруулдаг төдийгүй ажилгүйдлийн түвшин 25 хувьд хүрчээ.

Маракайбогийн бүс нутаг, Венесуэл улс хоёр бол Голланд өвчний сонгодог жишээ гэж эдийн засагчид үздэг. Энэхүү Голланд өвчин гэдэг нэр томъёо Нидерланд улс Хойд мөсөн далайгаас асар том байгалийн хийн орд газар нээж, үйлдвэрлэлд оруулсны дараа 1970-аад онд тус улсад тохиолдсон үйл явдлаас үүссэн ажээ.

Тус улсын хүсэн хүлээж байсан гэнэтийн их эд баялгийн оронд эдийн засаг нь бэлэн мөнгөний үерт автаж, үүний үр дүнд иргэд нь дотоодын үйлдвэрлэл, экспортын орлогоос илүү засгийн газрын хишиг, импорт хоёрт найддаг болсон байна.

“Голланд өвчин энд амьд сэрүүн, туйлж байна, энэ бол манай бүх асуудлын гол шалтгаан. Газрын тос манай

эдийн засгийг аймшигтай сүйрүүлж байна” гэж нэгэн импортын компаний хамтран эзэмшигч, Маракайбогийн Худалдааны Танхимийн ерөнхийлөгч Педро Гарсия хэлсэн юм.

Гарсия үүнийг сайн мэдэж байх ёстой. Тэр бол үндэснийхээ газрын тосны баялгаас удаан хугацаанд сайрхан хүртэж явсан тус бүс нутгийн бага гарын дээдсийн нэг билээ. Венесуэлд ОПЕК-ийн гишүүн бусад улсын адилаар газрын тостой бүхэн түүгээрээ сайрхан гайхуулдаг байна.

“Зарим хүн Бямба гаригийн оройн үдэшлэгт зориулан гутал авахаар Баасан гаригт Майами руу нисэх нь юу ч биш гэж боддог” хэмээн Маракайбогийн тэргүүлэх өдөр тутмын сонин Панорамагийн нийгмийн асуудлын буланг эрхлэн гаргагч Норка Марруфо хэлж билээ.

Энэ бол Валерогийн хувьд шал өөр ертөнц. Өрөмдөгч цамхагаар чимсэн Маракайбо нуурын усаар байнга нааш цааш хөвөх завин дээр ажилладаг байсан 25 настай Валеро энэ ажилдаа, авдаг цалиндаа дуртай байлаа. Газрын тосны улсын монополь үйлдвэр Петролеос де Венесуэла компаниас түүнд сар бүр 560 орчим ам. доллар өгөхийн зэрэгцээ эрүүл мэндийн үйлчилгээ, бусад өгөөмөр нэмэгдэл хангамжаар хангадаг байжээ.

Гуравдагч ертөнцийн стандартаар авч үзвэл муугүй хөлс шүү. Гэвч тэрээр ноднин ихэнхдээ, мөн сүүлийн хэдэн жилийн нэлээд хугацаанд ажилгүй байсан байна.

“Харамсалтай нь, энэхүү бизнесийн нэг өсч, нэг буурч байдаг

онцлогоос болж бүхий л болж бүтэхгүй зүйл хэтэрхий түгээмэл гарах болсон” гэж газрын тосны холбооны ажилтан Пастор Лопез хэлж байна. Мөн, орон нутгийн олон оршин суугчдын орлогын ихэнх хэсэг нь морин уралдааны бооцоо, даалууны мөрийд үрэгддэг гэж тэр тэмдэглэлээ.

Шинжээчид газрын тосны мөнгөний урсгалтай холбож үздэг Венесуэлийн өөр нэг сэжигтэй онцлог бол тус улс нэг хүнд ноогдох шотланд вискиний хэрэглээгээрээ дэлхийд тавдугаарт ордог байна.

Хэрвээ ОПЕК газрын тосны үнийг буулгахын тулд үйлдвэрлэлээ нэмэгдүүлсэн бол Валеро болон түүний нөхөд илүү их ажилтай болж болох байсан боловч тэд үнийг харьцангуй өндөрт барихыг оролдож байгаа Ерөнхийлөгч Хюго Чавезийг хүчтэй дэмжихэд дуу хоолойгоо нэгтгэж байна. Чавез Венесуэл дэх авилгалтай тэмцэхийг амласан учраас ерөнхийлөгчид урам зориг дүүрэн сонгогдсон билээ.

Инфляцийн асуудал хөндөгдөх үед ОПЕК дэлхийн газрын тосны үнийг өнөөгийнхөөс хоёр дахин их болгож амжилт олсон 1970-аад он, 1980-аад оны эхэн үеийн оргил үеийг олон Венесуэлчүүд дурсах дуртай байдаг.

Тэдний дор хаяж гуравны хоёр хувь нь ядуурлын байдалд амьдарч байгаа хэдий ч саяхан болсон үндэсний хэмжээний санал асуулгаар тус улс дэлхийн хамгийн баян орны нэг гэдэгт хүн амынх нь 80 хувь итгэж байна.

Иймээс засгийн газар шинээр

баялаг бий болгохоосоо илүү одоо байгаа баялгаа дахин хуваарилах нь түүний гол үүрэг гэж сая сая хүмүүс үзэх болжээ. Венесуэлд өндөр технологийн үйлдвэрлэлийн салбар бараг хөгжөөгүй бөгөөд газрын тосыг эс тооцвол дотоодын өргөн хэрэглээний бараануудаас өөр зүйл үйлдвэрлэх нь бага ажээ.

Өнөөдөр ОПЕК-ийн гишүүн орнуудын мөнгөний авдарт асар их мөнгө шуугин эргэлдэж байна: Тэд түрүү жил 160 тэрбум ам.доллар олноо энэ жил нэмэгдүүлж 200 тэрбум гаруй ам.доллар олох төлөвтэй байгаа бөгөөд газрын тосны ашиг Венесуэл улсын 26.7 тэрбум ам.долларын төсвийн тал орчим хувийг эзэлж байна.

Ерөнхийлөгч Чавезийг ноднин жил тангараг өргөх үед нэг баррель газрын тосыг 13 ам.доллараар борлуулж байсан бол удалгүй 8 ам.доллар

болж унасан юм. Түүний авч хэрэгжүүлсэн анхны арга хэмжээний нэг нь төсвийн зарлагыг танах явдал байлаа. Одоогоор энэхүү бусдыг татах чадвартай армийн хуучин хурандаагийн засгийн газар түрүү жилийн газрын тосны орлогоос 10 тэрбум доллараар илүү орлого олоод байна.

Сан Франциско Хрониклийн зөвшөөрлөөр хэвлэв.

Редакторын тэмдэглэл: Энэхүү нийтлэлд нийгэмд тулгамдсан асуудлыг нэгтгэн дүгнэхэд жирийн нэг иргэнийг ашиглах үр нөлөөтэй аргыг хэрэглэсэн байна. Ядуу дорой оршин суугчид нь олсон олз ашгаас хүртдэггүй нөөц баялаг ихтэй ихэнх оронд үүнтэй ижил аргыг хэрэглэж болох юм. Сэтгүүлч энд бичигдсэн мэдээллүүдийг баттай эх сурвалжаас авсан статистик тоо баримтаар бататгажээ.

Баялгийн хуваарилалт муугаас болж зөвж шааналж байгаа нөөц баялаг ихтэй ихэнх орнуудын адил Венесуэл дахь баян, ядуу иргэдийн амьдралын хэв маягийг энэхүү нийтлэлд сайн жишигж гаргасан байна. Харин уг нийтлэлд засгийн газрын албан тушаалтнуудын хэлсэн үгийг иш татсан бол зүгээр байлаа.

3. Газрын тосны цагаан толгой

Жонн Робертс

Газрын тос бол арвин баялаг нөөц, гэхдээ өндөр үнэ өртгөөр олддог. Геологийн янз бүрийн үе давхаргаас газрын тос гардаг боловч дэлхий дээрх газрын тосоор хамгийн баян бүс нутгуудын нэлээд нь газар зүйн эсвэл улс төрийн талаасаа хамгийн эрсдэлтэй газрууд байдаг. Газрын тосны түүхэнд гүйцэтгэх үүрэг олон арван жилийн турш өөрчлөгдөж ирсэн боловч газрын тосны тухай мэдээ сонины эхний нүүрнээс хэзээ ч холдож байсангүй. 1990 онд Ирак улс Кувейтэд халдан довтолсноор 1991 оны Персийн булангийн дайныг өдүүлсэн бөгөөд “газрын тосны дайн”-ы тухай ширүүн маргаан өрнүүлсэн юм. 2003 оны Иракийн дайн, цаашлаад энэ дайнд АНУ-ын үргэлжилсээр байгаа цэргийн оролцоо ч газрын тостой холбоотой байсан гэж зарим хүмүүс маргах биз. АНУ болон өндөр хөгжилтэй бусад томоохон орны газрын тосны импортоос хамааралтай байдал нь энэ бараа үндэсний аюулгүй байдлын асуудал төдийгүй олон улсын харилцаанд голлох үүрэг гүйцэтгэж байгааг харуулж байна.

Газрын тос мянга мянган жилийн турш бурханы ариун галыг асаахад болон түүнээс дутуугүй хугацаагаар анагаах ухаанд ашиглагдаж байна. Өнөөдөр түүний гол хэрэглээ бол онгоц, автомашины түлш болж байгаа явдал юм. Аж үйлдвэржсэн орнуудад тээврийн хэрэгслийн 97-гоос доошгүй хувь нь газрын тосоор ажиллаж

байгаа бөгөөд түүнийг орлуулах хямд төсөр хувилбар хараахан байхгүй байна. Түүнчлэн, дэлхийн зарим хэсэгт дулаанаар хангахад газрын тос чухал үүрэгтэй байхын зэрэгцээ петрохимийн салбарт хуванцар хийхэд болон түүхий хэлбэрийг нь замын хучилтад мөн өргөнөөр ашиглаж байна.

21 дүгээр зууны гол санаа зовоосон асуудлын дотор газрын тосны үйлдвэрлэл оргил үедээ орж байгаа эсэх тухай асуулт орж байна. Өөрөөр хэлбэл, газрын тосны нөөц шавхагдаж байна уу? Товчоор хэлбэл, түүнийг үйлдвэрлэгч орнууд түүний хэрэглэгч орнуудын байнгын хэрэгцээг хангаж чадах уу? Магадгүй, дунд ба урт хугацааны хамгийн чухал асуудал бол газрын тосны дэлхийн цаг уурын дулааралд үзүүлж буй нөлөө байж болно.

Газрын тосны геологи, газрын тосыг хэрхэн хэмждэг тухай болон дэлхий нийтийн эрчим хүчний хэрэглээний хэв шинжийг тайлбарласнаар энэ бүлэг эхэлнэ. Улмаар энэ нь дараахь гурван амин чухал асуулт руу хандана: Нэгдүгээрт, дэлхийн газрын тосны нөөц шавхагдаж байна уу? Хоёрдугаарт, газрын тосноос хараат байхын аюулгүй байдлын утга агуулга юу вэ? Эцэст нь, шатдаг түлшид хэт найдахын байгаль орчны үр дагавар юу вэ?

Түүхий нефть гэж юу вэ?

Түүхий нефть буюу газрын тос (харилцан орлуулж хэрэглэх хандлагатай нэр томъёонууд) бол техник талаасаа пентани ба хүнд нүүрс ус төрөгчийн хольц бөгөөд үндсэндээ түүхий нефтийн орд газраас илэрдэг. Пентани, хүнд нүүрс ус төрөгч хоёр байгалийн хийн орд газраас илрэх үед өтгөрүүлсэн хий буюу конденсац гэж нэрлэдэг. Практик дээр өтгөрүүлсэн хийг нефть гэж үздэг. Түүнчлэн, газрын тосны орд газраас пропан, бутан гэх мэт арай хөнгөн жинтэй шингэн нүүрс ус төрөгч гарч болох ба үүнийг шингэрүүлсэн шатдаг хий (ШШХ) гэж ангилдаг.

Олон талаар түүхий нефть, өтгөрүүлсэн, ШШХ-г нэг гэр бүлийн ойролцоо гишүүд гэж үзэж болно. Гэхдээ албан байгууллагууд газрын тосны үйлдвэрлэл буюу нөөцийн талаар ярихдаа ШШХ ба өтгөрүүлсэн хийг тооцоондоо оруулж ч болно, оруулахгүй ч байж болно гэдгийг анхаарах нь зүйтэй. Газрын тос экспортлогч орнуудын байгууллага (ОПЕК)-ын хувьд ШШХ ба өтгөрүүлсэн хийг гишүүн орнуудынхаа үйлдвэрлэлийн квотод оруулдаггүй боловч эдгээр нь ОПЕК-ийн зарим гишүүн орны нийт нүүрс ус төрөгчийн үйлдвэрлэлд нилээд хувийг эзэлж байж болох юм.

Түүхий нефтийн агууламж талбай бүрт харилцан адилгүй байдаг. Түүхий

нефтийн нягтыг ихэвчлэн Америкийн Нефтийн Институтээс (API/АПИ) боловсруулсан хэмжээсийн дагуу градус буюу хэмээр хэмждэг. Дэлхийн Эрчим Хүчний Бага Хурлаас 22° АПИ-с доош хэмийн түүхий нефтийг хүнд, 22-31° АПИ-тай бол дунд зэргийн, 31° АПИ-с дээш бол хөнгөн түүхий нефть гэж ангилдаг. Зарим өтгөрүүлсэн хий 60° хүртэл үзүүлэлттэй байдаг.

Хөнгөн, дунд зэргийн болон хүнд түүхий нефтийг “ердийн түүхий нефть” гэж үздэг. Зарим зэрэглэлийн түүхий нефтийг нефть боловсруулагчдын хүссэн ерөнхий чанарын үзүүлэлтэд яг тохируулан хольж болохын зэрэгцээ нефть дамжуулах хоолойг бөглөрүүлэхгүйн тулд өтгөрүүлсэн буюу шингэрүүлсэн шатдаг хийг хүнд түүхий нефтьтэй холих явдал олонтаа байдаг.

Хөнгөн зэрэглэлийн нефтийг ихэвчлэн хүнд зэрэглэлүүдэд нэмэлт болгон борлуулдаг бөгөөд энэ нь голдуу бензин, тийрэлтэт хөдөлгүүрийн түлш гэх мэт үнэ цэнэтэй боловсруулсан бүтээгдэхүүн гарах гарц өндөр байдагтай нь холбоотой. Хойд мөсөн далайн Брент ба Экофиск зэрэглэлийн түүхий нефть, Бонни Лайт гэх мэт Нигерийн түүхий нефть болон Африкийн бусад зэрэглэлийн нефтүүд нь хөнгөн түүхий нефтид ордог бол Ойрхи Дорнодын газрын тосны ихэнх нь хүнд зэрэглэлд ордог.

10° АПИ-с доош хэмийн газрын тосыг битум гэж нэрлэх нь түгээмэл бөгөөд тусгай арга ажиллагаа шаарддаг. Битумыг элс, элсэрхэг чулуу, буюу бусад тунадсан чулуулгаас олборлодог бол ердийн түүхий нефтийг өрөмдөж гаргадаг. Олон тооны ердийн бус түүхий нефтийн нэг болох битумийг одоогоор Канад, Венесуэл дэх элсэн барагшингаас үйлдвэрлэн гаргаж байна.

Битумд байгаа нефтийн агууламжийг элс, ус, бусад ашигт малтмалаас салгахын тулд янз бүрийн угаалга, ажиллагаа хийдэг бөгөөд дараа нь өтгөрүүлсэн хийгээр шингэлдэг. Эдгээр үйл явцыг дамжсаны үр дүнд үүсэх битумыг “синтетик түүхий эд” гэх бөгөөд заримдаа “синтетик круид” гэдгийг нь товчилж “синкруид” гэж нэрлэдэг боловч яг хэл шинжлэл талаас нь авч үзвэл синтетик буюу нийлэг эд огт биш юм.

Газрын тосыг хэмжих нь

Газрын тосыг хэмждэг тогтсон нэгж бол баррель эсвэл метр тонн байдаг. Харин газрын тосны үйлдвэрлэлийн хамгийн түгээмэл хэмжүүрийн нэгж нь нэг өдөрт ноогдох баррель (б/ө) эсвэл нэг жилд ноогдох метр тонн (мт/ж) байдаг. Баррель бол эзэлхүүнийг хэмжих нэгж, тонн бол жинг хэмжих нэгж учраас энэ хоёрын хооронд ямар нэг нарийн хамаарал байхгүй бөгөөд өөр өөр чанарын түүхий нефтийн жин

харилцан адилгүй байдаг билээ. Гэхдээ энд баримталдаг эрхий хурууны дүрэм бол нэг тоннд 7.33 баррель нефть багтана, 1 б/ө нь 49.8 мт/ж-тэй тэнцэнэ гэсэн дүрэм байдаг. Насост буй бензинийг ихэнх тохиолдолд литрээр хэмждэг бол АНУ-д галлоноор хэмждэг (нэг галлон нь 3.75 литртэй, 42 галлон нь нэг баррельтай тэнцэнэ), мөн зарим оронд Британийн Вант улсын галлонаар хэмжиж байж болно (нэг галлон нь 4.5 литртэй, 35 галлон нь нэг баррельтэй тэнцдэг).

Мөн нэг тонн нефтьтэй тэнцэх (тнт) гэсэн хэллэгийг хийн, нүүрсний, цөмийн, усан гэх мэт бусад төрлийн эрчим хүчний үндсэн хэлбэрүүдийн (дор бүрнээ өөрийн салбарын хэмжилтийн системтэй байдаг) үйлдвэрлэл, ашиглалтыг илэрхийлэхэд ашигладаг бөгөөд улмаар газрын тостой болон өөр хооронд нь шууд харьцуулах боломжтой болдог.

Дэлхийн эрчим хүчний бүтцэд газрын тосны эзлэх байр

Ер нь, газрын тос бол дэлхийн хамгийн чухал бараа түүхий эд юм. Энэ бол дэлхий дээр хамгийн өргөн хэрэглэгддэг түлш бөгөөд бидний ихэнх нь автомашин жолооддог эсвэл нефтээр ажилладаг нийтийн тээврийн хэрэгсэлд найддаг учраас түүнийг бага ашиглагддаг гэж хэлж болохгүй. Гэхдээ нефть шатахуун нь дэлхий дээрх арилжааны зориулалттай түлшний үйлдвэрлэлийн хамгийн их хувийг (2003 онд 3.637 триллион мт нефть үйлдвэрлэсэн нь дэлхийн нийт үйлдвэрлэл 9.741 триллион тнт түлшний 37.3 хувь) эзэлж байхад, дэлхий дээр хоол хийх, халаалт гэх мэт энгийн зорилгоор хамгийн энгийн түлшний хэлбэрүүд болох мод, шатдаг хог хаягдал зэргийг хэрэглэн амьдардаг 2 тэрбум орчим хүн байгааг энд дурдах нь зүйтэй¹.

Дэлхийн эрчим хүчний бүтэц дэх газрын тосны эзлэх байр суурийг авч үзэхийн тулд гол түлшний төрлүүдийн хэрэглээний хэмжээ болон тодорхой төрлийн түлш, эрчим хүч дагнан үйлдвэрлэдэг янз бүрийн зах зээлүүдийг авч үзэх хэрэгтэй. 2003 оны дэлхийн эрчим хүчний тэнцлийг арилжаанд борлогдож буй түлшний хэрэглээ талаас нь Хүснэгт 1-д үзүүлээ.

Гэвч энэ тэнцэлд зах зээлийн хувьд нилээд ялгаатай байдал агуулагдаж буй бөгөөд дор хаяж нэг хүнд ноогдох эрчим хүчний хэрэглээ талаасаа ялгаатай байна. Тухайлбал, АНУ-ын нэг хүнд ноогдох эрчим хүчний хэрэглээ түүнтэй амьжиргааны түвшин ерөнхийдөө адилхан Европынхтай харьцуулахад хоёр дахин их байдаг (Хүснэгт 2-ыг үзнэ үү).

ХҮСНЭГТ 1

2003 оны дэлхийн эрчим хүчний тэнцэл

(сэн тонн нефтьтэй тэнгэх буюу СТНТ хэмжээгээр)

	СТНТ	%
Газрын тос	3636.6	37.33
Байгалийн хий	2331.9	23.94
Нүүрс	2578.4	26.47
Цөмийн энерги	598.8	6.15
Усан	595.4	6.11
Нийт	9741.1	100

Эх сурвалж: Дэлхийн эрчим хүчний тухай БиПи-н статистик тойм, 2004 оны 6 дугаар сар.
www.bp.com/statistics нүүр хуудас дээр багтаа.

Олон Улсын Эрчим Хүчний Агентлаг (IEA) 2003 оны дэлхийн эрчим хүчний чиг хандлагын үнэлгээндээ 2000-2030 онд дэлхийн эрчим хүчний зах зээл дээр цөмийн бус, усан бус сэргээгдэх эрчим хүчний (өөрөөр хэлбэл, нар, салхины эрчим хүч магадгүй долгионы эрчим хүч) салбар хамгийн хурдан өсөлттэй байх бөгөөд зах зээлд эзлэх хувь нь бараг хоёр дахин, үйлдвэрлэлийн үнэмлэхүй хэмжээгээрээ гурав дахин өсөх болно гэжээ. Гэвч сэргээгдэх эрчим хүчний өсөлт нь зах зээлд эзлэх хувийн дөнгөж 2 хувийн өсөлтийг илэрхийлэх (2-оос 4 хувь болж) бөгөөд шатдаг түлшний зах зээлд эзлэх хувь мөн 2 хувиар нэмэгдэх (87-оос 89 хувь болж) төлөвтэй ажээ. Мөн газрын тосны эзлэх байр суурь алдагдаж, түүний оронд өөр шатдаг түлш буюу байгалийн хий ашиглагдах юм.

Харьцуулсан байдлаар авч үзэхэд, сэргээгдэх эрчим хүчний шинэ салбарууд нь цөмийн эрчим хүчний үйлдвэрлэлийн зогсонги байдлыг нөхөх төдий байна. 2030 онд цөмийн энергийн үйлдвэрлэл 2000 оны түвшинд хэвээр байх боловч ирэх 30 жилд нийт эрчим хүчний салбарын үйлдвэрлэл 66 орчим хувиар өснө гэж үзвэл зах зээлд эзлэх хувиа алдана гэсэн үг.

Харин газрын тосны салбар нийт зах зээлд эзлэх хувиа бага зэрэг алдах төлөвтэйгээс гадна үйлдвэрлэл нь 30 жилийн турш 60 орчим хувиар өсөх төлөвтэй байгаа учраас дэлхийн зарим газар газрын тос ашиглалтын тэсрэлттэй өсөлт гарна гэж үзэж байна. Жишээлбэл, Хятад улсын нефть ашиглалт 2000 онд 5 сая б/ө (жилд 250 метр тонн) байсан бол 2030 онд 12 сая б/ө (600 мт/ж) болж огцом өсөх төлөвтэй байна. 2004 онд түүхий нефтийн үнэ хамгийн их өсч рекорд тогтооход Хятадын өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээ нөлөөлсөн.

ХҮСНЭГТ 2

2003 оны дэлхийн эрчим хүчний тэнцэл, нэг хүнд ноогдох хэрэглээ ба бүс нутгаар

(Нийт дүнг сая тонн нефтьтэй тэнцэх хэмжээгээр-СТНТ; нэг хүнд ноогдох хэрэглээг нэг тонн нефтьтэй тэнцэх хэмжээгээр)

	Нефть	Б.хий	Нүүрс	Цөмийн	Усан	Нийт	Хүн ам	ТНТ/хүн
Хойд Америк	1093.2	686.3	612.7	201.1	133.9	2,727.3		
АНУ	914.3	566.8	573.9	181.9	60.9	2,297.8	291.0	7.896
Төв & Өмнөд Америк	216.6	98.6	17.7	4.7	127.8	465.5		
Бразил	84.1	14.3	11.0	3.0	68.9	181.4	176.3	1.029
Европ (ТУХН ороод)	942.3	975.7	535.9	285.3	174.3	2,913.4		
ЕХ-15	639.7	363.5	222.7	204.0	68.3	1,498.1	379.0	3.953
Франц	94.12	39.4	12.4	99.8	14.8	260.6	59.9	4.351
Герман	125.1	77.0	87.1	37.3	5.7	332.3	82.4	4.033
Орос	124.7	365.2	111.3	34.0	35.8	679.8	144.1	4.718
Турк	31.9	18.9	15.5	-	8.0	74.3	70.3	1.057
Их Британи	76.9	85.7	39.1	20.1	1.3	223.2	59.1	3.777
Ойрхи Дорнод	214.9	200.4	8.6	-	3.0	426.8		
Иран	54.0	72.4	0.7	-	2.0	129.1	68.1	1.896
Саудын Араб	67.0	54.9	-	-	-	121.9	23.5	5.187
Африк			118.6	60.7	90.6	2.9	18.5	291.0
Египет	25.0	22.1	0.7	-	3.2	52.0	70.51	0.737
Өмнөд Африк	24.2	-	88.9	3.0	0.8	116.0	44.76	2.592
Ази, номхон далай		1,048.1	310.9	1,306.2	104.7	137.5	2,908.4	
Бангладеш	4.2	11.0	0.4	-	0.2	15.9	143.8	0.111
Япон	248.7	68.9	112.9	52.2	22.8	504.3	127.5	3.956
Хятад*	275.2	29.5	799.7	9.9	64.0	1,178.3	1,294.9	0.910
Энэтхэг	113.3	27.1	185.3	4.1	15.6	345.3	1,049.6	0.329
Пакистан	17.0	19.0	2.7	0.4	5.6	44.8	149.9	0.299
Өмнөд Солонгос	105.7	24.2	51.1	29.3	1.6	212.0	47.4	4.473
Дэлхий	3,626.6	2,331.9	2,578.4	598.8	595.4	9,741.1	6,400**	1.522

* Хонг Конгийг тооцоогүй

**Зохиогчийн тооцоогоор

Эх сурвалж: Дэлхийн эрчим хүчний тухай бийтэн статистик тайм, 2004 оны 6 дугаар сар
хүн амын тоол (2000), Олон улсын санхүүгийн статистик, 2003 оны 12 дугаар сар
ЭХ-ийн үзүүлэлтээр (2000 оны 1 дүгээр сар)

ХҮСНЭГТ 3

Дэлхийн үндсэн эрчим хүчний эрэлт 1971–2030 (СТНТ)

	1971	2000	2010	2030	Жилийн дундаж өсөлт 2000-2030 (%)
Газрын тос	2,450	3,604	4,272	5,769	1.6
Хий	895	2,085	2,794	4,203	2.4
Нүүрс	1,449	2,355	2,702	3,606	1.4
Цөмийн	29	674	753	703	0.1
Усан	104	228	274	366	1.6
Бусад сэргээгдэх	73	233	336	618	3.3
Нийт	4,999	9,179	11,132	15,267	1.7

Эх сурвалж: Дэлхийн эрчим хүчний тойм 2007, Олон Улсын Эрчим Хүчний Агентлаг, Парис, 2007 оны 10 дугаар сар

Газрын тосны нөөц шавхагдаж байна уу?

Нөөц: дэлхий хэр их газрын тостой вэ?

Олон улсын эрчим хүчний талаарх халуун мэтгэлцээний хамгийн маргаантай сэдвийн нэг бол дэлхийн газрын тосны нөөцийн хэмжээ юм. Дэлхий 1 триллион баррель орчим газрын тосны нөөцтэй гэж голдуу ярьдаг. Байнгын өдөр тутмын хэрэглээний үүднээс авч үзвэл энэ бол мэдэгдэхүйц тоо боловч энэ бол уг нарийн төвөгтэй үйл явдлын дөнгөж эхлэл юм. Газрын тосны нөөцийн тухай тоо баримтын хувьд сайнд тооцогддог нэг эх сурвалж бол жил бүр шинэчлэгдэн гардаг Дэлхийн эрчим хүчний тухай БиПи-гийн статистик тойм юм. “Тогтоогдсон нөөц”-ийн (мөн тус салбарт “батлагдсан нөөц” гэж нэрлэдэг) хэмжээний тухай БиПи-гийн тоо баримтад жил бүр засвар орж байдаг. Ялангуяа, аль нэг улсын нөөцийн хувьд сүүлд шинээр олж нээсэн орд газрууд, олборлолт хэдийн хийж эхэлсэн талбайнуудын талаарх шинэчилсэн мэдээлэл, тогтоосон талбайгаас гаргаж авсан газрын тосны хэмжээ зэргийг харгалзан үзсэний үндсэн дээр засгийн газруудын гаргасан албан ёсны шаардлагыг тусгадаг.

Ер нь, тогтоогдсон нөөцөд юу орохыг бодитойгоор тогтооход анхаарал бага тавьж иржээ. БиПи компани үүнийг зүгээр л “ерөнхийдөө, одоо байгаа эдийн засаг, үйлдвэрлэлийн нөхцөл байдалд тодорхой орд газруудаас ирээдүйд гарган авах бодитой үндэслэлтэй хэмээн геологийн болон инженерийн мэдээлэлд заасан тоо хэмжээг авдаг” хэмээн тодорхойлж байна. Мэдээж хэрэг, технологи өөрчлөгдөхөд энэ тодорхойлолт ч бас өөрчлөгдөх болно.

Чулуун зэвсгийн үеийн хүмүүсийн хувьд зөвхөн газрын гадарга дээр нэвчин гарч ирсэн газрын тосыг олж авах, ашиглахаас үл хэтрэх төдий үйлдвэрлэл явуулж байсан учраас нөөцийн тухай мэдэхгүй, мэдэх боломжгүй байлаа. Технологи сайжирснаар хүмүүс хүрэээр нүх ухаж, газрын тосыг хувингаар хутган гаргаж ирж байсан бол хожим нь 10-20 фут өрөмдөж чаддаг болсон байна. Харин одоо бол өмнө нь хүн хүрэхийн аргагүй байсан газруудад, тухайлбал далайн гадаргаас хоёр мянган метрийн гүнд байгаа далайн ёроолоос цааш дахин хоёр мянган метрийн гүнээс байж болзошгүй газрын тосыг хүртэл хайгуулчид эрж олж чаддаг болжээ. Мөн технологи нь бидний олборлон гаргаж чадах газрын тосны төрлүүдийг ч сайжруулж байна.

Нөөцийг тооцоолох бэрхшээлийн нэг сайн жишээг Канад улс харуулдаг. Канадын Үндэсний Эрчим Хүчний Зөвлөлөөс (ҮЭХЗ) Атабаскагийн элсэн барагшинд 174.7 тэрбум баррель орчмын “тогтоогдсон нөөц” агуулагдаж байна хэмээн тооцоолжээ. Энэхүү тогтоогдсон нөөц гэдэг тодорхойлолтод тус орны нийт батлагдсан нөөц ба байж болзошгүй нөөцийн хагасыг оруулахаар тооцжээ. Харин энд “болзошгүй нөөц” гэдгээ “байж болох үндэслэлтэй нөөц хэмээн тодорхойлдог батлагдсан нөөцтэй ойролцоо нөөц” гэж тодорхойлсон байна. Энэ мэдэгдлийг хийх үедээ Канад улс өөрийн нөөцийг зөвхөн Саудын Арабын дараа хоёрдугаарт орох хэмжээтэй хэмээн албан ёсоор зарлаж байлаа. Харин энэ байр суурь нь БиПигийн 2003 оны статистикийн тоймд бичигдсэн Канад улсын бүх төрлийн нефтийн тогтоогдсон нөөцийн хэмжээ 6.9 тэрбум баррель гэсэн тоо эсвэл ҮЭХЗ-ийн өөрийнх нь тооцоогоор тус орны ердийн түүхий нефтийн батлагдсан нөөц 4.3 тэрбум баррель гэсний аль алинтай нь нийцэхгүй байна.

Хамгийн гол нь уг асуудал дээрх энгийн тодорхойлолтуудын нэгд болон өртөг зардалд оршиж байна. Газрын тос хаа нэгтээ байгаа л бол түүнийг гаргаж авахын тулд бид хэр их үнэ төлөхөд бэлэн байна вэ гэсэн асуулт ямагт тавигдана. 2004 онд нефтийн үнэ нэг баррель нь 50 ам.доллар байсан шиг байх юм бол газрын хөрснөөс улам их газрын тос олборлож, үйлдвэрлэх эдийн засгийн үндэслэлтэй юм.

Хувийн компаниуд холбогдох банк эсвэл зохицуулах эрх бүхий байгууллагад илгээх үйл ажиллагааны тайландаа нөөцийнхөө хэмжээг оруулж тайлагнах тохиолдолд асуудал улам ярвигтай болдог. Эдгээр нь ерөнхийдөө тухайн нөөцийн бодит боловсруулалтад зориулсан тогтсон тодорхой хөтөлбөрүүдтэй байхыг шаарддаг. Иймээс нөөцийн асуудлыг авч үзэхдээ хэдийгээр геологи, уул уурхайнхан газрын тос байгааг мэдэж байж болох боловч түүнийг нь албан ёсоор батлагдсан буюу тогтоогдсон нөөц гэж үзэж болохгүй байх олон тооны шалтгаан байдаг гэдгийг энд тэмдэглэх нь чухал.

ХҮСНЭГТ 4

Дэлхийн газрын тосны эрэлтийн өсөлт 2000–2030 (сая б/ө)

	Өсөлт, сая б/ө-өөр	Жилийн өсөлтийн %
Хойд Америкийн ЭЗХАХБ	9.5	1.1
Хятад	7	3.0
Зүүн Ази	5	2.75
Латин Америк	4.5	2.4
Өмнөд Ази	4.5	3.5
Ойрхи Дорнод	3.8	2.2
Африк	3.5	3.25
Шилжилтийн орнууд	2.5	1.5
Европын ЭЗХАХБ	2.5	1.0
Номхон далайн ЭЗХАХБ	2.0	0.8

Эх сурвалж: Дэлхийн эрчим хүчний тойм 2002, Олон Улсын Эрчим Хүчний Агентлаг, Парис, 2002 оны 10 дугаар сар

2004 онд дэлхийн хамгийн том, хамгийн олон жилийн туршлагатай газрын тосны аварга компани Роял Датч/Шелл батлагдсан нөөцөө хэтрүүлэн мэдэгдсэнээ хүлээн зөвшөөрсний дараа нөөцийн хэмжээг зарлахтай холбоотой асуудал сонины тэргүүн нүүрний мэдээгээр тавигдаж байлаа. 2004 оны 5 дугаар сарын сүүл гэхэд компанийхаа хувьцаа эзэмшигчид, санхүүгийн зах зээлүүдийг сандралд оруулж, гурван дээд удирдлага нь огцорсон дуулиант явдлын дүнд тус компани батлагдсан газрын тос, байгалийн хийн нөөцийнхөө хэмжээг таван сарын дотор дөрвөн удаа багасгасан юм. 2005 оны эхээр Шелл компани мөн л нөөцийнхөө хэмжээг 10 хувь бууруулснаа зарласан юм.

Өртөг зардал ба үнэ

Өртөг зардалын тухай асуулт бол байнга яригддаг сэдэв. Газрын тосны компаниуд өртөг зардалын нарийн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд газрын тосны хайгуул, олборлож боловсруулах, зах зээлд хүргэх бүхий л зардалын хувьд нэг баррель тутамд 10-15 орчим ам.доллараас илүүг зарцуулахыг хүсдэггүй. Түүгээр ч зогсохгүй, нэг баррель тутамд 12\$ байхыг боломжийн зардал гэж үзэж байгаа ч гэсэн энэ нь газрын тосны бусад үнэтэй харьцуулахад маш бага юм.

Түүхий нефтийн зах зээлийн үнэ нь эрэлт, нийлүүлэлтийн харьцаанаас эхлээд, геополитикийн хурцадмал байдал, мөн ямар байр суурь баримталснаас нь болж үнийн өөрчлөлт гарч болох ОПЕК-ийн болон хөрөнгийн зах зээл дэх фьючерс арилжаалагчдын үйл ажиллагаа зэрэг олон хүчин зүйлсээс онцгой хамаардаг бөгөөд сүүлийн хоёр жилд дунджаар нэг баррель нь 30 ам.доллар орчимд эргэлдэж, хамгийн өндөр нь 50\$/баррель хүрч байлаа.

Мөн боловсруулсан бүтээгдэхүүний үнэд татварын хувь агуулагдах бөгөөд хэрэглэгчдэд тусах зардал нь түүхий нефтийнхээс нилээд өндөр байдаг. Зарим бүтээгдэхүүн, тухайлбал нисэх онгоцны түлшинд татвар ноогдуулдаггүй боловч ихэнх хөдөлгүүрийн шатахуунд татвар ноогдуулдаг нь голдуу маш өндөр хувьтай байдаг. Баруун Европт маш их татвар ноогдуулдаг бөгөөд шахуурганд буй бензиний үнэ нэг баррель нь 180\$ орчим байдаг. 2003 оны 3 дугаар сарын сүүлээр Их Британид шатахууны шахуургад байгаа нефтийн үнэ нэг литр нь 76-82 пенсийн хооронд байсан бөгөөд 82 пенс гэж үзвэл нэг америк галлон тутамд 4.65 ам доллар буюу нэг баррель нь 195\$ байна гэсэн үг.

Дэлхий дахинд янз бүрийн хэлбэрээр борлуулагдаж буй нэг баррель нефтийн бүх үнийн дунджийг тооцож үзсэн гэсэн ч уг үнэ нээлттэй зах зээл дээрх түүхий нефтийн өдөр тутмын үнээс дор хаяж хоёр дахин их гарна гэж хэлж болох үндэслэлтэй. Харин газрын тос үйлдвэрлэлтэд гарах бодит биет зардал хэрэглэгчдийн төлж байгаа дундаж үнийн 15-хан хувь хүрэх төдий байх бөгөөд түүнээс ч бага байх нь олонтаа. Энэ нь, хэт туйлшруулан бодвол, газрын тосны баялгийн бүр нарийн түвэгтэй хэлбэрүүдийг гаргаж авъя гэсэн ч зардлын өсөлтийг шингээх ихээхэн зай үлдэж байна гэсэн үг.

Энэ бүх асуудал нь яагаад АНУ-ын Геологийн Судалгааны газар (АНУГСГ)-аас, илрүүлж болох нөөц бололцоо буюу бидний газрын хөрснөөс гарган авна гэж үзэх боломжтой газрын тосны хэмжээ нь ирэх 30 жилд зориулан БиПи компаний одоогоор тооцож гаргаад байгаа дэлхийн батлагдсан нөөцийн нийт хэмжээнээс хоёр дахин их байж болзошгүй гэсэн таамаглал дэвшүүлээд байгааг тайлбарлахад тусална.

Нөөц ба нөөц бололцоо

Нөөц бололцоо гэдэг бол нөөцөөс арай өөр зүйл юм. Нөөц бололцоог тодорхойлохдоо “нөөц дээр яваандаа бий болж болох эрчим хүчний бүхий л эх үүсвэрийн [нефть, байгалийн хий, нүүрс гэх мэт] нийлбэр дүнг нэмсэнтэй тэнцэнэ” гэжээ. Эрчим хүчний аюулгүй байдлын талаар санаа зовж буй улс төрч юмуу дэлхийн газрын тосны нөөц дуусч байгаа эсэх талаар шаналж яваа жирийн хүний хувьд зүгээр нэг нөөцийн тооцоо хийж байснаас нөөц бололцоог задлан шинжилж суусан нь илүү ач холбогдолтой байж магадгүй.

Хамгийн энгийн нь гэвэл, АНУ-ын Геологийн судалгааны газраас 2000 онд хэвлүүлсэн дахин үнэлгээндээ “үлдэж байгаа нөөцийн дундаж” буюу бидний мэдэх яг тэр нөөцийг 859 тэрбум баррель гэж тооцсон нь БиПи-гээс гаргасан 1.047 триллион баррелийн батлагдсан нөөцийн хэмжээнээс арай бага байна. Гэхдээ АНУГСГ энэ тоондоо “нөөцийн ердийн дундаж өсөлт” нэрээр 612 тэрбум

баррелийг нэмсэн нь газрын тос олж илрүүлэх арга техник сайжирснаар одоо байгаа олборлолтын талбайн нэмэгдэх хэмжээнээс гарах өсөлт юм байна. Мөн түүнчлэн “нээгдээгүй ердийн дундаж нөөц” буюу шинээр нээгдэх орд газруудаас гарах нефтийн хэмжээ 649 тэрбум баррелийг нэмж тооцжээ.

Эдгээр гурван төрлийн нөөцийн хэмжээ нийлээд тэдгээрийн өмнө таамаглал дэвшүүлж байсан дэлхийн нөөц баялгийн хэмжээ болох 2.12 триллион баррель хүрч байгаа хэдий ч энэ тоо бас эцсийн дүн биш юм. Нэг зүйл гэвэл, АНУГСГ-ын тоонд АНУ-ыг оруулаагүй байна. 1995 онд АНУГСГ-аас АНУ-ын “техникийн хувьд илрүүлж болох нөөц бололцоо” 165 тэрбум баррель түүхий нефть байна гэж тооцжээ. Түүнчлэн, 2000 оны судалгаандаа одоо байгаа ШШХ-н нөөц 68 тэрбум баррель, нөөцийн ердийн өсөлт 42 тэрбум баррель, нээгдээгүй нөөц бололцооны 207 баррелийг нэмж оруулжээ. Энэ дөрвөн хэсэг нэмэгдэхээр нийт 482 тэрбум баррель болж байна.

Хэрвээ АНУГСГ-ын урьдчилсан таамаглал биелэх юм бол өнөөдрөөс 2030 оны хооронд дэлхийд байх нөөцийн бааз суурь одоогийн нийтлэг тооцоо болох 1 триллион баррель орчим биш, харин 2.602 триллион баррель буюу 355 тэрбум метр тонноос багагүй байх юм.

Хэрэглээний асуудал

Дэлхий энэхүү байгаа газрын тосны нөөцөө ашиглаж дуустал эсвэл илүү хямд төсөр эсвэл байгальд хор нөлөөгүй орлуулагч олж авах хүртэл хэр удах вэ гэдэг нь бид түүнийг хэр хурдан хэрэглэж байгаагаас хамаарна. БиПи-гийн Статистикийн тоймд тодорхойлсон дэлхийн батлагдсан нөөцийн тоо хэмжээ 1.048 триллион баррель нь 143 тэрбум метр тонн орчим газрын тостой тэнцэнэ. 2002 онд өдөрт 75.7 сая баррель буюу 3.52 тэрбум метр тонныг ашиглаж байсан гэж үзвэл газрын тосны одоогийн хэрэглээ нь нөөцийг үйлдвэрлэлд харьцуулсан (Н/Ү) стандарт тоогоор 40.6 жил зарцуулах болно. БиПи-гийн Статистик тоймд гаргасан үндсэн үнэлгээг ашиглавал бид өнөөгийн хэрэглээний түвшнээ хэвээр барьж байсан цагт 40 жил ашиглахад хангалттай нефтийн нөөцтэй байна.

Гэвч дэлхийн нийтийн газрын тосны хэрэглээ өсөх хандлагатай байгаа бөгөөд АНУ-ын Эрчим хүчний Департаментийн харъяа Эрчим хүчний мэдээллийн удирдах газрын нилээд бодитой таамаглалаар 2025 он гэхэд энэ хэмжээ өдөрт 117 сая баррель хүрч болзошгүй байна.

Цэвэр таамаглалын шинжтэй жишээгээр бол одоогоос 2030 он хүртэлх буюу АНУГСГ-ын тайланд заасан хугацааны жилийн дундаж хэрэглээ өдөрт 100 сая баррель буюу жилд 4.65 тэрбум метр тонн байна гэж хэлж болно.

Тэгвэл нөөцийн хэмжээ хэвээр байгаа тохиолдолд түүнийг 30 орчим жилд

хэрэглэж дуусах нь ээ. Гэвч хэрвээ АНУГСГ-ын тооцоолсон нөөц бололцоог нөөц болгон тооцвол бид 76 жил хүрэлцэхүйц хангалттай газрын тостой байх юм.

Эрчим хүчний урт хугацааны чиг хандлагын урьдчилсан тооцоо бодит байдалд сайн нийцдэггүйг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй. Ромын Клубээс гаргасан *Өсөлтийн хязгаарууд* нэртэй 1972 оны тайланд, газрын тосыг 1972 оныхтой ижил хурдаар үргэлжлүүлэн хэрэглээд, тэр хугацаанд нөөцөд ямар ч өөрчлөлт гарахгүй гэж үзвэл дэлхийн газрын тосны нөөц баялаг 2003 он гэхэд дуусна! гэж таамаглаж байжээ. Тэр ч битгий хэл уг тайлангийн хамгийн өөдрөг хувилбарт ирээдүйн жишээнд нөөцийн хэмжээ тав дахин өснө гэж үзсэнээр бол дэлхийн бүх газрын тосны нөөц 2022 гэхэд шавхагдаж дуусна хэмээн Ромын Клуб төсөөлж байжээ. Аз болоход тэр таамаглал бодит байдлаас хол зөрсөн боловч, Ромын Клубын дэвшүүлсэн санаа нь газрын тосны үргүй ашиглалтыг эхнээс нь багасгахад сайнаар нөлөөлсөн байж болно-үнэхээр ч, сүүлийн 30 жилд бид эрчим хүчний ашиглалтаа илүү их үр ашигтай болгоод байгаа билээ. Гэхдээ энэхүү хамгийн удаан үргэлжлэх хугацаа нь ерөнхийдөө бидний эрчим хүчний нөөцийн талаар, ялангуяа газрын тосны нөөцийн тухай бодлыг өөрчилсөн гэдэг нь хараахан батлагдаагүй байж болно.

Эрчим хүчний үйлдвэрлэлийн уламжлалт ойлголтод эрчим хүчний хэмжиж болохуйц нийлүүлэлт хязгаарлагдмал гэж үзэх хандлагатай байдаг. Гэвч технологи сайжирч байгаа учраас эдгээр тооцоог тодорхой нэг хугацаанд тохируулна гэдэг бол туйлын ярвигтай зүйл. АНУГСГ-ын Петр МакКабегийн дүрсэлсэн дүр төрхөөр бол бид нөөц баялгаа газар дор булсан пирамид мэт үзсэн тохиолдолд байдал сайжирч болох юм. Уг пирамидийн хэдий хэр хэмжээтэй нь газар дээр ил буюу хэмжигдэхүйц байгаа нь цаг явах тусам өөрчлөгдсөөр байна. Улмаар бид технологио сайжруулах тусам уг пирамид бүр ч ил гарч байна. Энэ нь заавал нөөц баялаг хязгааргүй гэсэн үг биш бөгөөд харин зөвхөн эдгээр нөөцийг хэмжих бидний чадварт хязгаар байна гэсэн санаа юм.

Хамгийн гол нь бидний ерөнхийдөө бодож байгаагаас хамаагүй их газрын тос дэлхий дээр байгаа. Гэхдээ энэ газрын тосноос хэр ихийг үйлдвэрлэх вэ гэдэг нь бидний хэрэглээний хэв маяг болон хараахан батлагдсан нөөц гэж үзэж болохгүй ч одоо байгаа газрын тосоо олборлон гаргахын тулд дэлхий ямар үнэ төлөхөд байна гэдгээс аль алинаас нь маш их хамаарна.

Газрын тосыг хэрхэн ашиглаж байна вэ

Газрын тосны ирээдүйд гүйцэтгэх үүрэг түүнийг хэрхэн ашиглаж байгаагаас хамаарна. Энэ талаар АНУ бусдыгаа тэргүүлж байна. Барагцаалбал, дэлхийн 6.4 тэрбум хүн ам дунджаар жилд нэг метр тоннын дөнгөж гуравны нэг гаруйхныг

(2002 онд 0.36 мтнт орчим) хэрэглэж байна. АНУ-аас бусад дэлхийн томоохон аж үйлдвэржсэн орнууд энэхүү дэлхийн дунджаас ойролцоогоор 10 дахин ихийг хэрэглэж байна. Харин АНУ дангаараа дэлхийн дунджаас 20 дахин ихийг ашиглаж байна. Энэ нь, хэдийгээр АНУ дэлхийн хамгийн том нефть үйлдвэрлэгч орон боловч бас дэлхийн хамгийн том хэрэглэгч бөгөөд өдөр тутам хэрэглэдэг газрын тосныхоо талаас илүүг гаднаас тээвэрлэж авчирдаг дэлхийд тэргүүлэгч импортлогч орон болохыг харуулж байна.

Америкийн газрын тосны асар их хэрэглээ болон түүний импортын газрын тосноос хамааралтай байдал нь хэд хэдэн чиглэлээр сөрөг үр дагавар үүсгэж байна. Энэ нь ерөнхийдөө эрчим хүчнээс, нэн ялангуяа газрын тосноос үүсч буй тэнцвэргүй хэмжээний бохирдлын хариуцлагыг АНУ хүлээхэд хүргэдэг. Улс төрийн хэллэгээр бол энэ нь АНУ-д эрчим хүчний аюулгүй байдлаа алдах айдас төрүүлж, улмаар дэлхийн газрын тосны хамгийн том экспортлогч Саудын Араб ба АНУ-ын хооронд сонин холбоо тогтоход хүргэсэн юм.

Аж үйлдвэржсэн орнуудын хэрэглэж байгаа дэлхийн нефтийн санг гурван том ангилалд хуваадаг: эрчим хүчний үйлдвэрүүдэд зориулсан түлш, боловсруулалтын дунд шатны нэрэлтээс үүссэн тээврийн хэрэгслийн шатахуун, мөн тийрэлтэт хөдөлгүүрийн түлш ба нисэх онгоцонд зориулсан керосин гэж ангилна.

Мөн аж үйлдвэр, оршин суугчид, тээвэр гэсэн гурван төрлийн томоохон хэрэглэгчид байдаг.

2000 онд Эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллага (ЭЗХАХБ)-ын янз бүрийн гишүүн орнууд, ялангуяа аж үйлдвэржсэн орнуудын эрчим хүчний нийт хэрэглээ 1.5 тэрбум метр тонн нефттэй тэнцэх хэмжээнд хүрч байв. Үүнээс газрын тос 38 орчим хувийг нь буюу 460 сая тонн нефттэй тэнцэх хэмжээг эзэлж байв. Энэ хугацаанд, ялангуяа Япон, Солонгост цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд ашиглагдах нефтийн хэмжээнд тогтвортой буурах хандлага үүсэхэд байгалийн хийн хэрэглээ нөлөөлсөн юм.

2000 онд дэлхий дээр оршин суугчдын эрчим хүчний хэрэглээний ойролцоогоор 22 хувийг нефть эзэлж байв. 1990 ба 2000 онд оршин суугчдын нефтийн хэрэглээний бодит түвшин нийтдээ 260 сая тонн нефттэй тэнцэх хэмжээнд байсан нь энэ зах зээл оргил цэгтээ хүрсэн байж болохыг харуулж байна.

Газрын тосны хамгийн их хэрэглээ бол тээвэрт байдаг. 2000 онд ЭЗХАХБ-ын гишүүн орнууд суудлын автомашин, ачааны машин, нисэх онгоц, хөлөг онгоцуудаа хөдөлгөхөд 1.22 тэрбум тонн нефттэй тэнцэх шатахуун зарцуулсан бөгөөд энэ эрэлтийн 97 орчим хувийг газрын тос хангажээ. Үлдсэн 2 хувийг хий, 1 хувийг цахилгаан хангасан байна. ЭЗХАХБ-ын нийт тээврийн эрэлтийн 56

хувийг Хойд Америкийн ЭЗХАХБ буюу АНУ, Канад, Мексик эзэлсэн бол түүний дараагаар Европын ЭЗХАХБ (30 хувь), Номхон далайн ЭЗХАХБ (13 хувь) оржээ. АНУ бусад аж үйлдвэржсэн орнуудыг бодвол хамаагүй олон тээврийн хэрэгсэл ажиллуулж, хамаагүй их газрын тос хэрэглэсэн байна. Гэхдээ ирээдүйд гарч болох нэг өөрчлөлт бол байгалийн хий Хойд Америкийн тээврийн зах зээлийн 3.3 хувьд нэвтэрсэн бол бусад газарт 0.2 хувийг эзэлж байна. Харин цахилгаан эрчим хүч Европын ЭЗХАХБ-ын зах зээлийн 1.8 хувь, Номхон далайн ЭЗХАХБ-ын 1.5 хувийг эзэлж байсан бол Хойд Америкийн ЭЗХАХБ-ын зах зээлийн дөнгөж 0.1 хувийг нийлүүлсэн байна.

Дэлхийн тээврийн хэрэгсэл газрын тосоор ажиллах байдал нилээд хэдэн жил үргэлжилж болзошгүй байна. Түлшний үр ашигтай байдлыг сайжруулах зорилгоор бензин, цахилгаан хоёр хослуулан ашигладаг эрлийз машинууд зохион бүтээхийн зэрэгцээ дотоод шаталтын хөдөлгүүрийг сольж орлуулах бодит шаардлага урган гарч байна. Зайн түлшээр ажилладаг машинууд аль хэдийн бий болсон боловч суудлын автомашинд зайн түлш нийтээр хэрэглэх явдал дор хаяж 10-15 жилийн цаадах асуудал болох талтай. Түүнчлэн, зайн түлшийг өөрийг нь хэрхэн цэнэглэх асуудал эргэлзээтэй хэвээр байна. Зайн түлшний стандарт нь устөрөгч байж болох авч хамгийн сүүлийн үеийн устөрөгчийн үйлдвэрлэл өөрөө байгалийн хийн өргөн хэрэглээг шаарддаг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй. Хэдийгээр АНУ болон бусад аж үйлдвэржсэн орнууд аажмаар (зөвхөн байгаль орчны шалтгаанаар ч бус) зайн түлшийг тээвэрт ашигладаг ертөнц рүү шилжлээ ч гэсэн Энэтхэг эсвэл Хятадад шинээр цэцэглэж байгаа автомашины зах зээлүүд энэ үйл явцыг мөн адил дагана гэж бодох нь алдаа байж болох юм.

Газрын тосноос хараат байхын аюулгүй байдлын утга агуулга юу вэ?

Газрын тосноос хараат байхын аюулгүй байдлын утга агуулга нь тухайн хүн уг асуудлыг үйлдвэрлэгчийн байр сууринаас эсвэл хэрэглэгчийн байр сууринаас харж байгаа эсэхээс маш их хамаарна.

Үйлдвэрлэгч орны аюулгүй байдлын асуудлууд

Олон үйлдвэрлэгчдийн хувьд, газрын тос бол засгийн газрын мөнгө олох гол эх үүсвэр учраас дэлхий нийтээр газрын тосноос үргэлжлүүлэн хараат байх нь тэдэнд сайн зүйл. Энэ нь ялангуяа ОПЕК-ийн ихэнх гишүүд, тодруулбал Саудын Араб,

Ливи, Нигери, Венесуэлийн хувьд үнэн бодитой асуудал. Мөн Оман, Бруней, Йемен, Казакстан, Азербайжан гэх мэт ОПЕК-ийн бус тэргүүлэх үйлдвэрлэгч орнуудын хувьд ч үнэн.

ОПЕК-ийн зарим орон дан ганц түүхий нефтийн орлогод тулгуурлах нь бага байдаг. Учир нь, тэд нэг бол үйлдвэрлэлээ байгалийн хийн чиглэлд амжилттай төрөлжүүлж чадсан (Катар, Алжир хоёр), эсвэл өмнө нь олсон нефтийн ашгаасаа нилээд ихийг цааш нь хийж, түүгээрээ өнөөгийн үндэсний хөгжлийн ерөнхий зорилгодоо ашиглах сан бүрдүүлсэнтэй (Арабын Нэгдсэн Эмират Улс ба Кувейт) холбоотой. Иран гэх мэт зарим томоохон үйлдвэрлэгчид аль хэдийн нилээд олон чиглэлд төрөлжүүлсэн эдийн засагтай болжээ. Тэдний хувьд газрын тосны орлого бол засгийн газрын санхүүгийн тэргүүлэх эх үүсвэр боловч, газрын тос өөрөө эдийн засгийн олон тооны хөдөлгөгч хүчнүүдийн нэг байдаг.

Газрын тос үйлдвэрлэгч орнуудын (ОПЕК-ийн гишүүн ч бай, үгүй ч бай ялгаагүй) засгийн газрууд газрын тосны орлогоо дээд цэгт нь хүргэж өсгөх сонирхолтой байдаг гэж нотлох явдал нийтлэг байдаг. Гэвч энэ зорилгоо одоогийн орлогоо дээд цэгт хүргэх замаар биелүүлэх үү, аль эсвэл нэг, хоёр жил биш, харин 10-20 жилийн хугацаанд нийт орлогоо дээд цэгт хүргэх бодлого боловсруулах замаар зорилгодоо хүрэх үү гэдэг талаар нилээд маргаан өрнөдөг.

Ерөнхийдөө, ихэнх үйлдвэрлэгчид харьцангуй богино хугацаанд үйл ажиллагаа явуулах хандлагатай байдаг. Ирэх жилийнхээ боломжийг алдахгүйгээр энэ жилийн төсвийнхөө хэрэгцээг хангахуйц хэмжээний газрын тос гаргаж авах нь ямагт хамгийн чухал асуудал байсаар байна. Гэвч тэдний бодлыг 1970-аад онд гарсан газрын тосны үнийн хоёр томоохон хямрал өөрчилсөн байж болох юм. 1973 оны Араб-Израилийн дайнд АНУ, Нидерланд хоёр Израильд тусалсан гэж үзсэний үндсэн дээр Арабын газрын тос үйлдвэрлэгчид (ОПЕК бүхэлдээ биш) дээрх орнуудад газрын тос борлуулахгүй байх хориг тавьсны дараа газрын тосны үнийн эхний томоохон хямрал үүссэн юм. Хоёрдахь хямралт байдал 1979 оны Ираны хувьсгалын дараа үүсчээ.

1973 оны Арабын газрын тосны хоригоос хойш газрын тос үйлдвэрлэгчид түүнийгээ улс төрийн зэвсэг болгон ашиглаж болох юм гэсэн санаа аяндаа нилээд сонирхолтой сэдэв болон үлдсэн юм. Харин энэ байдлыг сүүлийн үеийн хэд хэдэн чиг хандлага бүрэн өөрчилсөн юм. Нэгдүгээрт, үйлдвэрлэгч орнууд өөрсдөө (хэзээ ч туйлширсан хандлага гаргаж байгаагүй Абу Дабигаас бусад нь) нэгэнт санхүүгийн нөөц ихээр хумигдахад хүрвэл тэд засгийн газрын урсгал зардлуудаа хэдхэн сар л санхүүжүүлж чадах юм байна гэдгээ мэддэг болжээ. Хоёрдугаарт, тэдний хүн ам нилээд өссөн учраас төрийн үндсэн үйлчилгээ болон өргөн хүрээг хамарсан цалингийн сангийн төлбөрт нь илүү их бэлэн мөнгө хэрэгтэй болно.

Гуравдугаарт, өнөөдөр газрын тосны үнэ (нэрлэсэн үнийн хувьд өндөр байгаа мэт санагдаж болох боловч) инфляци болон валютын ханшны хэлбэлзлээс болж бодит түвшингээрээ 1970-аад оны сүүл, 1980-аад оны эхэн үеийн оргил үеүдээс нилээд доогуур байгаа юм. Дөрөвдүгээрт, газрын тосны хэрэглээгээрээ тэргүүлдэг бараг бүх улс орон богино хугацааны нийлүүлэлтийн аливаа хямралын үр дагаварыг арилгахад туслах зорилготой стратегийн нөөц сангууд байгуулаад байна.

Энэ нь газрын тосны аливаа хориг, нийлүүлэлтийн бусад хямралт байдал нь түүний үнэ өсөхөд хүргэхгүй гэсэн үг биш. Харин энэ тохиолдолд үйлдвэрлэгч орнууд өөрсдөө нилээд хохирно гэсэн үг юм. 2002 оны 4 дүгээр сард Садам Хуссейн дангаараа тогтоосон газрын тосны хориг бусад үйлдвэрлэгчийн нэмэгдүүлсэн нийлүүлэлтээр нөхөгдөж, түүний үр дүнд зөвхөн Ирак улс ганцаараа хохирч үлджээ. Үйлвэрлэгч орнуудад хэн эрх барьж байгаагаас үл хамааран төр засгийн өдөр тутмын зардлаа нөхөх хэмжээний газрын тосны орлого шаардлагатай байдаг. Ийнхүү тэд өөрсдөө газрын тосны орлогоос хамааралтай болсон учраас засгийн газрууд нь зах зээлээ үргэлжлүүлэн барьж байхын тулд хэрэглэгчидтэйгээ сайн харилцаа тогтоосон хэвээр байх ёстой. Өнөөдөр ОПЕК, Олон улсын эрчим хүчний агентлаг (ЭЗХАХБ дахь газрын тосны томоохон хэрэглэгчдийг төлөөлсөн Парист төвтэй эрчим хүчний хяналтын байгууллага) хоёр ажил төрлийн нилээд сайн харилцаатай болоод байна.

Хэрэглэгч орны аюулгүй байдлын асуудлууд

Хэрэглэгч орнуудын хувьд ч мөн адил эдийн засгийн асуудал төдийгүй цэргийн асуудал байдаг. Эдийн засгийн ерөнхий нөхцлүүдийн хувьд хэрэглэгч улсуудад газрын тос нилээд чухал үүрэг гүйцэтгэдэг боловч эдийн засгийнх нь цорын ганц тулгуур биш байдаг.

Нийлүүлэлтийн хямрал удаан үргэлжлэх нь үнийн огцом өсөлтөд хүргэж болох ч, ихэнх аж үйлдвэржсэн орнууд эрчим хүчиндээ өөрийн гэсэн өндөр татвар ноогдуулах замаар үнийн ийм өсөлтөөс тодорхой түвшинд хамгаалах механизм суулгаж өгсөн байдаг. Үйлдвэрлэгчдэд төлж байгаа газрын тосны үнэ хэрэглэгчдэд төлж байгаагаасаа хамаагүй бага учраас тухайн засгийн газар үнийн өсөлтийг дагаж татвараа нэмэгдүүлэх, аль эсвэл татвараа хэвээр байлган үнийн өсөлтийг барихаар шийдэх эсэхээс уг үнийн өсөлтийн хэрэглэгчдэд үзүүлэх нөлөө хамаарна.

Нийлүүлэлтийн хомсдол хамгийн их бодитой нөлөө үзүүлдэг газар бол цэрэг армийн нефтийн хэрэглээ байдаг. Нефтиэс маш их хамааран үйл ажиллагаа явуулдаг цэрэг армийнханы хувьд шахмал байгалийн хий гэх мэт бусад төрлийн түлшийг танк, ачааны машинууддаа ашиглаж болох эсэхийг судлах урт удаан

ажил дөнгөж эхлээд байна. Хэдийгээр байлдааны хөлөг онгоцонд цөмийн эрчим хүчний хөдөлгүүр ашиглаж болох боловч байлдааны нисэх онгоцонд нефтийн гаралтай түлш хэрэглэхээс өөр аргагүй. Өнөөдөр нийлүүлэлтийн хямралаас урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх асуудал нь Дэлхийн II дайны үеийнхтэй адил амин чухал хэвээр байна.

Гол түлш, эрчим хүчний эх үүсвэр эсвэл гол орлогын эх үүсвэр эсэхээс үл хамааран газрын тосноос нийтлэг хамааралтай байдлаа ойлгосны үндсэн дээр үйлдвэрлэгч ба хэрэглэгч орны засгийн газрууд нилээд өргөн хүрээтэй, тогтмол яриа хэлэлцээ хийдэг болжээ. Саудын Арабын хэд хэдэн иргэд гол үүрэг гүйцэтгэсэн 2001 оны 9 дүгээр сарын 11-ний террорист халдлага болон Израиль-Палестины мөргөлдөөний талаарх зөрчилтэй үзэл бодлоос үүдэн Саудын Араб ба АНУ-ын хоорондын харилцаа хурцдаад байгаа билээ. Гэвч 1990-1991 онд Ирак улс Кувейтийг эзэлж авах үед бодитойгоор нүүрлэсэн буюу нүүрлэхээс эмээж байсан газрын тосны нийлүүлэлтийн хямралыг зохицуулахад, мөн 2002 оны сүүл, 2003 оны эхээр улс төрөөр амьсгалсан газрын тосны ажилчид ажил хаяж Венесуэл дэх үйлдвэрлэл уналтад орохтой давхцаад АНУ-ын цэрэг Иракийн дайнд хошуучлан орох хүнд нөхцөл байдлын үеэр газрын тосны нийлүүлэлтээ нэмэгдүүлэх арга хэмжээ авсан Саудын Арабын эзэнт улсын гүйцэтгэсэн үүргийг Вашингтон сайшаасан байна.

2004 оны 6 дугаар сард Саудын Арабын газрын тосны сайд Али Найми, дэлхийн нийтийн эдийн засгийн өсөлтийг алдагдуулах аюул занал учруулж буй түүхий нефтийн үнийн огцом хөөрөгдлийг дарах үүднээс тус бүлэглэлийн нийт үйлдвэрлэлийн дээд хэмжээг 2.5 сая б/ө -өөр нэмэгдүүлэхийг ОПЕК-ийн гишүүн орнуудын сайд нарт уриалсан байна.

Газрын тосонд хэт найдах нь байгаль орчинд ямар үр дагавартай вэ?

Газрын тос байгаль орчинд хоёр замаар нөлөөлдөг. Энэ нь нүүрс төрөгчийн давхар ислийн (CO_2) ялгаралтад нөлөөлдөг бөгөөд ер нь хүний хүчин зүйлсээс үүссэн CO_2 -ын ялгаралт нэмэгдэж байгаа нь дэлхийн цаг уурын дулааралтын гол шалтгаан гэж үздэг. Түүнчлэн газрын тос нь байгаль орчны ерөнхий бохирдол, түүний дотор хүчлийн бороо, хот суурингийн утаа тортог, далай тэнгисийн усны бохирдол, биологийн төрөл зүйлсийн цөөрөлт, экологийн системийн янз бүрийн сүйрэлд нөлөөлдөг.

Мөн газрын тосны үйлдвэрлэл газар нутгийн байдал, хөдөө аж ахуй, газар тариалангийн байдал, аялал жуулчлалд нөлөөлдөг. Энэ бүхнийг нэгтгэвэл, газрын тосны боловсруулалт, ашиглалт нь хүний эрүүл мэнд, үйл ажиллагаанд өргөн хүрээтэй нөлөө үзүүлж байна. Ерөнхийдөө эрчим хүчний ашиглалт, тэр дотроо нефть, шатахууны ашиглалт нь хүний эрүүл мэнд, сайн сайхан байдалд тустай эдийн засгийн ерөнхий хөгжилд эерэг нөлөө үзүүлдэг боловч тэд мөн байгаль орчны бохирдлын хэлбэрээр хүний эрүүл мэнд, орон нутгийн байгаль орчны доройтолд муугаар нөлөөлөөд зогсохгүй дэлхийн цаг уурын дулаарлаар дамжин дэлхийн нилээд буюу дийлэнх хэсгийн хөгжилд ноцтой үр дагавар авчрах боломжтой.

CO₂-ын асуудлыг хоёр хэсэгт хуваан авч үзэж болно. Нэгдүгээрт, дэлхийн цаг уурын дулаарлын асуудал, хоёрдугаарт, дэлхий дахинд түлш шатахуунаас гарч буй CO₂-ын ялгаралт маш их тэнцвэргүй тархалттай байгаа явдал юм. 2004 оны эхэн үеийн байдлаар, агаар мандалд ялгарч буй CO₂-ын нэмэгдэж буй хэмжээ ба цаг агаарын нөхцөл байдлын хооронд ямар нэг хамаарал байна хэмээн дүгнэсэн НҮБ-ын Цаг Уурын Өөрчлөлтийн Талаарх Засгийн Газар Хоорондын Зөвлөлийн (өөртөө 2500 орчим эрдэмтдийн санаа бодлыг нэгтгэдэг) дүгнэлтэд эргэлзсэн хэвээр байгаа шинжлэх ухааны байгууллага дэлхий дээр цөөхөн үлджээ.

ХҮСНЭГТ 5

Тугалгагүй бензиний татварын хувь, 2001 оны 4 дүгээр улирал

(хэрэглэгчдэд хүрэх эцсийн үнэд эзлэх хувиар)

Мексик	13
АНУ	26.5
Швейцари	64.9
Унгар	65.4
Турк	68.9
Нидерланд	72.6
Норвеги	75
Франц	75.3
Герман	76.2
Их Британи	78.9

Эх сурвалж: "Эрдэмтдийн Сан" (2002), ПУЭХА (Н.А.) Угсарт, 2002

Тэр ч байтугай олон тооны компани, түүний дотор БиПи, Шелл зэрэг аварга компаниуд хүртэл, нэг бол дэлхийн цаг уурын дулаарлыг бодит болгон хүлээн зөвшөөрөх ёстой эсвэл урьдчилан сэргийлэх зарчмаар CO₂-ын ялгаралтыг багасгах арга хэмжээ авах ёстой гэдэг талаар маргаж байна.

Хүн төрөлхтөн CO₂-ыг ялгаруулж, хүлэмжийн нөлөө үүсгэх замаар дэлхийн цаг уурын дулааралд нөлөөлж байна гэсэн дүгнэлт 1997 оны Киотогийн протоколын хөдөлгөгч хүчин болж байлаа. Энэхүү пакт нь, 2010 он гэхэд НҮБ-ын Цаг уурын өөрчлөлтийн хүрээний конвенцид заасан зорилт буюу тодруулбал, дэлхийн CO₂-ын ялгаралтыг 1990 оны түвшнээс 7 хувиар бууруулах зорилтыг хангахад чиглэсэн бодитой хөтөлбөр гаргах зорилготой юм.

Киотогийн Протоколыг хэрэгжүүлэх нь дэлхийн цаг уурын дулааралтай тэмцэх дэлхий нийтийн хүчин чармайлтын төвд үлдээд байна. Гэвч АНУ уг протоколд нэгдэн орохыг татгалзсан явдал нь эдгээр хүчин чармайлтад хүнд цохилт болсон хэвээр байна. 2001 онд Бушийн засаг захиргаа АНУ энэ протоколд нэгдэн орох нь тус улсын эдийн засагт ноцтой хүндрэл учруулахын зэрэгцээ хүн амын төвлөрөл ихтэй Хятад, Энэтхэг энэ үүргээс чөлөөлөгдөж байгаа нь буруу гэж үзэн нэгдэн орохоос татгалзжээ.

Бушийн засаг захиргаа цаг уурын дулааралд харьцангуй бага нөлөө үзүүлж байгаа хэмээн чөлөөлөгдсөн Хятад, Энэтхэгтэй барьцандаа ч биш, дэлхийн CO₂-ын ялгаралтын ихээхэн хэсгийн хариуцлагыг АНУ хүлээх ёстой гэдэг нь маргааны гол эх үүсвэр болоод байгаа юм. Энэтхэг, Хятад хоёр өөр хоорондоо 1995-1999 оны хугацаанд CO₂ ялгаруулалтыг 10 хувиар бууруулсан байхад АНУ хэрэглээгээ 6-аас багагүй хувиар нэмэгдүүлсэн байна.

АНУ-ын зүгээс арга хэмжээ авч болох олон арга зам бий. Үүний нэг нь бензин шатахууны татварыг нэмэгдүүлэх явдал юм. Энэ нь АНУ-ын автомашины хэрэглээг багасгах бөгөөд дэлхийн хүн амын 4-хөн хувь нь амьдардаг энэ орон дэлхий нийтийн хорт хий ялгаралтын 20 хувийг эзэлж буй тэнцвэргүй байдлаа нөхөж эхлэх юм.

Шатахууны татварын асуудлын хувьд АНУ аж үйлдвэржсэн ертөнцийн бусад нөхдөөсөө нилээд хол хоцорч байна (Хүснэгт 5). АНУ-ын нэг хүнд ноогдох ДНБ болох 35,895\$-ын арван гуравны нэг хувиас ч бага буюу 2,605 ам. долларын нэг хүнд ноогдох ДНБ-тэй (2002 оны харьцуулалтыг ашиглавал) Турк улсын хэрэглэгчид хүртэл АНУ дахь шатахууны татвараас 2.5 дахин их шатахууны татвар төлж чадаж байна. Мөн Туркийн хөдөөгийн хүн ам АНУ-ын хүн амынхаас ч өргөн уудам зайг туулахдаа автомашин бараг хэрэглэдэггүй байна.

Татварыг нэмэгдүүлэх нь зайлшгүй улс төрийн сөрөг үр дагавар авчирна гэж маргаж болох бөгөөд байгаль орчны бүр ч илүү ноцтой сөрөг үр дагаварыг зайлуулахын тулд заавал шатахууны хэрэглээнд өндөр татвар ноогдуулах шаардлагатай юу эсвэл АНУ хорт утаа ялгаруулалтын талаар хатуу зохицуулалт гаргах зэрэг зарим боломжит аргыг ашиглан нүүрс төрөгчийн хорт хий ялгаруулалтаар тогтоосон муу нэр хүндээ засч сайжруулахыг хичээж болох уу гэсэн асуултууд үлдэж байна.

Дүгнэлт: Газрын тосны үнэ

Газрын тос ерөнхийдөө хөгжилд чухал ач холбогдолтой төдийгүй тээвэрт амин чухал үүрэгтэй хэвээр байна. Яваандаа энэ бүхэн өөрчлөгдөх ёстой ч тэр өөрчлөгдөх өдөр хүртэл хэдэн арван жил шаардагдах магадлалтай. Өнөөдрийн хэрэгцээ шаардлагыг хангахуйц хэмжээний хангалттай газрын тос байгаа ч түүнийг гаргаж авахад тодорхой зардал гарах болно. Ер нь энэ зардал бэлэн мөнгөөр тоологддог. АНУ-ын хэрэглэгчид газрын тосны өртөг зардалд ихээхэн өсөлт гарахыг тэвчиж чадахгүй гэсэн нийтлэг ойлголт байдаг боловч АНУ-аас хамаагүй их газрын тос хэрэглэж, түүнийгээ илүү их үр ашигтай ашигладаг бусад аж үйлдвэржсэн орнуудын хувьд хэрэглэгчид амин чухал бүтээгдэхүүнийхээ нилээд өндөр өртгийг хүртэл тэвчиж чаддаг болохыг тогтоогоод байна. Түүнчлэн өнөөгийн зардлын түвшин маш харьцангуй байна. 2004 оны 10 дугаар сард газрын тосны нэрлэсэн үнэ ам.доллаароор нэг баррель нь 50\$ хүрч дээд амжилт тогтоосон боловч бодит үнэ (инфляцийг тооцсон) нь 1980-1981 оны газрын тосны үнийн оргил үеийн үнийн дөнгөж 60 хувьд хүрсэн юм. Цаашилбал, энэ зууны сүүлийн 25 жилд АНУ-ын орлого бодитойгоор өссөн учраас нэг өрхийн шатахуунд зарцуулах зардлын хэмжээ асар их буурсан юм.

АНУ-ын буюу өөр аль ч газрын хэрэглэгчид ирэх хэдэн жилд харьцангуй хяма үнэтэй газрын тосонд найдаж чадах эсэх нь бүхий л төрлийн хүчин зүйлсээс, түүний дотор дэлхийн эдийн засгийн байдал болон түүний улс төр, эдийн засгийн терроризмийн ажиллагаанд өртөмтгий байдлаас хамаарах болно. Гэвч газрын тосны нөөц хомсдохоос айж эмээх шаардлага байхгүй. Гэхдээ, өнөөдрөөс эхлээд газрын тос хэрэглэдэггүй цаг үе ирэх хүртэл хугацаанд хэт их газрын тос ашигласны байгаль орчны үр дагавраас айх шаардлага гарч болох юм.

4. Газрын тосны компаниуд ба олон улсын газрын тосны зах зээл

Катерин Стефан

21 дүгээр зууны газрын тосны компаниуд 19 дүгээр зуунд уг салбарт ноёрхож байсан Жон Д. Рокфеллерийн Стандарт Ойл компаниас нилээн өөр юм. Өнөөдөр дэлхийн хамгийн том газрын тосны компаниудын тоонд Саудын Арабын Арамко, Хятадын Петрочайна зэрэг улсын компаниуд орж байна. АНУ, Европоос гаралтай газрын тосны томоохон хувийн компаниудын тоо буурч байгаа боловч 1990-ээд оны сүүлээр эхэлсэн өндөр бооцоотой хэд хэдэн цуврал нэгдэх үйл ажиллагааны үр дүнд тэд өрсөлдөх чадвараа хадгалж үлдсээр байна.

Энэ бүлэгт эдгээр газрын тосны улсын ба хувийн компаниуд болон олон улсын газрын тосны зах зээлийн тухай танилцуулахын зэрэгцээ олон улсын зах зээл дээр газрын тосыг хэрхэн худалдан авч, борлуулдгийг тайлбарлах болно.

Түүнчлэн газрын тос, байгалийн хийн компаниудын дунд корпорацийн хариуцлагын нэр хүндээ дээшлүүлэх талаар өсөн нэмэгдэж буй чиг хандлагыг авч үзнэ.

Олон улсын газрын тосны салбар дахь өөрчлөлтүүд

Өнгөрөгч зууны ихэнх үеийн турш газрын тосны салбарт Экссон, БиПи, Роял Датч/Шелл гэсэн олон улсын газрын тосны гурван компанийн бүлэг болон Чеврон, Тексако, Галф, Мобил зэрэг Ойрхи Дорнодод газрын тосны томоохон орд газрууд олж авсан Америкийн дөрвөн компани нийлсэн Долоон Эгч Дүүс хэмээх компаниуд ноёлж байлаа. Эдгээрийн ихэнх нь АНУ-ын Дээд Шүүхээс 1911 онд Стандарт Ойл компанийг татан буулгах шийдвэр гаргаснаар үүсэн байгуулагджээ.

Эдгээр нь дор бүрнээ олон улсын газрын тосны нийлүүлэлт ба үнэд нөлөөлдөг, нэгээс олон оронд үйл ажиллагаа явуулсан, түүхий нефтийн хайгуулаас эхлээд, боловсруулалт, түгээлт хүртэл нефть үйлдвэрлэлийн үйл явцын бараг бүх салбарт идэвхтэй оролцдог учраас “томоохон” гэж нэрлэгддэг.

Өнөөдөр дэлхийн газрын тосны үнэд огцом савлагаа их гардаг, мөн арай жижиг бие даасан компаниуд болон аварга том үндэсний газрын тосны компаниуд (ҮГТК)-ын зүгээс ирэх өрсөлдөөн нэмэгдсэн зэргээс болж газрын тосны салбарын бүтэц өөрчлөгдөөд байна. Уг өөрчлөлтийн өөр нэг гол шалтгаан бол тухайн салбар дахь хөрөнгийн зах зээлийн ажиллагаа муутай байдал болон өсөх хэрэгцээ шаардлага хоёр юм. Газрын тосны орд шинээр нээж илрүүлснээр органик өсөлт гарах явдал улам хэцүү, эрсдэлтэй болсон учраас гол урагшлах зам нь худалдан авалт болсон байна. Шинээр төрөн гарсан хүчнүүд болох ҮГТК-ууд байгалийн баялгийг хяналтдаа авах нь улам ихэсч байна. 1990-ээд оны сүүлээс 2002 он хүртэл тус салбарт хэд хэдэн нэгдэх үйл ажиллагаа явагдаж, Долоон эгч дүүс задран, таван нэгдсэн “супер том” компани болж тэдний тоо буурсан бөгөөд өнөөдөр тэднийг Том Тав гэж нэрлэх болжээ.

Эдгээр компанийн хэмжээг хоёр үндсэн аргаар хэмжиж болно. Эхнийх нь, зах зээлийн капиталжилт буюу зах зээлийн үнийг нь харах явдал байдаг. Үүнд аливаа компанийг ямар үнэ цэнэтэй гэж хөрөнгө оруулагчид үзэж байгааг, улмаар тус компанийн гарт буй эдийн засгийн хүч чадлыг харуулдаг. Зах зээлийн капиталжилтийг тооцохдоо аливаа компанийн үлдэгдэл хувьцааны тоог нэг хувьцааны зах зээлийн өнөөгийн үнээр үржүүлж тодорхойлдог.

Хоёр дахь арга бол нөөцийг нь харах явдал. АНУ-д хувьцаа нь нийтээр арилжаалагддаг газрын тосны компаниуд үнэт цаасны зах зээлийг зохицуулах

эрх бүхий байгууллага болох АНУ-ын Үнэт цаасны арилжааны комисст /ҮЦАК/ жил бүр тайлангаа явуулах ёстой. Энэ тайланд компаниуд хэр их газрын тос, байгалийн хий олборлон үйлдвэрлэж чадна гэсэн итгэлтэй байгаагаа хувьцаа эзэмшигчдэд танилцуулдаг.

2004 онд Роял Датч/Шелл компани батлагдсан нөөцийнхөө хэмжээг хэтрүүлэн тооцооноо хүлээн зөвшөөрөх үед нөөцийн ангиллууд хэвлэлийн тэргүүн нүүрний мэдээ болж байлаа. Хэдийгээр Шеллээс өөр том компаниуд нөөцийнхөө хэмжээг шинэчилсэн тухай мэдэгдэл хийгээгүй боловч ингэж хүлээн зөвшөөрсөн явдал нь уг салбар дахь нөөцийн хэмжээг тайлагнах практикт асуудал үүсгэсэн юм.

Батлагдсан болон болзошгүй гэсэн хоёр үндсэн төрлийн нөөцийн ангилал байдаг: Газрын тосны инженерийн нийгэмлэг (ГТИН буюу SPE)-ээс гаргасан тодорхойлолтоор, батлагдсан нөөц гэдэг нь өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны арга барил, засгийн газрын зохицуулалтын хүрээнд тодорхой орд газраас “баттай үндэслэлтэйгээр” гарган авч чадах газрын тосны хэмжээ юм. ГТИН-ээс батлагдсан нөөцийн хувьд 90 хувийн итгэлцэлийн түвшин буюу баталгаатай гэж заажээ. Мөн батлагдсан нөөцийг боловсруулан гаргасан буюу боловсруулж гаргаагүй гэж ангилж болно. Нью Йоркийн Хөрөнгийн бирж дээр хувьцаа нь арилжаалагдаж буй бүх компани ҮЦАК-т газрын тос, байгалийн хийн батлагдсан нөөцөө тайлагнах шаардлагатай байдаг.

Болзошгүй нөөц гэдэгт гарган авах боломжгүйгээс илүү өндөр магадлалтай батлагдаагүй нөөцийг оруулна. ҮЦАК энэ талаар тэмдэглэхдээ олборлосон хэмжээ нь батлагдсан ба болзошгүй нөөцүүдийн тооцооны нийлбэртэй тэнцүү буюу их байх магадлал дор хаяж 50 хувьтай байх ёстой гэжээ.

Гурав дахь төрлийн нөөц болох боломжит нөөц гэж болзошгүй нөөцийг бодвол гарган авах боломж багатай гэж шинжээчид үзэж байгаа батлагдаагүй нөөцийг хэлнэ.

Хөрөнгө оруулагчид аливаа газрын тосны компанийн ирээдүйн үнэ цэнийг таамаглахдаа нөөцийн тооцоог нь хардаг. Компани эдгээр нөөцийг бүртгэж тооцох ажил нь ҮЦАК-ын заавар удирдамжийн дагуу хийгдэх ёстой. Таван том хувьцаат компанийн тухай товч мэдээллийг зах зээлийн капиталжилт, 2003 оны цэвэр орлого, 2003 оны үйлдвэрлэл гэх мэт үзүүлэлтэд тулгуурлан дор үзүүлэв. (Санамж: нэг өдөрт ноогдох баррель нефтьтэй тэнцэх буюу бнт/ө гэсэн нэгжийг байгалийн хийн үйлдвэрлэлийг газрын тосны үйлдвэрлэлтэй харьцуулан стандартчилахад хэрэглэдэг бөгөөд ингэснээр компаниуд хоёр биш, нэг тоо харуулж болох юм).

Газрын тосны томоохон компаниуд

ЭкссонМобил: ЭкссонМобил бол 1999 онд АНУ-ын Экссон, Мобил хоёр компанийн 80 тэрбум ам.долларын хөрөнгөтэй нэгдэх үйл ажиллагааны үр дүнд бий болсон дэлхийн хамгийн том нийтээр арилжаалагддаг газрын тосны хувьцаат компани юм. Тус компани нь УГТК бус компаниуд дотроо хамгийн том эрчим хүчний нөөцийн бааз суурьтай. Газрын тосны хайгуулаас эхлээд олборлолт, үйлдвэрлэл, маркетинг, петро-химийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хүртэл асар өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулдаг нь дэлхийн хаанаас ч хөрөнгө оруулалтын цорын ганц таатай боломж олж авах боломжийг олгодог. Түүний үйлдвэрлэлийн дараахь (нефть боловсруулалт, жижиглэн худалдаа) бизнесийн үйл ажиллагаанд компанийн өөрийн үйлдвэрлэлийн хүчин чадлаас хамаагүй их газрын тос шаардагддаг. Энэ байдал нь тус компанийг болон бусад супер том компанийг зах зээл дээрх түүхий нефтийг цэвэр худалдан авагч болгон хувиргадаг байна.

Зах зээлийн капиталжилт, 2004 оны 11 дүгээр сард: 316.5 тэрбум ам.доллар
2003 оны цэвэр орлого: 21.5 тэрбум ам.доллар, урд жилийнхээс 87.7% өссөн
2003 оны үйлдвэрлэл: 2003 оны тооцоогоор 4.2 сая бнт/ө буюу урд жилийнхээс 1% буурсан¹. Газрын тосны бусад компанийн адил үйлдвэрлэлийн өсөлт нь зах зээлийн хүлээгдэж байсан хэмжээнд хүрээгүй.

БиПи: БиПи компани 1998 онд АНУ-д төвтэй Амоко, 1999 онд Арко компаниудыг авснаар нэгдэх үйл ажиллагаагаа эхэлсэн. 2003 онд БиПи компани Оросын ТНК, Сиданко болон БиПигийн хөрөнгийг нэгтгэсэн шинэ томоохон нэгтгэл болох ТНК-БиПи-гийн 50 хувийг эзэмшихэд 6.8 тэрбум ам.доллар төлөхөөр тохирч Оросын зах зээлд нэвтэрчээ.

Зах зээлийн капиталжилт, 2004 оны 11 дүгээр сард: 215.3 тэрбум ам.доллар
2003 оны цэвэр орлого: 10.3 тэрбум ам.доллар, урд жилийнхээс 50.0% өссөн
2003 оны үйлдвэрлэл: 3.6 сая бнт/ө буюу урд жилийнхээс 3% нэмэгдсэн. ТНК-БиПи нэмэлт 500.000 бнт/ө-н хувь нэмэр оруулснаар 2004 онд нэмж 22% өсөх төлөвтэй байгаа².

Роял Датч/Шелл: Роял Датч/Шелл бол Нидерландын Роял Датч Петролеум, Их Британий Шелл Транспорт энд Трэдинг гэсэн хоёр компанийн нэгдэл юм. Хэдийгээр нэг компани мэт ажилладаг боловч хувьцаа эзэмших бүтэц нь бусад компани, тухайлбал ЭкссонМобил компанийхтай адилгүй. Англи-Голландын энэ компани зах зээлийн үнэ цэнээрээ дэлхийд гуравдугаарт орох аварга компани юм. Тус компани 2004 онд газрын тосны батлагдсан нөөцийнхөө хэмжээг хэтрүүлэн мэдээлснээ зарлаж, 3.9 тэрбум бнт хэмжээгээр бууруулах болсон нь

хөрөнгө оруулагчдыг цочирдуулсан юм. Мөн 1996 оноос хойш нөөцийнхөө хэмжээг өсгөн мэдээлж байснаа хүлээн зөвшөөрсөн нь тус компаний захирал ноён Филип Уаттсыг огцороход хүргэсэн мэдээ байлаа. Энэхүү томоохон компани нөөцөө нөхөж нэмэгдүүлэх талаар амжилт муутай байгаа бөгөөд Том Тав дотроо нөөцийн нас хамгийн багатайд орж байна.

Зах зээлийн капиталжилт, 2004 оны 11 дүгээр сард: нийлээд 108.5 тэрбум ам.доллар

2003 оны цэвэр орлого: 12.5 тэрбум ам.доллар, урд жилийнхээс 32.7% өссөн

2003 оны үйлдвэрлэл: 3.9 сая бнт/ө буюу урд жилийнхээс 2% буурсан³.

Тотал: Өнөөдөр Тотал нэрээр танил болсон тус компани хоёр удаагийн нэгдэх үйл ажиллагааны дүнд бий болжээ: эхлээд Францын Тотал, Бельгийн Петрофина компаниуд нэгдэж Тоталфина компани байгуулсан; дараа нь 2000 оны 3 дугаар сард Тоталфина ба Францын Элф Акуитайн хоёр нэгдсэн байна. Тус компанийн стратегийн гол онцлог нь өсөлт байсаар иржээ. Бусад олон компанитай адилгүй нь, 2003 онд хүлээгдэж байсан үр дүнгийнхээ мэдэгдсэн хэмжээнд хүрсэн бөгөөд 2005 оны турш үйлдвэрлэлийн өсөлттэй байхаар урьдчилан төсөөлж байна.

Зах зээлийн капиталжилт, 2004 оны 11 дүгээр сард: 127.5 тэрбум ам.доллар

2003 оны цэвэр орлого: 8.8 тэрбум \$, урд жилийнхээс 41.7% өссөн

2003 оны үйлдвэрлэл: 2.53 сая бнт/ө буюу урд жилийнхээс 4% өссөн⁴.

ЧевронТексако: Чеврон, Тексако хоёр компани зах зээлийн капиталжилт болон 12 тэрбум бнт батлагдсан нөөцдөө тулгуурлан нэгдэж АНУ-ын хоёр дахь том компанийг байгуулжээ. Тус компани газрын тосны нөөц болон 2.5 сая бнт/ө үйлдвэрлэлийн хэмжээгээрээ дэлхийд дөрөвдүгээрт орох том компани юм. Үйлдвэрлэлийн ямар нэг баттай өсөлтийн тухай мэдээлэл өгөөгүй бөгөөд 2005 оны турш үйлдвэрлэл хэвийн явагдана гэж үзэж байна. (2005 оны 5 дугаар сард тус компани нэрээ Чеврон болгож богиносгожээ.)

Зах зээлийн капиталжилт, 2004 оны 11 дүгээр сард: 112.1 тэрбум ам.доллар

2003 оны цэвэр орлого: 7.2 тэрбум ам.доллар, урд жилийнхээс 539% өссөн

2003 оны үйлдвэрлэл: 2.5 сая бнт/ө буюу урд жилийнхээс 3% буурсан⁵.

Том Тавын дараа зургаад **КонокоФиллипс** компани ордог. 2002 онд Коноко ба Филлипс Петролеум хоёр компани нэгдсэнээр АНУ-ын гурав дахь том компани, нөөцөөрөө дэлхийд зургаад орох том компани байгуулагджээ.

Зах зээлийн капиталжилт, 2004 оны 11 дүгээр сард: 57.7 тэрбум ам.доллар

2003 оны цэвэр орлого: 7.8 тэрбум ам.доллар, урд жилийнхээс 83.7% өссөн⁶

2003 оны үйлдвэрлэл: 1.6 сая бнт/ө буюу урд жилийнхээс 49% өссөн⁷.

Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэл нь буурч байгаа. 2004 оны үйлдвэрлэл нь хэвийн байх төлөвтэй байна.

Үүн дээр нэмээд Лукойл, Юкос, Сибнефть зэрэг Оросын шинэ компаниуд Том Тавд чухал өрсөлдөгчид болон гарч ирж байна. Хэдийгээр харьцангуй бага үнэ цэнэтэй гарсан боловч тэд асар их нөөцтэй бөгөөд их хэмжээний үйлдвэрлэл явуулдаг. Тэд мөн хувийн эзэмшлийн буюу хагас хувьчлагдсан компаниуд юм. 2004 оны эхний улиралд Орос улс Баруунд 49.19 сая метр тонн (4 сая б/ө) түүхий нефть экспортлосон нь урд жилийнхээс 18.1 хувь өссөн байна.

Гэвч 2003 оны сүүлээр Кремль 1990 оны Оросын өмч хувьчлалаар төрөн гарсан хоёр компани болох Юкос, Сибнефть компаниудад дарамт шахалт үзүүлж эхэлсэн нь Сибнефтьд Юкосоос арай бага тусч байна. Кремлиэс авсан арга хэмжээнүүд эдгээр компанийн өсөлтөд аюул занал учруулж байна. Дампуурлын дарамтаас гарах, татварын орлогыг нөхөн төлөх оролдлого нь Юкосын бүтээгдэхүүний 60 хувийг үйлдвэрлэж байсан Юганскнефтьгаз салбарыг 12 дугаар сард худалдахад хүргэсэн юм. Гэсэн хэдий ч, Юкос руу хийсэн энэхүү дайралтыг сүүлийн үед Оросын эдийн засгийн өсөлт удааширч байгаад буруутгах явдал элбэг болжээ.

Нөөц бүрдүүлэх нь

Ирэх арван жилд эдгээр аварга компанид тулгарах гол сорилт бол гарцын хэмжээг хэвээр хадгалахын тулд нөөцөө сэлбэх, дэлхийн газрын тосны эрэлт хэрэгцээг хангах явдал юм. Олон Улсын Эрчим Хүчний Агентлагийн тооцоогоор дэлхийн газрын тосны эрэлт 2004 онд ойролцоогоор 2 сая б/ө-р өсөх бөгөөд жилийн өсөлт нь 1988 оноос хойшхи хамгийн өндөр өсөлт байх юм. Компаниуд нэг бол бие даан шинээр нөөц олж ашиглах эсвэл нэгдэх, худалдан авах замаар бусдынхаа нээж илрүүлсэн нөөцөөс авч болох юм.

Нөөц баялгаа сайтар сахин хамгаалж, хяналтаа алдах дургүй улс орнуудад нөөц олж авна гэдэг бол арга заль шаардсан ажил. Гэвч 1990-ээд онд гадаадын хайгуулчдад үүд хаалгаа нээж өгсөн орны тоо нилээд өссөн бөгөөд одоогоор дийлэнх орнууд тодорхой хэмжээгээр нээлттэй байна. Гэсэн хэдий ч, дэлхийн газрын тосны нөөцийн ихэнх нь оршдог Ойрхи Дорнодын буланд буй газрын тос, байгалийн хийн нөөцөөс хүртэх боломж хязгаарлагдмал хэвээр байна.

Дэлхийн газрын тосны хамгийн том үйлдвэрлэгч Саудын Араб улс байгалийн хийн нөөцөөсөө гадныхан ашиглахыг зөвшөөрдөг боловч дэлхийн хамгийн том нөөц болох тус улсын газрын тосны батлагдсан нөөц 261 тэрбум баррель нефтийг газрын тосны улсын компани Сауди Арамко компани дангаар ашиглаж байна. Гадаадын хөрөнгө оруулагчид тус эзэнт улсын газрын тосны асар их нөөцийг сонирхох нь мэдээж боловч Саудын Араб хоёр жилийн өмнө гаргасан байгалийн хийн санаачилгынхаа гэрээнүүдийг эцэслэх асуудалтай байна. Байгалийн хийн орд газарт нь хоёр том үйлдвэр байгуулах зорилготой байсан 25 тэрбум ам.долларын хөрөнгөтэй ЭкссонМобил тэргүүтэй консорциум 2003 оны 6 дугаар сард задарсанаар хүчийг нь арай судруулсан хувилбар гаргахад хүрчээ⁸. Компаниуд болон засгийн газрын хооронд авах ашгийн хувь ба байгалийн хийн нөөцөд хүрэх боломжийн талаар тохиролцоонд хүрч чадаагүй учраас энэ наймаанд ЭкссонМобил болон АНУ-ын бусад бүх компани оролцоогүй байна.

ОПЕК-ийн гишүүн бус Мексик улсад нөөц баялгийн талаар хүчтэй үндсэрхэг үзэл өрнөж үйлдвэрлэлийн өмнөх шатны хөрөнгийг шууд өмчлөхийг хориглосон нь үйлдвэрлэлээ өргөтгөх зорилгоор тус улсын газрын тос, байгалийн хийн нөөцөд гадаадын хөрөнгө оруулалт оруулахыг зөвшөөрөх оролдлого хийгээд горьдлого тасарсан чөлөөт зах зээлийг дэмжигч Ерөнхийлөгч Винцент Фоксын сэтгэлийг гонсойлгосон юм. 2003 оны сүүлээр 5 ширхэг Олон төрлийн үйлчилгээний гэрээ (ОТҮГ)-нд эрх олгосон явдал Мексикийн байгалийн хийн салбарыг үр нөлөөтэйгээр нээж чадсаны зэрэгцээ төрийн хяналтын хууль ёсны эрхийг хэвээр хадгалсаар байна. Эдгээр ОТҮГ-нүүд нь үйлдвэрлэлийг нэмэгдүүлж, Мексикийн газрын тосны улсын компани Пемекстэй үйлдвэрлэлийн гэрээ байгуулсан компаниудаас 8 тэрбум долларын хөрөнгө оруулалт татан оруулах ёстой байв. Гэвч гэрээний нөхцөл хязгаарлагдмал бөгөөд ашгийн түвшин бага байсан учраас хэлэлцээний эхний шатанд санал болгосон газрын тосны хамгийн том хоёр талбайг эзэмших санал ирээгүй байна.

Гэсэн хэдий ч, Пемекс компани үйлдвэрлэлээ анх төлөвлөж байснаасаа бага боловч нэмэгдүүлэх юм. Пемексийн хайгуул, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны захирал Карлос Моралесын хувьд ОТҮГ-г боловсронгуй болгох шаардлагыг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ 2005 он бол үйлдвэрээ барьж босгох жил, 2006 он үйлдвэрлэл явуулах жил байна гэж үзэж байна.

Үндэсний газрын тосны компаниуд

Газрын тосны томоохон компаниуд хүчин чадлаа бэхжүүлж, түүнийгээ хадгалахыг хичээж байгаа ч эцсийн эцэст аливаа улсын байгалийн баялгийн бааз суурийг тухайн улсын засгийн газар, ҮГТК-иудаараа дамжуулан гартаа барих нь олонтаа байгааг Саудын Араб, Мексик хоёрын жишээ харуулж байна.

ҮГТК-ийг үндэсний тусгаар тогтносон байдлын бэлэг тэмдэг гэж үзэх нь олонтаа бөгөөд аливаа засгийн газрын төсөвт хамгийн чухал хувь нэмэр оруулагч нь байдаг. Засгийн газрын албан тушаалтнууд ч улс төрийн дарамт шахалтыг багасгахын тулд ҮГТК-иудаас олох орлогоо дээд цэгт хүргэхийг олонтаа эрмэлздэг. Ингэснээр тухайн ҮГТК нөөцийн бааз суурийг хяналтдаа авдаг хэдий ч шаардлагатай хөрөнгө оруулалтаа санхүүжүүлэхүйц хангалттай орлого бүрдүүлж чададаггүй. Жишээлбэл, Нигерид засгийн газрын орлогын 80-аас илүү хувийг түүхий нефтийн борлуулалтаар бүрдүүлдэг байна.

Аливаа орны эдийн засагт гүйцэтгэж буй үүрэг, засгийн газартайгаа тогтоосон харилцаанаас хамаарч ҮГТК-иудын стратеги харилцан адилгүй байдаг. Тэдний дотор арилжааны зорилгоо биелүүлэхэд голлон анхаардаг боловч технологийн дэвшлийн тэргүүн эгнээнд үлдэхийн төлөө тэмцэж байгаа компаниудын тоо нэмэгдсэн байна. Сүүлийн жилүүдэд ҮГТК-иуд экспортын зах зээлд гарах, оролцоогоо нэмэгдүүлэхийн тулд бие даасан компаниудад тал засч, тэдний хөрөнгө оруулалтын капитал, технологийг олж авахыг хичээх нь ихэсч байна.

Тэдний заримынх нь хичээл зүтгэл ч үр дүнгээ өгч байна. Вашингтоны тойрогт төвтэй ПиЭфСи Энержи /PFC Energy/ зөвлөх компаниас дэлхийн хамгийн том 50 эрчим хүчний компанийг зах зээлийн капиталжилтаар нь жагсааснаас үзэхэд Азийн ҮГТК-иуд 2003 оны үр дүнгээрээ уг жагсаалтыг тэргүүлж байна. Уг жагсаалтын тэргүүнд Тайландын ПиТиТи /PTT/, Хятадын ПетроЧайна /PetroChina/, Синопек /Sinopet/, Энэтхэгийн ӨвЭнЖиСи /ONGC/ компаниуд багтжээ. Эдгээр компани газрын тосны өндөр үнэ, бүс нутгийн эдийн засгийн сэргэлтээс ихээхэн ашиг орлого олжээ. Мөн тэргүүлэгчдийн тоонд Бразилийн Петробрас /Petrobras/ компани орсон байна.

Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд

Үндэсний газрын тосны компаниуд голдуу тухайн улсын нөөц баялгийн хэсэгт хайгуул хийж, олборлох хүсэлтэй гадаадын компаниудтай хууль ёсоор заавал

биелүүлэх үүрэгтэй гэрээ байгуулах замаар хөнгөлөлт эдлэх давуу эрхтэй байдаг. Эдгээр гэрээ бүтээгдэхүүн хуваах хэлэлцээр (БХХ), бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ) гэх мэт олон байдлаар тодорхойлогддог. Засгийн газрууд бие даасан компаниудтай нэг бүрчлэн хэлэлцээ хийдэг боловч ихэвчлэн уралдаант шалгаруулалтын аргаар газрын тосны талбай эзэмшүүлдэг.

БХХ-ийн хувьд аливаа гадаадын компани буюу компанийн консорциум ихэвчлэн хайгуулын зардлыг өөрөө санхүүжүүлж, газрын тос олдохгүй бол хүлээх хөрөнгө оруулалтын эрсдлийг өөрөө хариуцдаг. Компаниуд ингэж эрсдэл хүлээснийхээ хариуд илрүүлсэн ба үйлдвэрлэн гаргасан газрын тосныхоо тодорхой хувийг авах эрхээр шагнуулдаг. Засгийн газар өөрийн шагналыг хэд хэдэн хэлбэрээр авч болдог. Хамгийн нийтлэг арга бол гэрээний урамшуулал буюу ямар нэг газар газрын тосны хайгуул, олборлолт явуулах зөвшөөрөл олгосны хариуд тухайн хайгуулын компаниас урьдчилсан төлбөр авах явдал байдаг. Компаниуд газрын тос бодитойгоор олж илрүүлсэн эсэхээс үл хамааран гэрээний урамшуулал төлдөг. Энэ төлбөр нь тухайн төслөөр хүлээгдэж буй үнэ цэнийн тодорхой хувьтай тэнцүү байна. Эдгээр нь засгийн газарт шууд орлого оруулаад зогсохгүй тухайн компанийн тууштай ажиллах үүрэг хүлээж буйг харуулах нийтлэг арга хэрэгсэл юм.

Хэрвээ газрын тос олдох юм бол засгийн газар үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тодорхой хэсгийг авах, үйлдвэрлэлийн буюу ашгийн татвар ноогдуулах, нөөц ашигласны төлбөр авах зэргээр шан хүртэж болно.

ҮГТК-иудтай ажиллахын давуу талууд

Ямар нэг ҮГТК-тай түншлэх явдал нөөц газар олж авахыг хүссэн гадаадын компаниудад онцгой чухал ач холбогдолтой.

Орчин үеийн ҮГТК олон улсын газрын тосны томоохон компаниудын ашгийн бүтцийг дуурайхаас ч илүүт хийж чадах болжээ. Мөн арилжааны болон арилжааны бус үйл ажиллагааг хамарсан стратегийн зорилтуудтай ч байж болно. Түүнчлэн эдгээр зорилтуудын тэнцвэрт харьцааг хэрхэн барих талаар тодорхой ойлголттой болсон байна. Норвегийн засгийн газрын хэсэгчлэн эзэмшдэг Статойл компани бусад орны нөөцийг авч ашиглахад төдийгүй тэдгээр орон ба бусад гадаадын пүүс компанигай харилцаа тогтоохдоо хүртэл энэхүү эрлийз бүтцээ ашигласаар байна.

ҮГТК-иудтай ажиллахад тулгардаг бэрхшээлүүд

ҮГТК-иудтай ажиллахад тулгардаг хамгийн том бэрхшээл бол ил тод байдлын асуудал байж болно. Учир нь, улсын компаниуд санхүүгийн болон үйл ажиллагааны чухал мэдээллүүдээ гаргаж өгөх дургүй байдаг бөгөөд улмаар

гадаадын компаниуд тэдний санхүүгийн эрүүл саруул байдлыг үнэлж дүгнэхэд хэцүү болдог. Аливаа гадаадын компанийн хууль ёсоор төлбөл зохих хураамжууд, нөөц ашигласны төлбөрийг тойрсон ил тод байдал дутагдаж, ҮГТК ба засгийн газрын албан тушаалтнуудад уг орлогын санг будлиантуулах боломж олгох үед асуудлууд үүсч эхэлдэг. Хөгжингүй орнуудад ийм төлбөрийг ил болгох ажил тогтмол хийгддэг. Гэвч хөгжиж байгаа олон оронд энэ төлбөрийг нууц байлгасаар байгаа нь уг орлогыг ашиглаж шамшигдуулах боломжийн талаар санаа зовоход хүргэж байна. Жишээлбэл, Хүний Эрхийн Ажиглалт байгууллагын тайлангаар Ангол улсад 1997-2002 оны хугацаанд 4 тэрбум гаруй ам.долларын газрын тосны улсын орлого яасан нь мэдэгдэхгүй алга болсон байна⁹.

Бас нэг асуудал бол санхүүжилт байна. Зарим ҮГТК-иуд, хэдийгээр засгийн газраас санхүүжилт авч болохгүй боловч зардлынхаа өөрт ноогдох хэсгийг хариуцдаг учраас төслийн үйл явц удааширдаг. Бусад тохиолдолд засгийн газрын санхүүжилт гүйцэтгэлийн үр дүнг сайжруулж чадаагүй. Нигерийн Кадуна, Порт Харкортын нефть боловсруулах үйлдвэрүүдэд тус улсын засгийн газар сүүлийн 6 жилийн турш 400 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн нь боловсруулалтын ажиллагааны үр дүнг нэг их сайжруулаагүй бөгөөд хөрөнгө оруулагчид тэдгээр навсар үйлдвэрийг сонирхохоо больсон учраас засгийн газрын хувьчлах оролдлого сулрахад хүрчээ.

Мөн байгаль орчны, нийгмийн, хүний эрхийн зөрчлүүд нь хөрөнгө оруулагчдыг айлгадаг бэрхшээлтэй асуудал байна. (Энэ талаарх дэлгэрэнгүй мэдээллийг 7 дугаар бүлгээс үзнэ үү). ҮГТК-иуд ч, олон улсын газрын тосны компаниуд ч адилхан тэдний үйл ажиллагаанаас болж хохирсон нутгийн иргэдийн амьдралыг сайжруулах хангалттай зүйл хийхгүй байгаа нь олонтаа харагддаг. Нутгийн ард иргэдийн хүртэх үр шим хомс байдал болон заримдаа байгаль орчинд үзүүлэх хор хохирлоос болж тухайн компани ба засгийн газар хоёрын эсрэг хүчирхийлэл гарах явдал байдаг. Менежерүүд, ажилтнууд, нийлүүлэгчид, нутгийн ард иргэд зэрэг сонирхогч талуудын зүгээс хүчтэй шүүмжлээд зогсохгүй эсрэг арга хэмжээ авах болжээ. Нигери улсад үйл ажиллагаа явуулж байсан ЧевронТексако компани орон нутгийн иргэдийн эсэргүүцэл, хорлон сүйтгэх ажиллагаанаас болж үйлдвэрлэлээ 140.000 б/ө орчмоор бууруулаад байгаагаа хүлээн зөвшөөрч байна¹⁰.

Дэд бүтцийн сүйрэл, улс төрийн шуурга, хулгайгаар хил давуулан худалдах явдал зэрэг нь үйлдвэрлэлд хүнд цохилт болж байдаг. Олон ҮГТК-иуд тоног төхөөрөмжөө тогтмол засч шинэчлэх мөнгөгүй байдаг учраас заримдаа газрын тосны үйлдвэрлэл тасалдах явдал байдаг. Аливаа улсын үйлдвэрлэлийн хэмжээнд улс төрийн уур амьсгал ч бас нөлөөлж болно. Тухайлбал, саяхан Алжирт болсон үйлдвэрчний

эвлэлүүдийн эсэргүүцлийн хөдөлгөөний дараа үндэсний газрын тосны үйлдвэрлэлийг хөгжүүлэх хуулийн төсөл хойшилсон байна. Энэ хуулиар Сонатрах хэмээх улсын үйлдвэрийн газрын зохицуулалтын үүргийг болиулж, хайгуулын төслүүдийн уралдаант шалгаруулалтад гадаадын компаниудтай хүчээр өрсөлдүүлэх байжээ.¹¹ 2003 оны эхээр Венесуэлд газрын тосны ажилчид Ерөнхийлөгч Хюго Чавезийн засгийн газрыг түлхэн унагаах зорилгоор ажил хаялт хийсэн нь тус улс үйлдвэрлэлийн хүчин чадлынхаа 10 хувийг алдахад хүргэсэн байна¹².

Газрын тосны үнэ өндөр үед хулгайгаар хил давуулан худалдах явдал ихэсдэг. Ийм хулгайн тээвэр хийж байж болох сэжигтэй хөлөг онгоцуудыг илрүүлэх зорилгоор засгийн газрууд олон улсын усан замд харуул хийдэг. Нигери улсад гэхэд дамжуулах хоолойг эвдэн түүхий нефть хулгайлах явдал түгээмэл байдаг.¹³ Үндэсний түлш, шатахууны сайн бодлогод түлш шатахууны татаас байхгүй болгохыг шаарддаг боловч ийм алхам нь дотоодын эсэргүүцэл хөдөлгөөн гарахад хүргэж болох бөгөөд гарсаар ч байна. Татаасын тогтолцоо болон түлш шатахууны үнийг бусад орнуудынхтай уялдуулан зохицуулж чадаагүйгээс авилгал, хулгайн тээвэр, шатахууны хомсдол үүсдэг. Стандартчилсан арга зүй хэрэглэн дэлхийн 165 орны түлш шатахууны үнийг судалсан Германы Техникийн Хамтын Ажиллагаа байгууллагын судалгаагаар сүүлийн жилүүдэд Анголоос түлш, шатахууны үнийн дундаж харьцангуй өндөр байдаг Африкийн хөрш орнууд руу шатахууныг хулгайгаар хил давуулан худалдах явдал ихэсчээ. Түүнчлэн, Ираны хямд өртөгтэй дизель түлшийн нилээдийг Афганистан руу хулгайгаар хил давуулан худалдаж, тэрхүү орлого орон нутгийн цэргийн дарга нарт очиж байгааг уг тайланд харуулжээ¹⁴.

Өөр нэг саад тотгор бол хүнд суртал байдаг. ҮГТК-иудыг голдуу хэд хэдэн төрийн агентлаг хянаж байдаг нь шуурхай шийдвэр гаргахад хэцүү болгодог. Ийм олон агентлаг хэлэлцээ хийх буюу гэрээнд гарын үсэг зурахын өмнө эрчим хүчний сайдаасаа, тэр ч байтугай эрх баригч төрийн тэргүүнээсээ хүртэл урьдчилан зөвшөөрөл авах ёстой байдаг.

Нэр хүнд ба корпорацийн хариуцлага: улсын ба хувийн салбарын түншлэлүүд

Газрын тосны салбар хүний эрхийн хамгаалалтыг үл ойшоогч засгийн газруудтай гэрээ байгуулж байгааг хүний эрхийн байгууллагууд шүүмжилсээр удаж байна. Түүнчлэн газрын тосны үйл ажиллагаанаас байгаль орчинд болон нийгэмд үзүүлж

байгаа сөрөг нөлөө зэрэг санаа зовоосон нэмэлт асуудлууд нь компаниуд газар зүйн чиг шугамаас үл хамааран хийсэн үйл ажиллагааныхаа хариуцлагыг хүлээх шаардлагатай болгож байна. Тэд хямралт байдлыг хэрхэн зохицуулж чадахаас тухайн компанийн нэг үнэ цэнэтэй “зөөлөн” хөрөнгө болох компанийн нэр хүнд өсөх, буурах нь хамаарна.

Шүүмжлэлийг зогсоож, ашгаа хамгаалах үүднээс компаниуд уламжлал ёсоор үндсэн бус бизнесийн салбар гэж тооцдог байсан чиглэлүүдэд хөрөнгө оруулж байна. Эдгээр төрлийн үйл ажиллагааг тодорхойлох “тогтвортой хөгжил”, “корпорацийн хариуцлага” зэрэг түгээмэл хэллэгийг компаниуд ашиглаж байна.

Жишээлбэл, Роял Датч/Шелл компани Нигери улсад тогтвортой хөгжлийн хоёр төслийг санхүүжүүлэхээр төлөвлөж байна. Тус компани хөдөө аж ахуйн болон хумхаа өвчний төслүүдэд зориулж 15 сая ам.доллар, мөн хумхаа өвчин ба нялхасын эндэгдэлтэй тэмцэх ажилд 3.4 сая ам.долларын хандив өргөнө. Хоёр төсөл хоёулаа АНУ-ын Олон Улсын Хөгжлийн Агентлагийн тусалцаатайгаар хэрэгжих ажээ. Мөн Шелл Петролеум Девелопмент Компаний хамтарсан үйлдвэр (SPDC JV) тус бүс нутагт тогтвортой хөгжлийг хөхиүлэн дэмжих зорилгоор 2000 онд байгуулагдсан Ерөнхийлөгч Олюсегун Обасанжогийн Нигерийн Дельта Хөгжлийн Комисст 54.5 сая ам.долларыг хандивласан байна¹⁵.

БиПи компани 2 тэрбум ам.долларын өртөгтэй Индонези дахь Тангугийн шингэрүүлсэн шатдаг хийн төсөлдөө хүний эрхийн үнэлгээ хийлгэж эхлэх урд хожид байгаагүй алхмыг хийв. Аюулгүй Байдал, Хүний Эрхийн Сайн Дурын Зарчмуудын хүрээнд тулгуурласан уг тайланд БиПи компанийн зүгээс газрын үндсэн эрх, байгалийн баялаг, соёлын эрх, шашны эрхтэй холбоотой нутгийн ард иргэдийн асуудлыг хөндөн авч үзэж болох тодорхой алхмуудыг зааж өгчээ.¹⁶

Мөн БиПи компани Гүрж улсаар дамжуулан Каспийн тэнгисээс Газрын дундад тэнгис хүртэл тавих Баку-Тбилис-Сейханий нефть дамжуулах хоолойн 3.6 тэрбум ам.долларын өртөгтэй төсөлдөө хүний эрхийн асуудлуудыг хөндөн авч үзсэн байна. 2005 оны эхээр 93 хувьтай хийгдэж байна гэж эрх бүхий этгээдүүдийн мэдээлж байсан энэ шугам БиПи болон түүний консорциумын гишүүдэд Боспорын хоолойн нарийн завсраар явахгүйгээр Каспийн тэнгисээс Барууны зах зээлд түүхий нефть тээвэрлэн хүргэх боломж олгох юм.

Зарим орон газрын тосны төсөлд дотоодын компаниудыг оролцуулах бодлого баримталдаг. Нигерийн засгийн газраас тендерт оролцож байгаа гадаадын газрын тосны компаниуд тус салбарт ажиллах орон нутгийн иргэдийг сургах, дотоодын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн төлөвлөгөө гаргаж харуулахыг тендерт заавал тавигдах шаардлага болгожээ. Бразил, Ангол, Орос, Иран улсууд ч орон нутгийн бизнесийн хөгжил, ажил эрхлэлтийг гадаадын газрын тосны

компаниудтай хэлэлцээр хийх тэргүүлэх чиглэл болгоод байна. Мөн компаниуд дотоодын иргэдийг нефтийн инженерчлэл, геологийн мэргэжлээр Барууны их, дээд сургуулиудад суралцуулах тэтгэлэгт хөтөлбөр олонтаа хэрэгжүүлдэг. Саяхан ЧевронТексако компани Иракийн газрын тосны инженерүүдийн багийг сүүлийн үеийн технологийн дэвшлээс суралцуулахаар АНУ-д илгээжээ.

Түүнчлэн авилгалын талаарх олон улсын гэрээ, улам боловсрон хөгжиж буй хууль тогтоомж компаниудын бизнесийн арга барилыг өөрчилж байгаа боловч үндэсний хууль тогтоомж, зохицуулалтуудыг бодвол бизнесийн зан байдалд шууд нөлөө үзүүлэх нь бага байна. НҮБ-ын Глобал Компакт хэмээх сайн дурын хөтөлбөрт корпорацийн сайн иргэншлийг хөхиүлэн дэмжих зорилгоор компаниуд, засгийн газрууд, ажиллах хүчин, байгаль орчны байгууллагуудыг нэгтгэн яриа хэлэлцээ өрнүүлж байна. Уг санаачилга нь хүний эрх, ажиллах хүчин, байгаль орчны чиглэлийн есөн зарчимд тулгуурладаг. 2004 оны 1 дүгээр сард тус бүлэг ил тод байдал, авилгалтай тэмцэх явдалд тулгуурласан 10 дахь зарчмыг нэмж оруулахаар тохирсон байна. Амнести Интернэшнл, Хүний Эрхийн Ажиглагч болон бусад ТББ-ууд анхандаа Глобал компакт санаачилгыг таатай хүлээн авч байсан бол өнөөдөр уг пакт нь сайн дурын чанартай, стандартууд нь тодорхойгүй, хяналт шинжилгээ буюу сахиулах үйл явц байхгүй учраас түүний үр нөлөөтэй байдалд эргэлзсэн асуулт тавих болжээ¹⁷.

Илүү ил тод байдал, эдийн засгийн өсөлт, нийгмийн тэгш эрхийг төдийгүй байгаль орчныг хамгаалах явдал дэмжиж байсан анхны дэмжигч бол 1983 онд НҮБ-ын Байгаль орчин ба Хөгжлийн Дэлхийн Комиссийг даргалж байсан Норвегийн Ерөнхий сайд асан Гро Харлем Брундтланд байв. Мөн Брундтландын комисс гэдгээрээ алдартай тус комиссоос 1987 оны Брундтландын тайланг *Бидний нийтлэг ирээдүй* нэртэйгээр гаргажээ.¹⁸ Энэ тайланд, тогтвортой хөгжил гэдэг бол “ирээдүй хойч үеийнхээ хэрэгцээгээ хангах чадварыг алдагдуулахгүйгээр өнөөгийн эрэлт хэрэгцээгээ хангах хөгжил” гэж тодорхойлжээ.

Хүний эрхийн чиглэлээр бол өнөөгийн газрын тосны ихэнх томоохон компаниуд Аюулгүй Байдал, Хүний Эрхийн Сайн Дурын Зарчмуудыг төслүүдийнхээ удирдамж болгон хэрэглэж байна. АНУ ба Их Британийн засгийн газрууд 2000 онд гарын үсэг зурсан энэ баримт бичиг нь компаниудын зүгээс нутгийн ард иргэдийн хүний эрхийг хүндэтгэх, өөрсдийн үйл ажиллагааны аюулгүй байдлыг хангах аргуудыг зааж өгсөн заавал биелүүлэх үүрэггүй гэрээ юм.

Орлогын ил тод байдлын чиглэлээр “Төлснөө Нийтэл” хэмээх кампанит ажил компаниуд болоод засгийн газруудын аль алиных нь анхаарлыг ихэд татаж байна. ТББ-уудын нэгэн эвслээс 2002 онд санаачлан байгуулсан, олон улсын

санхүүжүүлэгч, хүмүүнлэгийн зүтгэлтэн Жорж Соросын ивээн тэтгэдэг энэ байгууллага бол эрчим хүчний компаниуд хүлээн авагч засгийн газруудад хэр их мөнгө төлж байгааг нийтэд ил болгож, засгийн газрууд уг орлогыг хариуцлагатайгаар ашигладаг болгох зорилготой олон улсын 200 гаруй ТББ-уудын нэгдсэн хөдөлгөөн юм. Энэ кампанит ажил нь компаниуд төлж байгаа бүх төлбөрүүдээ нийтлэх явдлыг тэдний олон улсын хөрөнгийн биржид бүртгэгдэх нэг нөхцөл болгон тавихыг шаардаж байна. Дэлхий Нийтийн Тайлагналын Санаачилга байгууллага бол компаниуд өөрсдийн үйл ажиллагааныхаа эдийн засаг, байгаль орчин, нийгэмд үзүүлэх үр нөлөөг сайн дураар тайлагнахад зориулсан заавар удирдамж боловсруулаад байгаа олон улсын стандарт тогтоогч байгууллага юм. Өөрсдийгөө “ДНТС-ын тайлагнагч” гэж нэрлэдэг компанийн тоо ноднин жил хоёр дахин нэмэгдэж 20 болсон байна.

Олборлох Салбарын Ил Тод байдлын Санаачилгыг 2002 оны Тогтвортой хөгжлийн дэлхийн чуулга уулзалт дээр Их Британийн Ерөнхий сайд Тони Блэйр эхлэн гаргасан бөгөөд орлогын ил тод байдлыг дэмжих чиглэлд компаниуд, засгийн газрууд, ТББ-ууд сайн дурын үндсэн дээр хамтран ажиллахыг уриалж байна (ОСИТБС-ын тухай хавсралтаас үзнэ үү). 2003 оны 5 дугаар сард 3 триллион ам.доллар орчмын хөрөнгө бүхий хөрөнгө оруулагч байгууллагуудын бүлэг энэхүү санаачилгыг дэмжсэн мэдэгдэл гаргасан байна. Транспаренси Интернэшнл буюу Олон улсын ил тод байдлын байгууллагаас дэлхийн хамгийн их авилгалд идэгдсэн орнуудын нэг гэж тооцогдсон Нигери улсад өөрийн гэсэн ил тод байдлын хөтөлбөр эхлэн хэрэгжүүлэх ажилд эртнээс ханцуй шамлан ороод байна. Анхандаа ОСИТБС-д нэгдэн орохоос татгалзаж байсан Ангол улс энэ 5 дугаар сарын дунд үеэр газрын тосны үйлдвэрлэлийн хөнгөлөлтөө өргөтгөх үүднээс ЧевронТексако компаниас 300 сая ам.доллар хүлээн авснаа ил болгосон бөгөөд “удахгүй” ОСИТБС-д гарын үсэг зурахаа амласан байна¹⁹.

Зах зээл

Британийн Хойд номхон далайн Брент түүхий нефть, АНУ-ын Булангийн Вест Тексас Интермедиэт (ВТИ буюу WTI) түүхий нефтийн зэрэглэлүүд дөрвөн жилийн турш дэлхийн нийт газрын тосны борлуулалтад жишиг болон ашиглагджээ. Хэдийгээр энэ хоёр зэрэглэлийн үйлдвэрлэл буурсаар байгаа ч дэлхийн хамгийн том үйлдвэрлэгчдийн ихэнх нь өөрийн гэсэн үнэ тогтоохоосоо илүү эдгээр жишигтэй харьцуулсан байдлаар үнэ тогтоохыг илүүд үзэж байгаа нь тун егөөтэй санагдаж байна.

Компаниуд үйлдвэрлэгч оронтой урт хугацааны гэрээ байгуулах, газар дээр нь буюу бэлэн мөнгөөр зах зээл дээрээс авах, фьючерсийн үндсэн зах зээл болох Нью Йоркийн Худалдааны Бирж дээрээс худалдаж авсан гэрээний биет түгээлтийг авах зэрэг хэд хэдэн аргаар газрын тос худалдаж авч болно.

Ер нь дэлхийн газрын тосны хамгийн идэвхтэй зах зээл бол Нимекс буюу НИХБ (Nymex), түүний Лондонд төвтэй арай бага үеэл болох Олон Улсын Нефтийн Бирж (ОУНБ буюу IPE) хоёр юм.

Фьючерсийн гэрээ нь ирээдүйд нийлүүлэх газрын тосыг тогтсон үнээр худалдан авах буюу худалдах боломжийг талуудад олгодог. ВТИ зэрэглэл нь НИХБ дээр хөнгөн, шинэ түүхий нефтийн фьючерсээр арилжаалагддаг бөгөөд тус бирж дээр мөн шатахуун, халаалтын тос, байгалийн хийн фьючерсийн гэрээнүүд хийгддэг. Эдгээр барааг нийтэд нь нефтийн комплекс гэж нэрлэдэг. Brent зэрэглэлийн түүхий нефть, халаалтын тос (гэр ахуйн халаалтад ашигладаг дунд шатны нефтийн нэрмэл бүтээгдэхүүн), байгалийн хийн фьючерсийг ОУНБ дээр арилжаалдаг. Олон тооны боломжит худалдан авагчид, борлуулагчид үнийн төлөө өрсөлддөг нээлттэй зах зээлийн хувьд эдгээр биржүүд нь өрсөлдөөнт үнүүдийг үр нөлөөтэй тогтоож байдаг.

Газрын тос үйлдвэрлэгч орнууд

Дэлхийн зах зээл дээр борлодог газрын тосны ихээхэн хэсгийг Нефть Экспортлогч Орнуудын Байгууллага буюу ОПЕК-ийн орнууд үйлдвэрлэдэг боловч энэ бүлгийн дэлхийн нийт үйлдвэрлэлд эзлэх хувь буурсаар байгаа нь голдуу өөртөө ноогдуулдаг үйлдвэрлэлийн квоттой нь холбоотой. ОПЕК нь газрын тос үйлдвэрлэгч 11 орноос бүрдэх бөгөөд тэдний нийт үйлдвэрлэлд эзлэх хувийн жинг нэгтгэн ашиглаж дэлхийн газрын тосны үнэд нөлөөлөхийг хичээдэг. Одоогийн гишүүн орнууд нь Алжир, Индонези, Иран, Ирак, Кувейт, Ливи, Нигери, Катар, Саудын Араб, Арабын Нэгдсэн Эмират Улс, Венесуэл улсууд юм.

Орос, Канад, Мексик, Норвеги зэрэг улс ОПЕК-ийн гишүүн бус хамгийн том экспортлогчид бөгөөд АНУ-ын хувьд Саудын Араб, Орос хоёрын дараа орох гуравдахь том экспортлогч юм.

ОПЕК-ийн үнийн бодлого

2000 оны 3 дугаар сараас хойш ОПЕК нефтийн үнийг нэг баррель тутамд 22\$-28\$ -ийн зорилтот хэмжээнд барих үүднээс үйлдвэрлэлийн хэмжээгээ тохируулж байна. Энэ үнийг ОПЕК-ийн сагс гэдэг бөгөөд долоон өөр зэрэглэлийн нефтийн дундаж үнэ юм. Гэвч нефтийн худалдааны нийтлэг валют болох долларын ханш сулрах, өндөр орлого олох дотоодын эрэлт хэрэгцээ нэмэгдэх зэрэг нөхцөл

байдлын өөрчлөлт нь үнийг түүнээс ч өндөр болгоход хүргэдэг. 2004 онд ОПЕК-ийн сагс дунджаар 30 \$/баррель байсан нь хэрэглэгч орнуудын хувьд нилээд гомдолтой байлаа. ОПЕК-ийн зарим үнэ тогтоогчид 22\$-28\$-н зорилтот хэмжээг нэмэгдүүлэхийг дэмжиж байна.

Хэдийгээр 2004 онд түүхий нефтийн үнэ дээд амжилтууд тууштай тогтоож байсан ч, зах зээл дээр хэт их түүхий нефть гаргахад хүргэж, улмаар эргээд тэдэнтэйгээ тэмцэх цаг ирнэ хэмээн ОПЕК-ийн газрын тосны зарим сайд нар санаа зовж байна. 2004 оны 6 дугаар сард Саудын Араб улс үйлдвэрлэлээ 600,000 б/ө-өөс 9.1 сая б/ө хүртэл огцом нэмэгдүүлсэн боловч ОПЕК-ийн бусад гишүүд хүчин чадлын боломжоос голлон шалтгаалж үйлдвэрлэлээ ингэж нэмж чадаагүй байна.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Газрын тосны компаниудын тухай мэдээллийн эх сурвалжууд

Газрын тосны хувийн компаниуд

Компанийн гаргасан шийдвэр, стратегийн талаар мэдээлэхдээ жилийн тайлангаас нь эхлэх нь зүйтэй бөгөөд энэ тайлан голдуу тухайн компанийн вэбсайт дээр байдаг. Түүнээс гадна, тухайн компанийн хөрөнгө оруулагчид эсвэл гадаад харилцааны хэлтсээс нэг хувийг илгээж болно.

- ▶ Жилийн эцсийн тайлангаас тухайн компанийн янз бүрийн бизнесийн үйл ажиллагаа болон үйл ажиллагааны үр дүнд нөлөөлж буй хүчин зүйлсийн дүнг үзэж болно. Компаниуд энэхүү дүндээ хөрөнгө оруулагчдын ашиг орлогод нөлөөлөх ямар нэг чиг хандлагын талаар өгүүлэх шаардлагатай байдаг. Жилийн эцсийн тайлангийн хамгийн чухал санхүүгийн мэдээллүүд бол орлогын тайлан, тайлан тэнцэл, бэлэн мөнгөний урсгалын тайлангууд байдаг.
- ▶ Жилийн эцсийн тайлангаас гадна, аливаа компани жил бүр санхүүгийн жилийн эцэст ҮЦАК-т илгээдэг жилийн эцсийн тайлангийн илүү дэлгэрэнгүй хувилбар болох 10К Маягтыг шинжилж үзэх хэрэгтэй. Ийм тайлангуудыг ҮЦАК-ийн вэбсайт www.sec.gov-н Эдгарын хэсгээс авч үзэж болно. Мөн компаниуд улирлын эцэст 45 хоногийн дотор ҮЦАК-т ирүүлэх ёстой улирлын тайлан болох 10Q Маягт гэж байдаг. Мөн хөрөнгийн биржийн жагсаалтад орсон компаниуд хөрөнгө оруулалтын стратегиа заасан танилцуулга гаргаж вэбсайт дээрээ тавьдаг.
- ▶ Аливаа газрын тосны компанийн үйл ажиллагааны үр дүнг тодорхойлох янз бүрийн шалгуур үзүүлэлт байдаг. Санхүүгийн харьцуулалт хийхийг хүсвэл дараахь үзүүлэлтийг харах хэрэгтэй. Үүнд: капиталын зардал, бэлэн мөнгөний урсгал, бэлэн мөнгө ба ноогдол ашгийн харьцаа, үйлдвэрлэлийн өмнөх шатны хөрөнгө, үйлдвэрлэлийн өмнөх шатны хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн өмнөх шатны орлого, нийт өр төлбөр ба урт хугацааны өр төлбөрийн харьцаа, зах зээлийн капиталжилт, цэвэр орлого ба орлогын харьцаа, нэг ажилтанд ноогдох цэвэр ашиг,

үйл ажиллагааны ашиг, хөрөнгийн өгөөж, өөрийн хөрөнгийн өгөөж, хувьцаа эзэмшигчийн өөрийн хөрөнгө ба нийт хөрөнгийн харьцаа, хувьцаа эзэмшигчийн өөрийн хөрөнгийн өгөөж, хувьцааны үнийн хэлбэлзэл, нийт хөрөнгө, нийт хөрөнгө оруулалт зарцуулалт, нийт орлого, үйлдвэрлэлийн дараахь шатны хөрөнгө, үйлдвэрлэлийн дараахь шатны хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн дараахь шатны орлого орно.

- ▶ Үйлдвэрлэлийн дараахь шатны үйл ажиллагааны харьцуулалт хийхийг хүсвэл нийт үйлдвэрлэл, бүс нутгаар задласан нийт үйлдвэрлэл, нөөцийн хэмжээ, нөөц ба үйлдвэрлэлийн харьцаа, газрын тосны гарц ба нийт газрын тос, байгалийн хийн гарцын харьцаа, түүхий нефтийн үйлдвэрлэл ба боловсруулах үйлдвэрийн хүчин чадлын харьцаа болон нэг баррель бүтээгдэхүүнд ноогдох үйлдвэрлэлийн дараахь шатны үйл ажиллагааны ашгийн харьцааг шалгах хэрэгтэй.
- ▶ Үйлдвэрлэлийн өмнөх шатны үйл ажиллагааны харьцуулалт хийхэд боловсруулсан бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн өсөлт, бүс нутгийн зах зээлд эзлэх хувь, боловсруулах үйлдвэрийн тоо, үндсэн орд газрын бүтээгдэхүүний борлуулалтын хувь, үндсэн орд газрын нийт боловсруулах хүчин чадлын хэмжээ, бүс нутгаар гаргасан бүтээгдэхүүний борлуулалт, бүс нутгаар гаргасан боловсруулалтын хүчин чадал, бүс нутгаар гаргасан боловсруулах зах зээлд эзлэх хувь, дэлхийн хэмжээнд байгаа жижиглэн худалдааны цэгийн тоо, нийт бүтээгдэхүүний борлуулалт, боловсруулах хүчин чадлын ашиглалтын хувь зэрэг үзүүлэлтээр олон сонирхолтой ажиглалт хийж болно.
- ▶ Өнөөдөр ихэнх газрын тосны томоохон компаниуд сонирхогч талуудынхаа байгаль орчин ба нийгмийн хэрэгцээг хангах аргуудыг заасан корпорацийн хариуцлагын буюу тогтвортой хөгжлийн тайлан гаргадаг.

Үндэсний газрын тосны компаниуд

- ▶ Хэдийгээр үндэсний газрын тосны компаниудаас мэдээлэл олж авахад илүү хэцүү ч тэдний ихэнх нь холбогдох мэдээлэл бүхий вэбсайтуудтай байдаг.

- ▶ Дагалдах мэдээллийг компанийн хөрөнгө оруулагчидтай харилцах хэлтэс, тухайн компанийн үйл ажиллагааг ажиглаж байдаг брокерийн газрын шинжээчид болон томоохон хувьцаа эзэмшигчидтэй нь утсаар ярьж тодруулж болно. Мөн цахим шуудангаар сэтгүүлчдэд зориулан өдөр бүр, долоо хоног бүр, сар бүр гаргадаг шинжээчдийн дүгнэлтүүд байдаг.
- ▶ Үйлдвэрлэлийн өмнөх эсвэл дараахь шатны үйл ажиллагааг хариуцсан гүйцэтгэх захирлууд, санхүүгийн ахлах ажилтнууд, эсвэл маркетинг ба борлуулалт хариуцсан гүйцэтгэх захирлуудаас ярилцлага авах хүсэлт тавь.
- ▶ Өдөр тутмын үйлдвэрлэлийн хэмжээг хянаж, экспортын хэмжээг дундаж үнээр нь үржүүлж орлогыг нь тодорхойл. Албан ёсны үйлдвэрлэлийн хэмжээ голдуу үнэн зөв биш буюу зарим тохиолдолд олж авах боломжгүй байдаг боловч эрчим хүчний олон сонин хэвлэл, олон улсын мэдээний агентлагууд дэлхийн ихэнх үйлдвэрлэгчдийн үйлдвэрлэлийн хэмжээний тооцоог нийтэлж байдаг. Мөн ОПЕК хоёрдогч эх сурвалжууд буюу сэтгүүлчдэд тулгуурлан гишүүдийнхээ өдөр тутмын үйлдвэрлэлийн хэмжээний талаар сар бүр тайлан гаргадаг.
- ▶ Түүнчлэн Оксфордын Эрчим Хүчний Институт, Олон Улсын Хэрэг ба Эрчим Хүчний Тагнуулын Роялын Институт, ПиЭфСи Энержи зэрэг эрчим хүчний чиглэлээр дагнан мэргэжсэн судалгааны хүрээлэн, зөвлөх компаниудын шинжилгээг олж авч болно. Тэдний вэбсайтууд дээрх олон судалгаа төлбөртэй байдаг ч хязгаарлагдмал хэмжээний мэдээлэл үнэ төлбөргүйгээр тавигдсан байгаа.

5. Газрын тосны гэрээний цагаан толгой: Лиценз-хөнгөлөлтийн гэрээ, хамтарсан үйлдвэр, бүтээгдэхүүн хуваах гэрээ

Женик Радон

Байгалийн нөөц баялаг ихтэй орнууд нийгэм, эдийн засгийн хөгжлийн сан бүрдүүлэхэд уг баялгаа ашиглах сонирхолтой байдаг. Олон засгийн газар энэ зорилгоор газрын тос, байгалийн хийг нь олборлон борлуулах сонирхолтой гадаадын компаниудтай гэрээ байгуулдаг. Зөв гэрээ хэлэлцээр байгуулах нь аливаа засгийн газрын байгалийн баялгийнхаа үр шимийг хүртэх хүчин чармайлтад амин чухал үүрэгтэй.

Энэ бүлэгт тус салбарын стандарт болсон өөр өөр төрлийн гэрээнд голлон анхаарахын зэрэгцээ гэрээ хэлэлцээрийн үед голдуу орхигддог олон нийтийн ашиг сонирхлыг хөндсөн чухал асуудлуудыг авч үзнэ. Хэвлэл мэдээллийн

хэрэгслүүд эдгээр асуудлын талаар мэдээлэх нь улс орондоо ямар төрлийн гэрээ хамгийн сайн тохирох талаар олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд зориулсан мэдээллээр хангах ач тустай.

Засгийн газрууд байгалийн нөөц баялгаа олборлон гаргах гурван боломжит хувилбар байдаг. Тэд Саудын Араб, Мексик, Венесуэл, Иран, Оман улсуудын адил хайгуул, олборлолт, боловсруулалт хариуцсан улсын компаниуд байгуулж болно. АНУ, Их Британи, Орос, Канад шиг байгалийн баялгаа олборлон гаргах ажилд хувийн компаниудыг урин оролцуулж болно. Эсвэл тэд Индонези, Нигери, Азербайжан, Казакстан шиг дээрх хоёр системийг хослуулан ашиглаж болно.

Гэрээний нөхцлүүдэд аливаа үйлдвэрлэгч улс байгалийн баялгаасаа хэр их орлого олохыг болон тухайн засгийн газар байгаль орчин, эрүүл мэндийн болон гэрээлэгчид хамаарах бусад стандартыг сахиулах зохицуулалтын эрх мэдэлтэй байх эсэхийг голдуу тодорхойлдог.

Засгийн газар олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалахад, тухайлбал газрын тосны хаягдал нийтийн хэрэглээний ундны усыг бохирдуулахгүй байх нөхцлийг хангах зэрэгт зохицуулалтын эрх мэдлээ ашиглах хэрэгтэй болно. Гэхдээ бас хүлээн авагч засгийн газрын хувьд эдийн засгийн болон ажлын байрны өсөлтийг хангахад чиглэсэн хөрөнгө оруулалтын эерэг уур амьсгал бий болгохоос гадна хөрөнгө оруулалтын хуулиуд гаргаж, хууль зөрчигсдөд хүлээлгэх шийтгэлийг тогтоож өгөх ёстой. Хүлээн авагч засгийн газрууд эдгээр харилцан зөрчилтэй эрэлт хэрэгцээг зөв тэнцвэржүүлж сурах хэрэгтэй.

Цаашлаад улам ярвигтай асуудал бол засгийн газар аливаа гэрээнд оролцогч талын хувьд ашиг орлогоо дээд цэгт хүргэхийг хичээж буй жирийн нэг бизнесийн байгууллага мэт ажиллах ёстой. Энэ нь засгийн газрыг өөрөө өөрийгөө зохицуулахад хүрсэн эвгүй байдалд оруулдаг. Мөн нөөц баялаг ихтэй хөгжиж байгаа орнуудын засгийн газрын хувьд зуу зуун чадварлаг хуульчдыг хөлслөн ажиллуулах давуу тал бүхий газрын тосны томоохон компаниудтай тэнцвэргүй байдалд хэлэлцээ хийхээс аргагүй байдал тулгардаг.

Гэрээнд анхаарвал зохих өөр нэг асуудал бол ихэнх эрчим хүчний гэрээ хэлэлцээрт асар их хөрөнгө оруулалтын зардал, их хэмжээний ашиг орлогоос үүдсэн авилгалын боломжууд их байдаг явдал юм. Аливаа яриа хэлэлцээ, гэрээний нөхцлийн талаар нийтэд ил болгосон мэдээлэл ихэвчлэн маш бага байдаг учраас хэлэлцээний ширээний ард сууж байгаа аль ч тал зохисгүй үйлдэл хийх боломжтой. Ихээхэн унацтай тендерт оролцож байгаа компаниуд голдуу зүсээ хувиргасан засгийн газрын албан тушаалтнууд, тэдний төлөөлөгчдөд тал засах үүднээс заримдаа хууль бус төлбөр хийсэн байдаг. Тодорхой нэг компани уралдаант шалгаруулалтад шалгарсан эсэхийг, эсвэл ямар нэг засгийн газрын албан

тушаалтантай ойр дотно холбоо сүлбээтэй эсэхийг тодорхойлох хэцүү. Хэрвээ тухайн засгийн газрын албан тушаалтан зохицуулагчийн үүрэг давхар гүйцэтгэдэг бол авилгал авах магадлал бүр ч их байдаг. Энэ төрлийн авилгал оролцсон эрүүгийн гэмт хэргийн мөрдөн байцаалт Ангол, Конго-браззавил, Казакстан болон бусад газарт явагдаад байна¹.

Газрын тосны гэрээ

Гэрээнүүд хэдийгээр агуулгын хувьд маш олон янз байдаг ч хоёр гол асуудлыг тогтсон байх ёстой. Үүнд засгийн газар ба оролцогч компаниудын хооронд ашгийг (заримдаа “түрээсийн төлбөр” гэж нэрлэдэг) хэрхэн хуваах вэ, зардлуудад яаж хандах вэ гэсэн хоёр асуудал байна.

Хэлэлцээг нарийн түвэгтэй болгодог зүйл бол дутуу эсвэл ташаа мэдээллээс үүсэх тодорхойгүй байдал өндөр түвшинд байдагт оршино. Гэрээнд гарын үсэг зурж байх үед уг талбайд хайгуул хийж, олборлолт явуулах зардал хэр их байх, уг зардлыг ирээдүйн газрын тос буюу байгалийн хийн үнээр нөхөж чадах эсэх, тухайн талбайд газрын тос, байгалийн хийн нөөц хэр их байгаа зэргийг газрын тосны компани ч тэр, хүлээн авагч засгийн газар ч тэр баталгаатай мэдэхгүй байх явдал нийтлэг байдаг. Ер нь, арван хайгуулын хүчин чармайлтын ес нь алдагдал хүлээдэг².

Компаниуд хөрөнгө оруулагчдын дотоод зардлыг нэмэгдүүлэх болзошгүй алдагдлаас өөрсдийгөө хамгаалахыг эрмэлздэг. Иймээс гэрээний яриа хэлэлцээний явцад хөрөнгө оруулагч ба засгийн газрын ашиг сонирхлын хооронд үндэслэлтэй бөгөөд харилцан хүлээн зөвшөөрөхүйц тэнцвэр олж тогтоохын төлөө чадварлагаар үнэ хаялцан тохиролцох шаардлагатай. Эдгээр яриа хэлэлцээний үед хүлээн авагч засгийн газрууд олон улсын санхүүгийн болон хууль эрхийн мэргэжилтнүүдэд хандаж зөвлөгөө авах явдал олонтаа тохиолддог.

Засгийн газраас гаргах шаардлагатай анхны шийдвэрийн нэг бол үйлдвэрлэлийн үйл явцын нөхцлүүдийг тогтооход чиглэсэн гэрээний системийн төрлийг сонгох явдал юм. Үүнд: лиценз буюу хөнгөлөлтийн гэрээ, хамтарсан үйлдвэр (ХҮ), бүтээгдэхүүн хуваах гэрээ (БХГ) гэсэн гэрээний системийн төрлүүд байдаг.

Гэрээний аль ч төрөл, ялангуяа арилжааны утга агуулгаараа, өөрийн гэсэн давуу ба сул талуудтай байдаг. Ижил төстэй төрлийн гэрээнүүд хүртэл гэрээний нарийн ширийн агуулгаараа ихээхэн ялгаатай байж болдог. Түүнээс гадна, лиценз-

хөнгөлөлтийн гэрээний болон БХГ-ний заалтууд бие биетэйгээ адилхан болж ирдэг нь бүр ч төөрөгдүүлдэг. Засгийн газар ба хөрөнгө оруулагчид гэрээний тохирсон нөхцлүүдээ нийтэд танилцуулах ёстой. Хэрэв ингэхээс татгалзаж байвал, ийм тохиролцоог олон нийтээс нуухад хүргэх зайлшгүй шалтгаан байхгүй учраас түүнийг нууцлах шаардлагын тухай асуулт тавигдах ёстой.

Концесс буюу лицензийн гэрээ

Концесс буюу лицензийн гэрээг анх 1900-аад оны эхээр нэг талт гэрээ байдлаар нэвтрүүлснээс хойш нилээд хувьсан хөгжиж ирсэн бөгөөд тэр үед өнөөгийн нөөц баялаг ихтэй олон орон бусад улс буюу эзэнт гүрнээс хараат, колони эсвэл тэдний ивээлд багтдаг байсан учраас гэрээ нэг талтай байв.

Ийм гэрээний орчин үеийн хэлбэрүүд нь голдуу тодорхой нэг орд газраас олборлох газрын тос буюу ашигт малтмалын нөөцөд ямар нэг тогтсон хугацаагаар хайгуул, олборлолт, боловсруулалт, борлуулалт хийх онцгой эрхийг аль нэг газрын тосны компанид олгох байдлаар илэрдэг. Ийм эрхийн лицензийг авахын тулд компаниуд уралдаант шалгаруулалтад үнэ хаялцан өрсөлдөхийн зэрэгцээ гэрээний урамшууллауд нэмж санал болгох нь олонтаа. Энэ төрлийн гэрээ дэлхийн хэмжээгээр нилээд түгээмэл бөгөөд Кувейт, Судан, Ангол, Эквадор гэх мэт янз бүрийн улс үндэстэнд хэрэглэгддэг.

Давуу талууд: Аливаа хөгжиж байгаа орны байр сууринаас авч үзвэл энд бодитой давуу талууд бий. Нэгдүгээрт, лиценз буюу концесс нь бусад төрлийн гэрээг бодвол илүү шулуун шударга бөгөөд ялангуяа үндсэн нөхцлүүдийг тогтоохдоо нийтийн тендерийн систем ашигладаг бол бүр сайн. Зайлшгүй шаардлагатай мэргэжлийн дэмжлэг, мэдлэг туршлагын түвшингийн хувьд хамтарсан үйлдвэрийн юмуу бүтээгдэхүүн хуваах гэрээнд шаардагддагийг бодвол тийм ч нарийн түвэгтэй бус. Гэхдээ концессийн тендерийн тогтолцоог боловсруулахад сайн санхүүгийн зөвлөхүүд шаардлагатай байгаа хэвээр байна. Мөн хүлээн зөвшөөрөгдөхүйц бөгөөд найдвартай эрх зүйн дэд бүтэц, түүний дотор нарийн түвэгтэй гэрээ хэлэлцээрийг тайлбарлан ойлгох чадвартай шүүхтэй байх шаардлагатай. Их Британи, Норвеги, Канад гэх мэт ихэнх аж үйлдвэржсэн орнуудад эрх зүйн тогтолцоо сайтар хөгжсөн учраас лиценз буюу концессийн гэрээндээ хүлээн авагч орны эрх зүйн тогтолцоонд буй хоосон орон зайг нөхөх заалт нэмж оруулах гэж зоволгүйгээр зөвхөн арилжааны нөхцлүүдээ голлон анхаарах боломжтой.

Лицензийн гэрээний санхүүгийн болон бусад нөхцлүүдийг хүлээн авагч засгийн газрын боловсруулсан төсөлд зааж өгөх бөгөөд түүнийгээ нийтэд зарлан,

тендерт өрсөлдөх компаниудад нээлттэй болгоно. Тендерт ялсан компани дуудлага худалдааны үнээ -ихэвчлэн лицензийн төлбөр ба/буюу гэрээний урамшуулал- төлөх бөгөөд эдгээр төлбөрийг тухайн газраас газрын тос олдож, арилжааны үйлдвэрлэл явагдсан эсэхээс үл хамааран хүлээн авагч засгийн газар авдаг.

Харин арилжааны үйлдвэрлэл явагдах тохиолдолд хүлээн авагч засгийн газар нийт орлогод тулгуурлан нөөц ашигласны төлбөр ба/эсвэл цэвэр орлогод тулгуурласан ашгийн татвар авах бөгөөд аль алинийг нь үйлдвэрлэлийн хэмжээ ба бүтээгдэхүүний борлуулалтын үнэд тулгуурлан тооцдог. Олборлолттой холбоотой бүх санхүүгийн эрсдэл, түүний дотор хайгуулын зардлыг тендерт ялагч өөрөө хариуцдаг. Товчоор хэлбэл, энэхүү уралдаант шалгаруулалтын систем нь санхүүгийн хүчин чадал сайтай, техникийн мэдлэг чадвартай боломжийн өрсөлдөгч компаниудын сонирхлыг татахгүй байгаагаас болж цаг хугацаа ба боломж алдахаас өөр ямар нэг ноцтой санхүүгийн болон бусад хүндрэл бэрхшээл хүлээн авагч засгийн газрын хувьд цөөн байдаг.

Сул талууд: Хөгжиж байгаа орны төдийгүй тендерт оролцогчийн байр сууринаас авч үзэхэд үүсэх гол сул тал бол арилжааны чанартай асуудал байдаг. Концесс олгохоор зарласан газарт чичирхийллийн судалгаа бүрэн хийгдээгүй байдаг учраас голдуу тэр газрын нөөц боломжийн тухай мэдлэг мэдээлэл дутагддаг талтай. Ингэснээр тухайн уралдаант шалгаруулалтын систем жирийн нэг дуудлага худалдаа болох нь олонтаа.

Газрын тосны компаниудын хувьд лицензийн үнэд хэр их үнэ хаяхаас хамаарч тооцоолсон эрсдэлийг үүрэхээс өөр сонголт байхгүй. Тухайн концесс нь уг компанийн зардлыг нөхөж, ашиг өгөх баталгаа байхгүй учраас үнийн саналынхаа хэмжээг тооцохдоо болгоомжтой хандах болно. Тухайн газрын тухай мэдлэг, баримт хангалтгүй байгаа тохиолдолд хүлээн авагч засгийн газар дуудлага худалдааны системээр боломжит ашиг орлогоо дээд цэгт хүртэл нэмэгдүүлж чадахгүй. Уралдаант шалгаруулалтын баримт бичигт холбогдох хөрөнгө оруулалтыг хийх буюу лицензээ алдах эрсдэлд учрах тогтоосон цаг хугацааг буюу наад захын үйл ажиллагааны хөтөлбөрийг зааж өгөх учраас шалгаруулалтад оролцогчид үнийн саналдаа илүү нухацтай, хамгаалалтын байдалтай хандах нь зүйн хэрэг.

Концессийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү бүлгийн төгсгөлд оруулсан Хайрцаг 1-ээс авна уу.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Лиценз буюу концессийн гэрээний талаарх асуултууд

Хэрвээ танай улсын засгийн газар ямар нэг лицензийн буюу концессийн гэрээнд орсон бол тухайн нөхцөл байдлыг илүү сайн ойлгохын тулд тавьж болох хэд хэдэн асуулт байдаг. Ийм асуултуудын заримыг ХҮ-үүд, БХГ-үүдэд мөн адил хэрэглэж болдог.

- Хэрвээ тендерийн нөхцлүүдийг нийтэд зарлан мэдэгдээгүй бол энэ мэдээллийн талаар болон нөхцлүүдийг нь яагаад нууцлаад байгаа талаар засгийн газрын албан тушаалтнуудаас асуу.
- Уг концесс хэр удаан хугацаанд хүчинтэй вэ? Хэдэн компани үнийн санал гаргасан бэ? Ялсан компани ямар үнэ төлөхөөр тохирсон бэ? Концессийн лицензийг боловсруулах ажилд гадны ямар мэргэжилтнүүд засгийн газарт зөвлөгөө өгсөн бэ?
- Үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжих хугацаа хэр урт вэ, ялагч компани хэр их хөрөнгө оруулалт хийхээр тохирсон бэ? Байгаль орчны ямар стандартууд мөрдөх вэ, эдгээр стандартын мөрдөлтийг ямар байгууллага хянах вэ? Байгалийн баялаг олборлох газраас нутгийн иргэдийг ямар нэг байдлаар нүүлгэн шилжүүлэх үү?
- Төв засгийн газар ба орон нутгийн засгийн газрын хооронд ашиг орлогыг хэрхэн хуваах вэ?

Компанид зориулсан асуултууд

- Тухайн концесст зориулж хэр их мөнгө, хэнд төлөх вэ? Концессийн гэрээний нөхцлүүдийг нийтэд ил болгож мэдэгдэх үү? Компанийн ажилтнууд энэ концессийг авахын тулд ямар нэг засгийн газрын албан тушаалтан буюу түүний гэр бүл, найз нөхдөд бэлнээр буюу бэлэн бусаар төлбөр төлөөгүй гэдгээ нийтэд нотлон харуулах уу? Дотоодын гүйцэтгэгч компаниудыг ямар шалгуураар сонгож гэрээ байгуулах вэ?

Хамтарсан үйлдвэрүүд

Хамтарсан үйлдвэрийн (ХҮ) тухай нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тодорхойлолт буюу утга агуулга байхгүй учраас бэлэн тайлбар, тодорхойлолтуудаас авч хэрэглэж болно. ХҮ гэдэг нь энгийнээр хэлвэл цаашид тодруулах шаардлагатай зарим хэлбэрээр хамтын үйл ажиллагаа явуулахыг хүсч байгаа хоёр буюу түүнээс дээш тал гэсэн үг. “Хамтарсан үйлдвэрийг орчин үеийн гэрлэлтийн үйл явцтай харьцуулж үзвэл хамгийн сайн ойлгож болно... Энд танилцаж дотносох хугацаа гэж байна. ... Хамтарсан үйлдвэрт оролцогч талууд бие биеийнхээ зорилго, ашиг сонирхол, бизнесийн арга барилыг мэдэж, ойлгодог байх шаардлагатай. Ийм ойлголтгүйгээр бодитой хэрэгжихүйц сүй тавих гэрээний төсөл (ө.х, хамтарсан үйлдвэрийн гэрээнүүд) боловсруулах боломжгүй. Орчин цагийн гэрлэлтэд тохиолддог бүтэлгүйдэл буюу амжилт муутай байдал ч бизнесийн хамтарсан үйлдвэрүүдэд мөн адил тохиолддог³.”

Ийнхүү энэ төрлийн бүтцийг тодорхойлох нээлттэй байдлаас үзэхэд ХҮ-үүдийн хэлбэрийг газрын тосны компани ба хүлээн авагч засгийн газрын хооронд байгуулдаг үндсэн гэрээ болгон ашиглах явдал нийтлэг бус гэхэд гайхах зүйлгүй юм. Харин Нигери улс үндэс үл хамаарах өвөрмөц онцлогтой: тус улсын үндэсний газрын тосны компани ХҮ-ийн санхүүгийн үүрэг хариуцлагын өөрт ноогдох хэсгийг ханган биелүүлж чадахгүй болтлоо энэ хэлбэрийг илүүд үзэж иржээ. Одоо бол Нигерид хийгдсэн шинэ гэрээнүүдийн ихэнх нь БХГ-нүүд байна.

ХҮ-ийн онцлог бол шийдэх асуудлуудын жагсаалт урт байдаг оршино. Аливаа ХҮ-ийн оролцогч талууд ХҮ болж нэгдэн орохын өмнө материаллаг асуудлуудаа урьдчилж шийдэлгүйгээр бүх зүйлийг хамтран хийхийг шаарддаг учраас санал зөрөлдөх буюу санал тэнцэж болзошгүй байдлыг зөвхөн хойш тавихаас аргагүйд хүрдэг. Энэ байдал ялангуяа 50, 50 хувийн оролцоотой үед их гардаг. ХҮ-үүд бүх асуудлыг нарийвчлан авч хэлэлцсэн, талууд бие биетэйгээ хэрхэн ажиллахаа тохирсон байхын тулд урт удаан хугацаанд цаг сунган уйгагүй ярьж хэлэлцэх шаардлагатай байдаг.

Давуу талууд: Аливаа засгийн газрын хувьд ХҮ байгуулахын цорын ганц давуу тал бол ямар нэг төслийн төлөө шийдвэр гаргах, хариуцлага хүлээхэд ганцаарддаггүй явдал юм. Энэ талаар засгийн газар газрын тосны томоохон компанийн мэдлэг туршлагад найдаж болдог. Засгийн газар татвар, нөөц ашиглалтын төлбөр зэрэг бусад урамшуулал хүртэхээс гадна ашгаа хувааж авах болно.

Сул талууд: Хуваалцах нь бас сул талтай. Тэгвэл хүлээн авагч засгийн газрыг байгалийн баялгийн олборлолтод шууд, хариуцлагатай оролцогч болгох үүднээс эрсдэл ба зардлуудыг ч бас хуваалцах ёстой. Хариуцлагатай байдал нь бас байгаль орчны сүйрлийг агуулсан болзошгүй үүргийг авчирдаг.

Хамтарсан үйлдвэрийн онцлог шинжүүд

- ▶ ҮГТК (Үндэсний газрын тосны компани) ба ОУГТК (олон улсын газрын тосны компани) хоорондын түншлэл
- ▶ ҮГТК, ОУГТК хоёр эрсдэл ба зардлаа хувааж хариуцана
- ▶ Жишээ: Нигери, Норт Вест Шелф (Австрали), Орос

Цэвэр ХҮ

Бүх зардал, эрсдэлийг хуваалцана

Ердийн ХҮ

Засгийн газар хайгуулын ажил хүртэл даана

Бүрэн гүйцэтгэх ХҮ

Засгийн газар хайгуул, үйлдвэрлэл хүртэл бүрэн хариуцана

Хуучин ЗХУ маягийн ХҮ

Засгийн газар нөхөн сэргээлт, хөгжлийн ажил хүртэл, үйл ажиллагааны бэлэн мөнгөний урсгал хүртэл хариуцана.

ҮГТК ←

→ ОУГТК

Эрсдэл хуваалт

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Хамтарсан үйлдвэрийн тухай асуултууд

“ХҮ” гэдэг нэр томъёог дөнгөж танилцуулах төдийд л сэтгүүлчдийг засгийн газрын болон компанийн ажилтнуудаас асуулт асуухад хүргэж байх ёстой.

- ▶ Уг ХҮ-ийн гол зорилго юу вэ? Хайгуул уу, олборлолт уу, үйл ажиллагаа юу?
- ▶ Тал бүр ямар хувь нэмэр оруулах вэ, тухайлбал бэлэн мөнгө, ноу хау, менежмент гэх мэт? Тал бүр ямар ашиг хүртэх вэ? Тал бүрийн хүлээх үүрэг хариуцлага юу вэ, үйл ажиллагаа юу, борлуулалт уу, мөн/эсвэл төрийн зохицуулалт уу?
- ▶ Уг ХҮ хэр удаан оршин тогтнох вэ? Уг ХҮ-ийн эрх зүйн үндсийг бүрдүүлэгч ямар гэрээ хэлэлцээрүүд байна вэ: тухайлбал, ХҮ-ийн засаглалын нөхцлүүдийг заасан үүсгэн байгуулах гэрээ, газрын тосны талбай дээрх үйл ажиллагааг хэрхэн удирдаж явуулах болон бусад асуудлын тухай заасан үйл ажиллагааны гэрээ гэх мэт.
- ▶ Уг ХҮ-ийн үйл ажиллагаа хэрхэн дуусгавар болох буюу татан буугдах вэ? Нэг тал нь нөгөөгийнхөө эрхийг дангаар залгамжлан үлдэж болох уу, ямар тохиолдолд тэгэх вэ?
- ▶ Яагаад хамтарсан үйлдвэрийн хэлбэрийг сонгосон бэ? ХҮ-ийн хэлбэр ашиглах шийдвэр нь өөрөө, яагаад хүлээн авагч засгийн газар эрсдэл хуваана гэж, улмаар дараа дараагийн санхүүгийн хариуцлагыг хүлээнэ гэж бодож, уг гэрээг хүлээн зөвшөөрсөн тухай үндэслэл биш юмаа гэхэд тайлбар гаргаж өгөхийг шаарддаг. Аливаа ХҮ-ийн шинээр боловсруулж, хэлэлцэн тохирсон нөхцөл бүрийг бараг заалт бүрээр нь иж бүрэн нягтлан шалгах шаардлагатай.
- ▶ Засгийн газар энэхүү нэмэлт эрсдэл, үүрэг хариуцлагыг хүлээснийхээ хариуд юу хүртэж байна вэ?

ХҮ-ийн хэлбэр өөрөө хоёрдмол утгатай байдаг түүний гол сул тал оршино. Мөн яриа хэлэлцээг нарийн түвэгтэй, эрчимтэй болгож өгдөг. ХҮ нь бусад ямар ч гэрээнээс илүү гарах өвөрмөц давуу тал байхгүй бөгөөд илүү өргөн хүрээг хамарсан яриа хэлэлцээ шаардаж магадгүй юм. Товчоор хэлбэл, ХҮ-ийн хэлбэр нь газрын тосны гэрээний мэргэжилтнүүдээс илүү их хуулийн зөвлөгөө авахыг шаардах бөгөөд энэ нь засгийн газар ба компаниудад өндөр өртөгтэй тусдаг. Түүнээс гадна ХҮ нь яриа хэлэлцээ хийхэд ихээхэн хугацаа зарцуулдаг.

Бүтээгдэхүүн хуваах гэрээ

Бүтээгдэхүүн хуваах гэрээг (БХГ) анх 1966 онд Индонезид хэрэглэжээ. Хэдийгээр Индонези улс 1945 онд тусгаар тогтнолоо тунхагласан боловч Данийн колонийн үеийн уул уурхайн хууль болох Индише Мийнветэд тулгуурласан гадаадын газрын тосны компаниудын үйл ажиллагаа явагдсаар байлаа⁴. Харин үндсэрхэг үзэл сэргэмэгц лиценз, концессийн арга бол империалист, колонийн үеийн арга барил хэмээн үл итгэх болсон байна. Засгийн газар шинээр концесс олгохоо зогсоож, харин нөөц баялгийг төр өмчилж, ашиг хуваах системийн талаар яриа хэлэлцээ хийдэг “Индонезийн дүрэм” гэгчийг нэвтрүүлсэн нь өнөө үед БХГ гэдэг нэрээр олны танил болжээ. Анхандаа гадаадын компаниуд энэхүү өөрчлөлт нь хуулийн урьдач жишээ буюу жишиг үүсгэж, улмаар бусад газрын концесст нөлөөлж болзошгүй хэмээн эмээж түүнийг хатуу эсэргүүцэж байсан байна. Гэвч бие даасан компаниуд БХГ-нд ороод ирмэгц, томоохон компаниуд дагахаас өөр арга байсангүй.⁵ БХГ-нүүд дэлхий дахинд түгэн дэлгэрч одоогийн байдлаар, ялангуяа Төв Ази, Кавказид бизнес эрхлэх нийтлэг нэг хэлбэр болоод байна⁶.

БХГ-нд байгалийн нөөц баялгийг төр эзэмшинэ гэдгийг хүлээн зөвшөөрөхийн зэрэгцээ гадаадын корпорациуд газрын тосны талбай дээрх үйлдвэрлэлийг удирдан явуулахыг зөвшөөрдөг⁷.

БХГ-ний дагуу хайгуул, үйлдвэрлэлийн ихэнх санхүүгийн эрсдлийг газрын тосны компани өөрөө хариуцдаг. Төр ч бас зарим эрсдэлтэй тулгардаг. БХГ-нд голдуу ҮГТК хувь эзэмшигч болж консорциумд нэгддэг бөгөөд уг гэрээний дагуу олгосон талбайд үйлдвэрлэл явуулж байгаа консорциумд олсон ашгийнхаа зарим хэсгийг “хувь эзэмшлийн хөрөнгө” болгон нэмэрлэдэг. Хүлээн авагч засгийн газрын хувьд анхны хувь нийлүүлэх хөрөнгийн зардлыг бусад компанийн тусламжтайгаар “гаргадаг” явдал олонтаа. Энэхүү гаргасан зардлыг БХГ-ний дагуу хүлээн авагч засгийн газрын ирээдүйд олох ашиг орлогоос тухайн компаниудад эргүүлж төлөх юм.

Хэрвээ засгийн газар өөрийн хувь эзэмшлийн хөрөнгийг гаргахыг зөвшөөрөхгүй байвал газрын тосны компаниуд өөрсдөө илүү их хувь эзэмшихээр

тохиролцохыг хичээнэ. Эзэмших хувийн зохистой буюу үндэслэлтэй хэмжээг тогтоох шинжлэх ухааны ямар нэг тодорхойлогч байхгүй учраас хэрхэн яаж хуваахыг хатуухан наймаалцсаны үр дүнд хэлэлцэн тохирдог.

БХГ-ний онцлогууд

- ▶ Анх 1960 онд Индонезид хэрэглэж эхэлсэн
- ▶ Ажиллах үүрэг
- ▶ Урамшууллын төлбөр
- ▶ Нөөц ашигласны төлбөр
- ▶ Үйлдвэрлэлийн зардлын нөхөлт (Газрын тосны зардал)

Ашиг- Газрын тосны зардал = Газрын тосны ашиг

- ▶ Газрын тосны ашгийг компани, хүлээн авагч засгийн газар хоёр хуваана
- ▶ Хэр сайн наймаалцахаас тухайн орны нийт эзэмшлийн хувь хамаарна
- ▶ Хөгжиж байгаа орнууд одоо БХГ-г илүүд үзэж байна

БХГ-ний санхүүгийн нөхцлүүд лицензийн гэрээнийхтэй төстэй боловч бүтэц нь өөр учраас санхүүгийн үр дүн нь ч өөр гарахад хүргэж болно. Засгийн газар гэрээний урамшуулал авах явдал олон байдаг ч үүнээсээ татгалзах буюу ирээдүйн ашгаас хүртэх хувиа нэмэгдүүлэх тохиролцоо тогтмол хийгддэг. Газрын тосны компанийн хувьд юуны өмнө үйл ажиллагааны урсгал зардлуудаа болон капиталын хөрөнгө оруулалтаа нөхөж авах эрхтэй. Ийм урсгал зардалд тухайн жилд ашигласан буюу хэрэглэсэн материалын зардлууд, харин капиталын хөрөнгө оруулалтад байшин барилга, тоног төхөөрөмж, компьютер гэх мэт удаан эдлэгдэх хөрөнгийн зардлууд орно. Урсгал зардлын хувьд тухайн зардал гарсан жилд нь буюу тэр дор нь нөхөөд байдаг бол капиталын хөрөнгө оруулалтын зардлыг олон жилийн хугацаанд хуваан нөхдөг. Мөн ном сурах бичиг, хөдөлмөрийн багаж гэх мэт тодорхой зүйлсийг үйл ажиллагааны зардал эсвэл капиталын зардал болгох ёстой талаар нягтлан бодогч нар янз бүрийн үндэслэлтэй дүгнэлтэд хүрч болохуйц саармаг хэсэг байдаг.

Компани жилийн орлогоосоо үйл ажиллагааны зардал, капиталын зардал хоёроо нөхөөд үлдэж байгаа хэсгийг зохих тохирсон хувийн дагуу засгийн газартай хуваадаг.⁸ Гадаадын компанийн хувьд өөрт ноогдох ашгаасаа татвар төлөх ёстой боловч хүлээн авагч засгийн газар түүнийг нь авахаас татгалзаж, харин тухайн компанийн эзэмших хувийг тохирохдоо уг хувьд оруулж тооцдог явдал олонтаа байдаг.

Өнөөдөр БХГ-нүүд хувьсан хөгжиж өөр хоорондоо адил төстэй болсон боловч зөвхөн ашиг хуваах үндсэн зарчимд тулгуурласан маш олон янзын хувилбар бий болсон байна. Тэдгээр нь эрчимтэй яриа хэлэлцээний үр дүн бөгөөд тухайн нөхцөл байдалд оролцогч тал бүрийн санаа зовоосон асуудал, ашиг сонирхлууд харилцан адилгүй байх нь мэдээж учраас ийм ялгаа үүсэхэд гайхах зүйлгүй.

БХГ-ний нарийн түвэгтэй байдал нь аливаа улсын хууль эрхийн орчин сайтай байдлаас хамаардаг. Тухайлбал, ямар нэг улсад газрын тосны үйл ажиллагааг зохицуулах үндсэн дүрмүүд байхгүй бол ихэвчлэн хуулиар зохицуулдаг энэ асуудлуудыг БХГ-нд хөндөн авч үзэх шаардлагатай болно. Товчоор хэлбэл, аливаа улсын эрх зүйн тогтолцоо хэдийчинээ найдвар багатай, урьдаас тааварлашгүй байх тусам БХГ-ний хүрээнд төдийчинээ олон асуудлыг хамруулан, зааж өгөх шаардлагатай гэсэн үг.

Хүлээн авагч засгийн газрын давуу тал: Санхүүгийн болоод үйл ажиллагааны бүх эрсдэл олон улсын газрын тосны компанид үлддэг. Яриа хэлэлцээний зардлаас (голдуу зөвлөхийн зардал) өөр эрсдэлтэй алдагдал хүлээн авагч засгийн газарт учрахгүй. Хэрвээ хайгуул буюу үйлдвэрлэлийн төсөл нурах юм бол хүлээн авагч засгийн газар ямар нэг материаллаг алдагдал хүлээхгүй, сайндаа л нэг боломжоо алдаж байна гэсэн үг. Засгийн газар БХГ-гээ сайн боловсруулсан тохиолдолд ямар нэг төсөл хайгуул, үйлдвэрлэлийн хөтөлбөрт заасан нөхцлүүдийнхээ дагуу хийгдэхгүй байвал уг гэрээг цуцлах буюу өөр газрын тосны компанид шилжүүлж болдог. Мөн хүлээн авагч засгийн газар ямар нэг хөрөнгө оруулалт хийхээр тохироогүй тохиолдолд ямар ч хөрөнгө оруулалт хийлгүйгээр аль ч боломжит ашгийг хуваан хүртэх нэмэлт давуу талтай байна.

Хэрвээ тухайн БХГ-г хууль болгон баталсан бол энэ нь олон улсын газрын тосны компаниудын хувьд эрх зүйн баталгаа болох бөгөөд Азербайжан болон хуучин зөвлөлтийн бүгд найрамдах улсуудад хэрэглэгдэж байгаа шинэлэг арга юм. Харин засгийн газрын байр сууринаас авч үзвэл энэ арга нь аливаа гэрээг оролцогч талууд хялбархан өөрчилж болох уян хатан хэрэгсэл байсныг зөвхөн парламентаар батлуулан өөрчилж болдог “уян хатан бус” хууль болгон хувиргадаг талтай. Олон тохиолдолд БХГ нь энд хөндөгдөж буй асуудлуудтай холбоотой

одоогийн ба ирээдүйн бүх хуулиудын дээр тавигддаг. Иймээс хэрэв дээр дурдсан хууль, зохицуулалтууд нь БХГ-ний дагуу газрын тосны компанийн эдлэх эрхэд сөргөөр нөлөөлөхөөр байвал засгийн газар олон нийтийн ашиг сонирхолд нийцүүлэн шинээр хууль тогтоомж, зохицуулалт гаргах эрхээсээ татгалзаж буулт хийх болдог.

Урамшуулал

- ▶ **Гарын үсгийн урамшуулал**
Гэрээнд гарын үсэг зурагдсаны дараа төлөгдөнө
- ▶ **Нээлт хийсний урамшуулал**
Анхны нээлт хийсний дараа төлөгдөнө
- ▶ **Үйлдвэрлэлийн урамшуулал**
Үйлдвэрлэл тодорхой түвшинд хүрсний дараа хийгдэх төлбөр
 - ▶ Газрын тосны компанийн хувьд түгээмэл бус
 - ▶ Газрын тосны компани орлогын өндөр татварыг илүүд үздэг

Хүлээн авагч засгийн газрын сул тал: Бүгдийг нэг дор багтаасан баримт бичгийн хувьд БХГ-ний онолын уян хатан байдал нь бас нэг сул тал юм. Энэ нь маш өндөр түвшний мэргэжлийн яриа хэлэлцээ шаардахын зэрэгцээ тухайн засгийн газар техникийн, байгаль орчны, санхүүгийн, худалдааны, хууль эрх зүйн гээд олон талын мэдлэг туршлагатай байхыг шаарддаг. Санхүүгийн заалтуудыг боловсруулахдаа, хэдийгээр нарийн мэдээлэл бэлэн байхгүй байлаа ч гэсэн тухайн газрын тосны талбайн нөөц бололцоог зөв үнэлэх ёстой. Үнэнийг хэлэхэд, хүлээн авагч засгийн газар газрын тосны компаниудыг бодвол мэдээллийн сан, техникийн болон худалдааны мэдлэгээр нилээд дулимаг байх явдал элбэг байдаг.

Хамгийн гол нь, тухайн хүлээн авагч засгийн газар эзэмшил хувь буюу урамшууллынхаа нилээд хэсгийг ашгаар дамжуулан шууд авч байгаа тохиолдолд БХГ нь уг засгийн газрыг өөртэйгөө зөрчилдөхөд хүргэдэг. Засгийн газрын хувьд илүү өндөр ашиг хүртэх хүсэл сонирхлоо байгаль орчны болон бусад хууль тогтоомжуудыг сахиулах үүрэгтэйгээ уялдуулах шаардлагатай байдаг. Байгаль орчны хууль тогтоомж сахиулах зардал нь ашгийн хувийг багасгахад хүргэдэг. Түүнчлэн, компани өөрөө хэдийчинээ бага ашиг хүртэнэ, төдийчинээ бага татвар

засгийн газарт төлдөг. Гэхдээ, БХГ-ний нөхцөлд зааснаар бол хүлээн авагч засгийн газар хамгийн наад зах нь газрын тосны талбай дээрх үйл ажиллагаанд идэвхгүй шийдвэр гаргагч байдлаар оролцдог сул талтай.

Түүнчлэн, байгаль орчны болон бусад стандарт гэрээний заалт болж орсон тохиолдолд тэдгээрийг мөрдөх уян хатан боломжийг хүлээн авагч засгийн газар БХГ-гээр дамжуулан газрын тосны компаниудад олгодог. Гэрээний заалт нь хууль тогтоомж буюу дүрмийг бодвол тойруулж маргахад илүү хялбархан, тэр ч байтугай түүнийг зөрчиж болдог. Шалтгаан нь тун энгийн. БХГ-ний заалтыг зөрчих, тэр ч байтугай байгаль орчны тухай заалтыг зөрчих нь зөвхөн гэрээний зөрчил байна. Ихэвчлэн зөрчил гаргагч тал зөвхөн уг зөрчлөө арилгах, магадгүй бүр хохирлыг нөхөн төлөх шаардлагатай байх болно. Харин ямар нэг ноцтой бөгөөд материаллаг зөрчил гарсан тохиолдолд л тухайн гэрээг цуцлах боломжтой.

Түүнээс гадна, зөрчил гаргагч тал энэ зөрчил бол нөгөө талын үйлдэл буюу эс үйлдлийн шууд үр дүн хэмээн маргаж болох юм. Аливаа гэрээний заалтыг зөрчих явдал бол гэрээг хэлэлцэн тохирох үйл явцыг өргөтгөсөн хэлбэр бөгөөд хэдийгээр илүү ёжтой ч гэсэн гэрээг дахин хэлэлцэхэд хүргэж болно. Нөгөө талаас, хууль тогтоомж зөрчинө гэдэг бол гэмт үйлдэл бөгөөд хуулиар тогтоосон шийтгэл хүлээх, тэр ч байтугай олон түмнээс ял зэм хүртэх боломжтой. Харин гэрээний зөрчил бол хувийн асуудал.

Дээр нь, БХГ-г аливаа орны парламентаар хэлэлцүүлэн батлуулсан тохиолдолд гэрээнд оролцогч аль ч талын уян хатан байдлыг хязгаарлаж, гэрээний аливаа өөрчлөлтийг заавал парламентаар батлуулах шаардлагатай болдог. БХГ ч бас нэг төрлийн гэрээ учраас тодорхойгүй зүйлсийг засгийн газар ба газрын тосны компаниуд харилцан хэлэлцэн шийдвэрлэж байх шаардлагатай болно. БХГ-г гэрээ төдийгүй хууль болгосноор засгийн газар зарим үүрэг хариуцлагаа газрын тосны компаниудад шилжүүлэхийн зэрэгцээ уян хатан байдлаа нилээд алдаж байна гэсэн үг.

Цаашилбал, гэрээг хууль болгох явдал нь хууль эрхийн дэд бүтцэд нэг удаагийн онцгой нөхцөл байдлууд бий болгодог бөгөөд үүнээс болж тухайн улсын хөрөнгө оруулалтын уур амьсгал муудахад хүргэдэг. БХГ-нүүд нь ямар ч ерөнхий эсвэл зарчмын хуулиудын дэргэд онцгой тохиолдол болж үлддэг учраас БХГ-нүүдээ хууль болгосон Азербайжан улсад эрх зүйн харилцан уялдаатай, өргөн дэлгэр тогтолцоо бүрэлдэн хөгжих боломж бага байна. Товчоор хэлбэл, ийм БХГ нь эрх зүйн эерэг ялгаварлан гадуурхалтын нэг хэлбэр буюу газрын тосны компаниудад онцгой эрх олгосон хэрэг юм. Аялал жуулчлал, банк, томоохон хэмжээний газар тариалан гэх мэт бусад салбарт хөрөнгө оруулагчид ч хүлээн авагч засгийн газар ба парламентад нөлөөлж үүнтэй адил онцгой хандахыг хүсэх

нь дамжиггүй. Үүний цэвэр үр дүн бол эрх зүйн эмх замбараагүй байдал ба ерөнхийдөө хуулийг үл хүндлэх явдал юм.

Засгийн газрын авах хувь

Олон гэрээнд компаниуд хүлээн авагч засгийн газарт гэрээний урамшуулал төлөхийг шаарддаг. Дараа дараагийн урамшуулал нь хайгуул буюу үйлдвэрлэлийн тодорхой шатанд хүрэх үеэс хамаарч болно.

Гэрээндээ дотоодын хөрөнгө оруулалтын заалт оруулах нь үнэн хэрэгтээ хүлээн авагч оронд нилээд үнэтэй тусч болох юм. Учир нь, газрын тосны компаниуд дотоодын үйлдвэрлэлд ийм хэлбэрийн татаас олгосны төлөө БХГ-ндээ илүү хөнгөлөлт үзүүлэхийг хүсэх болно. Ихэнх тохиолдолд, засгийн газар олсон ашгийнхаа хэсгийг ажилчдыг сургах буюу дотоодын бизнес эхлэн эрхлэгчдэд арилжааны зээл олгох зэргээр ашиглах нь илүү хялбар бөгөөд ил тод байдаг.

Эх газрын ба гүн усны нөхцөл дэх засгийн газрын авах хувь⁹ (хувиар)

Улс	Эх газрын	Гүн усны
Португали	43.2	39.7
Луизана муж улс	69.3	47.2
Тайланд	67.0	57.5
Нигери	84.8	64.2
Малайз	89.4	68.1
Индонези	89.8	81.1

Ер нь тухайн улсын засгийн газар нөөц баялгийнхаа эзэн нь учраас түрээсийн орлогынхоо дийлэнх хэсгийг авах хууль ёсны эрхтэй. “Засгийн газрын авах” буюу авч үлдэж байгаа орлогын хувь олон хүчин зүйлээс, түүний дотор тухайн хөрөнгө оруулалт нь компаниудын хувьд санхүүгийн, худалдааны, улс төрийн, байгаль орчны талаасаа хэр эрсдэлтэй болох, дэлхийн хэмжээнд тэдгээр компаниудад зориулсан өөр төслүүд элбэг байгаа эсэх, хэлэлцэн тохирох үед газрын тосны зах зээл дээр зонхилж байсан үнэ зэргээс хамаардаг.

Аливаа төслийн ашигт ажиллагаанаас засгийн газрын авах хувь хамаарч болно. Иймд, хөрөнгө оруулалт амжилттай байгаа тохиолдолд тухайн баялгийг олборлож, үйлдвэрлэх сонирхолд сөргөөр нөлөөлөхгүйгээр засгийн газрын орлого нэмэгдэж болно. Гэвч практик дээр аливаа төсөлд оруулсан хөрөнгө оруулалтаас бодитойгоор олох үр ашигт яв цав нийцсэн татварын тогтолцоо бүрдүүлнэ гэдэг тун хэцүү мэт байдаг.

Нефтийн орлогын сангаас авах татварыг урьдчилан тодорхойлох боломжгүй учраас аливаа компани зөвхөн тухайн татварын тогтолцооны үзүүлэх нийт үр нөлөөг төдийгүй тухайн орд газрын ашиглалтын янз бүрийн хугацааны үеүдэд ноогдох татварын ачааллын талаар (татварын бүтэц) санаа тавих болно¹⁰.

Яагаад засгийн газрын авах хувь ийм байгааг ойлгохын тулд орд газар бүрийн онцлогийг харгалзах ёстой: Эх газарт уу, далай дээр үү? Гүехэн усанд уу, гүн усанд уу? гэх мэт. Мөн тухайн орны геологийн түүх ч чухал: Томоохон, харьцангуй хөгжсөн газрын тосны салбартай Норвегид уу? Азербайжаных шиг арай жижиг, шинэ газрын тосны орд газар уу? Хөрөнгө оруулалтын эрсдэл их байх тусам ашгийн хувь илүү их байхыг компаниуд шаарддаг.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Бүтээгдэхүүн хуваах гэрээний тухай асуултууд

Лицензийн гэрээний талаар асуусан зарим асуултаас гадна хөрөнгө оруулагчдыг хэрхэн олж тогтоон, сонгосон тухай сэтгүүлчид засгийн газрын албан тушаалтнуудаас асуух ёстой.

- ▶ Уралдаант шалгаруулалт байсан уу?
- ▶ Засгийн газар ямар ямар төрлийн төлбөр хүлээн авах вэ? Урамшууллууд байх уу? Уг урамшууллууд хэзээ, ямар хэмжээгээр төлөгдөх вэ?
- ▶ Компаниуд өөр ямар төрлийн төлбөрүүд хийх вэ? Ямар нөхцлүүд тавигдах вэ? Тухайн компаниуд татвар төлөх үү, тийм бол хэдэн хувийн татвар төлөх вэ? Тэд үйлдвэрлэл эхэлмэгц нөөц ашигласны төлбөр төлж эхлэх үү?
- ▶ Компаниуд үйл ажиллагаа явуулж байгаа газраа эмнэлэг, сургууль барих зэргээр нутгийн ард иргэдэд хөрөнгө оруулах үүрэгтэй юу? Орон нутгийн хөдөлмөрчдийг татан оролцуулах уу? Тэднийг сургах уу? Хэрвээ тийм бол, ийм үүрэг амлалт авсных нь төлөө засгийн газраас татварын буюу бусад хөнгөлөлт үзүүлэх үү? Энэ үүрэг амлалт нь ашгаас хасагдах зардал уу, аль эсвэл татварын үүргээс нэг бүрчлэн хасагдах хөнгөлөлт байх уу?
- ▶ Хүлээн авагч засгийн газар газрын тосны компаниудтай ашгаа хэрхэн хуваах вэ?
- ▶ Байгаль орчинд учруулсан хохирлын зардалд яаж хандах вэ? Тэдгээр нь хасагдах зардал байх уу? Тэдгээр нь бүх тохиолдолд, түүний дотор газрын тосны компаниудын хайхрамжгүй үйл ажиллагаанаас болсон ч гэсэн хасагдах зардал байх уу? Ийм зардлуудыг газрын тосны компаниуд дангаараа хариуцах уу? (Хэрвээ засгийн газар байгаль орчны хор хохирлын зардлыг хуваалцдаг бөгөөд улмаар түүний хүртэх ашгийн хувь буурдаг бол үүний үр дүнд байгаль орчны хууль тогтоомжуудын хэрэгжилт сул болоход хүрдэг.)

- ▶ Дотоодын гүйцэтгэгчдэд тавигдах гэрээний шаардлагуудын талаар засгийн газрын болон компанийн төлөөлөгчдөөс асуу. (БХГ-нүүдэд тодорхой хэмжээний материал, түүхий эдийг дотоодын нийлүүлэгчдээс ханган нийлүүлэх заалтууд орох нь олонтаа. Иймд хээл хахууль, тал тохой татах явдлаас ангид байх нөхцлийг хангахын тулд дотоодын нийлүүлэгчдийг сонгох шалгуурууд ил тод байх ёстой.)
- ▶ Компаниуд ба засгийн газрын хооронд орлого, зардлуудыг хэрхэн тооцоолж, хуваах вэ? (Компаниуд юуг зардал гэж тооцох нь засгийн газарт очих мөнгөний хэмжээнд ихээхэн нөлөөлдөг. Аляскад компаниудын нягтлан бодох бүртгэлийн практикийн эсрэг хууль ёсны нэхэмжлэл гаргасан нь тус муж улсад 6 тэрбум ам.долларын нэмэлт орлого оруулжээ¹¹.)
- ▶ Элэгдэл хорогдол тооцох хувь нь хэд вэ, энэ нь бусад орнуудын туршлагатай харьцуулахад ямар байна вэ? Газрын тосны үнийг яаж тооцоолж байна вэ?

Хэрвээ танай оронд буй БХГ-нүүд нийтэд зориулсан баримт бичиг биш бол засгийн газар болон компанийн төлөөлөгчдөөс яагаад энэ мэдээллийг олон нийттэй хуваалцахгүй байгааг асуу. (Азербайжан гэх мэт зарим оронд БХГ-нүүдийг нийтэд ил болгодог ч зөвхөн хууль болон батлагдсан учраас л нийтлэх шаардлагатай болдог байна¹². Гэвч ихэнх орон эдгээр гэрээг нууцалдаг.)

- ▶ Хэрвээ БХГ-г парламентаар хуульчлан баталдаг бол энэ нь одоо хүчин төгөлдөр байгаа болон ирээдүйд гарах байгаль орчны болон аюулгүй байдлын зохицуулалтуудаас дээгүүр тавигдах уу? Хэрвээ сүүлд нь тус улс газрын тос, байгалийн хийн үйл ажиллагаатай холбоотой бүр хатуу зохицуулалт гаргах бол ямар үр дагавартай вэ? Компаниуд дээрх зохицуулалтуудыг даган мөрдсөнөөр гарах нэмэлт зардлууд нь татвараас хасагдах зардалд тооцогдох уу, аль эсвэл тухайн засгийн газар газрын тосны компаниудад нөхөн төлбөр олгох шаардлагатай юу?
- ▶ Уг гэрээнд компаниуд байгаль орчинд хохирол учруулвал торгууль төлөхийг шаарддаг уу? (Байгалийн хийн зарим гэрээнд хий шатаах нь хүлэмжийн хий ялгарах нөлөө үзүүлнэ гэж үзээд ингэсэн компаниуд торгууль төлөхийг шаарддаг.)

Гэрээний тодорхой заалт

Лиценз буюу концессийн гэрээ, БХГ хоёр нь өөр өөр байр сууринаас боловч нэг ижил асуудалд чиглэдэг учраас тодорхой хэмжээний нийтлэг заалтуудтай байдаг. Дараахь хэсэгт эдгээр илүү нийтлэг заалтын заримаас авч үзнэ.

Талууд: Аливаа гэрээний оролцогч талуудыг сонгохдоо сайтар нягтлан шалгах хэрэгтэй. Ялангуяа, талууд өөр өөр улсынх байх, талуудын нэг нь засгийн газрын буюу төрийн байгууллага байх үед илүү анхаарах хэрэгтэй. Хүлээн авагч засгийн газар аливаа гэрээний шууд оролцогч тал байхын хэрээр шууд хариуцлага, хязгааргүй үүрэг хүлээдэг. Гэхдээ өөрийн үйлдвэрийн газруудынхаа нэгийг гэрээний тал болгон оролцуулснаар хүлээх үүргээ хязгаарлаж болно. Төрийн өмчийн үйлдвэрийн газрыг засгийн газрын гүйцэтгэх гар хөл гэж ойлгосон тохиолдолд эдгээр хоорондоо холбоотой боловч тусдаа хуулийн этгээдүүдийг хооронд нь хольж хутгах явдал элбэг байдаг.

Жишээлбэл, хүлээн авагч засгийн газар ямар нэг төслийг хангалттай эрчим хүчээр хангахаар тохирч болох бөгөөд хэрвээ хангаж чадахгүй бол үүргээ биелүүлээгүйд тооцож болно. Харин үндэсний цахилгаан эрчим хүчний компани эрчим хүчээр хангахаар тохирсон бол, тэр компани хэдийгээр бүхэлдээ төрийн өмчийнх байсан ч гэсэн, эрчим хүчээр хангаж чадаагүй бол зөвхөн тухайн компани л үүрэг хүлээх бөгөөд хохирлыг зөвхөн түүний эд хөрөнгөөс нөхөн төлүүлж болно. Ер нь, засгийн газар аливаа арилжааны гэрээнд хэзээ ч шууд гэрээлэгч тал болж оролцохгүй байх нь зүйтэй, гэвч дандаа ингэх боломжгүй байдаг. Газрын тосны гэрээ хэлэлцээрт үндэсний газрын тосны компаниуд засгийн газарт зуучлагчийн үүрэг гүйцэтгэх нь олонтаа байдаг.

Эдгээр болон бусад шалтгааны үүднээс засгийн газар өөрийн арилжааны үйл ажиллагааг засаг захиргааны болон зохицуулалтын чиг үүргүүдээсээ салгаж өгөх ёстой. Зохицуулалтын чиг үүргээ гүйцэтгэхийн тулд гэрээний үүрэг хүлээнэ гэж ойлгож болохгүй.

Ямар нэг гэрээ хэлэлцээрт хүлээн авагч засгийн газартай хамтран ажиллаж байгаа газрын тосны компани ихэвчлэн тухайн гэрээний тал болон оролцох өөрийн салбарыг байгуулдаг. Энэ төрлийн салбар компани нь өөрийн гэсэн хязгаарлагдмал хөрөнгөтэй эсвэл огт хөрөнгөгүй байх бөгөөд хүлээсэн үүргээ биелүүлэхэд, ялангуяа байгаль орчны бохирдлоос үүссэн хохиролтой холбоотой асуудлаар, эх компанийх нь санхүүгийн нөөцөд найдах боломжгүй байна. Иймд хүлээн авагч засгийн газар хүлээсэн үүргээ биелүүлж чадахуйц санхүүгийн нөөц

бүхий найдвартай гэрээлэгч талтай байхын тулд тухайн салбар компанийн цаад эх компаниас баталгаа шаардах ёстой.

Нягтлан бодох бүртгэлийн яриууд. Ашгийн хэмжээг тодорхойлохын тулд нягтлан бодох бүртгэлийн арга зүйн талаар шийдвэр гаргасан байх ёстой. АНУ, Их Британи, Франц улсууд дор бүрнээ өөрийн гэсэн үндэсний бүртгэлийн стандарттай бөгөөд Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөлөөс олон улсын нягтлан бодох бүртгэлийн зарчмуудыг тодорхойлох ажил хийгдэж байна. Нягтлан бодох бүртгэлийн стандартууд нь өөр өөрийнхөөр хэрэглэж, тайлбарлах орон зай үлдээдэг бөгөөд ноцтой маргаан өрнөхөд ч хүргэж болно.¹³

Түүнчлэн, нягтлан бодох бүртгэлийн стандартуудад тодорхой нэг төрлийн зарцуулалтыг хоирглосон заалт байдаггүй. Иймээс тодорхой зарцуулалтуудад яаж хандвал зохихыг тухайн гэрээндээ тодруулж өгөх ёстой.

Нийтлэг нэг эзэнтэй буюу удирдлагатай компаниуд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, үзүүлсэн үйлчилгээнийхээ төлөө бие биенээсээ төлбөр суутган авдаг компани хоорондын үнийн үед асуудал бүр ч хэцүү болох бөгөөд энд нягтлан бодох бүртгэлийн стандарт нь тодорхой шийдвэр бус зөвхөн заавар болдог байна. Компани хоорондын үнэ нь зардлыг хөөрөгдөж, засгийн газарт төлөх төлбөрийн хэмжээг бууруулж болно.

Зардал нөхөлт. Компаниудын төлж байгаа татвар, засгийн газартай хуваалцаж байгаа нөөц ашигласны төлбөр нь тухайн компаний олсон ашигт тулгуурладаг учраас компаниудын гаргаж буй зардлууд хүлээн авагч засгийн газрын орлогод чухал нөлөөтэй. Компаниуд зардлаа хэрхэн бүртгэж байгаагаас тайланд ямар ашиг гарах нь тодорхойлогдоно.

Үйл ажиллагааны урсгал зардал ба капиталын хөрөнгө оруулалтын зардал гэсэн хоёр төрлийн зардал байдаг. Урсгал зардлууд нь тухайн гарсан жилдээ тооцогдож явах учраас нийт орлогоос шууд хасагдаж, ашгийн хэмжээг шууд бууруулдаг. Капиталын хөрөнгө оруулалтын зардлууд нь урт хугацааны зардал бөгөөд тодорхой заасан хугацааны турш элэгдэл хорогдол тооцогдож байдаг. Засгийн газрын байр сууринаас авч үзвэл элэгдэл хорогдлын хугацаа хэдийчинээ урт байна, энэ хугацаанд олох ашгийн хувь төдийчинээ өндөр байна. Нөгөө талаас, аливаа компани элэгдэл хорогдлыг илүү хурдацтайгаар тооцох замаар зардлаа аль болох хурдан нөхөхийг хичээх болно. Иймээс, компаниуд хөрөнгийн элэгдэл, хорогдол тооцохдоо ашиглаж байгаа нөхцлүүд нь засгийн газрын хүртэх орлогод ихээхэн нөлөө үзүүлж болно.

Өөр нэг асуудал бол зардал бүр хүчинтэй эсэх тухай юм. Тухайлбал, хүлээн авагч оронд ажилласны урамшуулал болгож гадаадын ажиллагсадад төлж байгаа шагнал урамшуулал нь хүчинтэй зардал мөн үү? Гадаадын ажиллагсадад зориулж гадаадаас вино импортлож байгаа нь зайлшгүй зардал уу? Нисэх онгоцоор зорчих зардлыг энгийн ангиллаар хязгаарлах ёстой юу? Зардлын тухай нарийвчилсан бодлого зайлшгүй шаардлагатай .

Өрөмдөгч цамхаг болон бусад урт настай буюу “байнгын” хөрөнгө оруулалт болох капиталын хөрөнгө оруулалт чухал ач холбогдолтой. Тэдгээрийг удаан хугацаагаар ашиглаж болох учраас ашиглалтын хугацаанд тодорхой хэмжээгээр элэгдэл хорогдол тооцож, зарлагдаж байх ёстой. Газрын тосны компаниуд тухайн жилийн ашгийнхаа хэмжээг багасгаж, хүлээн авагч засгийн газарт бага татвар төлөх, бага ашиг хуваарилах үүднээс эдгээр зардлыг хурдан нөхөж, тухайн гарсан жилд нь бүрэн тооцохыг илүүд үздэг. Хэрвээ засгийн газар капиталын хөрөнгө оруулалтын элэгдэл хорогдлыг хурдан тооцохыг зөвшөөрөх юм бол газрын тосны компанийн хувьд хэсэг хугацааны дараа үйл ажиллагаагаа зогсоолоо гэхэд алдах зүйл бага байна. Эцсийн эцэст, тухайн компани зарцуулсан зардлынхаа дийлэнхийг аль хэдийн нөхөөд авчихсан байх болно.

Татвар ноогдуулах буюу нөхөн төлбөр. Олон тохиолдолд байгалийн баялгийн үйлдвэрлэл, борлуулалтаас олох орлого тухайн засгийн газрын төсвийн хамгийн их хувийг эзэлдэг учраас үйлдвэрлэлд хэрхэн татвар ноогдуулах нь туйлын чухал асуудал юм. Гэвч хэрвээ засгийн газар хэт их татвар авах юм бол компаниудыг тухайн орноос арай илүү нөхцөлтэй газрууд руу түлхэх аюултай.

Засгийн газар хэрэглэж болох хэд хэдэн төрлийн татвар байдаг. Эхнийх нь болох ашгийн татварыг аж ахуйн нэгжийн орлогын татвар хэлбэрээр авч болох ба эсвэл аливаа ашгаас засгийн газрын авахаар тохирсон хэмжээний нэг хэсэг болгон ангилж болно. Татварын байцаагч нар үйлдвэрлэл ба борлуулалтын хэмжээний тоо баримтыг болон тухайн бүтээгдэхүүнийг борлуулсан үнийн мэдээллийг цуглуулж авдаг бөгөөд компанийн гаргасан зардлуудыг хянан шалгадаг. Аливаа компани өөр нэг оронд буй салбартаа борлуулсан газрын тосны үнэ зах зээлд зонхилох үнээс доогуур эсвэл дээгүүр байж болно. Энэ төрлийн шилжих үнэлгээ нь татварын удирдлага султай орнуудад татвараас зайлсхийх боломж олгож болно.

Газрын тосны компаниудад голдуу ноогдуулдаг өөр нэг татвар бол нөөц ашигласны төлбөр буюу онцгой татвар бөгөөд хэдийгээр үйлдвэрлэлийн тоо хэмжээнд тулгуурлан тогтоосон тогтмол хураамж байж болох боловч ихэвчлэн үйлдвэрлэлийн үнийн дүнгийн тодорхой хувиар тооцдог. Энэ татварыг голдуу

бусад татвараас дээгүүр тавьж ноогдуулдаг. Аж ахуйн нэгжийн орлогын татвартай харьцуулахад энэ татварыг удирдахад хялбар төдийгүй түүнийг хураахдаа тухайн төсөл ашигтай болж эхлэх хүртэл хүлээх шаардлагагүй учраас засгийн газрууд ийм татварт дуртай байдаг. Нөгөө талаас, ашгийг огт харгалзалгүйгээр үйлдвэрлэлд шууд ноогдуулдаг учраас эдгээр татвар үр ашиггүй байж болно. Тухайн төсөл дөнгөж зардлаа нөхөж байгаа буюу харьцангуй ашигтай бус байхад нөөц ашигласны төлбөр буюу онцгой татвар ноогдуулах нь цаашид хөрөнгө оруулалт хийх сонирхлыг бууруулж байж болно.

Удирдахад хялбар өөр нэг орлогын эх үүсвэр бол урамшууллауд байдаг. Хүлээн авагч засгийн газрын зүгээс тухайн компани хайгуулын ажил эхлэхээсээ өмнө нэг удаагийн төлбөр төлөхийг (гэрээний урамшуулал), эсвэл үйлдвэрлэлийн явц тодорхой түвшинд хүрмэгц тогтмол хэмжээний төлбөрийг тасралтгүй төлөхийг (үйлдвэрлэлийн урамшуулал) шаардаж болно. Урамшууллауд нь тогтмол төлбөр бөгөөд тухайн төслийн амжилттай байдал буюу ашигт ажиллагааг харгалздаггүй, мөн ихэвчлэн татвараас хасагдах зардалд ордог.

Норвеги улс аливаа төслийн үйл ажиллагааны үе шат бүрд харьцангуй сайн тохирсон боловсронгуй систем хэрэглэдэг бөгөөд газрын тосны орлогын нилээд хувийг засгийн газарт шагнал болгон өгдөг байна. Татвар ноогдуулах журам нь энгийн аж ахуйн нэгжийн татвар (28 хувь) ба нэмэлт нефтийн онцгой татвар (50 хувь) хоёроос бүрддэг. Энэ хоёр татвар хоёулаа тухайн компанийн цэвэр ашигт тулгуурлах бөгөөд Норвегийн эх газрын бүсэд явуулж буй үйл ажиллагаатай холбоотой бүх зардал татвараас хасагдах зардалд тооцогддог. Хөрөнгө оруулалтыг элэгдэл хорогдлын өндөр хувиар хөхиүлэн дэмждэг. Түүнчлэн, өндөрсгөсөн шимтгэл тогтоож, аливаа компани оруулсан хөрөнгөөсөө 30 хувь илүү хэмжээний зардлыг онцгой татвараас хасагдуулах боломж олгодог. Жишээлбэл, капиталын зардал нь 100 сая ам.доллар бол тухайн компани 130 сая ам.долларыг нөхөн авч болно гэсэн үг. Иймээс, Норвегийн газрын тосны татварын систем нь олсон ашгийг нефтийн онцгой татварын бүрэн нөлөөнөөс хамгаалах өндөрсгөсөн шимтгэлтэй учраас бага хэмжээний ашигтай төслүүдэд тааламжтай байдаг¹⁴. Гэхдээ Норвеги бол байгалийн баялгийн татварын тогтолцоог удирдах талаар өргөн туршлагатай улс гэдгийг энд тэмдэглэх нь зүйтэй.

Байгаль орчин. Засгийн газар болгон байгаль орчноо хамгаалах үүрэгтэй. Гэвч, байгаль орчны стандартуудыг БХГ ба лиценз буюу концессийн гэрээнд зааж өгсөн тохиолдолд газрын тосны компаниудад байгаль орчны стандартыг, шууд бус байдлаар ч гэсэн, тайлбарлан хэрэглэх, тохиролцох, тэр ч байтугай хориг тавих эрх олгож, улмаар байгаль орчны хууль, журам хоёрдмол утгатай болоход хүргэдэг.

Тухайлбал, Азербайжаны газрын тос боловсруулах томоохон төслүүдийн БХГ-нд гэрээлэгч компаниуд “олон улсын газрын тосны салбарын нийтээр хүлээн зөвшөөгдсөн стандарт ба практикт нийцүүлэн” агаарт хорт хий ялгаруулахыг зөвшөөрдөг. Гэтэл гол асуудал нь тийм стандарт огт байдаггүйд оршино!

Түүнчлэн, хэрвээ байгаль орчны стандарт нь гэрээний жирийн нэг заалт юм бол компаниуд, засгийн газар хоёр уг заалтыг өөр өөрийнхөөрөө тайлбарлан хэрэглэхийн зэрэгцээ үр нөлөөтэй хориг тавьж болно. Тодорхойгүй нөхцлүүдийн утга санааг гэрээнд оролцогч талууд харилцан тайлбарлаж эсвэл хэлэлцэн тохиролцож болдог нь аливаа гэрээний тогтсон стандарт бөгөөд энэ нь аль аль талын зөвшөөрөл шаардлагатай гэсэн үг.

Хөгжиж байгаа орнууд байгаль орчны стандартууд, тэдгээрийн хэрэгжүүлэлт султай байх юм бол байгаль орчноо тонон дээрэмдэхийг зөвшөөрч, улмаар арилжааны бараа бүтээгдэхүүний зардлыг шууд бусаар тэтгэж байна гэсэн үг.

Ерөнхийдөө Барууны орнуудад байгаль орчны стандарт илүү өндөр байдаг боловч ялангуяа бараа түүхий эдийн эрэлт ихтэй байдаг газрын тос, байгалийн хийн салбарт яагаад ийм байх ёстойг тайлбарлах оновчтой шалтгаан байдаггүй. Мөн газрын тосны компаниуд нэг улсад буй байгаль орчны хатуу стандартаас зайлсхийж, ийм хууль тогтоомж султай өөр орнуудыг (тухайлбал өрөмдлөгөөс үүссэн хортой шаврыг хаяхад) ашиглаж байгаа үед асуудал үүсдэг.

Газрын тосны компаниуд байгаль орчны бохирдлыг үнэлж, хянахад их хэмжээний хөрөнгө оруулахаасаа илүү байгаль орчны стандартыг зөрчсөнийхөө төлөө харьцангуй бага хэмжээний торгууль төлөхийг илүүд үздэг. Ингүүлэхгүй байхын тулд торгуулийн хэмжээ хангалттай өндөр байх ёстой. Мөн компаниуд ихэвчлэн төслөө хэрэгжүүлж дуусаад тухайн газрыг нөхөн сэргээх үүрэгтэй байдаг. Герман зэрэг зарим оронд энэ үүргийг хатуу сахиулдаг бол бусад улс арай зөөлөн шаардлага тавьдаг.

Үйл ажиллагааны хөтөлбөр. Аливаа компанийн хайгуул, олборлолтын төлөвлөгөөг нарийвчлан гаргасан үйл ажиллагааны хөтөлбөр нь голдуу усны гүнд байгаа болон газар хөдлөлийн бүсэд байгаа газрыг хэрхэн өрөмдөх зэрэг техникийн болон санхүүгийн асуудлуудын цаана гол асуудлаа нуусан бүрхэгдүү байж болно. Энэ асуудлын хувьд, мөн л байгаль орчныг хэрхэн хамгийн сайн хамгаалахтай холбоотой асуултууд тавигддаг бөгөөд энэ нь зарим талаар зайлшгүй шаардлагатай хамгаалалтын тоног төхөөрөмжүүдийг суурилуулах зардлаас хамаарч байдаг.

Газрын тосны компани хэтэрхий өндөр өртөгтэй гэж үзсэн тодорхой төслийг ялангуяа дэлхийн өөр нэг газар хэрэгжүүлж байгаа бусад төсөлтэйгээ харьцуулж үзсэний үндсэн дээр явцыг нь удаашруулах явдал олон байдаг. Ийм учраас ямар нөхцөлд төслийг хойшлуулах эсвэл бүр зогсоож болох, ямар нөхцөлд

ингэж болохгүйг үйл ажиллагааны хөтөлбөртөө тодорхой заасан байхыг хүлээн авагч засгийн газар шаардах ёстой.

Тогтворжуулалт. Тогтворжуулалтын заалтууд нь засгийн газар буюу хууль тогтоомжийн өөрчлөлт гэрээний аль нэг заалтад нөлөөлөхөөс газрын тосны компаниудыг хамгаалдаг бөгөөд гэрээнд өөрөөр тохироогүй бол хойшид хууль тогтоомжийн өөрчлөлтөөс болж ямар нэг нэмэлт зардал гарвал хүлээн авагч засгийн газраас тэдэнд нөхөн төлбөр олгодог.

Уул нь, тогтворжуулалтын заалтууд нь тухайн гэрээнд нөлөө үзүүлж болзошгүй улс төрийн тодорхой эрсдлүүдийг хөндөн авч үздэг байв. Хөгжиж буй оронд ажиллаж байгаа компаниудын хамгийн их санаа зовдог зүйл бол хүлээн авагч засгийн газар тухайн хөрөнгө оруулагчийн өмч хөрөнгийг улсын болгож хураан авах эсвэл нэг талын шийдвэрээр гэрээг цуцлах явдал байжээ.

1970-аад онд Ливи улс газрын тосны компаниудын эзэмшил хувь, өмч хөрөнгийг улсын болгон хураан авсны дараа гадаадын хөрөнгө оруулагчид ба тус улсын хооронд хэд хэдэн маргаан өрнөсөн юм. Ливи улс дангаараа нэг талын шийдвэрээр газрын тосны компаниудын эзэмшил хөрөнгийг улсын болгосон нь гэрээгээ зөрчсөн хэрэг бөгөөд үүнийхээ хариуцлагыг хүлээж, хохирлыг барагдуулах шаардлагатай хэмээн Арбитрийн шүүхээс шийдвэрлэсэн байна.

Тогтворжуулалтын заалт нь тухайн улсын эрх зүйн болон зохицуулалтын нөхцөл байдлыг урт удаан хугацаагаар хөдөлбөргүй болгож, хэрвээ хийсэн өөрчлөлт нь хөрөнгө оруулагчид нөлөөлж байвал засгийн газар хохирлыг нөхөн төлөхийг шаарддаг учраас түүнийг “хүлээн зөвшөөрч” байгаа засгийн газарт туйлын хохиролтой сул тал болдог.

Тогтворжуулалтын заалтыг өнөөдөр ямар утгатай вэ, маргааш ямар утгатай болох вэ гэж цаг хугацааны талаас нь сайтар шинжилж үзэх ёстой.

Үнэ. Газрын тосны зах зээлийн үнэ яаж тодорхойлогдох нь татварын эсвэл хуваах ашгийн хэлбэрээр хүлээн авагч засгийн газарт төлөх төлбөрт шууд нөлөө үзүүлдэг учраас шийдвэрлэх ач холбогдолтой. Газрын тосны борлуулалтын үнийг тооцох цорын ганц бодитой арга бол тухайн бүс нутаг дахь бараа, түүхий эдийн арилжааны зах зээлээс тогтоосон үнээс эхлэх явдал юм. МакГрау Хиллийн эзэмшдэг нефтийн үнийн үйлчилгээний Платтс компаниас түгээмэл борлуулагддаг түүхий нефтийн дэлгэрэнгүй жагсаалтыг өдөр тутмын зах зээлийн үнэтэй нь хэвлэн гаргадаг. Аливаа гэрээнд ихэвчлэн ямар үнийг жишиг болгон хэрэглэхээ зааж өгөх ёстой.

Харин гэрээний хүлээн зөвшөөрөгдөх үнэ хэмээн хэзээ ч тооцож болохгүй

нь ойлгомжтой зүйл бол хоорондоо холбоо сүлбээ бүхий компаниудын хооронд төлсөн үнэ юм. Учир нь, энэ үнийг дотооддоо тогтоодог бөгөөд зах зээлийн үнийг заавал тусгасан байх шаардлагагүй байдаг.

Холбоотой компани гэж нэг нь нөгөөгөө хэсэгчлэн буюу бүрэн эзэмшдэг компани төдий ойлголт биш юм. Энэ нь бас борлуулагч талтай гэрээний эсвэл өөр бусад холбоотой компани байж болох бөгөөд уг холбоо нь заавал нийтэд ил болсон буюу илэрхий байх албагүй. Компаниудын өөрийн салбарт борлуулсан нефтийн үнэ түүний зах зээлийн үнээс хамаагүй доогуур байж болох учраас тэдний ингэж тайлагнасан үнэд тулгуурлан татвар ноогдуулах нь засгийн газарт хор хохиролтой. Нэг баррель нефтийн үнийн хувьд өчүүхэн зөрөөтэй байсан ч гэсэн нийт дүнгээр нь тооцвол нилээд ялгаатай байж болно.

Цуцлалт. Аливаа гэрээг ямар тохиолдолд цуцалж болохыг зааж өгөх шаардлагатай. Тухайлбал, байгаль орчны шаардлагыг давтан зөрчсөн бол гэрээг цуцалж болно. Мөн компаниуд тухайн газарт үйл ажиллагаагаа явуулахгүй байвал гэрээгээ цуцлах хэрэгтэй. Энэ тохиолдолд, хүлээн авагч засгийн газар уг талбай дээр ажиллахад бэлэн байгаа өөр нэг компанид гэрээг шилжүүлж болно.

Гадны мэргэжилтнүүд. Хөгжиж байгаа орнууд гэрээ хэлэлцээр хийхдээ ихэвчлэн гадны мэргэжилтнүүдэд найдах ёстой болдог. Сонирхолтой нь, тэдний дотор олон улсын эрчим хүчний компаниудын зарим мэргэжилтэн орсон байдаг. Засгийн газрын албан тушаалтнууд хичнээн мэдлэг туршлагатай байсан ч гэсэн тэдний хэн нь ч байгалийн баялгийн боловсруулалтын бүхий л талыг хянаж чадахгүй учраас газрын тос, байгалийн хийн компаниудын хуримтлуулсан мэдлэг туршлагад найдах нь зайлшгүй. Гадны мэргэжилтнүүдэд үнэлэлт дүгнэлт өгч, сонгож, дараа нь удирдан чиглүүлдэг байх ёстой. Аливаа үндэстний мэргэжилтнүүд бодитойгоор хараат бус байх шаардлагатай бөгөөд ингэснээрээ жинхэнэ зөвлөгч, өмгөөлөгч нар байж чадна.

Дүгнэлт

Газрын тосны гэрээ зайлшгүй нарийн түвэгтэй байдаг бөгөөд зөрчил, авилгалд өртөж болох учраас эдгээр гэрээ төдийгүй түүний дэд хэсгүүд болон ямар нэг зохицуулалтын нөхцлүүдийг бүрэн дүүрэн ил тод болгож нийтэд танилцуулах ёстой. Зөвхөн энэ тохиолдолд л эдгээр гэрээ болон төрийн албан хаагчид, засгийн газрын албан тушаалтнуудын гаргасан шийдвэрийн үр ашигтай, зөв зүйтэй байдлыг олон нийт үр нөлөөтэй шүүн хэлэлцэж чадна.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Гэрээний заалтын тухай асуултууд

- ▶ Хөрөнгө оруулагчид үйлдвэрлэлээ зогсоох буюу тухайн орд газрыг ашиглахад нэмж хөрөнгө оруулахаас татгалзаж болох ямар заалтууд байна вэ?
- ▶ Газрын тосны салбарт нөлөөлөхүйц шинээр гарсан хууль тогтоомж, зохицуулалтуудыг хэрэгсэхгүй болгоход чиглэсэн тогтворжуулалтын заалтууд уг гэрээнд байна уу?
- ▶ Газрын тос буюу байгалийн хийн компаниудын төлөх ёстой татвар, бусад урамшууллыг тооцохдоо газрын тос, байгалийн хийн ямар үнийг ашиглах вэ?
- ▶ Хэрвээ байгаль орчны асуудлаар дахин давтан зөрчил гаргасан бол гэрээг цуцалж болох буюу цуцлах ёстой юу? Хэрэв тийм бол “давтан” гэдэг нь яг ямар утгатай вэ? Хэрэв гэрээ цуцлагдахад хүрвэл холбогдох тоног төхөөрөмжийг хэн өмчлөх вэ?
- ▶ Хэрвээ газрын тосны компани тухайн газар үйл ажиллагаа явуулахгүй байгаа бол үйл ажиллагаагаа зогсоосон эсэхийг нь яаж тодорхойлох вэ? (Тухайн асуудлыг шийдвэрлэх ёстой гэдгээс өөр үүнд өгөх тогтсон хариулт байдаггүй. Мөн уг асуудлыг шийдэх оновчтой хувилбарыг нийтэд зарлан мэдэгдэх ёстой.)
- ▶ Засгийн газарт гэрээний асуудлаар зөвлөгөө өгч буй гадны ямар зөвлөхүүд байна вэ? Тэднийг хэрхэн сонгосон бэ? Тэд ямар туршлагатай хүмүүс вэ? Тэдний ажлын хөлсөнд хэн, хэдийг төлж байна вэ? (Мөн бас нэг санаанд оромгүй асуулт бол: Авах ёстойгоо авч байгаа учраас тэдэнд хэтэрхий бага хөлс төлөөд байна уу!)
- ▶ Тухайн “хараат бус” мэргэжилтнүүд өмнө нь газрын тосны компаниудад ажиллаж эсвэл тэдгээрийг төлөөлж байсан уу? Тэд газрын тосны компаниудаас ямар хөлс авч байсан бэ? Тэд засгийн газартай хамтран ажиллаж дууссанаа дараа үргэлжлүүлэн тодорхой хугацаагаар газрын тосны компаниудыг төлөөлж ажиллахгүй байхыг зөвшөөрөхөд бэлэн байна уу?

Лаго Агрио: Эквадорын гашуун амт

Николас Розен

2005 оны 3 дугаар сарын 16

Эквадор улсад, Лаго Агрио буюу “Гашуун нуур” хэмээх нуурын эргэн тойрны Амазоний ширэнгэн ойн бүс нутагт орших газрын тосонд бохирдсон зурвас газар өнөөдөр тун ярвигтай, хуулийн урт удаан үргэлжилсэн маргааны бай болоод байгаа бөгөөд удах тусам уг нуурын нэр шиг гашуун болсоор байна.

2003 онд Эквадорт АНУ-ын хэсэг хуульчдын баг Лаго Агриогийн бүс нутагт амьдардаг олон мянган нутгийн уугуул иргэд, бусад оршин суугчдыг төлөөлөн ЧевронТексако компаний эсрэг 1 тэрбум ам.долларын нэхэмжлэлтэй зарга үүсгэжээ. Шүүхээс Тексакогийн (2001 онд Чевронтой нэгдсэн) салбар ТексПет компани хэдэн арван сая галлоноор тоологдох хорт хаягдал усыг ширэнгэн ойд асгасны хариуцлагыг хүлээх ёстой хэмээн буруутгаж, тэрхүү өндөр өртөгтэй цэвэрлэгээг хийх ёстой гэж үзсэн байна. Харин

ЧевронТексако компани тус компанийн хүчин чармайлтаар ТексПетийн Эквадорын засгийн газартай байгуулсан гэрээний үүрэг биелсэн хэмээн маргаж байна.

ТексПет компани тус улсын газрын тосны улсын компани болох ПетроЭквадортой хамтран түншилж 1972-1990 оны турш Лаго Агриог тойрсон Ориент хэмээх газрын тосны орд газрыг ажиллуулж байжээ. Ингээд Тексако өөрийн эзэмшил хувиа 1992 онд ПетроЭквадорт худалдаж, 40 сая ам.долларын өртөгтэй, олон жилийн хугацаатай цэвэрлэгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд үүнийг нь Эквадорын засгийн газраас баталсан байна. Саяхан ЧевронТексако компани Лаго Агриогийн бүс нутгийн янз бүрийн өрөмдлөгийн талбайд шинжилгээ хийж үзээд бохирдлын түвшин Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллагын (ДЭМБ) стандартыг

хангаж байгааг харуулсан байна. Ийнхүү ЧевронТексакогийн хуулийн дагуу хүлээсэн үүрэг болон уг нэхэмжлэлээс хамгаалах хуульчдын ажил дуусгавар болжээ.

Гэвч зарга мэдүүлэгчид Амазоны Ажиглагч гэх мэт байгаль орчныг хамгаалагч бүлгүүдийн дэмжлэгтэйгээр Лаго Агрио гамшигт автсан хэвээр байна хэмээн мэдүүлж байна. Тэд, голын болон ундны ус аймшигтайгаар бохирдсон байна, энэ нь тус бүс нутагт хорт хавдраар өвчлөлтийн түвшин онцгой өндөр байгаагийн шалтгаан хэмээн маргадаг. Тэд уг ширэнгэн ойд саяхан хийсэн АНУ-ын газрын тосны аварга компанийн шижилгээг “хогийн шинжлэх ухаан” хэмээн нэрлэсэн байна.

Лаго Агриогийн оршин суугчдын өмгөөлөгчид анхандаа энэхүү бохирдлын асуудалд хүргэсэн гол шийдвэрийг Нью Йоркийн Уайт Плэйнст төвтэй Тексакогийн удирдах газар гаргасан гэж үзээд АНУ-ын шүүхэд хандсан байна. Харин 2002 онд Нью Йоркийн нэгэн шүүгч, “уг хэрэг бол бүх талаараа Эквадор улсад хамаатай, АНУ-д ямар ч хамаагүй” хэмээн мэдэгдсэн байна. Уг шүүгч Нью Йорк дахь шүүх ажиллагааг зогсоогоод тус компанийг Эквадорийн шүүхэд нэхэмжлэл гаргахыг үүрэг болгожээ.

Одоо Эквадорт энэ хэрэг ший-

дэгдтэлээ хэдэн жил ч болж мэдэх юм. Асуудлыг улам хүндрүүлсэн нэг зүйл бол ЧевронТексако компани өөрийн арбитрийн нэхэмжлэлийг Эквадорын засгийн газрын эсрэг гаргаж, энэхүү шүүх ажиллагаанаас гарсан бүх зардлыг тус улсын засгийн газар нөхөн төлөхийг шаардсан байна.

Лаго Агриогийн хэрэг ямар ч байдлаар шийдэгдлээ гэсэн энэ бол үндэстэн дамнасан корпорациудын хүлээх хуулийн хариуцлагатай холбоотой цорын ганц шийдвэр төдийгүй Эквадор улсын дотоод улс төрийн нэг халуун асуудал болохуйц маш чухал асуудал юм. Чеврон Тексакогийн эсрэг шийдвэр гарвал үүнтэй төстэй шүүхээр заргалдах явдал Эквадор, АНУ-д болон дэлхийн бусад хэсэгт ч өрнөхөд хүргэж болзошгүй. Түүнчлэн Эквадор улс газрын тосны салбарт идэвхтэй оролцож байгаа өнөө үед тус улсын тухай гадаадын газрын тосны компаниудын ойлголтод сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Харин ЧевронТексако шүүх хуралд ялсан тохиолдолд, халуун орны өтгөн ойт нутгийг нь гадаадын сувдаг корпорациуд, Эквадорын цэвдэг сэтгэлт засгийн газартай хуйвалдан тонон дээрэмдэж, сүйтгэн бусниулсан хэмээн үздэг нутгийн уугуул иргэдийн бүлэг ба тэдний дэмжигчид нэгдэн Эквадорт улс төрийн үймээн самуун дэгдээж болох юм.

ХАЙРЦАГ 1

АНХНЫ КОНЦЕССУУДЫН ОНЦЛОГ

ОРЧИН ҮЕИЙН КОНЦЕССУУДЫН ОНЦЛОГ

Монополь ба Өрсөлдөөн

- ▶ Маш том газар нутаг
- ▶ Концессийн урт хугацаа
- ▶ Ашиглалтын онцгой эрх
- ▶ Хуваарь ба үйл ажиллагааны хөтөлбөрийн бүрэн хяналт
- ▶ Үйлдвэрлэлийн шаардлага байхгүй
- ▶ Сайтар тодорхойлсон газар нутаг
- ▶ Цаг хугацаа хязгаарлагдмал
 - хайгуулийн үе шат (3-5 жил)
 - үйлдвэрлэлийн үе шат (15-20 жил)
- ▶ Орхиж явах дүрэм
- ▶ Үйл ажиллагааны хөтөлбөр шаардлагатай
- ▶ Нэмэлт хөрөнгө оруулалтын шаардлага
- ▶ Лицензийн уралдаант шалгаруулалт

Концесс авагчийн ашигт ажиллагаа ба Улсад орох орлого

- ▶ Нөөц ашигласны төлбөр (олборлон гаргасан нэг тонн тутамд тогтмол хэмжээгээр)
- ▶ Бага хэмжээний санхүүгийн урамшуулал
- ▶ Нөөц ашигласны төлбөр өндөр (их нефть байх тусам өндөр, бага нефть байх тусам бага хувьтай)
- ▶ Бодит орлогын татвар
- ▶ Урамшууллауд
- ▶ Жилийн түрээс (газрын хэмжээнээс хамаарч)
- ▶ Санхүүгийн нөхцлүүд илүү тэгш шударга

Ерөнхий тоо баримтууд

- ▶ Газрын тосны гэрээнүүдийн хамгийн эртнийх нь (1901 оны Д'Арсигийн концесс, Перс)
- ▶ Нөөц баялаг ихтэй орнууд гадаадын газрын тосны компаниудаас эдийн засгийн болон техникийн хувьд хараат байсан учраас сул дорой байр суурьтай байв
- ▶ Гадаадын империалист хөрөнгө оруулагчдын эсрэг дайсагнал
- ▶ Өнөөдөр хөгжиж байгаа орнууд концессийн гэрээнд эргэлзсэн байна
- ▶ Гордон Барровын Судалгаа (1995): 116 орны 62 нь концессийн гэрээ хэрэглэж байна*
- ▶ Концесс хэрэглэдэг орнуудын тоо буурсаар байна
- ▶ Энэ төрлийн гэрээг одоо хүртэл хэрэглэж байгаа орнууд: Шаржах (Арабын Нэгдсэн Эмират), Их Британи, Норвеги, Турк, Сомали, Тринадад, Австрали, Шинэ Зеланд

* Андрей Качепованик, "Концессууд: Д'Арсигийн Концесс Хүртэл", Газрын тос, Найсагийн хий, Экономик дүнхийн зурвгийн тэглүүл, Боть 1, Дугаа 1, 2005 оны 1-н сар

ХАЙРЦАГ 2

Дэлхий дахинд хийгдсэн газрын тосны гэрээнүүд, 2004

ЛИЦЕНЗ, КОНЦЕСС » 62 улс	БХГ » 52 улс	БХГ ба ЛИЦЕНЗ	ХҮ ба/буюу БХГ ба/буюу ЛИЦЕНЗ	БУСАД
Ази, Австрали Зүүн Тимор ба Австралийн хамтарсан нефть боловсруулах газар ¹⁵	Ази, Австрали Хятад*, Энэтхэг, Индонези, Малайз, Мянмар, Вьетнам			
	Төв Ази, Кавказ Азербайжан, Албани, Гүрж, Киргизстан	Зүүн Европ Орос*	Төв Ази, Кавказ Казакстан (ХҮ, БХГ, үйлчилгээний гэрээнүүд), Туркменистан (ХҮ ба БХГ)	
Европ Норвеги*, Их Британи*	Европ Мальт			
Ойрхи Дорнод Арабын Нэгдсэн Эмират Улс	Ойрхи Дорнод Катар, Сири, Йемен	Ойрхи Дорнод Ирак, Иордан		Ойрхи Дорнод Кувейт* ба Саудын Араб* ¹⁶ , Иран* (буцааж худалдан авалтууд) ¹⁷ , Оман
	Африк Алжир, Ангол, Конго, Зааны Ясан Эрэг, Египет, Экваторын Гвиней, Габон...	Африк Судан	Африк Ливи (ХҮ ба БХГ), Нигери* (ХҮ ба БХГ)	
Хойд Америк АНУ*	Хойд Америк Канад*		Хойд Америк Канад* (хайгуулын ХҮ)	
Төв ба Өмнөд Америк Аргентин, Бразил, Эквадор...	Төв ба Өмнөд Америк Гватемал...			Төв ба Өмнөд Америк Мексик* ОТУГ ¹⁸), Венесуэл* (лиценз ба эрсдлийн үйлчилгээний гэрээ)

* Дэлхийд тэргүүлэх газрын тос үйлдвэрлэгчид, Эх сурвалж: Эрчим Хүчний Мэдээллийн Удирдах Газар, 2003

6. Хөгжиж байгаа орны эдийн засгийг үнийн цочирдлоос хамгаалах нь

Рандалл Додд

Нөөц баялаг эдийн засгийн хөгжилд саад бэрхшээл учруулдаг гэдгийг одоо бид сайн мэдэх болжээ. Харин засгийн газрын зүгээс газрын тосны орлогыг тогтвортой болгох, эдийн засгийн өсөлт, хөгжилтийг хөхиүлэн дэмжихийн тулд авч болох бодлогын арга хэмжээний талаар сайн мэдэхгүй байгаа.

Товчоор дахин тэмдэглэхэд, аливаа орны нөөц баялгаар баян байдал нь эдийн засгийг гажуудуулж, улмаар нөөц баялгийн ашиглалт үр ашиг багатай болж, хөрөнгө оруулалт бууран, өсөлтийн чиг хандлага алдагдахад (ялангуяа, үйлдвэрлэл болон бусад худалдааны бараа, бүтээгдэхүүний салбарт) хүргэх үед нөөц баялгийн хяслан тохиолддог. Энэхүү эдийн засгийн гажуудал нь авилгал, хэт чангарсан валютын ханш, гадаад зээлийн хэтрэлт, тогтвортой бус өндөр цалин хөлс, засгийн газрын үрэлгэн зарцуулалт зэрэг хэлбэрээр газар авч болно. Эдгээр асуудлыг 2 дугаар бүлэгт илүү дэлгэрэнгүй тодорхойлсон байгаа.

Эдийн засгийн эдгээр хүндрэл бэрхшээлийг шийдэхийн тулд засгийн газар санхүүгийн сайн удирдлагатай байж, түүнийгээ хэвээр хадгалж байхыг шаардах болно¹. Мөн тусгай санхүүгийн институци, санхүүгийн арга хэрэгслүүд ашиглах зэрэг бодлогын бусад шийдэл байж болох юм. Энэ бүлэгт эдийн засгийн хөгжилд тулгарч буй томоохон сорилтуудын нэг болох байгалийн баялгийн борлуулалтын орлогоос хамааралтай улсад бараа түүхий эдийн үнийн хэлбэлзлийг хэрхэн удирдах вэ гэдэг асуудлыг шийдвэрлэхэд тустай байж болох санхүүгийн институциуд, арга хэрэгслүүдийг голлон авч үзэх болно. Газрын тос, байгалийн хийн үнэ нилээд хувьсамтгай байдаг бөгөөд бизнесийн энгийн мөчлөгийг заавал дагах албагүй байдаг. Энэхүү хувьсамтгай байдал нь эдийн засгийн зардал үүсгэх бөгөөд энэ зардлыг засгийн газар болон хувийн салбар үүрдэг. Мөн энэ нь засгийн газрын орлого байгалийн нөөцийн орлогоос ихээхэн хамааралтай үед төлөвлөлт хийхэд маш хэцүү болгодог.

Зарим томоохон экспортлогчдын газрын тосны орлогоос хамааралтай байдал, 2000

Засгийн газрын өөрөөр үс төсөнгийн орлогоос нийт орлогоос хэдхэн хувийг

Ангол	90%
Эквадорын Гвиней	88%
Оман	85%
Нигери	82%
Саудын Араб	79%

Эх сурвалж: ОУВС-ийн ажиртал тооцоо ба АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн үйлдвэр газар

Бараа, түүхий эдийн үнийн хувьсамтгай байдал нь төсвийн сахилга бат сахихад хэцүү болгодог. Нөөц баялгийн үнэ гэнэт өсөх үед засгийн газар зарцуулалтаа нэмэгдүүлэх хандлагатай байдаг бөгөөд энэ нь эргээд инфляци, үргүй зардлыг нэмэгдүүлдэг. Харин үнэ гэнэт унахад бүр ч илүү хохирол учирдаг. Энэ үед засгийн газар нэг бол зардлаа багасгаж, татвараа нэмэгдүүлэх эсвэл орлогын

өөр эх сурвалж олох буюу зээл авах сонголт хийхэд хүрдэг. Аль аль нь өөрийн гэсэн эрсдэлтэй. Зардлаа багасгаж, татвараа нэмэгдүүлэх арга хэмжээг хурдан авахад хэцүү. Энэ нь эдийн засагт агших хүчин бий болгодог бөгөөд ихэвчлэн эмэгтэйчүүд, ядуучуудад илүү хүнд тусдаг. Мөн энэ нь улс төрийн эмх замбараагүй байдал бий болгодог. Газрын тос болон бусад байгалийн баялгаас олох засгийн газрын орлого бага, зээлжих чадвар муутай үе таардаг учраас гадаадаас зээл авахад амаргүй төдийгүй хямд байдаггүй. Товчоор хэлбэл, ийм төрлийн хувьсамтгай үед төсвийн төлөвлөлтийг чангаруулахад хэцүү байдаг. Энэ нь засгийн газар төсвөө бүхэлд нь газрын тосны үнийн төсөөллийг тойруулан бүрдүүлэхийг шаарддаг бөгөөд харин уг төсөөлөл нь шал буруу байсан байж болох юм.

Засгийн газар үнийн хэлбэлзлээс үүсч буй эрсдэлд өртөх явдалыг бууруулж чадах олон тооны санхүүгийн институциуд, арга хэрэгслүүд байдаг. Тогтворжуулалтын сан, хуримтлалын сан гэх мэт санхүүгийн институциуд нь төсвийн хямралыг зөөдрүүлэх нөөцийн үүрэг гүйцэтгэж болно. Түүнчлэн, фьючерс, опцион болон бусад төрлийн хамгаалалтын арга хэрэгсэл нь зарим эрсдлийг түүнийг даахад бэлэн байгаа хөрөнгө оруулагч нарт шилжүүлэх замаар засгийн газрыг хамгаалж болно. Гэхдээ, эрсдлийг бууруулах явдал нь өөрийн гэсэн өртгөөр бүтэх буюу газрын тос, байгалийн хийн үнэ санаанд оромгүй өндөр байх үед зарим орлогоосоо татгалзахыг шаарддаг. Харин засгийн газрууд ийм олз ашгаас улс төрийн хувьд тэр бүр татгалзаж чаддаггүй.

Бодлогын эмчилгээ

Америкийн зохиолч Жон Штайнбек *East of Eden* номондоо, хөдөө аж ахуйгаас олох байгалийн нөөц баялгийн найдваргүй байдлын тухай дүрсэлжээ. Үүндээ зарим жилд хур бороо их, зарим жилд гантай гэх мэт бороо хэрхэн давтамжтайгаар ордог тухай дүрслэн бичсэн байна. Бороо хур ихтэй жилд газрын хөрс баян, үржил шимтэй байж хүмүүс баян чинээлэг болцгоодог. Харин гантай жилд газрын хөрс хуурайшиж, нүцгэрэн хүмүүс ядуурч, голдуу ийш тийш нүүцгээдэг. Тэрээр үүнийг дүгнэхдээ: “Хүмүүс ган гачигтай жилд баян чинээлэг жилүүдээ умартаж, хур бороо ихтэй жилд ган гачгийн талаарх бодлоо ор тас мартдаг явдал хэзээ ч тасрахгүй байна. Ер нь дандаа л ийм байдаг шүү дээ” гэжээ.

Гэвч заавал ийм байх албагүй. Төрийн бодлогыг зохистойгоор боловсруулж, хэрэгжүүлж чадвал нөөц баялгийн орлогыг тогтворжуулж, улмаар энэ төрлийн хүндрэл бэрхшээлээс зайлсхийн бүтээлч бус зан үйлийг бус, ололт амжилтыг хөхиүлэн дэмжиж болно.

Үнийн хэлбэлзлийн эдийн засгийн үр нөлөөг удирдах нь

Байгалийн баялгийн үнийн хувьсамтгай байдал нь газрын тосны шинэ орд газар нээх, ОПЕК-ийн үйлдвэрлэлийн квотыг сулруулах, эсвэл шинэ технологи худалдаанд нэвтрэх зэрэг үнэ буурахад хүргэсэн үйл явдлуудаас үүсэн гарч болно. Нөгөө талаас, ОПЕК үйлдвэрлэлийн квотоо хязгаарлах, газрын тос экспортлогч оронд улс төрийн үймээн самуун дэгдэх, газрын тосны эрэлт нэмэгдэх, дайн дажин, терроризм гарах, эсвэл худалдаачдын дунд бухимдал үүсэх зэрэг нь бүгд газрын тосны үнэ өсөхөд хүргэдэг.

Үнийн хэлбэлзэл хөгжиж байгаа орнуудад хяслан авчирдаг нэг арга зам бол улсын төсөвт үзүүлэх нөлөөгөөр дамжих явдал байдаг. Байгалийн баялгийн үнэ өсөхөд улсын төсвийн орлого тэр хэмжээгээр нэмэгддэг. Байгалийн баялгийн үнэ өссөнөөр нэмэгдэж буй төсвийн орлогыг төсвийн алдагдлыг бууруулахад, зарцуулалтыг нэмэгдүүлэхэд, эсвэл аль алинд нь тодорхой хэмжээгээр ашиглаж болно. Харин үнэ унахад үүний эсрэг үйл явдал тохиолдох бөгөөд гарч болох хамгийн их магадлалтай үр дүн нь төсвийн алдагдал нэмэгдэх явдал юм. Засгийн газар энэхүү хэлбэлзлийг зөөлрүүлэх арга олохгүй бол “зогс, яв” гэх маягийн мөчлөг дагасан давтамжид ордог. Энэ нь, газрын тосны үнэ өсөхөд засгийн газар зарцуулалтаа нэмэгдүүлж, үнэ буурахад зарцуулалтаа багасгаж байна гэсэн үг.

Нөөц баялгийн үнэд огцом уналт гарахад шууд үүсэх үр дагаврын нэг бол хөгжиж байгаа орны гадаад зээлээ хурдан төлөх чадвар буурдаг явдал юм. 1998 оны намар, сүүлийн есөн сарын турш газрын тосны үнэ нэг баррель нь 21 ам.доллараас 13 ам.доллар болж унасны (38 хувийн уналт) дараа, Оросын засгийн газар гадаад өрийн төлбөрөө хойшлуулах мэдэгдэл гаргасан нь дэлхийн хэмжээгээр санхүүгийн хямрал үүсгэсэн юм.

Үнийн томоохон өөрчлөлтүүд эдийн засгийн бусад ноцтой хүндрэл бэрхшээлийг үүсгэж болно. Урт хугацааны төлөвлөгөө тасрах; засгийн газар, бизнес, хувь хүмүүс зарцуулалтаа багасгах шаардлага тавигдаж болно. 108 дугаар хуудсанд үзүүлсэн хүснэгтэд ДНБ, экспортын орлого, улсын төсвийн орлого нь тухайн орны гол экспортын барааны үнийн (2-р багана) өөрчлөлтөөс маш их хамааралтай байдаг 10 орны жишээг харуулав. Хүснэгтэд үзүүлсэн тоонууд нь бараа, түүхий эдийн олон улсын үнийн өөрчлөлтүүд ба тухайн орны ДНБ, экспортын орлого, улсын төсвийн орлогын 1989-2002 оны өөрчлөлтүүдийн (экспортын дүнг ам.долларт шилжүүлсэн) хоорондын корреляцийн итгэлцүүрүүд юм. Уг үзүүлэлтүүдээс харахад эдгээр орны эдийн засгийн гол үзүүлэлтүүд нь

тэдний хувьд бүрэн хянаж чадахгүй олон улсын үнийн түвшинтэй хэрхэн нягт уялдаатай байгаа нь харагдаж байна. Өөр нэг нэмэлт жишээ бол Мексик улс бөгөөд газрын тосны орлого экспортынх нь 10 хувь, улсын төсвийн орлогынх нь 40 хувийг эзэлж байна.

Байгалийн баялгийн үнийн эдгээр хэлбэлзлээс өөрсдийгөө хамгаалахын тулд хөгжиж байгаа орны засгийн газрууд үнийн сөрөг өөрчлөлтөөс хамгаалах үнэт цаасны арга хэрэгслүүдийг ашиглаж болно. Эрсдлийн хамгаалалт буюу *хэджинг* бол үнийн хэлбэлзлийн эрсдлийг хөрөнгө оруулагчидтай хуваалцах нэг арга хэрэгсэл юм. Хэрвээ улсын төсвийг үнийн эдгээр хэлбэлзлээс хамгаалахгүй бол үнийн өөрчлөлт тухайн эдийн засгийг бүхэлд нь хамран нөлөөлөх магадлалтай.

Байгалийн баялгийн орлогод найддаг засгийн газрууд эдгээр бараа, түүхий эдийн үнийн өөрчлөлтөд өртөмтгий байдлаа бууруулахын тулд эрсдлийн хамгаалалтын аргыг олон янзаар хэрэглэж болно. Үүний гурван гол арга нь, 1) тогтворжуулалтын ба хуримтлалын сан, 2) бараа, түүхий эдийн бонд, 3) үнэт цаас ашиглан эрсдлээс хамгаалах явдал юм.

1) Нөөц баялгийн үр нөлөөг тогтворжуулах

Байгалийн нөөц баялаг хяслан болж хувирах зарим арга зам бол түүний хувь хүний болон засгийн газрын зарцуулалтад үзүүлэх нөлөө болон валютын ханш, олон улсын худалдааны өрсөлдөх чадварт үзүүлэх макро эдийн засгийн нөлөө юм. Жишээлбэл, эдийн засагт гадаад валют их хэмжээгээр орж ирэх нь гадаад валютын зах зээл дээрх тухайн орны валютын ханшийг өсгөх дарамт үзүүлж болно. Энэ нь тухайн орны дотооддоо тарьж ургуулж, үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний үнийн өрсөлдөх чадвар буурахад хүргэнэ. Үүний улмаас үйлдвэрлэлийн болон хөдөө аж ахуйн салбарт үүсэх уналтыг Голланд өвчин гэдгээр мэдэх билээ.

Хөрөнгө мөнгө гэнэт ихээр өссөний хор нөлөөг бодитойгоор багасгах буюу урьдчилан сэргийлэх нэг арга бол тухайн шинээр бий болсон хөрөнгө мөнгийг удаан хугацаанд ухаалгаар удирдан зарцуулах санхүүгийн институциуд байгуулах явдал юм.

ХҮСНЭГТ 1

Гол экспортын барааны үнээс хамаарах корреляцийн хамаарал

Улс	Бараа, түүхий эд	ДНБ	Экспорт	Орлого
Бурунди	Кофе	-0.55	0.44	1.00
Колумб	Газрын тос	0.05	0.30	0.62
Этиоп	Кофе	0.44	0.33	0.36
Гана	Кокоа	0.75	0.22	0.72
Казакстан	Газрын тос	0.65	0.90	0.44
Никрагуа	Кофе	0.48	0.40	0.48
Нигери	Газрын тос	0.30	0.66	0.11
Уганда	Кофе	0.65	0.52	0.64
Уругвай	Үхрийн мах	0.20	0.00	0.45
Венесуэл	Газрын тос	0.01	0.71	0.50

- ДНБ ба Орлогыг 1995 оны дотоодын валютын бодиг дүнгээр
- Экспортыг ам. долларын нэрлэсэн дүнгээр
- Олон улсын санхүүгийн статистик, 1989-2002

Корреляцийн итгэлцүүр нь хоёр хувьсагч зэрэг хөдөлж өөрчлөгдөж байгаа түвшнийг хэмждэг. 1 гэсэн утгатай байвал хоёр хувьсагч шууд хамааралтайг, сөрөг утгатай байвал урвуу хамааралтай байгааг, 0 утгатай байвал бие биенээсээ үл хамааран өөрчлөгдөж байгааг харуулна. 0.5 гэсэн утгатай байгаа нь нэг хувьсагчийн хөдөлгөөний хагасыг нөгөө хувьсагчийн адил төстэй хөдөлгөөнөөр тайлбарлах буюу хооронд нь холбон ойлгож болно гэсэн үг. Иймээс үнэ 10 хувиар өсч буюу буурч байвал, төсвийн орлого түүний тал хувиар буюу 5 хувиар даган өсч, буурна гэсэн утгатай.

Тогтворжуулалтын сан

Тогтворжуулалтын сангийн тухай эдийн засгийн суурь ухаан Библийн судар адил эрт дээр үед үүссэн билээ. Иосефийн тухай түүхэнд Иосеф хэрхэн Египетийн удирдагч нарт зөвлөгөө өгч, “тарган” жилүүд хэмээн нэрлэсэн асар их ургацтай долоон жилийн ургацыг нөөцөлж, түүнийгээ ирээдүйн “туранхай” жилүүдэд хэрхэн хуваарилан зарцуулахыг заасан байдаг. Энэхүү нөөцийн удирдлага нь Египетийн орлогыг удаан хугацаанд тогтвортой байлгаж, түүний энх тайван байдал, хөгжил цэцэглэлтэд хувь нэмрээ оруулсан байдаг.

Тогтворжуулалтын сангууд нь нөөц баялгийн үнэ зорилтот түвшнээсээ давж гарах үед илүүдлийг хуримтлуулж, эргээд зорилтот түвшнээсээ унах үед уг сангаа ашиглах зориулалттай байдаг. Үүний тулд тогтворжуулалтын сан нь бараа, түүхий эдийн үнэ өсч олз ашиг их олох үед зарим орлогыг урсгал зарцуулалтаас авч үлдээд, түүнийгээ үнэ өөрөөр эргэж төсвийн хомсдол үүсэх үед нэмэлт орлого бий болгодог. Тухайлбал, засгийн газар нэг баррель газрын тосны үнэ 30\$ байхаар

жишиг үнэ тогтоолоо гэж бодъё. Газрын тосны үнэ 30\$-оос дээш байх үед илүүдэл орлогыг тогтворжуулалтын санд шилжүүлнэ. Газрын тосны үнэ 30\$-оос доош буувал төсвийн алдагдлыг нөхөх үүднээс үнийн зөрүүг тогтворжуулалтын сангаасаа шилжүүлэх юм.

Үр нөлөөтэй байхын тулд тогтворжуулалтын санд хоёр төрлийн төсвийн хамгаалалт шаардлагатай. Нэгдүгээрт, тогтворжуулалтын сангийн илүүдлийг зээл авалтыг нэмэгдүүлэх барьцаа болгон ашиглахгүй байх шаардлагатай, ингэх нь зарцуулалтын хомсдлыг нэмэгдүүлж тогтворжуулалтын нөлөөг алдагдуулах аюултай. Энэ шаардлага байхгүй тохиолдолд үнийн оргил үед засгийн газрын зарцуулалтыг дарж чадахгүй. Хэрвээ засгийн газар нэмж зээл аваад, магадгүй тогтворжуулалтын сангаас олох ашгаасаа хэтэрсэн хүү төлөөд байх юм бол мөнгө хуримтлуулсны утга учир байхгүй болно. Шинээр авсан зээлийн хүүгийн зардал ч бараа, түүхий эдийн үнэ их биш байх үеийн ирээдүйн орлогод ачаалал авчрах болно.

Хоёрдугаар хамгаалалт нь үнийн хямралд орсон үед чухал ач холбогдолтой бөгөөд тухайн сангийн чанд хатуу байдлыг баталгаажуулж, улмаар ямар нэг богино хугацааны зорилгод ашиглуулахгүй гэсэн үг. Тогтворжуулалтын сан нь бараа, түүхий эдийн үнэ зорилтот хэмжээнээсээ доош унах үед улсын төсөвт тодорхой хэмжээний мөнгө шахаж оруулах зориулалттай. Гэвч, зарим үед засгийн газар нэмэлт санхүүжилт гаргахыг шаардан, тус сангийн менежерүүдэд ихээхэн дарамт үзүүлдэг. Иймд, тус сангийн хуримтлалыг ирээдүйн тогтворжуулалтын зорилгод зориулж хамгаалах үүднээс улс төрийн шууд дарамт шахалтаас хамгаалагдсан, тус сангаар үйлчлүүлэгч ард иргэдийн өмнө эцсийн хариуцлага хүлээж төлөөлөх мэргэжлийн хүнээр удирдуулах шаардлагатай. Үүнийг хийх нэг арга бол хууль тогтоох байгууллагаас ямар нэг комисс юмуу зөвлөлийг тодорхой хугацааны дараа бүрэн эрх нь дуусгавар болох байдлаар дунд хугацаагаар томилон ажиллуулах явдал юм.

Амжилттай ажиллаж байгаа ийм сангийн нэг жишээ бол Чилийн Зэсийн Сан юм. 1985 онд байгуулагдсан тус сан улсынхаа Төв Банкнд данстай бөгөөд бие даасан удирдах зөвлөлтэй (түүний дотор төрийн өмчийн зэсийн корпораци КОДЕЛКО-н гишүүд ордог) ажээ. Тус сан Чилийн засгийн газарт төсвийн хомсдолд орохоос сэргийлэхэд туслах талаар итгэл хүлээсэн байна. Харин өөр нэг муу жишээ бол Венесуэлийн Макро Эдийн Засгийн Тогтворжуулалт, Хөрөнгө Оруулалтын Сан (ФИЕМ буюу ФИЕМ) бөгөөд энэ санд төсвийн хатуу дэг журам дутагдсанаас засгийн газар зарцуулалтаа нэмэгдүүлэхийн тулд хуримтлагдсан хөрөнгөнөөс зээл авах боломжтойгоос гадна тус санд төлөх ёстой хуваарьт төлбөрийнхөө хугацааг хойшлуулж болдог байна. Үүний үр дүнд ФИЕМ дөнгөж 700 сая \$-ын нөөцтэй² (газрын тосны үнэ маш өндөр байсан ч гэсэн) үлдсэн бөгөөд түүний үр нөлөө буурсаар байна.

Амжилттай ажиллаж буй тогтворжуулалтын сан нь улсын төсвийг тогтворжуулаад зогсохгүй валютын ханш чангарахаас сэргийлэх замаар Голланд өвчнөөс хамгаалдаг байна. Үүний тулд тухайн улсын валютын үнэ ханшийг нэмэгдүүлэхэд чиглэсэн дарамтыг багасгахын үүднээс тус сангийн хуримтлалыг гадаад валютаар нэрлэгдсэн үнэт цааснуудад хөрөнгө оруулах замаар хамгаалж болно.

Аливаа үр нөлөөтэй тогтворжуулалтын сан үндэснийхээ нөөц баялгийг эдийн засгийн тогтворжуулагч хүчин болгон хувиргаж чаддаг. Гэхдээ энэхүү бодлогын стратегид нэг хязгаарлалт бий. Энэ нь эхлээд “тарган” сайхан жилүүд ирнэ гэсэн төсөөлөлд тулгуурладаг. Сан ирээдүйд олох орлогоороо л барьцаалж зээл авахгүй л бол нөөц баялгийн үнэ нь зорилтот түвшинээсээ дээш гараагүй тохиолдолд улсын төсөв тогтворжуулах нөлөө үзүүлж чадахгүй. Иймээс ийм сан нь эдийн засгийн нэмэлт урамшуулагч болж ажиллахаасаа өмнө юун түрүүнд эдийн засгаа хүндрэлээс авч гаргах улс төрийн нэмэлт ачаалал үүрдэг.

Хуримтлалын сан

Хуримтлалын сан нь ирээдүйд зориулж мөнгө хуримтлуулах гол зорилготойгоороо тогтворжуулалтын сангаас ялгаатай. Энэ нь нэг бол засгийн газарт хойшлуулшгүй санхүүжилт хэрэгтэй үед буюу “бороотой өдөр”-өөс аврах зорилготой, эсвэл ирээдүй хойч үед зориулж мөнгө хуримтлуулдаг байж болно. Ялангуяа зөвхөн өнөө үеийнхэн нь хэрэглээд шавхагдаж болзошгүй үл нөхөн сэргээгдэх байгалийн баялагтай тохиолдолд ийм сан онцгой чухал. Хуримтлалын санд буй хөрөнгө итгэлцлийн сан үүсгэх бөгөөд түүнээс олох орлого удаан хугацаагаар зарцуулагдаж болно. Үүний нэг жишээ бол 1977 онд байгуулагдсан Аляскийн Байнгын Сан юм. 2003 оны эцэс гэхэд уг сан 28 тэрбум гаруй ам.долларын хөрөнгө хуримтлуулсан байв. Эдгээр хөрөнгө нь Аляскийн бүх иргэдэд зориулан зарцуулах орлогыг бүрдүүлдэг³.

2) Бараа, түүхий эдийн бондууд

Бонд буюу өрийн бичиг нь санхүүжилт бүрдүүлэхийн тулд засгийн газар эсвэл корпорациаас гаргадаг үнэт цаас юм. Ердийн бонд нь жилийн эсвэл хагас жил тутмын хүүгийн тогтмол төлбөр (купоны төлбөр ч гэдэг) ба хугацааны эцэст төлөх үндсэн төлбөрөөс бүрддэг. Жишээлбэл, 30 жилийн хугацаатай, 5 хувийн купоны төлбөртэй АНУ-ын төрийн сангийн 1000\$-ын бонд нь хагас жил тутамд 25\$-ын купоны төлбөртэй (бондын үндсэн төлбөрийн 5 хувьтай тэнцэх) байх ба 30 жилийн дараа 1000\$-ыг бүтнээр нь буцааж төлөх юм. Ердийн бондын үнэ нь ирээдүйн бүх купоны ба үндсэн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр тодорхойлогддог. Ирээдүйн төлбөрүүд

нь одоогийн төлбөрөөс бага үнэ цэнэтэй бөгөөд алс ирээдүйд төлөгдөх төлбөрүүд нь ойрын ирээдүйд төлөгдөх төлбөрүүдээс бага үнэ цэнэтэй учраас, ирээдүйн төлбөрүүдийг зохих хэмжээгээр багасган өнөөгийн үнэ цэнэд нь хүргэх байдлаар бондын үнэ цэнийг тодорхойлдог.

Бараа, түүхий эдээр индексжүүлсэн бондууд

Бараа, түүхий эдийн бонд нь ердийн бондоос ялгаатай. Учир нь тэдгээрийн купоны эсвэл үндсэн төлбөрүүдийг цаана нь байгаа тодорхой нэг барааны үнийн дагуу тохируулах байдлаар зохицуулдаг. Жишээлбэл, газрын тосны бондыг 1000 баррель газрын тосыг уг бондын хугацаа дуусах үеийн газрын тосны зах зээлийн үнээр үржүүлсэн хэмжээтэй тэнцэх хэмжээний үндсэн төлбөртэйгээр тогтоож болно. Нэг баррель газрын тосны үнийг 25\$-р тооцвол 25000\$ болно гэсэн үг. Хэрэв тэр үед газрын тосны үнэ 20\$ болж буурсан тохиолдолд уг бондыг гаргасан зээлдэгч зөвхөн 20000\$ эргүүлж төлөх ёстой байна. Иймээс хэрэв бондын хугацаа дуусахад үнэ доогуур байх юм бол тухайн зээлдэгч үнэ өндөр байх үеийнхээс бага мөнгө төлөх үүрэгтэй бөгөөд энэ нь хөгжиж байгаа орны зээлдэгчийн газрын тосны үнийн эрсдлийг хөрөнгө оруулагчид шилжүүлж байна гэсэн үг.

Хэрэв үнэ өссөн тохиолдолд уг засгийн газар илүү их төлбөр төлөх болно. Гэхдээ газрын тосны үнэ өссөний улмаас тухайн улсын газрын тосны экспортын орлогын урсгал мөн нэмэгдэх учраас тухайн засгийн газар энэ их өрийг төлөхдөө арай дээр байр сууринд очсон байх болно.

Энэ төрлийн бараа, түүхий эдээр индексжүүлсэн бондыг үнэт цаас давхар хавсаргасан ердийн бонд гэж үзэж болох бөгөөд тэрхүү үнэт цаас нь тухайн бондын купоны болон үндсэн зээлийн төлбөрийг газрын тосны үнэд шилжүүлэн хөрвүүлэх үүрэгтэй байна. Дан ганц бондын үндсэн төлбөр нь эдийн засгийн хувьд форвардын буюу урьдчилан худалдах гэрээтэй адил байх бөгөөд купоны цуврал төлбөрүүд нь эдийн засгийн хувьд свап эсвэл цуврал форвардын гэрээнүүдтэй адил утгатай байна⁴.

Бараа, түүхий эдтэй холбосон бондууд

Бараа, түүхий эдийн бондын өөр нэг хувилбар нь купоны болон үндсэн төлбөрүүдийг цаад бараа бүтээгдэхүүнийх нь үнэтэй опцион хэмээх үнэт цаас дагалдуулах замаар холбож өгдөг.⁵ Опцион нь тухайн холбогдох бараа, түүхий эдийн үнэ нь “цохилтын” буюу “төлбөр хийх” хэмээх тогтоосон зорилтот үнээс дээш гарах тохиолдолд (эсвэл зөвхөн доош буух юм бол) төлбөр хийгддэг. Жишээлбэл, нэг баррель нь 50\$-ын цохилтын үнэтэй 1000 баррель газрын тосны опцион нь 50\$-аас хэтэрсэн зах зээлийн үнийг нэг мянга дахин үржүүлсэн хэмжээний төлбөр төлнө.

Бараа, түүхий эдтэй холбосон бондын хувьд, хэрвээ газрын тосны үнэ зорилгот буюу цохилтын үнээс доош унавал купоны болон үндсэн төлбөрүүд буурах, гэхдээ үнэ цохилтын үнээс дээш гарах юм бол дээрх төлбөрүүд өсөхгүй байхаар зохицуулсан байж болох юм. Газрын тосны үнэ буурах эрсдлийг бонд эзэмшигчээс шилжүүлэхийн тулд зээлдэгчийн зүгээс бондын хөрөнгө оруулагчид бондын үр ашгийн урамшуулал хэлбэрээр эрсдлийн төлбөр буюу даатгалын “шагнал” төлөх шаардлагатай болно. Иймээс газрын тосны үнэ цохилтын үнээс доош унахад зээлдэгч бага хэмжээний төлбөр төлөх боломжтой опцион эзэмшиж эхэлнэ гэдгийг бондын үнэ ба купоны ашигт тусгах ёстой юм. Бондын хөрөнгө оруулагчид эрсдэл хүлээснийхээ төлөө нэг бол бага үнэ төлөх эсвэл илүү өндөр хувьтай купоны төлбөр авах ёстой.

Бараа, түүхий эдтэй холбосон бондууд ихэвчлэн хоёр үндсэн төрөлтэй байдаг. Дээр дүрсэлсэн “богино” заалттай худалдах опцион бүхий бондууд нь зээлдэгч нэг бол тогтоосон хэмжээнээс бага төлбөр төлөх эсвэл бараа, түүхий эдийн үнэ цохилтын үнээс доош унасан тохиолдолд тухайн барааны үнээр төлбөр төлөх эрхийг олгодог. Энэ төрлийн бараа, түүхий эдтэй холбосон бондууд нь барааны үнэ буурах эрсдлийг гадаадын бондын хөрөнгө оруулагч нарт шилжүүлдэг байна. Харин “урт” худалдан авах опцион бүхий бондууд нь бондын хөрөнгө оруулагч нэг бол тогтоосон хэмжээнээс өндөр төлбөр авах эсвэл барааны үнэ цохилтын үнээс хэтэрсэн тохиолдолд тухайн барааны үнээр тооцсон төлбөр авах эрх олгодог. Энэ тохиолдолд, бондын хөрөнгө оруулагч үнийн өсөлтөөс олох өндөр ашгаа хуваалцахад хүрэх бөгөөд хөгжиж буй орны зээлдэгчийн хувьд бага хүүтэй зээл авснаараа хожих юм.⁶

Эдгээр бүх төрлийн бараа, түүхий эдийн бондууд нь хөгжиж байгаа орнуудад тусалж, тэдэнд учрах барааны үнийн эрсдлийн заримыг нь шилжүүлж авахын зэрэгцээ нөгөө талаас өндөр өртөгтэй тусч болно. Форвардын гэрээ дагуулсан ч бай, опционы гэрээ дагуулсан ч бай бараа, түүхий эдийн бондууд нь ердийн бондуудаас илүү нарийн түвэгтэй байдаг. Санхүүгийн зах зээлүүдэд нарийн түвэгтэй байдал нь энгийн байдлаасаа илүү үнэ өртөгтэй байдаг. Түүнчлэн, богино заалттай опцион бүхий бараа, түүхий эдтэй холбосон бондуудад олгох опционы урамшуулал нь нэмэлт зардал болдог бөгөөд зээлдэгчид энэхүү нэмэлт зардлыг купоны өндөр хүүгийн хэлбэрээр төлдөг. Гэхдээ, ямар ч тохиолдолд хөгжиж байгаа орны зээлдэгчид бонд нарийн түвэгтэй болох тусам илүү их бондын ашиг төлдөг. Бараа, түүхий эдийн үнэ унасан тохиолдолд арай бага купоны болон үндсэн төлбөр төлөх боломж олгодог бөгөөд барааны үнийн урт хугацааны эрсдлийг даахад бэлэн байгаа гадаадын хөрөнгө оруулагчдад нэн тэргүүнд зарвал зохих бондууд ч гэсэн өндөр үр ашигтай байж болно.

3) Үнэт цаас ашиглан хамгаалах нь

Тогтворжуулалтын сангууд ба бараа, түүхий эдийн бондууд нь эрсдлийн удирдлагын хоёр стратеги юм. Харин хүндрэл бэрхшээлийг илүү шууд бөгөөд боломжийн зардлаар авч үздэг өөр нэг бодлогын арга бол бараа, түүхий эдийн үнийн өөрчлөлтөөс хамгаалахад үнэт цаас ашиглах явдал юм.

Зах зээл дээр олон янзын үнэт цаасны арга хэрэгсэл байдаг. Тэдний зарим нь фючерсийн зах зээл дээр (ихэвчлэн фючерс ба опционы төрлийн гэрээнүүд байдаг) бусад нь лангууны зах зээл дээр (урьдчилан худалдах гэрээ, опцион, свапууд) арилжаалагддаг⁷.

Биржээр арилжаалагддаг гэрээнүүд ихэвчлэн богино хугацаатай байдаг бөгөөд урт хугацаагаар үр нөлөөтэй хамгаалахын тулд тэдгээрийг нэг сараас нөгөө сар хүртэл эргэлдүүлж болно⁸. Эргэлдүүлнэ гэдэг нь нэг сарын дараа хугацаа нь дуусах фючерсийн гэрээ борлуулаад, түүнийгээ хугацаа нь дуусахаас өмнө худалдан авч, эргүүлээд нэг сарын дараа хугацаа нь дуусах өөр нэг гэрээ худалдахыг хэлнэ. Жишээлбэл, эрсдлээс хамгаалагч этгээд эхлээд 1 дүгээр сард 2 дугаар сарын газрын тосны фючерсийг худалдана, дараа нь түүнийгээ хугацаа нь дуусахаас нь өмнө худалдаж аваад 3 дугаар сарын фючерс худалдана, тэгээд түүнийгээ хугацаа нь дуусахаас нь өмнө худалдаж аваад 4 дүгээр сарын фючерс худалдана гэх мэт. Энэхүү эргэлдүүлэх үйл явцтай холбоотой эрсдэл санаа зовсон хүмүүс энэ аргад эргэлздэг. Эргэлдүүлэх үйл явцын өөрийн үндсэн эрсдэл ба зах зээлд хөрвөх чадваргүй болох эрсдлүүд нь бодитой боловч урт хугацааны явцад эрсдэл багатай бөгөөд огт хамгаалаагүй байсныг бодвол боломжийн үр дүнтэй гэдэг нь нотлогдсон байна. Түүнчлэн, олон тооны үндэстэн дамжсан газрын тосны компаниуд, дэлхийн хэмжээний хөдөө аж ахуйн корпорациуд, бусад бизнесийн байгууллагууд энэ аргыг үнийн эрсдлээс хамгаалах хямд төсөр бөгөөд үр нөлөөтэй хамгаалалт гэж үзэн тогтмол хэрэглэдэг байна.

Энэхүү аргын нэг чухал хувилбарыг Австралийн Буудайн Зөвлөл хэрэглэдэг.⁹ Тус зөвлөл оролцогч фермерүүддээ ургацын хамгийн доод үнийг амладаг буюу үнэн хэрэгтээ тавигдсан опционуудыг оролцогч фермерүүдэд үнэгүй олгодог. Дараа нь, фючерсийн бирж дээр буудайн фючерс зарах замаар энэхүү хөдөө аж ахуйн хөтөлбөрөө эрсдлээс хамгаалдаг. Саяхан 1990-ээд оны сүүл үе гэхэд Австралийн Буудайн Зөвлөл нь Чикагогийн Худалдааны Зөвлөл дээр буудайн фючерсийн зах зээлийн хамгийн том оролцогч болсон байсан.

Фючерс буюу форвард/урьдчилан худалдах гэрээгээр хамгаалах

Хамгаалалт нь эрсдлийг дараахь байдлаар багасгадаг. Газрын тосны үйлдвэрлэл, экспорт нь тухайн улсын нийт үйлдвэрлэл ба экспортын хэмжээтэй тэнцүү байх нэгэн улсын тухай энгийн жишээ авч үзье. Үнийн түвшин 20 хувь өсөх буюу буурахад тус улсын нийт үйлдвэрлэл ба экспортыг 20 хувиар өсгөх буюу бууруулна. Тус улс газрын тосны “богино” хугацаат байрлалаар энэхүү цочирдлоос хамгаалж болно. Тухайлбал, урьдчилан худалдах гэрээ буюу форвардын зах зээл дээр газрын тос борлуулж болно. Богино хугацаат урьдчилан худалдах байрлалын хувьд тодорхой хэмжээний бараа, түүхий эдийг ирээдүйн тодорхой хугацаанд тодорхой үнээр нийлүүлэхээр тохирч борлуулахыг шаарддаг. Хэрвээ газрын тосны урьдчилан худалдах гэрээг 12 дугаар сарын 31-нд нэг баррелийг нь 25\$-р нийлүүлэхээр 1 дүгээр сарын 1-нд зарсан бол газрын тосны үнэ 5\$-р буурсан тохиолдолд урьдчилан худалдах гэрээнд хамрагдсан нэг баррель газрын тос тутмаас 5\$-ын ашиг гарна гэсэн үг. Харин газрын тосны үнэ нэг баррель нь 5\$-р өсвөл урьдчилан худалдах гэрээнд хамрагдсан нэг баррель газрын тос тутмаас 5\$ алдана.

Хамгаалалтын дүүжин

Одоо байгаа эрсдлүүдийг авч үзэх дараахь жишээнүүд байдаг. Фермерүүд бүтээгдэхүүнээ тарьж ургуулахаар шийдсэн хугацаа ба ургацаа хурааж, зах зээл дээр нийлүүлэх хугацаа хоёрын хооронд үнэ унах эрсдэлтэй тулгардаг. Газрын тос үйлдвэрлэгч орны засгийн газрууд төсвийн жилийн турш газрын тосны үнэ унах эрсдэлтэй тулгардаг бол газрын тос импортлогч улсын засгийн газрууд газрын тосны үнэ өсөх эрсдэлтэй тулгардаг.


Эрсдлийн хамгаалалтын хамгийн сайн тодорхойлолт бол одоо байгаа эрсдлийг багасгах явдал юм. Нөгөө талаас, одоо байгаа эрсдлийг нэмэгдүүлэх үйл ажиллагаанд оролцох явдал бол спекуляцийн үйл ажиллагааны хамгийн сайн тодорхойлолт мөн.

Одоо байгаа эрсдлийг заримдаа эрсдлийн менежмент гэж нэрлэдэг үйл явц болох эрсдлийн хамгаалалтын үнэт цаас ашиглан багасгаж болно. Үүний тулд одоо байгаа эрсдлээс учрах алдагдлыг (мөн одоо байгаа эрсдлээс олох ашгийг) нөхөхүйц үнэт цаасны гэрээнд ордог. Хамгаалалтад ашиглаж буй үнэт цаасны үнэ цэнэ нь одоо байгаа үнийн эрсдлийн үнэ цэнэтэй ижил хэмжээгээр боловч эсрэг чиглэлд өөрчлөгдөж байх ёстой. Жишээлбэл, 1 тэрбум баррель газрын тос экспортлогч улс газрын тосны үнэ нэг доллараар унах бүрт 1 тэрбум ам.долларын алдагдал хүлээх эрсдэлтэй. Иймд тус улс газрын тосны үнэ нэг доллараар унах

бүрт 1 тэрбум доллараар үнэ цэнэ нь нэмэгдэж байх газрын тосны фючерсийг Нью Йоркийн Худалдааны Бирж дээр борлуулах замаар эрсдлээс хамгаалж болно.

Одоогийн эрсдэл ба хамгаалалтын үнэ цэнэ хоёрын хамаарлыг хүүхдийн дүүжин буюу дүүжин даажин тоглоомын санхүүгийн хувилбар гэж үзэж болно. Дүүжингийн нэг үзүүр нь дээшээ болох тэр хэмжээгээр нөгөө үзүүр нь доошоо бууж, хэрвээ аль нь ч хөдлөхгүй бол хоёулаа хэвтээ тэнхлэгийн дагуу тэнцүү байрлалд тогтдог. Дараахь зурагт энэ ойлголтыг графикаар дүрсэлсэн бөгөөд тухайн үеийн байрлалын үнэ цэнэ буюу экспортлоход бэлэн байгаа ургац эсвэл газрын тосны үнэ цэнэ (S) өсөхөд фючерсийн буюу ирээдүйн байрлалын үнэ цэнэ (F) унаж байгааг болон эсрэг тохиолдлыг эндээс харж болно. Аль ч тохиолдолд дээрх хоёр байрлалын нийлбэр дүүжингийн төвийн байрлалтай тэнцүү байна.

Эрсдлийн хамгаалалт: Одоо байгаа үнийн эрсдэл болон хамгаалалтын өөрчлөлтийн нийлбэр тэг байна: $S=F$



Эрсдлийн хамгаалалт нь үнэ унах үед олз ашиг, үнэ өсөх үед алдагдал авчрах бөгөөд улмаар нөөц баялгийн борлуулалтын орлогын өсөлт, бууралтын үр нөлөөг нөхөж байдаг. Энэ нь үнийн хувьсамтгай байдлаас үүсэх төсвийн орлогын тогтворгүй байдлыг багасгаж өгдөг. Энэ нь мөчлөг дагасан төсвийн бодлогоос урьдчилан сэргийлэхэд туслахын зэрэгцээ эдийн засгийн байдлыг тогтворжуулах, тогтвортой өсөлтийг хөхиүлэн дэмжихэд чиглэсэн мөчлөгийн эсрэг үүрэг илүүтэй гүйцэтгэх боломжийг засгийн газарт олгодог. Түүнчлэн,

жилийн эцэст үйлдвэрлэл, экспортын хэмжээ ямар байхыг, тухайлбал 250 сая ам.доллар байна гэдгийг, 1 дүгээр сард хүн бүр мэдэж байх болно. Засгийн газар ч бас гадаад өр, зээлээ төлөхдөө (газрын тосны үнэ ямар ч байсан хамаагүй) эдгээр санхүүжилт орж ирнэ гэдгийг мэдэж байх болно.

Үнэт цаасаар дамжуулан хамгаалах ажлыг фючерс, форвард, свапийн гэрээний алинаар нь ч хийж болно.¹⁰ Фючерсийн ба форвардын гэрээний аль аль нь тодорхой нэг зүйлийг тогтоосон хэмжээгээр, тодорхой үнээр, ирээдүйн тодорхой хугацаанд худалдан авах буюу худалдах үүрэг хүлээдэг. Ялгаа нь фючерсийн гэрээнүүд нь стандартчилагдсан, нийтэд арилжаалагддаг, тооцооны төвүүдээр дамжуулан тооцоо хийгддэг онцлогтой. Аливаа орны газрын тосны бүтээгдэхүүн нь ихэнх томоохон биржүүдэд арилжаалагддаг стандарт бүтээгдэхүүнүүдтэй адилгүй байж болно. Хэрвээ өөр зэрэглэлийн газрын тос үнийн хэлбэлзлийн хувьд бусадтайгаа адилгүй гэж үзвэл тухайн засгийн газар лангууны зах зээлээр дамжуулан форвардын гэрээ байгуулж болно. Энэ нь үнэт цаасны дилерүүдээр (ихэвчлэн томоохон банкууд эсвэл брокер дилерүүд) дамжин арилжаалагддаг хэрэглэгчид тохируулсан гэрээнүүд юм. Лангуугаар дамжсан гүйлгээнүүд нь дараахь ашиг тустай. Тухайлбал, тэдгээр нь талууд хэрэгцээндээ тохируулан гэрээ байгуулах боломж олгодог бөгөөд эхний барьцааны хөрөнгө буюу ашгийн хувь шаарддаггүй. Лангуугаар дамжсан гүйлгээнд бас зарим нэг сул тал бий: Тэдгээр нь албан ёсны бирж дээр явагддаггүй, иймээс ил тод байдал бага, ямар нэг биржийн тооцооны төвөөр баталгааждаггүй, улмаар эрсдлээс хамгаалагчийн хувьд үнэт цаасны дилерт итгэхээс аргагүйд хүргэдэг эрсдэлтэй. Түүнээс гадна, лангууны зах зээл нь ямар нэг луйвар, заль мэхнээс сайн хамгаалагддаггүй байдаг бол биржүүдийг засгийн газрын зүгээс болон бирж өөрөө хянаж байдаг.

Үнэт цаасаар дамжуулан эрсдлээс хамгаалахын давуу талууд бол хямд төсөр байдаг, буцааж болох бодлого байдаг (өөрөөр хэлбэл, засгийн газар хамгаалалтаа авахаар шийдэж болно), мөн энэ нь заавал “тарган” сайхан жилүүд эхэндээ байхаас хамаардаггүй. Мөн бараа, түүхий эдийн бондуудад хөрөнгө оруулахад бэлэн байгаа цөөн тооны хөрөнгө оруулагчдад үр ашгийг нь хүртээж байхын оронд ердийн өр, зээлийн арга хэрэгслүүдийг ашиглан зээл авах боломж олгодог. Тогтворжуулалтын сангуудтай адилгүй нь, үнэт цаасаар дамжуулан эрсдлээс хамгаалах нь албан тушаалтнуудыг авилгалд уруу татахгүйгээс гадна шинэ буюу өргөтгөсөн хөтөлбөртөө хялбар санхүүжилт олохыг хичээсэн хүмүүсийн бай болоод байхгүй. Сул тал нь гэвэл фючерсийн гэрээнд үнийн өсөлтөөс олох ашгийг алддаг. Энэ асуудлыг шийдэх нэг арга бол урт хугацаагаар бус харин хоёр, гурван жилийн хязгаарлагдмал хүрээнд хамгаалалт хийх эсвэл үнийн дүнгийн

зөвхөн 75 буюу 80 хувийг хамгаалж, үнийн өөрчлөлтийн зарим нөлөөг эдийн засаг өөрөө “мэдрэх” боломж олгох явдал юм.

Опционы хамгаалалт

Хэрвээ засгийн газар фьючерс буюу форвардын гэрээний алийг нь ч ашиглахыг хүсэхгүй, улмаар газрын тосны үнийн гэнэтийн өсөлтөөс үүдэх боломжит ашгаас татгалзаж байвал, түүний оронд опцион ашиглаж үнийн уналтаас хамгаалах “даатгал” хийлгэж болно¹¹. Опцион хэрэглэснээр, засгийн газар опцион борлуулагч буюу газрын тосны хамгийн доод үнийг баталгаажуулж байгаа “даатгагч”-д урамшуулал төлж байна гэсэн үг. Жишээлбэл, засгийн газар хэрвээ газрын тосны үнэ нэг баррель нь 25\$-оос доош унах юм бол ноцтой санхүүгийн хүндрэлд орно гэдгээ тодорхойлсон байж болно. Иймд засгийн газар нэг баррель нь 25\$-ын цохилтын үнэтэй опционыг худалдан авах замаар энэ боломжоос хамгаалах болно. Хэрвээ үнэ 25\$-оос дээш хэвээр байх юм бол уг опцион үйлчлэхгүй, харин үнэ нь 25\$-оос доош унавал уг 25\$ ба түүнээс доогуур байгаа газрын тосны зах зээлийн үнэ хоёрын зөрүүг уг опционыг гаргагч төлөх юм. Энэ нь засгийн газрыг үнийн уналтаас хамгаалах бөгөөд харин алдагдлыг тухайн хөрөнгө оруулагч хүлээнэ.

Опцион нь газрын тосны үнийн уналтаас сэргийлэх даатгалын бодлого болж үйлчилдэг бөгөөд эндээс үзэхэд үнийн өндөр хэлбэлзлийн эсрэг даатгал нь харьцангуй тогтвортой үнийн даатгалаас илүү чухал болох нь харагдаж байна. Иймд газрын тос гэх мэт үнийн хэлбэлзэл ихтэй барааны опционы урамшуулал нь богино хугацааны хүүгийн хувь гэх мэт хэлбэлзэл багатай зүйлсийг бодвол илүү өндөр байдаг. Энэ нь эрсдэл ихтэй жолооч нарын хувьд автомашины даатгалын хувь өндөр байдагтай адилхан. Засгийн газрууд энэхүү нэг талт мөрийний эрсдэлтэй талыг хүлээн зөвшөөрөх хөрөнгө оруулагчдыг олж татахын тулд газрын тосны үнийн өөрчлөлтийн эрсдлийг тусгасан урамшуулал төлөх хэрэгтэй болно. Опционы эдгээр урамшуулал маш их үнэтэй байж ч болно. Гэхдээ, хэрэв газрын тосны үнэ өсвөл засгийн газар түүнээс ч илүү ашиг орлого олох боломжтой нь нэг давуу тал юм.

Эрсдлээс хамгаалах туршлага

Газрын тос экспортлогч орнууд эрсдлийг багасгахын тулд эрсдлийн хамгаалалтын арга хэрэгсэл ашиглаж байгаа хэмжээний талаар нийтэд зориулсан мэдээлэл бага байдаг. Мексик улс, Техас муж улс зэрэг зарим газрын тос үйлдвэрлэгчид ийм хэрэгслүүдийг амжилттай хэрэглэж байгаагаас гадна хөгжиж байгаа орнуудад эрсдлийн хамгаалалт хэрэглэх явдал харьцангуй хязгаарлагдмал байна гэдэгтэй

зах зээлийн шинжээчид санал нэг байдаг.¹² Хөгжиж байгаа орнууд яагаад санхүүгийн давуу талыг нь эс харгалзан засгийн газрын эрсдлийн хамгаалалтаас жийрхээд байгаагийн хэд хэдэн шалтгаан байдаг.

- ▶ Гол эсэргүүцэл нь улс төрийн шинжтэй байж болно. Хэрвээ сангийн сайд нь фючерсийн гэрээ ашиглан газрын тосны үнийн уналтаас хамгаалах арга хэмжээ авлаа гэхэд үнэн хэрэгтээ газрын тосны зах зээлийн үнэ өсч тухайн орон уг ашгаас хүртэж чадахгүйд хүрэх юм бол уг сайдын хашир байдлыг магтан сайшаах хүн цөөн байх болно. Түүнчлэн, засгийн газар яагаад газрын тосноос ийм их ашиг олох боломжийг алдав гэдгийг тайлбарлахад хэцүү байх болно. Нөгөө талаас, хэрэв сангийн сайд нь хамгаалах арга хэмжээ аваагүй байлаа гэхэд газрын тосны үнэ доош унах тохиолдолд засгийн газар өөрсөддөө ирэх зэмлэлээс зугтаж, олон улсын зах зээлийг буруутгаж болно. Хэрэв сангийн сайд нь үнийн гэнэтийн огцом уналтын эрсдлээс хамгаалахын тулд опционы урамшуулал төлөхөөр боллоо гэхэд тэр мөнгийг нийгмийн наад захын хэрэгцээнд зарцуулахгүй “дэмий үрлээ” хэмээн буруутгагдаж болох юм. Үүнээс дүгнэхэд, засгийн газар эрсдлийн хамгаалалтын бодлогоо нийтэд тайлбарлахад хэцүү гэж үзэж болох юм.
- ▶ Эрсдлийн хамгаалалт нь мөн өндөр үнэтэй тусч байж болно. Үнэт цаасны бүхий л гүйлгээнд борлуулалтын хураамж, дилерт төлөх үйлчилгээний хөлс, барьцаанд тавих хөрөнгийн зардал гэх мэт зардал гардаг. Түүнчлэн, опционы урамшуулал маш өндөр үнэтэй байх бөгөөд засгийн газрын эрсдлээс хамгаалахыг хүссэн барааны үнийн хэлбэлзэл болон хугацаанаас хамаарч энэ зардал нэмэгддэг.
- ▶ Эрсдлийн хамгаалалт бол нарийн түвэгтэй ажил бөгөөд нилээд ур чадвар, институцийн чадавхи шаарддаг. Бараа, түүхий эдийн эрсдлийн удирдлагын хэрэгслүүд нь засгийн газрын ажилтнуудад уламжлал ёсоор тавьдаг шаардлагаас хамаагүй боловсронгуй санхүүгийн мэдлэг чадварын түвшин шаардах болно. Гүйлгээний эрсдлийн бүтцийг ойлгох, эрсдлийн удирдлагын стратегийг тогтоох, хамгаалалтын гэрээнд орж, гүйлгээнд хяналт тавих зэрэгт мэдлэг туршлага шаардлагатай. Харин худалдааны эрсдлийн менежерүүдтэй гэрээ байгуулах, эсвэл Дэлхийн Банк, НҮБ-ын Худалдаа Хөгжлийн Бага Хурал гэх мэт байгууллагаас хангаж өгсөн техникийн заавар зөвлөгөөг ашиглан эдгээр мэдлэг туршлагыг олж авч болно.

ДүГНЭЛТ

Эрсдлийн хамгаалалт нь бараа, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хамгаалж чадах боловч газрын тос үйлдвэрлэгч орнуудад нийтлэг байдаг авилгалын асуудлаас сэргийлж чадахгүй. Төсвийн нийт зохисгүй удирдлага, авилгал хоёрыг (төсвийн хөрөнгийг шууд идэж шамшигдуулах, улс төрийн зорилгоор буруу удирдан зарцуулах гэсэн утгаар) аль алиныг нь багасгах нэг арга бол засгийн газрын төсвийн ил тод байдлыг өндөр түвшинд хүргэх явдал юм.

Засгийн газруудад улсын төсөв болон төсөвлөлтийн үйл явцыг илүү ил тод болгох шахаалт үзүүлэх зорилгоор хэдэн зуун төрийн бус байгууллага нэгдэн “Төлснөө Нийтэл” нэртэй нөлөөллийн компанит ажлыг эхлүүлсэн бөгөөд корпорациуд газрын тос, металл болон бусад ашигт малтмалыг олборлосныхоо төлөө хөгжиж байгаа орнуудын засгийн газарт төлж байгаа нөөц ашигласны төлбөр, эрхийн төлбөр ба бусад бүх төлбөрөө тайлагнадаг болгохыг зорьж байна. Уг компанит ажил нь корпорацийн тайлангууд болон хөгжиж байгаа орны улсын төсвийг илүү ил тод болгож, улмаар зохисгүй удирдлага ба авилгалыг ил гаргах, багасгахад чиглэгдэж байна.

Баялаг хяслан болно гэж бодоход санаа зовмоор боловч энэ талаар өчүүхэн зүйл хийгээд байгааг харах юм бол бүр ч бухимдах болно. Дээр дурдсан бодлогын эмчилгээнүүд бүгд хэрэгжих үндэслэлтэй, боломжийн өртөгтэй бөгөөд тэдний аль нь ч бодлогын ноцтой асуудал үүсгэхгүй. Эмчилгээний арга бүрийн бусад давуу тал, дутагдал, өмнөх туршлагуудаас авч болох сургамжийг олж мэдэх үүднээс тэдгээрийг гүнзгийрүүлэн судлах, шинжлэн дүгнэж мэдээлэх нь ихээхэн тустай. Улс төрийн шинжтэй хамгийн том тулгамдсан асуудал бол юу ч хийхгүй зүгээр суусны өртөг зардлын тухай ойлголт нийтлэг дутагдах, мөн бодлогын эмчилгээний зохих аргуудын ач тусын талаарх бодлого боловсруулагчдын мэдлэг хомс байх явдал юм.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Орлогын талаарх асуултууд

- ▶ Танай улсын засгийн газрын орлогын ямар хувийг газрын тос, байгалийн хий, ашигт малтмал гэх мэт байгалийн баялгийн борлуулалт эзэлдэг вэ? Энэ нь нөөц ашигласны төлбөр, түрээс эсвэл ашгийн хэлбэрээр орж байна уу? Энэ дүн нь дотоодын эсвэл гадаадын валютаар тогтмол хэмжээтэй байхаар гэрээ хийгдсэн үү эсвэл үйлдвэрлэсэн буюу экспортлосон баялгийн хэмжээгээр засгийн газарт төлбөр төлж байна уу?
 - ▶ Танай улсын засгийн газрын төсвийн орлого экспортын гол бараа, түүхий эдийн үнээс хэр их хамаардаг вэ?
 - ▶ Үнийн хэлбэлзлийн улсын төсөвт үзүүлэх нөлөөг багасгах талаар танай улсын засгийн газар ямар алхмууд хийж байна вэ?
 - ▶ Бизнесийн байгууллагууд ба хувь хүмүүсийг үнийн цочирдлоос хамгаалахад туслах талаар засгийн газар юу хийж байна вэ?
 - ▶ Тус улсын бараа, түүхий эдийн үнийн эрсдэлд өртөмтгий байдлыг багасгах талаар засгийн газар ямар нэмэлт арга хэмжээнүүд авах гэж байна вэ?
-

7. Газрын тосны үйлдвэрлэлийн байгаль орчин, нийгэм, хүний эрхийн үр дагаварууд

Дэвид Васкоу, Карол Уелч

Нүүрс төрөгчийн эрин үе аж үйлдвэрийн хөгжил, орчин үеийн амьдралын хэв маягт эерэг үүрэг гүйцэтгэсэн нь эргэлзээгүй боловч энэхүү ахиц дэвшлийн үнэ өртөг бодож байснаас илүү өндөр гарах төлөвтэй байна. Газрын тосны олборлолт, тээвэрлэлт, хэрэглээний байгаль орчин, нийгэм, хүн амын эрүүл мэнд, дэлхий дахины хүний эрхийн байдалд үзүүлэх сөрөг нөлөөг өнөөдөр ихээхэн нягтлан судлах цаг болжээ.

1989 оны Эссон Валдез, 2002 оны Престижийн осол гэх мэт их хэмжээний газрын тос алдаж асгасан явдал нь далай тэнгисийн эрэг орчмын нутаг ус болон далайн мэдрэмтгий экосистемийг бохирдуулсан билээ. Мөн цаг уурын өөрчлөлт бол дэлхий дахины байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд учирч буй томоохон аюул болохыг хүлээн зөвшөрсөн хэдий ч дэлхийн цаг уурын дулааралтад газрын тосны гүйцэтгэх үүргийн талаар газрын тос үйлдвэрлэгчид маргасаар байна.

Газрын тос олборлохын тулд газрын гадаргын бүр гүнд, голдуу их алслагдсан, байгаль орчны хувьд мэдрэмтгий байршилтай газар хүрч ажиллах хэрэгтэй болдог. Газрын тос өөрөө болон түүнтэй хамт хөрсөн дороос гарч ирж байгаа материалууд нь маш хортой химийн бодисууд агуулсан байдаг. Энэхүү шингэнийг боловсруулан гаргаж, алс холын зайд тээвэрлэх нь техникийн хувьд хүнд бөгөөд байгаль орчны хувьд аюултай ажил юм. Газрын тосыг гоожуулж алдах явдал тогтмол гарч ургамал, амьтанд сүйтгэл учруулдгаас гадна газрын тосны үйлдвэрлэлийн бүхий л шатанд хор хөнөөлтэй ослоуд гарч болдог.

Мөн газрын тос олборлолт нь нийгмийн ноцтой үр дагавартай байж болно. Газрын тосны өрөмдлөгийн газрууд голдуу аюулгүй байдлын их хэмжээний техник, хэрэгслүүдээр хамгаалагдсан байдаг. Зарим тохиолдолд газрын тосны компаниуд цэрэг, цагдаагийнхантай түншилж ажилладаг бөгөөд хүний эрхийн аймшигтай олон зөрчил гардаг байна.

Газрын тосны төслүүдийн шууд нөлөөнд өртөж буй хүмүүстэй нэг бол огт зөвлөлдөхгүй байх, эсвэл төслийн шийдвэр гаргах зөвлөлдөөнд бүрэн оролцуулахгүй байх нь элбэг. Нутгийн ард иргэд өөрсдөд нь үзүүлж буй сөрөг нөлөөний эсрэг тэмцэх үед эрх мэдэлтнүүд тэднийг нухчин дарах үйл ажиллагаа явуулж, улмаар хүчирхийлэл, хүний эрхийн зөрчлүүд гарахад хүрдэг.

Өрөмдлөгийн газрууд нь ихэвчлэн нутгийн ард иргэдийн нийгмийн бүтцийг өөрчилдөг. Ажилд орох ихээхэн итгэл найдвар тавивч, ажил олодохгүй байгаа олон хүмүүс тэнд ажилд орсон хүмүүст дургүйцэх тохиолдол олон гардаг. Газрын тосны хайгуул, үйлдвэрлэлийн ажил нь техник их оролцдог үйл явц бөгөөд ур чадваргүй хүмүүс ажиллахаар олон ажлын байр бий болгоод байдаггүй.

Бас газрын тос олборлож эхэлмэгц, дотоодын бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ огцом өсөх явдал олонтаа тохиолддог. Өрөмдлөгийн газар ажилд орсон эрчүүд уламжлалт ажил хөдөлмөр, уламжлалт амьдралын хэв маягаа орхиход хүрдэг. Мөн гэр бүлээсээ хол ажиллаж амьдарч буй газрын тосны ажилчид биеэ үнэлэгчдэд ханддаг учраас тийм газруудад ДОХ өвчин гарах хувь өндөр байдаг.

Иймд хөгжил ба ядууралд газрын тосны үзүүлэх нөлөөг үнэлэхдээ эдгээр болон бусад олон сөрөг үр дагаварыг тооцоолж, үнэлгээ өгөх ёстой. Мөн эдгээр сөрөг нөлөөг багасгах, хариу үйлдэл үзүүлэх талаар засгийн газар болон компаниудын зүгээс авч буй арга хэмжээнд шүүмжлэлтэй хандаж, задлан шинжилж байх ёстой.

Газрын тос бол хэрвээ ил тод, адил тэгш байдлаар зөв удирдах юм бол нутгийн ард иргэдэд ихээхэн санхүүгийн үр шим авчирч чадах баялаг мөн боловч тэр ашиг тусыг тухайн ард иргэдэд нийгмийн болон байгаль орчны талаасаа үзүүлж болзошгүй сөрөг үр дагавар талаас нь авч үзэж байх ёстой.

Газрын тосны үйлдвэрлэл дэх байгаль орчны асуудлууд

Газрын тосны үйлдвэрлэлийн бүхий л үйл явцад байгаль орчны сөрөг үр дагаврууд бодитойгоор оршиж байдаг. Хайгуул, эх газрын болон далай тэнгисийн усан дээрх өрөмдлөг, боловсруулалт, дамжуулах хоолой болон бусад хэлбэрийн тээвэрлэлт нь бүгд л экологид төдийгүй хүн амын эрүүл мэндэд ноцтой аюул занал учруулдаг. Агаар, ус, газар гээд байгалийн ямар ч орчинд хор нөлөө учирч болдог. Байгаль орчинд учруулах хор хөнөөлийн түвшин нь тухайн үйл ажиллагаа явуулагчийн хариуцлагатай байдал, засгийн газрын хяналт, тодорхой экосистемийн нөхцлөөс хамаардаг. Ихээхэн зохицуулалттай орчинд хүртэл зарим гарз хохирол учирсаар байна.

Хайгуул, өрөмдлөг, олборлолт

Газрын тос, байгалийн хийг газрын гадарга дээр гаргаж ирэхээс ч өмнө буюу хайгуулын үйл явцад уг үйлдвэрлэлийн үр нөлөө мэдрэгддэг. Газрын тос, байгалийн хийн орд газрууд ерөнхийдөө тундсан чулуулгаас илэрдэг. Иймээс эдгээр ордууд газрын гүний хаана байгааг олж тогтоох хайгуулын явцад янз бүрийн чичирхийллийн судалгааны арга, техник ашигладаг.

Сүүлийн үед газрын тосны нөөцийг олж илрүүлэхийн тулд нисэх онгоц, хиймэл дагуулаас өндөр технологи бүхий алсаас мэдрэх арга техник ашиглах явдал улам бүр нэмэгдэж байна. Гэвч эдгээр арга нь тэр бүр амжилт олоод байдаггүй бөгөөд газрын гадарга дээр хийх хайгуулын аргууд нийтлэг хэвээр байгаа нь байгаль орчны үр дагавар дагуулсаар байна.

Газрын гадаргаас хайгуул хийх арга нь чичирхийллийн долгион биетээр үүсгэх замаар шатдаг түлшний орд газрыг олж илрүүлэх боломж олгодог. Эдгээр арга, түүний дотор чичирхийллийн машин (“хүнд цохилтын машин”), газрын гүнд нүх өрөмдөж тэслэх, далайн гүнд ашигладаг тусгай “хийн буу” болон тэдгээрийг дагалдах хүнд механизмууд нь голдуу алс хязгаар, байгаль орчны хувьд эмзэг газруудад ашиглагддаг.

Түүнчлэн өргөн хүрээг хамарсан хайгуулын өрөмдлөгийн арга ялангуяа газрын тосны нөөцийн хэмжээ нь сайн тогтоогдоогүй хөгжиж байгаа орнуудад түгээмэл хэрэглэгддэг. Ийм үйл ажиллагаа нь өрөмдлөгийн газрын орчимд төдийгүй дагалдах дэд бүтцийг байгуулах, түүний дотор зам барих ажлын үр дүн болон орон нутгийн байгаль орчинд халддаг. Шатдаг түлшний үйлдвэрлэлийн хайгуулын шатанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ голдуу хийгддэггүй¹.

Хайгуулын үйл явцын дараа газрын тосны хэд хэдэн цооног өрөмдөж үйлдвэрлэл эхлэх бөгөөд үүний дараа жинхэнэ олборлолт явагддаг. Газрын тосны орлод нилээд хэмжээний байгалийн хий агуулагдах бөгөөд түүнийг мөн газрын тосны хамтаар гаргаж ирдэг. Байгалийн хийг нэг бол газрын тосны цооногуудаас (хамтатгасан хий байдлаар) эсвэл тусгайлан хий олборлох зорилгоор өрөмдсөн цооногуудаас (хамтатгаагүй хий байдлаар) тусд нь гаргаж авч болно.

Түүхий нефть, түүний өрөмдөлт, олборлолтоос үүсэх дайвар бүтээгдэхүүнүүд бүгд л нилээд хэмжээний хорт бодис, бусад бохирдуулагч агуулж байдаг. Өрөмдөлтийн явцад мөн их хэмжээний “шаар” буюу чулуулгийг газрын гадаргуу дээр гаргаж ирэх бөгөөд энэ нь зайлуулбал зохих тодорхой хэмжээний хаягдал материалууд бий болгодог.

Мөн уг шаар нь “өрөмдөлтийн шавар” хэмээх шингэнээр бүрхэгдсэн байдаг учраас асуудалтай байдаг. Уг шингэнийг өрөмдөлтийг бага зэрэг тослох, цооногийн даралтыг тогтворжуулах үүднээс ашигладаг. Нэгэнт олборлолтын явцад ашиглагдсан учраас эдгээр өрөмдөлтийн шингэн нь хорт бодис, түүний дотор хүнд металл болон химийн бусад хорт бодисоор бохирдсон байдаг. Нэг цооногоос ийм шаар, шавар өдөрт 60.000-300.000 галлон хүртэлх хэмжээгээр гарч болно². Түүнээс гадна, жинхэнэ олборлолтын явцад дотроо хатуу биет агуулсан, уусгасан их хэмжээний ус гадарга дээр гарч ирдэг. “Үйлдвэрлэсэн ус” буюу ажилласан ус гэж нэрлэдэг энэхүү ус ерөнхийдөө олон тооны ихээхэн хортой бодис, түүний дотор хүнд металлууд (тугалга, цайр, мөнгөн ус) ба ууршимтгай органик нэгдлүүд (бензен, толуен) агуулж байдаг.

Мөн үйлдвэрлэсэн ус нь давсны агууламж өндөртэй байдаг бөгөөд хэрвээ газрын гадарга дээр асгах юм бол орон нутгийн экосистем дэх ургамалд туйлын хор хөнөөлтэй. Үйлдвэрлэсэн ус нь аливаа цооногоос олборлон гаргаж ирсэн шингэний 90-ээс илүү хувийг эзлэх бөгөөд АНУ-д үйлдвэрлэсэн нэг баррель газрын тос тутмаас бараг 8 баррель орчим ийм ус гардаг (байгалийн хийн цооногийн хувьд үйлдвэрлэсэн усны хэмжээ арай бага байдаг)³.

Эдгээр хаягдал, хорт бодис, түүний дотор өрөмдөлтийн шаар, шавар ба үйлдвэрлэсэн усыг зохисгүйгээр хаяж, гадагшлуулах нь нутгийн иргэд, амьтад, ургамлын бүрхэвчид ихээхэн хохирол учруулж болно. Ийм хаягдлуудыг, ялангуяа шаар, шаврыг хаяж цэвэрлэх нэг тохиромжтой бөгөөд заримдаа дутуу ашиглагддаг арга бол үет нүхнүүд ашиглах явдал юм. Эдгээр нүхийг зөв зохистой үелээгүй эсвэл үйлдвэрлэл явагдаж дууссаны дараа шороогоор дарж булахгүй бол газрын тос болон бусад хорт бодис газрын хөрс ба хөрсний усанд нэвчин шингэх боломжтой. Үет нүхнүүдээс гадна төмөр сав ашиглан хаягдлыг цуглуулж, улмаар эмзэг мэдрэмтгий экосистемээс гадагшлуулах арга байна.

Ихээхэн хортой, давсжилт ихтэй үйлдвэрлэсэн усыг усны суваг болон газрын хөрсөнд асгах нь экосистемд туйлын хор хөнөөлтэй байж болно. Үйлдвэрлэсэн усанд хэд хэдэн зөөлрүүлэх аргууд, тухайлбал шүүлтүүр болон биологийн аргыг хэрэглэж болно. Олон тохиолдолд, үйлдвэрлэсэн усыг цооногт буцаан шахаж, олборлолтын даралтыг тэнцвэржүүлэхэд ашиглаж болдог. Эдгээр тохиолдолд үйлдвэрлэсэн усыг буцааж шахахын өмнө хөрс, усыг бохирдуулахаас сэргийлэх арга хэмжээ хангалттай авах ёстой. Далай тэнгисийн усанд олборлолт явагдаж байгаа тохиолдолд үйлдвэрлэсэн усыг ингэж буцааж оруулах нь ховор, харин түүний оронд газар дээр авчран цэвэрлэх арга хэмжээ авах ёстой.

Байгалийн хийн олборлолт ч тухайн газартаа нилээд их байгаль орчны хүндрэлтэй асуудлууд үүсгэдэг. Байгалийн хийг тусд нь салгаж, хэрэглээнд зориулан боловсруулахгүй тохиолдолд голдуу цооногийн орчимд шатаах буюу “дөл бадраах” бөгөөд тэгснээр хортой бохирдуулагч ялгардаг. Газрын тос, байгалийн хийн олборлолтоос агаарт ялгарч буй хорт хийн хамгийн том эх үүсвэр болох энэхүү шатаалт нь нүүрс төрөгчийн дан исэл, азотын исэл (утааны гол бүрэлдэхүүн хэсэг), хүхрийн исэл (хүчлийн борооны гол шалтгаан) зэргийг ялгаруулдаг. Шатаалтын түвшин хамгийн өндөртэй Нигери улсад нутгийн ард иргэд гомдол гаргаж, тэдний эрүүл мэндэд учирч буй ноцтой үр нөлөөг уг шатаалттай холбон тайлбарлаж байна.

Байгалийн хийг шатаахгүй тохиолдолд, боловсруулаагүй хий нь агаар мандалд дэгдэж, их хэмжээний метан буюу цаг уур өөрчлөх чадалтай хийг ялгаруулах нь олонтаа. Түүнчлэн байгалийн хийг олборлох үед нилээд хэмжээний азотын хүчил агуулсан байх нь олонтаа бөгөөд энэхүү хорт бодис нь үхэлд хүргэх аюултай төдийгүй дамжуулах хоолойг зэвэнд идүүлдэг аюултай (азотын хүчилтэй хийг голдуу “исгэлэн хий” гэж нэрлэдэг). Иймд энэхүү химийн бодисыг байгалийн хийнээс аль болох хурдан салгах ёстой.

Газар дээрх нефть олборлолтын гол хор нөлөө нь тухайн үйлдвэрлэл явагдаж буй газрын хил хязгаараас ч давж гардаг оршино. Ялангуяа, хөгжиж байгаа орнуудын алслагдмал газар нутагт газрын тосны шинэ шинэ орд газрууд илэрч олборлолт улам ихээр явагдахын хэрээр олборлолтын газар нутаг хүрээгээ тэлж үйлдвэрлэлийн болон ажилчдын байр барих ажилд их хэмжээний ой мод өртөж устдаг. Мөн эх газар дээрх өрөмдлөг нь ан амьтад, түүний дотор хүмүүсийн амьдралд чухал үүрэгтэй бэлчээрийн мал сүргийг хорт бодисын алдагдалд өртүүлэх аюултай. Газрын тос, газрын тосонд бохирдсон хоол хүнс идэх буюу ус уух нь амьтдад үхлийн аюултай буюу эрүүл мэндэд нь урт хугацааны аюул занал учруулдаг.

Олборлолтын байгаль орчинд учруулдаг ноцтой үр нөлөөний нэг нь тийш хүрэх зам барих асуудал юм. Ойн эмзэг бүсэд учрах үр дагавар нь заримдаа газрын цэвэрлэгээний шууд үр нөлөөнөөс ч бодитойгоор илүү гардаг. Хүн хүрэх боломжгүй газруудад зам тавьж өгснөөр тэдгээр алс бөглүү нутагт мод бэлтгэгчид, хулгайн анчид ихээр очих боломж олгодог. Ингээд ой цаашдын халдлагад өртөж, зам дагуух орчны амьтан, ургамал цэвэрлэгдэх болно. Мөн эдгээр зам нь ойн амьтдын эзэмшил газар нутгийг ихээхэн багасгаж, тэдний амьдрах орчныг хэсэгчлэн хувааж, алдагдуулах болно.

Зарим нэг тооцоогоор, ойн бүсэд тавьсан шинэ замын нэг километр тутамд 400-2400 га (1000-6000 акр) газрын ой устаж, газарт ордог байна⁴. Эквадор улсад гэхэд газрын тосны үйлдвэрлэлд зориулж 500 километр зам тавьсны улмаас нэг сая га (2.5 сая акр) халуун орны ойн бүс газарт орсон тооцоо байдаг⁵.

Газрын тосны компаниуд ой модонд учруулах сөрөг нөлөөг багасгах үүднээс зам барихгүй ч ховорхон тохиолдолд хүртэл нисдэг тэрэг, онгоц буух талбай байгуулах шаардлагатай бөгөөд мөн л амьтдын амьдрах орчныг хувааж, нүүдлийн замд нь сөрөг нөлөө үзүүлдэг байна.

Дэлхийн хэмжээгээр ихэнх газрын тосны өрөмдлөгийн талбай эх газарт байрладаг боловч далай, тэнгисийн байгаль орчинд чухал нөлөө үзүүлэх боломжтой усан дээрх өрөмдлөгийн талбай ч нилээд их байдаг. Усан дээрх үйлдвэрлэл ялангуяа Африк (орд газруудын бараг тал хувь нь), Европ (талаас илүү хувь нь), Ази Номхон далайн (орд газруудын гуравны хоёр орчим нь) бүс нутагт түгээмэл байдаг⁶.

Усан дээрх өрөмдлөг нь давтагдашгүй сорилтуудтай тулгардаг бөгөөд ялангуяа газрын тос шилжүүлэн тээвэрлэх үеийн эрс тэс уур амьсгалын нөхцөл нь осол гарах магадлалыг нэмэгдүүлдэг⁷. Усан дээрх үйлдвэрлэл нь сэтгүүлчид (эсвэл зохицуулагчид) очиж шалгахад хэцүү байх нь элбэг бөгөөд үйл ажиллагаа явуулж буй компаниудын зохицуулалтаас зугтах боломжийг нэмэгдүүлдэг. Хөрөнгө мөнгө багатай, байгаль орчны яамд султай хөгжиж байгаа орнуудад шалгалтынхныг газрын тосны тавцан дээр аваачих нисдэг тэрэг байдаггүй. Заримдаа компаниуд өөрсдөө тээврийн хэрэгслээр хангадаг боловч тэр тохиолдолд хэзээ шалгалт хийгдэхийг мэдэж байна гэсэн үг.

Үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн далай тэнгисийн байгаль орчинд үзүүлэх нөлөөг тодорхойлоход тухайн усан дээрх үйлдвэрлэлийн байрлал чухал байж болно. Загас болон далайн бусад амьтдын үржлийн газар байрласан өрөмдлөгийн цамхагууд тэдний үржлийн хэв маягийг өөрчилж, тоо толгойд нь нөлөөлж болно. Тухайлбал, дун, наль хорхой гэх мэт хуягт усны амьтад нефтин бүрхүүлд орох юм бол амьсгалах, хооллоход нь хэцүү болдог. Нефтиэр бүрхэгдсэн

загасны түрс нэг бол үхэх эсвэл гажигтай үр хөврөл төрөх болно. Мөн далайн булан тохойн хаагдмал хэсэгт ойр байрласан үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж нь байгаль орчинд илүү их хор хөнөөл учруулж болно. Далайн эргийн болон бусад хаалттай булан тохойн давалгааны таталт түрэлт нь газрын тосыг аажмаар тарааж, далайн эрэг рүү нэвчих боломжтой болгодог.

Халуун орны бүсэд бол эрэг орчмын газар нь голдуу мангроу мод маягийн ургамлын экосистемээс тогтох бөгөөд ийм зүйлийн ургамлын үндэс уснаас дээш агаарт гарч ургадаг. Ургамлын ийм үндсэн дээр нефть алдагдвал уг ургамлыг төдийгүй тэдгээрт тулгуурласан бусад төрөл зүйлсийг ч бүрмөсөн устгадаг. Хөрсийг тогтворжуулж, эргийг хамгаалахад түүнчлэн загас болон далайн бусад амьтдын орчинг хэвийн байлгахад мангроу мод чухал үүрэгтэй байх нь элбэг байдаг. Панамын эрэг орчмын мангроугийн бүс нутаг дээр 50.000 баррель нефть

Газрын тос үйлдвэрлэлийн явцад үүсэх хорт бодис болон бусад бохирдуулагчийн үзүүлэх нөлөөний жишээнүүд

<i>Химийн бодис</i>	<i>Нефть үйлдвэрлэлийн холбогдох талууд</i>	<i>Эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөө</i>
Бензин	Үйлдвэрлэсэн ус	Хорт хавдар үүсгэгч, нөхөн үржихүйн хордуулагч, хөгжлийн хордуулагч
Толуен	Үйлдвэрлэсэн ус	Хөгжлийн хордуулагч, цусны хордолтын шинж тэмдэг, мэдрэл хордуулагч, элэг хордуулагч, бөөр хордуулагч
Мөнгөн ус	Үйлдвэрлэсэн ус ба өрөмдлөгийн шингэн (шавар)	Хөгжлийн хордуулагч, цусны хордолтын шинж тэмдэг, эндокрин хордуулагч, мэдрэл хордуулагч, нөхөн үржихүйн хордуулагч, дархлаа хордуулагч
Цайр	Үйлдвэрлэсэн ус ба өрөмдлөгийн шингэн (шавар)	Цусны хордолтын шинж тэмдэг, хөгжлийн хордуулагч, нөхөн үржихүйн хордуулагч
Тугалга	Үйлдвэрлэсэн ус ба өрөмдлөгийн шингэн (шавар)	Хорт хавдар үүсгэгч, нөхөн үржихүйн хордуулагч, хөгжлийн хордуулагч
Натри	Үйлдвэрлэсэн ус	Хөрсийг бохирдуулж, ургамал ургах боломжгүй болгоно
Азотын хүчил	Байгалийн хийн олборлолт	Цусны хордолтын шинж тэмдэг, мэдрэл хордуулагч, нөхөн үржихүйн хордуулагч
Хүхрийн давхар исэл	Байгалийн хий шатаалт	Хүчлийн бороонд гол нөлөөлөгч

алдагдан урссаны улмаас эргийн дагуух 20 миль газрын ургамлын бүрхэвчийг устгажээ⁸.

Газрын тос алдагдах нь зэрлэг ан амьтдын амьдралд ч бодитой нөлөө үзүүлдэг. Загас болон усны хуягт амьтдад хор хөнөөл учрах буюу тэднийг үхэлд хүргэж болно. Газрын тос залгисан буюу түүгээр амьсгалсан далайн сүүн тэжээлт амьтдын элэг, бөөр гэх мэт гол эрхтнүүд хорддог. Нефть алдагдсан газраас барьсан сүүн тэжээлт амьтдад дотор эрхтний гэмтэл, дотуур цус алдалт илэрсэн байна. Түүнчлэн тэдний дархлалын систем алдагдаж, зарим тохиолдолд зан араншин нь хүртэл өөрчлөгдөж болдог. Эдгээр үр нөлөө нь амьтдыг аюулд өртөх, араатанд баригдахад улам эмзэг болгодог.

Газрын тос нь эрэг орчимд үүрээ засч, эргийн дагуу нүүдэллэн амьдардаг шувуудын өдийг бохирдуулах, тэдний дархлаа болон нисэх, шумбах чадварыг алдагдуулснаар хор хөнөөл учруулаад зогсохгүй газрын тос залгисан шувуу үхэж ч болно. Нефть алдагдснаас болж хэдэн арван мянган шувуу үхдэг бөгөөд хаана, хэзээ ийм явдал болсноос (тухайлбал, нүүдлийн зам ба улирал нь уг тоонд нөлөөлдөг) хамаарч тоо нь харилцан адилгүй байдаг⁹. Мөн алдагдсан газрын тос нь халуун орны шүрэн хаднуудад нөлөөлж тэднийг өнгө алдан, хагарч бутрахад хүргэдэг.

Далайн усан дээрх өрөмдлөгөөс үүссэн нефтийн хаягдлыг зайлуулах асуудал ч мөн байгаль орчны хувьд санаа зовоосон асуудлын нэг юм. Нефтийн өрөмдлөгийн тавцангууд олборлолтод ашиглах өрөмдлөгийн шингэн байдлаар өдөрт ойролцоогоор 400.000 галлон далайн ус ашигладаг бөгөөд ингэж ашигласныхаа дараа уг газрын тосонд бохирдсон усыг далайд буцааж асгадаг¹⁰. Ингэж далайд асгахын нэг илэрхий үр нөлөө бол мөнгөн усны бохирдол юм. Үүнээс болж бохирдсон загасыг идэх нь хүний бие мөнгөн усанд хордох бодитой шалтгаан мөн гэж үзэх явдал улам нэмэгдэж байна. Мексикийн буланд орших газрын тосны өрөмдлөгийн тавцангийн доорх шавар болон тундсанд байгаа мөнгөн усны агууламж АНУ-ын Байгаль орчны хамгаалалтын газрын стандартын дагуу хүлээн зөвшөөрөгдөх хэмжээнээс 12 дахин өндөр байгааг нэгэн судалгаагаар тогтоосон байна¹¹. Далайн усанд хаяж буй хаягдлын асуудлыг шийдэх ганц арга бол уг хаягдлыг цуглуулж, хог шааранд тухайлан зориулж гаргасан газарт хаях явдал юм.

Газрын тосыг зах зээлд хүргэх нь: дамжуулах хоолой ба боловсруулалт

Газрын тос, байгалийн хийг тээвэрлэхэд ашигладаг дамжуулах хоолойнууд нь байгаль орчинд ноцтой хор хөнөөл учруулж болно. Заримдаа дамжуулах хоолойг

газар доогуур тавьдаг боловч газар дээр барих нь газарт булснаасаа хямд учраас хөгжиж байгаа олон оронд газар дээрх дамжуулах хоолой бараг түгээмэл гэж хэлж болохоор байна. Эдгээр нүд залхам ил хоолойнууд бэлчээрийн амьтдад саад болохын зэрэгцээ малчид, фермерүүдэд хүндрэл бэрхшээл учруулдаг.

Дамжуулах хоолойн алдаатай залгалт, жийрэгний эвдрэл, зэврэлт зэргээс болж уг хоолой цоорч, тасарч болно. Дамжуулах хоолой хагарч нефть алдагдсаны талаас илүү хувь нь бүтцийн асуудлуудаас, хамгийн нийтлэг нь зэврэлтээс болсон байдаг¹². Нефть алдагдах хамгийн нийтлэг шалтгааны нэг бол дамжуулах хоолойн алдалт бөгөөд тухайлбал, 1997 онд дамжуулах хоолойн алдалт тээвэрлэгч танкеруудынхаас хоёр дахин их байжээ¹³.

Газар дээрх дамжуулах хоолойноос алдсан нефть газрын хөрсийг гэмтээж, гадаргын усыг бохирдуулдаг бол газар доогуурх хоолойноос алдсан нефть хөрсний гүний усны нөөцийг бохирдуулахаас гадна хаана алдсаныг нь олж илрүүлэхэд маш хэцүү байдаг. Ингэж хоолойгоор нефть алдах буюу тасарснаас болж гал гарах, тэсэрч дэлбэрэх аюулд хүргэж болно. Угаасаа тэсрэмтгий чанартай байгалийн хийн хувьд тэсэрч дэлбэрэх онцгой аюултай.

Олборлолтын үйл ажиллагааны нэгэн адил дамжуулах хоолой барих нь газар нутгийг төдийгүй байгаль орчны хувьд эмзэг мэдрэмтгий газруудыг сүйтгэх явдал олон тохиолддог. Жишээлбэл, дамжуулах хоолой тавихад зориулж гаргасан өргөн зурвас зам нь өндөр үнэ цэнэ бүхий ой шугуй дундуур шууд дайран өнгөрснөөр эдгээр газрын халдлагад өртөх боломжийг нээдэг. Дамжуулах хоолойд хүрэх олон зам ч мөн зэрлэг ан амьтдын амьдрах орчинг тасалж, хумихад хүргэдэг.

Боливи улсад Энрон, Шелл, Трансредез компаниудын байгуулсан 630 километрийн урттай Кюиба хэмээх байгалийн хий дамжуулах хоолой 1990-ээд оны сүүлээр дэлхийн хамгийн том халуун орны онгон дагшин хуурай ой болох Чикюитаногийн ой дундуур тавигдсан юм. Энэ ойд олон тооны ховор бөгөөд эмзэг төрөл зүйлийн амьтан, ургамал, түүний дотор ховордсон төрөл зүйлийн амьтан, ургамлын олон улсын худалдааны конвенцийн жагсаалтад орсон 90 орчим төрөл зүйл байдаг байна. Орон нутгийн ард иргэдийн яриагаар, хийн хоолой барьж байгуулснаар уг зурвас замыг дагасан хор хөнөөлтэй үйл ажиллагаанд дөхөм болж, түүний дотор хулгайн ан хийх, хууль бусаар мод бэлтгэх, мал тэнүүчлэн бэлчих явдлыг хөнгөвчилж өгсөн байна. Тэр ч байтугай, Канад улсын уул уурхайн нэгэн компани цианидаар алт боловсруулах аюултай аргыг ашиглан уг эмзэг ойд алтны далд уурхай сэргээн ажиллуулах оролдлого хийсэн байна¹⁴.

Газрын тос боловсруулах явдал бол газрын тосны үйлдвэрлэлийн байгаль орчинд ноцтой нөлөө үзүүлдэг нэг үе шат юм. Боловсруулах үйлдвэрүүд буцалгах, ууршуулах, уусгагч ашиглах зэрэг аргыг ашиглан түүхий нефтээс бензин шатахуун

болгон ашиглаж болох хэсгийг ялган гаргадаг. Газрын тосноос бензин, дизель түлш, тийрэлтэт хөдөлгүүрийн түлш, керосин, тосолгооны шингэн, асфальт зэрэг эцсийн бүтээгдэхүүнүүд гардаг. Дундаж боловсруулах үйлдвэр өдөрт 3.8 сая галлон нефть боловсруулдаг¹⁵. Энэхүү газрын тосноос байгаль орчинд хаягдал дайвар бүтээгдэхүүн болгон гарах өчүүхэн хэсэг буюу 0.3 хувь нь ганцхан газраас л өдөрт 11.000 гаруй галлон нефтиэр хэмжигддэг¹⁶. Боловсруулалтын явцад ашиглаж байгаа усанд хүнд металл болон бусад бохирдуулагч хорт бодисын ул мөр байгаа эсэхийг анхаарч хандах ёстой.

Мөн боловсруулах үйлдвэрүүд нь их хэмжээний агаар бохирдуулагч бодисууд ялгаруулж байдаг. АНУ-д мөнгөн ус, тугалга, давхар ислүүд гэх мэт маш их хортой Тогтмол Биохуримтлалтай Хорт Бодисууд (ТБХБ)-ыг агаарт ялгаруулж байгаа гуравдахь том эх үүсвэр бол нефть боловсруулах салбар байдаг бөгөөд 2001 онд 184,000 гаруй фунт ТБХБ-ууд агаарт ялгаруулсан байна.¹⁷ 2001 онд дэлхийн хэмжээгээр 48 сая фунт хорт бодис, түүний дотор хорт хавдар үүсгэгч бензин болон хөхүүл ханиалга, хүүхдийн хөгжлийн бэрхшээлүүд үүсгэж болох химийн бодисууд зэрэг ууршимтгай органик нэгдлүүд, агаарт ялгаруулсан байна¹⁸. Мөн боловсруулах ажиллагаа нь хүчлийн борооны гол нөлөөлөгч болох хүхрийн давхар ислийг ихээр ялгаруулж болно.

Боловсруулах үйлдвэрийн иж бүрэн тоног төхөөрөмж ч бас нефть алдалт болон осолд өртөмтгий байдаг. Нефть хадгалах сав, торхнууд цоорч гоожих нь боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжөөс нефть алдахад чухлаар нөлөөлдөг бөгөөд заримдаа тэдгээр газарт гарсан гал түймэр, тэсрэлт дэлбэрэлт нь их хэмжээний химийн хорт бодис агаарт ялгарах нэг эх сурвалж болдог.

Газрын тос алдалт

Газрын тосны олборлолт, тээвэрлэлтийн явцад асгаж алдах нь элбэг байдаг. Олон улсын хэмжээгээр 1978-1997 оны хооронд бүртгэгдсэн ослуудаас үзэхэд жил тутам 20-430 сая галлон нефть алдаж байжээ. Энэ хугацаанд гарсан ослуудын тоо нэг жилд 136-382 хүрч байв¹⁹. Ингэж алдах явдал нефть хадгалах сав, дамжуулах хоолой, нефть тээвэрлэгч хүнд даацын том хөлөг онгоцууд буюу танкерууд, ачааны хөлөг онгоц болон бусад тээвэрлэгчээс гарч байжээ.

Эдгээр алдалтын дийлэнх хувь нь нэг дор 10000-аас 1 сая галлон хүртэл нефть далайд асгадаг хүнд даацын хөлөг онгоцны осолтой харьцуулахад бага хэмжээтэй боловч эдгээр бага хэмжээний алдалт нийлээд ихэнх жилүүдэд 15-20 сая галлон хүрч байсан байна²⁰. Хэрэв байнга ийм явдал тохиолддог бол түүний уршгаар нефтийн бохирдолд ургамал, амьтад автах явдал ужгирч хүнд даацын танкеруудынхаас ч илүү хохирол учирч болох юм.

Гэвч хамгийн томоохон бөгөөд нүдэнд ил харагдах нефтийн алдалт ихэвчлэн хүнд даацын танкеруудын ослоос үүдэлтэй байдаг. Тухайлбал, 2002 оны *Престиж*-ийн ослоор хойд Испаний эрэг орчимд ойролцоогоор 17 сая галлон орчим нефть алдсан байна. Томоохон хүнд даацын танкер ингэж осолдох нь нийтлэг бус хэдий ч ерөнхийдөө 10 сая галлоноос дээш хэмжээгээр нефть алдсан маш том ослуудын тооноос тухайн жилд алдсан нийт алдалтын хэмжээ хамаардаг.

Сүүлийн хэдэн арван жилд газрын тос тээвэрлэгч супер танкерууд үнэхээр супер буюу 1960 онд 150 сая галлоны даацтай байсан бол өнөөдөр 240 сая галлоны даацтай болоод байна. Маш том бөгөөд жолоодлогын эв муутай танкерууд осолд өртөмтгий байдаг²¹. Түүнчлэн хөлөг онгоцны загвар, барьж байгуулах ажлыг хангалтгүй хийснээс осол гарах үед их хэмжээний нефть алдахад хүрдэг. Тухайлбал, дан хуяг (буюу арьс)-тай хөлөг онгоцууд давхар хуягтайгаа бодвол осолд хамаагүй илүү өртдөг. 1990 оны АНУ-ын Газрын тосны бохирдолтын тухай хуульд АНУ-ын усан хилд үйл ажиллагаа явуулахаар шинээр барьж байгуулах танкер хөлөг онгоцыг давхар хуягтай хийх, мөн 2010 он гэхэд АНУ-ын усан хилд явж буй бүх танкерыг давхар хуягтай болгосон байхыг шаардаж байна. Сүүлийн үеийн нефть алдалт, ялангуяа *Престиж*-ийн ослоос үүдэн засгийн газар хоорондын байгууллага болох Олон Улсын Далайн Тээврийн Байгууллагаас 2010 он гэхэд дан хуягтай томоохон танкеруудыг ашиглалтаас шахан гаргах ажлыг эрчимжүүлэхийг шаардаад байна. Нефть алдалтын өөр нэг гол хүчин зүйл бол хөлөг онгоцны нас бөгөөд хуучин хөлөг онгоцууд гал түймэр, тэсрэлтэд өртөх нь илүү түгээмэл байна.

Бага хэмжээний ужиг алдалт нь засгийн газрын ажилтнууд, хэвлэл мэдээллийнхэн, тухайн газраас гадуурх олон нийтийн хараа хяналтад бага өртдөг учраас ихэвчлэн том хэмжээний осол гарсан үед л газрын тосны танкеруудын аюулгүй байдал, алдагдсан газрын тосны талаар хариу арга хэмжээ авах дохио болдог. Жишээлбэл, АНУ-д 1989 онд Аляскад гарсан *Экссон Валдез*-ийн осол нь АНУ-ын засгийн газраас нефтийн алдагдалтай холбоотой хууль боловсруулан гаргахад хүргэсэн юм. 11 сая галлон нефть алдсан уг осол нь онцгой байдлын үед зохицуулалттайгаар шуурхай арга хэмжээ авахад болон эрх мэдлийн тодорхой хуваарьтай байхад хүндрэлтэй асуудлууд байгааг илрүүлсэн билээ. Ингээд 1990 оны Газрын тосны бохирдолтын тухай хуулиар хариу арга хэмжээ авах үндэсний тогтолцоо бий болгож, улмаар нефть алдалтын дараа янз бүрийн засгийн газрын байгууллагууд, оролцогчид, салбарууд болон хариуцагч талуудыг удирдан зохицуулах үүрэгтэй хороо байгуулж, бүрэн эрх олгосон байна²². Мөн уг хуулиар хариуцагч талуудад цэвэрлэгээний зардлыг гаргах үүрэг хүлээлгэж, боломжит

иргэний шийтгэлүүдийг ноогдуулахын зэрэгцээ онцгой байдалд хариу арга хэмжээ авах газрын тос алдалтын эсрэг сан байгуулжээ²³.

Газрын тосны алдалтын эсрэг хариу арга хэмжээ авах өргөн хүрээг хамарсан хатуу төлөвлөгөө гаргаж хүлээх хариуцлагыг сайтар тодорхойлох нь газрын тос үйлдвэрлэгч орнуудад шийдвэрлэх үүрэгтэй хэдий ч олон тохиолдолд ийм төлөвлөгөө дутагдаж байна. Жишээлбэл, Азербайжан улс газрын тосны үйлдвэрлэлийнхээ хэмжээг эрс нэмэгдүүлж байгаа хэдий ч тус улсад газрын тос алдалтын эсрэг хариу арга хэмжээ авах үндэсний төлөвлөгөө хараахан байхгүй байна. Түүнчлэн энэ нь Каспийн тэнгис дэх газрын тос алдалтын эсрэг хөрш орнуудтайгаа үр нөлөөтэй хамтран ажиллах, зохицуулахад саад учруулж байна.

Газрын тос алдалтын эсрэг арга хэмжээний зардал нь тухайн алдсан газрын байрлал, эмзэг мэдрэмтгий газруудад, тухайлбал экологийн эмзэг систем, аялал жуулчлалын бүс нутагт үзүүлэх үр нөлөө, эргээс алслагдсан зай, асгасан нефтийн төрөл зэрэг хүчин зүйлсээс хамаарч янз бүр байж болдог. Эрэг орчимд алдагдсан нефть нь далай дээр алдагдсаныг бодвол илүү өндөр өртөгтэй цэвэрлэгддэг. Мөн асгарсан нефтийн төрөл ч цэвэрлэгээний зардалд нөлөөлдөг. Хөнгөн жинтэй түүхий ба боловсруулсан нефть илүү хурдан агаарт ууршиж, задардаг учраас цэвэрлэгээний ажил бага шаарддаг. Харин хүнд жинтэй түүхий нефтийн хувьд илүү эрчимтэй хүчин чармайлт шаарддаг бөгөөд цэвэрлэгээний зардал нь хөнгөн жинтэй түүхий нефтийг цэвэрлэхээс 4 дахин их байж болно²⁴. Цэвэрлэгээний зардалын хувьд Африкт нэг тонн тутамд 1,000\$ байхаас эхлээд АНУ-д 24,000\$-оос дээш (Экссон Валдезийн ослыг тооцоонд оруулаагүй байх үед) гэх мэт янз бүр байдаг. Экссон Валдезийн ослын хувьд Экссон компани цэвэрлэгээний ажилд 2.1 тэрбум ам.доллар зарцуулсан гэжээ²⁵.

Далайн усанд нефть алдагдах үед хариу үйлдэгчид ихэвчлэн уг нефтийг эргээс холдуулахыг хичээдэг. Усан дахь нефтийг задалж, сарниулдаг химийн бодис болох саармагжуулагчийг эрэг орчимд үзүүлэх нөлөөг багасгахад ашигладаг. Гэвч саармагжуулагчаар хэрэглэж буй химийн бодисууд хортой байж болох бөгөөд загасыг химийн бодисоор хордуулж, улмаар хор нөлөөг даамжруулж болох учраас түүнийг хэрэглэх явдлыг шүүмжлэх маргаан тойрч гарсангүй. Өөр нэг арга бол нефть идэгч бактериуд ашигладаг био эмчилгээ юм. Бас нэг боломж бол асгарсан газрын тосыг шатаах явдал боловч тэнд ажиллагсдад халтай төдийгүй хяналтанд байлгахад хэцүү байдаг. Өөр нэг хариу арга хэмжээ бол асгарсан нефтийн тархалтыг удаашруулах зорилгоор хашилт тавих явдал юм. Ийм хашилт нь хөвөгч хэрэгсэлтэй байх бөгөөд усан дээр болон доор байрлаж нефтийн тархалтыг хааж байдаг. Ингэж хааж өгөх нь асгарсан нефть эмзэг газруудад хүрэхээс сэргийлэх, нефтийг нэг газар төвлөрүүлж хялбархан цэвэрлэх боломжтой болгоход тустай.

Газар дээр асгарсан нефтийн хувь усан дээрх шиг хурдан тархдаггүй бөгөөд хашиж тогтооход илүү хялбар байдаг. Гэсэн хэдий ч хөрсийг бохирдуулснаар тухайн газрыг бэлчээрийн болон газар тариалангийн зорилгоор ашиглах боломжгүй болгохын зэрэгцээ газрын гүний усыг хүмүүсийн ундны хэрэгцээ, газар тариалан, мал усалгаанд хэрэглэх боломжгүй болгодог.

Газрын тос ба байгалийн хийн хэрэглээ

Газрын тос, байгалийн хийн хэрэглээ өөрөө байгаль орчин, хүн амын эрүүл мэндэд тухайн улсын болон дэлхийн нийтийн хэмжээнд маш их нөлөө үзүүлж байдаг.

Газрын тосноос үйлдвэрлэн гаргадаг гол бүтээгдэхүүний нэг бол бензин шатахуун бөгөөд энэхүү автомашины түлш нь олон тооны агаар бохирдуулагч хорт бодисууд үүсгэдэг (мөн харьцангуй бага хэмжээний газрын тосыг эрчим хүч үйлдвэрлэл болон ахуйн хэрэглээний дулаанд ашиглаж байна). Шатахуунаас үүсэх бохирдуулагч бодисын дотор ууршижтай органик нэгдлүүд (бензин, толуен гэх мэт) болон зарим хорт бодисууд; хүчлийн бороо, газрын гадарга дээрх озонд нөлөөлдөг азотын ислүүд; утааны гол элементүүд; хүчлийн борооны гол үүсгэгч хүхрийн давхар ислүүд; архаг ханиалга гэх мэт амьсгалын замын өвчин үүсгэдэг бичил биетүүд; нүүрс төрөгчийн дан исэл орохын зэрэгцээ шатахууны найрлагаас тугалгыг хараахан ялгаж аваагүй орнуудад бол тугалга ордог.

Эдгээр бохирдуулагчид ба нас баралт хоёр хоорондоо корреляцийн хамааралтай байгааг олон судалгаа харуулаад байна²⁶. Хүхрийн болон азотын хийнүүд үүлдэнд хуралдаж хүчиллэг усан дуслууд үүсгэдэг үзэгдэл болох хүчлийн борооны улмаас ой мод, нуур цөөрөм, гол мөрөн, хөрсний усны нөөцөд хор хохирол учирсаар байна. Түүнээс гадна, цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэлд голлон ашиглагддаг байгалийн хий шатаах ажиллагаанаас азотын ислүүд үүсч, хүчлийн бороо болон утаа униар үүсэхэд нөлөөлдөг.

Газрын тос, түлш шатахууны хэрэглээ ч бас дэлхийн хэмжээнд цаг уурын өөрчлөлт (голдуу, дэлхийн цаг уурын дулаарал гэж нэрлэдэг) гаргах ноцтой үр дагавартай. Цаг уурын өөрчлөлтийн үзэгдлийг ногоон хүлэмжин дотор юу болдогтой зүйрлэж болох бөгөөд дэлхийн агаар мандалд тодорхой хэмжээний хий үүсч дулаан ялгаралтыг хааж байна гэсэн үг. Газрын тос, байгалийн хийн эх үүсвэрээс ялгардаг хамгийн гол “хүлэмжийн хий” бол нүүрс төрөгчийн давхар исэл (CO_2) юм. Энэ нь бензин шатахууны хэрэглээ болон цахилгаан эрчим хүч үйлдвэрлэхээр шатааж буй газрын тос, байгалийн хийнээс бий болдог. Дэлхийн хэмжээгээр үйлдвэрлэж буй нийт цахилгаан эрчим хүчний 18 хувийг байгалийн хий, 7.5 хувийг газрын тосноос гарган авч байна. Харин адил хэмжээний эрчим хүч үйлдвэрлэхэд газрын тос байгалийн хийнээс 1.5 дахин их CO_2 ялгаруулдаг²⁷.

Агаар мандалд ялгарч буй CO_2 -ын өсөн нэмэгдэж буй хэмжээ ба цаг уурын нөхцөл байдлын хооронд ямар нэг хамаарал байна хэмээн дүгнэсэн НҮБ-ын Цаг Уурын Өөрчлөлтийн Талаарх Засгийн Газар Хоорондын Зөвлөлийн (өөртөө 2500 орчим эрдэмтдийн санаа бодлыг нэгтгэдэг) дүгнэлтэд эргэлзсэн хэвээр байгаа шинжлэх ухааны байгууллага дэлхий дээр тун цөөхөн үлджээ. Нэгэн Шинжлэх ухааны Үндэсний Академи сайтар боловсруулсан гаргасан 2001 оны тайландаа “хүний үйл ажиллагааны үр дүнд хүлэмжийн хий дэлхийн агаар мандалд хуримтлагдаж байгаа бөгөөд газрын гадаргын агаарын температур ба далай усны дэд гадаргын температур нэмэгдэхэд хүргэж байна” гэжээ²⁸.

Цаг уурын өөрчлөлтийн үр дагавар бодитой бөгөөд өргөн хүрээтэй байх талтай. Мөсөн голууд болон туйлын мөсөн дуулга хайлбал далайн усны түвшин дээшлэхэд хүргэж болзошгүй байна. Хар салхи гэх мэт цаг уурын онцгой үзэгдлүүдийн давтамж, эрчим ихсэж болох юм. Дулааралт нэмэгдсэнээр зарим бүс нутагт цөлжилт үүсгэж байхад зарим газарт ой мод, газар тариалангийн бүс нутаг багасаж болно. Дэлхийн агаарын температурын өсөлт янз бүрийн өвчний векторуудад (дамжуулагчдад) нөлөөлж байгаа учраас халуун хумхаа гэх мэт халдварт өвчнүүд илүү өргөн хүрээтэй тархаж болзошгүй байна. Далай тэнгисийн усны температур нэмэгдсэнээр далайн экосистемийн хамгийн бүтээлч хэсэг болох шүрэн хаднууд ихээр үхжихэд хүргэх талтай.

Хүмүүс өөрсдөө дэлхийн цаг уурын өөрчлөлтийн гол шалтгаан гэсэн ойлголт Киотогийн протоколийн цаад хөдөлгөгч хүчин болж байлаа. Энэ нь 1997 онд НҮБ-ын Цаг уурын өөрчлөлтийн хүрээний конвенцийн (конвенц өөрөө 1992 онд батлагдсан) нэг протокол болж хүлээн зөвшөөрөгдсөн олон улсын гэрээ юм. Киотогийн протокол нь дэлхийн хэмжээний CO_2 -ын ялгаралтыг 1990 оны түвшнээс 7 хувиар бууруулах замаар дээрх конвенцийн зорилгыг хангахад чиглэсэн үүрэг хариуцлага, хүрээг бий болгох цаад санаа агуулдаг. Уг протокол хөгжингүй орнуудын нүүрс төрөгч ялгаруулалтыг бууруулахад голлон анхаарч байна.

Уг гэрээг хэрэгжүүлэх нь дэлхийн цаг уурын дулааралтай тэмцэх дэлхийн нийтийн хүчин чармайлтын гол чиглэл болж үлдээд байна. 2004 онд Орос улс уг гэрээнд нэгдэн орсноор 2005 оны 2 дугаар сараас эхлэн энэ протокол хүчин төгөлдөр болж байна. Киотогийн протоколыг үр нөлөөтэй болгох хүчин чармайлтад хүнд цохилт болсон асуудал бол 2001 онд Бушийн засаг захиргаа уг гэрээнд нэгдэн орохоос татгалзсан явдал юм. АНУ дэлхийн нийт нүүрс төрөгчийн ялгаралтын 22-оос дээш хувийг дангаар хариуцан цаг уурын өөрчлөлтөд хувь нэмэр оруулагч цорын ганц томоохон улс үндэстэн хэвээр үлдэж байна²⁹.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Байгаль орчны үр нөлөөний тухай асуултууд

- ▶ Хайгуул, өрөмдлөгийн үйл ажиллагаа нь эмзэг ой, хамгаалагдсан үржил шимт газар, далай тэнгисийн эмзэг газар болон экологийн хувьд аюулд өртөхүйц бүс нутаг зэрэг байгаль орчны хувьд эмзэг газарт явагдаж байна уу? (Эмзэг газрын жишээнд IUCN буюу Дархан цаазат газруудын холбооны хамгаалалтад орсон газрууд, Дэлхийн Өв Санд орсон газрууд, НҮБ-д бүртгэлтэй үндэсний паркууд, Рамсарын конвенциор хамгаалагдсан үржил шимт газрууд орно).
- ▶ Дамжуулах хоолойн зурвасыг дээр дурдсаны адил байгаль орчны хувьд эмзэг газруудаар дайруулан тавьж байна уу? Хайгуул, өрөмдлөг хийх, дамжуулах хоолой байгуулахын тулд эдгээр газарт зам тавьж байна уу? Амьтдын, ялангуяа ховордсон төрөл зүйлийн амьдрах орчинг эвдэн сүйтгэж байна уу?
- ▶ Хайгуулын явцад тэсэлгээ хийх, чичиргээний машин ашиглах зэрэг газар дээрх чичирхийллийн судалгааны аргын оронд алсаас мэдрэх техник ашиглаж байна уу?
- ▶ Үйлдвэрлэсэн ус, өрөмдлөгийн шавар, шаар зэрэг олборлолтын дайвар бүтээгдэхүүнд хэрхэн хандаж, хаяж зайлуулж байна вэ? Өрөмдлөгийн шаврыг дахин ашиглаж байна уу? Үйлдвэрлэсэн усыг цооногт буцаан шахаж байна уу? Хаягдал хийх нүхийг яг нарийн зааглаж тогтоосон уу? Хаягдлыг зөөж гадагшлуулах сав ашиглаж байна уу?
- ▶ Нефтийг дагасан байгалийн хийг агаарт дэгдээх буюу шатааж байна уу?
- ▶ Далай дээрх цооногуудаас гарах хаягдлыг далайд шууд хаяхын оронд газар дээр тээвэрлэн авчраад зохих ёсоор янзлан хаяж байна уу?
- ▶ Дамжуулах хоолой барихдаа цоорч асгарах, тэсэрч дэлбэрэх аливаа аюулаас сэргийлж давхар ханатай, автоматаар хаагддаг хавхлагатай хийж байна уу?

- ▶ Олборлох ажиллагаа, дамжуулах хоолой, боловсруулах үйлдвэрийн байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг (БОНБҮ) хангалттай хийж байна уу? Тухайн БОНБҮ хайгуулын ажлаас эхлээд олборлох төслийн бүхий л цар хүрээг хамарч байна уу?
- ▶ БОНБҮ-г хараат бус шинжээч хийж гүйцэтгэсэн үү? Энэ үнэлгээнүүд нийтэд ил болсон уу? Тэдгээрийг өөр шинжээчид дахин нягтлан шалгах боломжтой юу? Төлөвлөсөн төслийн бүхий л хувилбаруудыг, түүний дотор ямар ч төсөл хэрэгжүүлэхгүй байх боломжийг бүрэн судалсан уу? Дамжуулах хоолойн хувьд тавьж болох өөр чиглэлийн хувиалбарыг бүрэн тооцож үзсэн үү?
- ▶ Боловсруулах үйлдвэрүүдэд хорт бодисын ялгаралт, осол гарах боломжийг хамгийн доод хэмжээнд хүртэл багасгах ямар арга хэмжээ авагдаж байна вэ?
- ▶ Газрын тос тээвэрлэгч танкерууд нефть асгаж алдахаас сэргийлэхэд шаардлагатай давхар хуяг болон технологитой юу? Авбал зохих аюулгүй байдлын өөр арга хэмжээ байна уу? Онцгой байдлын эсрэг хариу арга хэмжээ авах төлөвлөгөө гаргасан уу?

Хүний эрх ба нийгмийн асуудлууд

Ард иргэдийн оролцоо ба эрх мэдэл

Газрын тос олборлолт, тээвэрлэлт нь ийм ноцтой үр дагавартай байдаг учраас газрын тос олборлох, тээвэрлэх төсөл боловсруулах ажил туйлын маргаантай байж болно. Ихээхэн үр дагавар бүхий төслийг зөвхөн ард иргэд санал нэгтэй зөвшөөрч, үүний үр дүнд тухайн компанид чөлөөт бөгөөд мэдээлэлтэй зөвшөөрлийн хэлбэрээр “үйл ажиллагаа явуулах нийгмийн лиценз” олгосон тохиолдолд уг төслийг үргэлжлүүлэх ёстой гэж иргэний нийгмийн олон бүлэг, ард иргэд маргадаг. Ямар ч тохиолдолд нийгмийн болон байгаль орчны янз бүрийн боломжит эрсдлүүдийг харгалзан үзэж чадаагүй муухан боловсруулсан ажиллагааны үр дүнд тухайн оролцогч компаниудад урьдчилан төлөвлөгдөөгүй зардал гарах, нэр хүнд нь ихээхэн унах явдал гардаг.

Мөн ийм муухан ажиллагаа нь өөрсдийгөө ямар ч эрх мэдэлгүй гэж үзэн сэжигтэй хандаж байгаа нутгийн иргэдийн дунд хурцадмал байдал үүсгэж, уг төслийн эсрэг тэмцэхэд хүргэж болно.

Дотоодын тодорхой хууль дүрэм байхгүй буюу зарим хуулийг хэрэгжүүлэх чадвар муутай үед олон компани Дэлхийн Банкнаас гаргасан заавар удирдамжийг өөрсдийн зөвлөлдөх ажиллагаа, нийгмийн ба байгаль орчны бодлогыг чиглүүлэх жишиг болгон авч үздэг. Дэлхийн Банкны хувийн салбарт зээл олгох хэрэгсэл болох Олон Улсын Санхүүгийн Корпорацид (ОУСК) тус корпорациас санхүүгийн дэмжлэг авах хүсэлтэй компанийн дагаж мөрдөх ёстой нийгмийн хамгааллын болон байгаль орчны олон тооны бодлого байдаг. Түүнээс гадна, ОУСК-д мэдээллийг ил тод болгох болон зөвлөлдөх үйл явцад тавигдах тодорхой шаардлагууд байдаг.

Байгаль орчны хувьд хамгийн эмзэг бөгөөд газрын тосны орд газрын хөгжил, дамжуулах хоолой байгуулах асуудлыг бараг цаг ямагт анхаарах ёстой байдаг. А зэрэглэлийн төслүүдийн хувьд³⁰ ОУСК-иар үйлчлүүлэгч хувийн салбарынхан төслүүддээ байгаль орчны үнэлгээ (БОУ) хийлгэхийг шаарддаг. Эдгээр үнэлгээг нийтэд ил болгож, олон нийтээр хэлэлцүүлэх ёстой. ОУСК тухайн төслийг батлахаас дор хаяж 60 хоногийн өмнө БОУ-г гаргасан байх ёстой. Эдгээр төслүүдэд эмзэг өртөмтгий ард иргэдэд мэдээлэлтэйгээр шийдвэр гаргах боломж олгох үүднээс энэхүү зөвлөлдөх хугацааг дор хаяж 120 өдөр болгож сунгахыг иргэний нийгмийн олон бүлэг хүсэх байсан бизээ.

Бас эдгээр үнэлгээнд юу юу агуулагдах ёстой, яаж хийгдэх ёстойг ОУСК-иас зааж өгсөн байдаг. Ийм үнэлгээ нь төслийн боломжит хувилбаруудыг, түүний дотор “ямар ч төсөл хэрэгжихгүй байх нөхцөл байдал”-ыг судалж, төслийн сонголт, боловсруулалтыг сайжруулах арга замыг тогтоох ёстой. Мөн юуны өмнө байгаль орчны сөрөг нөлөөнөөс урьдчилан сэргийлэх, дараа нь түүнийг аль болох багасгах, хор хохирлыг барагдуулахыг хичээх ёстой. Үр нөлөөг хэрхэн удирдахыг тодорхой зааж өгсөн байх ёстой. Тухайн үнэлгээнд байгаль орчны асуудлуудыг өргөн хүрээтэй авч үзэж, агаар, ус, газар төдийгүй хүний эрүүл мэнд, аюулгүй байдал, шилжин суурьшил болон нутгийн уугуул иргэдэд үзүүлэх нөлөөг оруулж тооцох шаардлагатай. Эмзэг төслүүдийн хувьд тухайн төслийн санхүүжүүлэгч БОУ хийлгэх хараат бус талыг хөлслөн ажиллуулахыг ОУСК шаарддаг бөгөөд хараат бус, нэр хүнд бүхий шинжээчдээс бүрдсэн зөвлөх хэсэг тухайн төсөл, түүний байгаль орчинд үзүүлэх нөлөөний талаар зөвлөгөө өгөхийг зөвлөмж болгож байна.

Үр нөлөөтэй ажиллагаанд мөн олон нийттэй зөвлөлдөх явдал ордог. Эмзэг төслүүдийн хувьд, ОУСК-иас төслийг хэлэлцэх явцад тухайн төслөөс

нөлөө үзүүлж болох ард иргэд, иргэний нийгмийн бүлгүүдтэй хоёр удаа зөвлөлдөхийг шаарддаг. Эхний зөвлөгөөнийг үнэлгээний ажил эхлэхээс өмнө, аль болох эрт хийх ёстой. Харин БОУ-ний төсөл бэлэн болсны дараа уг тайланг хэлэлцэх зорилгоор хоёрдахь зөвлөгөөнийг хийх ёстой. Зөвлөлдөх үйл явцын үеэр тухайн төсөл нөлөөлөх хүмүүст ойлгомжтой хэл, хэлбэрээр (түүний дотор бичиг үсэгт тайлагдсан хувийг харгалзана) бичигдсэн материалыг гаргаж өгсөн байх ёстой. БОУ-ний төслийг уг төсөл нөлөөлөх ард иргэд, орон нутгийн иргэний нийгмийн бүлгүүдэд ойр хүртээмжтэй байдлаар нийтэд зориулсан газруудад, тухайлбал тухайн орон дахь Дэлхийн Банкны суурин төлөөлөгчийн газар, үндэсний болон орон нутгийн захиргааны байгууллагууд дээр тавьсан байх шаардлагатай.

Мөн БОУ өөрөө гүйцэтгэлийн хураангуй, төслийн танилцуулга, нийгэм, эдийн засаг, байгаль орчны нөхцөл байдлын суурь үзүүлэлтүүд, төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөө, боломжит хувилбаруудын шинжилгээ болон үзүүлэх нөлөөг багасгах, хяналт шинжилгээ хийх, чадавхийг бэхжүүлэх зэрэг шаардлагатай ажилд зориулсан байгаль орчны үйл ажиллагааны төлөвлөгөөг агуулсан байх ёстой. Төсөл нэгэнт хэрэгжиж эхэлсэн бол цаашид гарч болох аливаа асуудлыг авч хэлэлцэх зөвлөгөөнийг тогтмол хийж байх ёстой.

Цэрэгжүүлэлт ба хүний эрхийн зөрчлүүд

Газрын тосны салбарын хүний эрхийн нөлөөний талаар санаа зовоож буй асуудлууд улам ихээр төвлөрөх болсон нэг зүйл бол газрын тосны үйлдвэрлэлийн “цэрэгжүүлэлт” бөгөөд ялангуяа үндэстэн дамнасан корпорациудын үйлдвэрлэлийн үйл ажиллагаагаа хамгаалах зорилгоор ажиллуулж буй аюулаас хамгаалах хүчнүүдийн түрэмгий ажиллагаа юм. Газрын тосны салбар дахь цэрэгжүүлэлт нь тус салбар түлш шатахууны эх үүсвэрийг дэлхийн хэмжээнд эрчимтэй эрж хайх болсны улмаас газрын тосны компаниуд ялзарсан эсвэл дарангуйлагч төр засагтай орнуудад үйл ажиллагаа явуулах буюу өргөжүүлэх явдал улам ихэссэнтэй холбоотой. Газрын тосны компаниуд олборлолтын болон дамжуулах хоолойн үйл ажиллагаагаа хамгаалах хууль ёсны эрх ашигтай байхын хажуугаар тус салбар эдгээр орнууд дахь хүний эрхийн тухай ойлголт муутай аюулгүйн хүчнийхэнтэй хамтран ажиллах нь ихэссэн байна.

Ихэнх тохиолдолд үүнд оролцож байгаа аюулгүйн хүчнийхэн засгийн газраас санхүүждэг үндэсний арми, дотоодын цэрэг, цагдаагийнхан байна (гэхдээ зарим тохиолдолд газрын тосны компаниуд хамгаалалтын хувийн компаниуд хөлсөлсөн байдаг). Нигери, Бирм, Индонези, Перу зэрэг улсад эдгээр аюулгүйн хүчнийхний үйл ажиллагаа маш олон төрлийн хүний эрхийн зөрчил гаргадгийн

дотор чөлөөтэй үг хэлэх, шүүхэд хандах эрхийг хаах, эрүүдэн шүүх, боолчлох, албадан хөдөлмөр эрхлүүлэх, хүчиндэх, шүүхээс гадуур хүний амь нас хөнөөх, цаазлах явдал гардаг. Олон тохиолдолд компаниуд ба засгийн газар, аюулгүйн хүчнийхний хооронд голдуу хөлслөх гэрээ буюу бусад гэрээний зохицуулалтаар дамжуулан ойр дотно харилцаа тогтоодгоос болж нилээд олон газрын тосны компаниуд хүний эрх зөрчигчдийн үйл ажиллагаанд холбогдож, тэр ч бүү хэл орооцолдоод байна.

Олборлох үйл ажиллагаа, дамжуулах хоолой байгуулах ажлын их хэмжээний сөрөг нөлөөллийн эсрэг гарч болзошгүй дотоодын эсэргүүцлийг (буюу тэдний хувьд дотоодын эсэргүүцэл гэж үзэж байгаа зүйлийг) дарах буюу хамтран цэг тавих гэсэн газрын тосны компаниуд ба засгийн газруудын оролдлогоос үүдэн цэрэгжүүлэх үйл явц эхэлдэг.

Зарим тохиолдолд, газрын тостой холбоотой нийгмийн болон байгаль орчны сүйрлүүд, түүний дотор газрын тос алдаж асгах, хорт хаягдал хаях, нутгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр болсон орон нутгийн экологи сүйрэх, орон нутгийн хөгжил хангалтгүй буюу буруу замаар явах, мөн хураагдсан газар нутаг болон бусад хохирлын нөхөн төлбөрийг хангалтгүй барагдуулах, хөдөлмөрийн нөхцөл тааруу байх зэргээс болж ард иргэдийн өрнүүлсэн хүчтэй эсэргүүцэл тэмцлийн хариуд цэргийн хүч хэрэглэх явдал гардаг. Энэхүү олборлож байгаа газрын тосны нөөц баялаг бол бидний хяналтад байх ёстой гэсэн нутгийн олон ард иргэдийн үзэл бодол дээрх эсэргүүцлийг дэврээх нь элбэг байдаг. Газрын тосны үйлдвэрлэлээс нийгэмд болон байгаль орчинд үзүүлж байгаа хор нөлөөг сөрсөн эсэргүүцлийг дарахад цэргийн хүч ашигласан хамгийн цуутай тохиолдол нь Нигерийн Нигер Дельтад болсон явдал байж магадгүй.

Байгаль орчны сүйрэл ба хүний эрхийн зөрчил

Баян байдлын гаж үзэгдлийн нэг гол жишээ бол Нигери улс юм. ОУВС-ын ажлын баримт бичгээс үзэхэд 1965 онд нэг хүнд ноогдох газрын тосны орлого 33\$ орчим байхад нэг хүнд ноогдох орлогын хэмжээ 245\$ байжээ. Гучин таван жилийн дараа нэг хүнд ноогдох газрын тосны орлого 325\$ болчихоод байхад нэг хүнд ноогдох орлогын хэмжээ 1965 оны түвшиндээ л үлджээ. “Өөрөөр хэлбэл, газрын тосны бүх орлого-нийтдээ 350 тэрбум ам.доллар нийлээд амьжиргааны түвшинг огт нэмэгдүүлээгүй болж таарч байна³¹.” 1970-2000 оны хугацаанд ядуурлын түвшин нийт хүн амын гуравны нэг орчим хувиас бараг 70 хувь хүртэл өссөн байна³².

Нигер Дельта зэрэг газрын тос үйлдвэрлэгч бүс нутгийн ард иргэдийн хувьд газрын тосны үйлдвэрлэлийн нөлөө сүйрлийн шинжтэй байна. Хүний Эрхийн Ажиглагч байгууллага “газрын тосонд тулгуурласан хөгжил нь байгаль

орчныг төдийгүй тэнд амьдарч буй ард олны амьжиргааг илт ноцтойгоор сүйрүүлж байна” гэж дүгнэсэн байна³³. Нигер Дельта бол биологийн хувьд мангроу ургамлаар баян нутаг бөгөөд тэндхийн ихэнх хүмүүсийн амьжиргааны үндэс нь загас агнуур, газар тариалан байдаг. Газрын тос алдаж асгах явдал Дельтад хэтэрхий олон гардагас ус, хөрсийг бохирдуулж загас үхэж, тариалан сүйдэж байна. Газрын тос тээвэрлэх зорилгоор компаниудын гаргаж, ашиглаж буй сувгууд нь байгалийн усны урсгал, усны чанарт нөлөөлж, мөн л “тариалангийн ургацыг үхүүлж, загасчлах газруудыг устган, ундны усны нөөцийг алдагдуулж байна³⁴.” Мөн газрын тосны компаниудын нэрийн өмнөөс хангалттай нөхөн төлбөргүйгээр газар нутгийг албадан хураах явдал олон гарч байна.

Хараат бусаар ажиллах шүүхийн систем байхгүй учраас ард иргэд ихэнх тохиолдолд эдгээр буруутай үйлдлийг засч залруулж чадахгүйд хүрч байна. Энд газрын тосны компаниуд ба ард иргэдийн хоорондын харилцаа хурцдаж мөргөлдөөн нийтлэг гарах болсонд гайхах зүйлгүй юм. Дельтад газрын тос олборлосноос үүдсэн байгаль орчны сүйрэл болон нутгийн иргэдийн амьжиргааны гол эх үүсвэр болсон загас агнуур, газар тариалангийн үйлдвэрлэлийг сүйрүүлсний хариуд ард иргэд үндэстэн дамнасан газрын тосны компаниудын үйл ажиллагааг эсэргүүцсээр байна. Эсэргүүцлийн тактик болгож олон нийтийн жагсаал цуглаан хийх, газрын тосны байгууламжуудыг хүчирхийллийн бус аргаар эзлэн авах, заримдаа дамжуулах хоолойн ажиллагааг зориуд зогсоон саатуулах зэрэг аргыг ашигласан байна.

Харин энэ үеэр засгийн газар тухайн бүс нутаг дахь аюулгүйн хүчнээ нэмэгдүүлж, газрын тосны компаниуд үйл ажиллагаагаа хамгаалах зорилгоор дотоодын цагдаа зэрэг аюулгүйн хүчнийхнийг хөлслөн ажиллуулах нь олонтаа байна. Хүний Эрхийн Ажиглагч байгууллагын мэдээгээр эдгээр үйлдвэрлэгчдийг хамгаалж буй засгийн газрын аюулгүйн хүчнийхний үйл ажиллагаа хүний эрхийн хүнд ноцтой зөрчлүүд, түүний дотор цаазлан хороох, зодох, шүүлгүйгээр шоронд хорих явдал гаргаж байгаа ажээ. 1999 онд Хүний Эрхийн Ажиглагчийн ажлын хэсэг Нигер Дельта дахь нөхцөл байдлыг сурвалжлах үеэрээ газрын тосны компаниудтай холбоотой гомдол гаргахыг оролдсон хүмүүсийг харгислан шийтгэх явдал олон давтагдсаныг баримтаар тэмдэглэн авсны зэрэгцээ тус бүс нутаг дахь хамгийн том үйлдвэрлэгч Роял Датч/Шелл компани уг хүний эрхийн зөрчилд орооцолдсон засгийн газрын аюулгүйн хүчнийхэнд мөнгө төлж байсныг тогтоожээ. “Тайван ч бай, үгүй ч бай ямар нэг эсэргүүцлийн арга хэмжээнд оролцсон хүмүүс эсвэл газрын тосны учруулсан хор хохирлыг барагдуулахыг уриалсан залуучууд, эмэгтэйчүүд, хүүхдүүд, уламжлалт удирдагчид аль нь ч бай ялгаагүй тэднийг байнгын цагдаа, цэргийн хүчнийхэн зодох, баривчлан хорих, бүр амь насыг нь хөнөөх явдал бараг газар сайгүй гарах болжээ³⁵.”

Хамгийн дуулиантай нь гэвэл 1995 онд тэр үеийн ерөнхийлөгч асан генерал Сани Абачагийн засгийн газар зохиолч Кен Саро-Уиуаг Дельтад хамгийн нөлөөтэй олон нийтийн байгууллага болох Огонигийн Ард Түмний Амьдрах Эрхийн Төлөө Хөдөлгөөн (ОАТАЭТХ)-ий бусад найман идэвхтэн гишүүний хамт тэдний хийхийг оролдсон гэмт хэрэгтээ буруутай гэсэн баттай нотлох баримтгүйгээр цаазаар авсан байна³⁶.

Бусад тохиолдлуудад, дарангуйлагч дэглэмийг сөрсөн эсэргүүцэл эсвэл ямар нэг үндэстэн ястны буюу салан тусгаарлах хөдөлгөөн зэрэг аюулгүй байдлын тогтворгүй орчинд ажиллаж байгаа газрын тосны компаниудын үйл ажиллагааг хамгаалах гэсэн түрэмгий оролдлогуудад аюулгүйн хүчнийхэн оролцож байна. Газрын тосны үйлдвэрлэл бол аливаа орны эрх баригч дээдсийн эрх дархын асуудал гэж үзэж байна. Дотоодын эсэргүүцлийн хөдөлгөөнүүдээс учрах бодит аюул заналын хүнд, хөнгөн байдал янз бүр боловч аюулгүйн хүчнүүд тухайн аюулгүй байдлын хөндөгдөж байгаа асуудлын хил хязгаараас хол давсан аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд идэвхтэй оролцож байгаа жишээ олон байна. Түүнчлэн энд үзүүлж буй эсэргүүцлийг нухчин дарах аргууд нь хүмүүс түүнээс айж эмээх уур амьсгал төрүүлэхээс гадна ерөнхийдөө нутгийн ард иргэд тухайн төслийг үг дуугүй хүлээн зөвшөөрч, дуулгавартай дагахыг шаардсан айлган сүрдүүлэлт байдаг.

Газрын тосны салбар дахь энэ төрлийн цэрэгжүүлэлтийн хамгийн тод жишээ бол 1990-ээд оны эхээр Бирм улсад Юнокал болон түүний консорциумын түнш компаниуд Яданагийн хий дамжуулах хоолойг барьж байгуулахад Бирмийн цэргийн хунттай хамтран ажиллахаар шийдсэн явдал байв. Хэдийгээр энэхүү цэргийн харгис дэглэмийнхэн хүний эрхийн аймшигт зөрчлүүдээрээ алдартай боловч тус компани дамжуулах хоолой барих үедээ тэр үеийн Хууль, Дэг Журмыг Тогтоох Төрийн Зөвлөл (ХДЖТТЗ) буюу одоогийн Энх Тайван, Хөгжлийн Төрийн Зөвлөлтэй ямар ч атугай гэрээ байгуулсан юм³⁷. Энэхүү цэрэгжүүлэлт нь зөвхөн аюулгүй байдлыг хангах төдий биш дамжуулах хоолойн дэд бүтцийг барьж байгуулахад тэнд бэлэн байгаа хөдөлмөр эрхлэгчдийг албадан татан оролцуулах зорилготой явдал байсан гэж хүний эрхийн төлөө тэмцэгчид үзэж байна. Зам дагуу байрласан цэргийнхний дарангуйлал аюулгүй байдлыг хангах үндсэн зорилгоосоо хальсны дотор бүхэл бүтэн тосгоныг хүчээр нүүлгэн шилжүүлэх, цэргийн үйл ажиллагаа болон гарнизон байгуулах ажилд албадан хөдөлмөрлүүлэх, тэр нутгийн тосгоны иргэдийг хүчирхийлэх, алж хөнөөх явдал гарч байв³⁸.

Тухайн бүс нутагт газрын тосны үйл ажиллагаа явуулахад саад болох гэсэн нутгийн иргэдийн оролдлогыг нухчин дарахын тулд ч цэрэгжүүлэх явдал байдаг. Жишээлбэл, Латин Америкт нутаг дэвсгэрт нь газрын тосны өрөмдлөг хийх,

дамжуулах хоолой байгуулах гэсэн газрын тосны компаниудын хүчин чармайлтыг нутгийн уугуул иргэдийн хэд хэдэн бүлэг эсэргүүцэж байна. Колумбид болсон нэгэн сайн мэдэх жишээнд нутгийн уугуул иргэд болох Ю'ва хүмүүс халуун орны эмзэг ойд байрласан онгон дагшин нутагт нь газрын тосны өрөмдлөг хийхийг оролдсон Оксидентал Петролеум компаний ажиллагааг эсэргүүцсэн билээ. Оксидентал компаний төслийг 2000 оноос цааш үргэлжлүүлэн явуулахын тулд Колумбийн эрх баригчид уг төслийн гол замыг хаан эсэргүүцэл илэрхийлсэн Ю'ва босогчдын эсрэг зэвсэглэсэн цагдаа нар авчирч мөргөлдүүлсэн байна. Эсэргүүцлийн хөдөлгөөн хэд хэдэн удаа давтан гарсны дараа 2002 онд Оксидентал компани газрын тосны концессоо цаашид үргэлжлүүлэн эдлэхгүй байхаар шийдсэн байна³⁹.

Цэрэгжүүлэлтийн үеэр хүний эрхийн зөрчлүүд гарвал уг зөрчлийн төлөө газрын тосны компаниуд ямар хэмжээний хариуцлага хүлээх нь голдуу маргаантай байдаг. Аюулаас хамгаалах хүчнээс тодорхой тусалцаа авна гэдэг бол аливаа компани цэрэгжүүлэлтэд оролцсоны хөдлөшгүй нотлох баримт боловч энэ тусалцааны хэмжээ харилцан адилгүй байдаг. Бирмийнх шиг зарим тохиолдолд газрын тосны компани аюулгүй байдлаа хамгаалуулахаар үндэсний цэргийнхнийг хөлсөлдөг бол бусад тохиолдолд Шелл компани Нигерид хийсэн шиг тухайн компани дотоодын аюулгүйн хүчнийхэнд мөнгө төлсөн байдаг⁴⁰. Мөн газрын тосны компаниуд цэргийнхэнд материаллаг дэмжлэг үзүүлсэн байдаг. Жишээлбэл, Шелл компани Нигерийн аюулгүйн хүчнийхнийг буу зэвсгээр хангасан байхад Чеврон компани цагдаагийн хүчнийхнийг дуудаж нисдэг тэрэг болон нисгэгчдээр хангасан бөгөөд тэд Чевроны нефть өрөмдлөгийн тавцан дээр байсан тайван замаар эсэргүүцэн жагсагчдыг буудсан байдаг⁴¹. Компаниуд болон аюулгүйн хүчнийхэн хамтран ажиллаж байгаа өөр бусад хэлбэрийн дотор аюулгүй байдлын хамтарсан стратеги боловсруулах, өдөр тутмын аюулгүй байдлын товч мэдээлэл хийх, цэрэг, цагдаагийнхныг унаа, буу зэвсэг, хоол хүнс, эм тариагаар хангах явдал ордог.

Харин аюулгүйн хүчнийхэнд өгсөн санхүүгийн буюу материаллаг тусалцааны түвшин нь зөвхөн газрын тосны компанийн хүлээх хариуцлагын тухай асуултад хариулт болох юм. Дотоодын цэрэг, цагдаагийн хүчний аюулгүй байдлын үйлчилгээнд найддаг газрын тосны компаниуд тэдгээр хүчний гаргасан хүний эрхийн зөрчлүүдийн талаар сайн мэддэг байх ёстой гэж хүний эрхийн тэмцэгчид маргаж байна. Компаниуд хүний эрхийн зөрчил гаргахаас сэргийлэх буюу гаргахыг буруушаах, эсвэл эдгээр хүчнүүдтэй хамтарч бизнес эрхлэхээс зайлсхийх хүчин чармайлт идэвхтэй гаргах ёстой гэж тэд ярьж байна.

Цэрэгжүүлсэн үйл явдлын жишээний товчоон

- ▶ Нигери: Нигер Дельтад зөрчил гаргасан дотоодын аюулгүйн хүчнийхэнд Шелл компани мөнгө төлжээ; мөн нутгийн иргэдийн удирдагчдыг шүүн цаазлах үеэр туйлбартай алхам хийж чадаагүй (1990-ээд он)
- ▶ Нигери: Чеврон компани Нигерийн цэрэг, цагдаагийн хүчнийхнийг дуудаж, тээвэрлэн авчирснаар тэд тайван замаар эсэргүүцэл илэрхийлэгчид рүү Чевроны нисдэг тэрэгнээс буудаж, амийг нь хөнөөсөн. (1998, 1999 он)
- ▶ Бирм: Юнокал компани Яданагийн дамжуулах хоолойг хамгаалуулахаар Бирмийн цэргийнхэнтэй гэрээ байгуулсан; тосгоны иргэдийг хороох, хүчиндэх, эрүүдэн шүүх, дэд бүтцийн барилгад хүчээр ажиллуулах явдал гарч байна (1994 оноос хойш одоог хүртэл)
- ▶ Колумби: Оксидентал Петролеум компанийн газрын тосны төслийг эсэргүүцсэн нутгийн уугуул Ю'ва иргэдийн гишүүдийг хөөн зайлуулахад Колумбийн зэвсэглэсэн цагдааг авчирч ашигласан (1990-ээд оны сүүлээр)

Бирм улсын жишээнд гэхэд ХДЖТТЗ-ийн хүний эрхийн зөрчлүүдийн талаар мэдэж байсан байж болох боловч ХДЖТТЗ-ийг хүний эрхийг зөрчихийг бид хүсээгүй, тийм даалгавар ч өгөөгүй гэсэн Юнокал компанийн тайлбартай хүний эрхийн тэмцэгчид маргасаар байна⁴². Хүний эрхийн тэмцэгчдийн тэмдэглэж байгаагаар, тус компани хүний эрхийн зөрчил гарах гэж байна гэдгийг сайн мэдэж байсан бөгөөд тэдгээрээс урьдчилан сэргийлэх эсвэл ХДЖТТЗ-тэй хамтарч бизнес эхлэхээ болих ёстой байсан гэж үзэж байна⁴³.

Нигери улсад Кен Саро-Уиуаг болон ОАТАЭТХ-ий нөхдийг нь цаазлан хорооход хүргэсэн шүүх хуралд Шелл компани идэвхгүй байр суурь баримталсан нь ч асуудалтай байна. Иргэний нийгмийн зүгээс улам их дарамт шахалттай учирсны дараа Шелл компани шударга шүүх ажиллагаа явуулахыг уриалсан хэдий ч шүүх хурлын бодит үйл ажиллагаа болон гаргасан шударга ёсыг зөрчсөн шийдвэрийн эсрэг тодорхой эсэргүүцэл илэрхийлээгүй хэрэгт Хүний Эрхийн Ажиглагч болон бусад бүлэглэлүүд тус компанийг зэмлэн буруушааж байна⁴⁴.

2000 онд аюулаас хамгаалах хүчнийхний гаргаж буй хүний эрхийн зөрчлүүдийн талаар тасралтгүй маргах болсон нь АНУ-ын Төрийн Департамент, Их Британий Гадаад Хэрэг болон Хамтын Нийгэмлэгийн газрын зүгээс газрын тос ба уул уурхайн компаниудыг зарим нэг төрийн бус байгууллагын хамт нэг дор цулуулж *Аюулгүй байдал ба Хүний эрхийн Сайн дурын Зарчмууд* хэмээх багц зарчим боловсруулан гаргахад хүргэсэн юм. Уг зарчмууд нь олборлох салбарын (нефть, уул уурхайн) компаниудын аюулгүй байдлын зохицуулалтад хүний эрхийн хамгаалалт тогтооход чиглэсэн удирдамж гаргах зорилготой байв. Энэхүү зарчмууд нь хувийн хамгаалалтынхантай харилцах харилцаа, улсын хамгаалалтынхантай харилцах харилцаа, аюулгүй байдлын орчинтой холбоотой эрсдийн үнэлгээ гэсэн гол бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Уг зарчмуудын заалтын дотор компаниуд засгийн газрын аюулаас хамгаалах хүчинтэй харилцах бодлогоо тодорхой болгох ёстой гэжээ. Уг зарчимд анхнаас нь гарын үсэг зурсан газрын тосны компаниудын тоонд Чеврон, Тексако, Коноко, Шелл, БиПи компаниуд орж байна.

Уг зарчмуудыг зарим газар олборлох салбарт зориулсан энэ төрлийн анхны заавар удирдамж бөгөөд дэлхий нийтийн жишиг хэмээн зарлан тунхаглаж байна. Гэвч зарим ТББ-ууд үүнд болгоомжтой хандаж байна. Эмнести Интернэшнл байгууллага эдгээр зарчмыг талархан хүлээн авсан боловч энэ байгууллага уг зарчмуудыг боловсруулахад оролцсоноо үл харгалзан түүнийг соёрхон батлаагүй байна. ЕэрфРайтс Интернэшнл зэрэг бусад бүлэг уг зарчмын сайн дурын шинж чанарыг хангалтгүй гэж үзэн шүүмжилжээ. Мөн компаниуд аюулаас хамгаалах хүчнүүдтэй байгуулсан аюулгүй байдлын гэрээ, зохицуулалтуудынхаа нөхцлийг ил гаргахыг хөхиүлэн дэмжээгүй хэмээн уг зарчмуудыг шүүмжилж байна.

Шилжин суурьшилт ба албадан шилжүүлэлт

Газрын тосны үйлдвэрлэлийн зарим төслөөс болж хүмүүс шилжин суурьших шаардлагатай болдог нь нийгэм, эдийн засгийн талаасаа хохиролтой практик юм. Газрын тосны компаниуд газрыг албадан хурааж авсныхаа төлөө болон мөн шилжин суурьших явцад нутгийн ард иргэдэд учирсан бусад хохирлын зохих нөхөн төлбөр олгож чадаагүйн улмаас ноцтой асуудлууд үүсч болдог. Зурвас замын дагуух газрыг эрчимтэй ашиглаж, байгалийн нөөц баялгийг эвдэн сүйтгэхэд хүргэдэг учраас дамжуулах хоолой байгуулахад нөхөн төлбөр ихээхэн санаа зовоох тусгай асуудал байдаг.

Олон тохиолдолд, нөхөн төлбөрийн асуудлаар тохиролцохын тулд компаниуд нийт ард иргэдтэй зөвшилцөлгүйгээр тэдний цөөн хэсэг эсвэл удирдагч нартай нь ярьж тохирох болно. Ерөнхийдөө нөхөн төлбөрийн хэмжээг

олон нийтэд мэдэгддэггүй бөгөөд энэ нь тухайн нөхцөл байдлаас хамаарч янз бүр байна гэж үзэж болно.

Перу улсад 2003 онд хийсэн байгаль орчны байгууллагуудын шалгалтаар Камисеагийн дамжуулах хоолойг байгуулж буй компаниудын консорциум нутгийн ард иргэдийн туршлагагүй байдлыг далимдуулж, газар болон байгалийн баялгийн нөхөн төлбөрийн хэмжээг тооцох зохих ёсны аргыг ашиглаагүй нь илэрчээ⁴⁵. Мөн үүнтэй адил 2002 онд хийсэн шалгалтаар Шелл, Энрон компанийн консорциум Кюибагийн дамжуулах хоолойг тавихад нутгийн иргэдээс авч ашигласан газрын эрхийнхээ бүх зардлыг бүрэн төлж чадаагүй байсныг тогтоосон байна⁴⁶.

ОУСК-ийн сайн дурын бус шилжин суурьшилтийн бодлогыг хөгжиж байгаа орнуудад хэрэгжиж буй төслүүдэд зориулсан нэг заавар гэж үздэг. Уг бодлогын дагуу, сайн дурын бус шилжин суурьшилт оролцсон аливаа төсөлд шилжин суурьшилтын төлөвлөгөө дагалдах ёстой бөгөөд уг хөтөлбөрийг боловсруулахад нутгийн ард иргэд оролцох ёстой. Шилжин сууж байгаа иргэдэд бүрэн шилжихтэй холбоотой бүх зардлыг тэднийг нүүхээс нь өмнө нөхөн олгох ёстой. Нөхөн төлбөрийн хэмжээнд тухайн нөхцөлд тохирсон газар, орон байр, дэд бүтэц, бэлэн мөнгө орно. Шилжин сууж байгаа хүмүүсийн нүүж суух, шинэ газар очиж төвхнөхөд шаардлагатай туслалцааг үзүүлэх ёстой. Тэд шилжин суурьшсанаар дор хаяж хуучин байснаасаа доордох ёсгүй бөгөөд төслийн санхүүжүүлэгчид тэднийг орлого олох чадвараа дээшлүүлэхэд нь туслах шаардлагатай. Тухайн газрыг албан ёсоор эзэмших эрх дутагдах нь нөхөн төлбөрөөс татгалзах шалтгаан гэж үзэхгүй. Төслийг санхүүжүүлэгчид Шилжин Суурьшуулах Үйл ажиллагааны Төлөвлөгөө боловсруулж олон нийтэд танилцуулах ёстой бөгөөд уг төлөвлөгөөг тухайн улс дахь Дэлхийн Банкны төлөөлөгчийн газар, үндэсний ба орон нутгийн засгийн газрын байруудад тавьсан байх шаардлагатай.

Гэвч ОУСК-ийн “сайн дурын бус” шилжин суурьшилт гэсэн тодорхойлолт өөрөө маргаантай байдаг. Аливаа төсөл ард иргэдэд сөрөг нөлөө үзүүлэхээр байх л юм бол хүмүүс нүүхээс аргагүй болдог. Жишээлбэл, ОУСК-ийн бодлогоор бол аливаа байгууламжаас үүссэн бохирдол эрүүл мэндэд муугаар нөлөөлсний улмаас нүүж байгаа оршин суугчдыг сайн дураар нүүж байгаад тооцох нь ээ. Иймээс, олон ТББ энэхүү сайн дурын бус байдлын тодорхойлолтыг хэт явцуу гэж үзэж байна.

Сайн дурын буюу сайн дурын бус шилжин суурьшилтаас гадна албадан шилжүүлдэг тохиолдлууд бий. Тухайлбал, Бирм улсад Юнокал компанийн Яданагийн дамжуулах хоолойн зурвасыг татаж, аюулгүй байдлыг хангах үүднээс ХДЖТТЗ-өөс бүхэл бүтэн тосгоныг галдан шатааж, буу тулган хүчээр нүүлгэж

байсан байна⁴⁷. Уг нүүлгэн шилжүүлэлтийг аюул занал учруулж, айлган сүрдүүлэх байдлаар хийсэн учраас цэргийн энэхүү ажиллагаа нь олон улсын заншлын хуулийг зөрчсөн байна гэдгийг АНУ-ын давж заалдах шүүх тогтоосон байна.

Нутгийн уугуул ард иргэд

Газрын тосны өрөмдлөг нь зах хязгаар нутгуудад хүрч хийгддэг учраас газрын тосны компаниуд хааяа нутгийн уугуул иргэдтэй холбоо тогтооход хүрдэг бөгөөд тэдний ихэнх нь гадаад ертөнцтэй хэзээ ч харилцаж үзээгүй хүмүүс байдаг. Эдгээр ард иргэд газрын тосны хайгуул, өрөмдлөг тэдний нутаг дээр хийгдэж байгаа талаар бага буюу огт мэдэхгүй байх нь дэндүү олонтаа тохиолддог. Ийм хүмүүс аливаа орны албан ёсны эрх зүйн тогтолцоонд хамрагдаагүй байх нь ч элбэг байдаг.

Нутгийн уугуул иргэд гадны өвчин эмгэг, бусад нийгмийн аюул заналд хүчээр холбогдож, татагдан ордог нь тэдний уламжлалт амьдралын хэв маягийг эвдэхэд хүргэдэг. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа нь нутгийн уугуул иргэдийн оршин буй экологийн эмзэг бүс нутгийг сүйтгэж, тэдний ариун дагшин гэж үздэг газруудад халдаж болох юм.

Дархлаа тогтоогүй нутгийн уугуул иргэдэд халдварт өвчин хүргэх явдал түгээмэл байдаг. Жишээлбэл, 1990-ээд онд Перугийн Амазон дахь Урарина омгийн хүмүүсийн бүс нутагт газрын тосны ажилчид очсоноор Ураринагынхан урд хожид тэнд огт гарч байгаагүй пертуссас (бүгшүүлсэн ханиалга), чичрэг зэрэг өвчин туссан байна⁴⁸.

Нутгийн уугуул иргэдэд үзүүлэх нөлөө: Камисеагийн дамжуулах хоолойн жишээ

Алс хязгаар Перугийн Амазонд байгалийн хий олборлож, түүнийгээ далайн эрэг рүү тээвэрлэх зорилготой Камисеагийн төсөл бол дэлхий дээрх олборлох салбарын сүүлийн үеийн төслүүдээс хамгийн маргаантайгийн нэг юм. Тус төсөл экологийн хувьд дэлхийн хамгийн үнэ цэнэтэй халуун орны шигүү ойн нэгэнд байрладаг. Дэлхийн Унаган Байгалийн Сангаас (World Wildlife Fund) уг газрыг “Глобал 200” эко-бүс нутгийнхаа нэг болгон зааж, биологийн асар олон төрөл зүйлийг агуулсан, дэлхийн хэмжээнд чухлаар үнэлэгдэх экологийн үүрэгтэй уг газрыг дархлан хамгаалах ажилд тэргүүлэх ач холбогдол өгөөд байна.

Гэтэл уг экспортын байгууламжууд олон улсад нэртэй далайн экологийн нөөц газарт байрлаж байна.

Мөн уг төсөл нь хамгаалагдсан дархан газрын хүрээнд сайн дураар тусгаарлагдан амьдарч буй Камисеа нутгийн уугуул иргэдийн эрхийг зөрчиж байгаа юм. Уг дархан газрыг Нанти ба Нахуагийн тусгаарлагдсан ард иргэдийн газар нутгийг баталгаажуулах, тэднийг гадны нөлөөнөөс хамгаалах зорилгоор байгуулсан байна. Тэдний бусдын нөлөөллөөс хол байж, өөрсдийн хөгжлийн замыг тодорхойлох эрхийг Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагаас гаргасан Нутгийн уугуул болон овог, аймгийн хүмүүсийн тухай 169 дүгээр конвенцид тодорхой зааж өгсөн бөгөөд үүнд Перугийн засгийн газар нэгдэн орсон байдаг. Дотоодын ТББ-уудын мэдээгээр төслийн ажилтнууд эдгээр ард иргэд дээр урьдчилж мэдэгдэлгүйгээр очиж байсан байна.

Уг дархан газарт төслийн ажилчид болон бусад гадны хүмүүс очсоноор ямар нэг гадны өвчний дархлаа тогтоогүй эдгээр тусгаарлагдсан хүмүүст өвчин халдааж байна. Халуун орны анагаах ухааны Лондонгийн сургууль ба Перугийн Эрүүл мэндийн яамны хамтарсан эрүүл мэндийн үзлэгийн урьдчилсан дүнгээр Камисеа голын дагуу нутаглаж байгаа Нантичууд бүгдээрээ амьсгалын замын хурц өвчнөөр өвчилсөн байсан бөгөөд уг нь ийм өвчний ердийн халдвар тухайн хүн амын хувьд 50 орчим хувь байх байжээ.

Тусгаарлагдаагүй амьдарч байгаа нутгийн уугуул иргэдэд ч уг төслийн боловсруулалт, байгаль орчны удирдлагын төлөвлөгөө, санал болгож буй нөхөн төлбөрийн арга хэмжээний тухай хангалттай мэдээлэл өгч зөвлөлдөөгүй байна. Камисеагийн төслийн цаана буй компаниудын консорциум нутгийн ард иргэдийн туршлагагүй байдлыг далимдуулан газар нутаг, байгалийн баялгийг нь ашигласны төлөө төлөх нөхөн төлбөрийг тооцохдоо зохих ёсны аргыг ашиглаагүй байсныг байгаль орчны байгууллагууд тогтоосон байна. Түүнчлэн ард иргэдийг гурван өөр тохиролцоо санал болгосон гурван өөр компанитай хүчээр тохиролцуулах гэж тулгажээ. Ингэснээр үүнд өртсөн хүмүүсийн хувьд хэлэлцэн тохирох байр суурь нь суларч, муудсан байна.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл http://www.bicusa.org/bicusa/issues/Camisea_factsheet8-2003.pdf хаягаар хандана уу.

Эрх зүйн асуудлууд

Хүний эрхийн зөрчлүүд нь аюулгүй байдлын түрэмгий хүчнүүдтэй холбоо сүлбээтэй газрын тосны компаниудын эсрэг зарга мэдүүлэхэд хүргэж байна. Тодруулбал, АНУ-д буй өмгөөлөгч нар АНУ-ын Холбоотны Нөхөн Төлбөр Нэхэмжлэлийн Хуулийн (ХНТНХ) дагуу цуврал шүүх хурлууд хийгээд байгаа бөгөөд уг хуулиар олон улсын хууль зөрчсөний улмаас үүссэн хохирлын нөхөн төлбөрийг нэхэмжлэх боломжийг зарга мэдүүлэгчид олгодог. Юнокал, Чеврон Тексако, Экссон Мобил зэрэг газрын тосны компанийн эсрэг зарга мэдүүлсэн хэргүүдэд дээрх компаниуд газрын тосны үйл ажиллагаандаа аюулгүй байдлын тусалцаа авч байхдаа аюулгүйн хүчнийхний үйлдсэн хүний эрхийн зөрчлүүдэд оролцсон хэмээн нотолсон байна. ХНТНХ-ийн дагуу гаргасан нэхэмжлэлээс тухайн компаниудыг өмгөөлж байсан хүмүүсийн хувьд энэ хууль бол анхнаасаа өөр зорилгоор хийгдсэн хууль, иймээс эдгээр нэхэмжлэл нь АНУ-ын шүүхийн хил хязгаарыг хол давсан байна, ингэснээр дараагийн хэдэн жилд эрх зүйн хэцүү сорилттой тулгарах болно хэмээн маргаж байна.

Мөн засгийн газар ба гадаадын хөрөнгө оруулагчид, түүний дотор газрын тосны компаниудын хооронд тухайн компанийн хөрөнгө оруулалтын нөхцлийг тодорхойлж тохирдог тусгай пакт болох Хүлээн Авагч Засгийн Газрын Гэрээ (ХАЗГГ)-ний болзошгүй нөлөөнүүдийн талаар хүний эрхийн тэмцэгчид санаа зовж буйгаа илэрхийлсээр байна⁴⁹. ХАЗГГ-нүүд нь эсрэг тохиолдолд хэрэглэгдэх олон нийтийн ашиг сонирхлын бодлогын дарамт шахалтаас зайлсхийх боломжтой эрхүүд болон онцгой эрхүүдээр хөрөнгө оруулагчдыг хангаж байдаг. Баку-Тбилис-Цейханы (БТЦ) дамжуулах хоолойн жишээнд гэхэд Турк улс болон БТЦ консорциумын (БиПи компанийн толгойлсон) хооронд байгуулсан ХАЗГГ-нд эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны шинэ хууль, зохицуулалтууд хэрэглэснээс болж бизнест үзүүлэх нөлөөний эсрэг нөхөн төлбөр шаардах эрхийг уг дамжуулах хоолойн консорциумд олгосон байна⁵⁰. Түүнчлэн хэрвээ ямар нэг асар их, материаллаг аюул занал байхгүй л бол засгийн газар төслийн аливаа асуудалд, тухайлбал эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчны шалтгаанаар саад болохыг хориглосон байна. Цаашилбал, Туркийн засгийн газар өөрөө дамжуулах хоолой байгуулах газрыг албадан чөлөөлөх, цагдаагийн хамгаалалтаар хангах үүрэг хүлээсэн байна.

Ажилчид ба ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөө

Газрын тос олборлох, тээвэрлэх үйл ажиллагаа өөрөө ихээхэн капитал хөрөнгө шаарддаг. Ийм үйл ажиллагаанаас ажил эрхлэлтэд үзүүлэх нөлөө тун бага. Ажил эрхлэлтэд хамгийн их нөлөөлдөг зүйл бол байгууламжуудыг барьж байгуулах үе

бөгөөд энэ үеийн ажил эрхлэлт сайндаа л хэдхэн сар үргэлжилдэг. Жишээлбэл, Азербайжан, Гүрж, Туркэд байгуулж байгаа БиПи-гийн газрын тос, байгалийн хий дамжуулах хоолой нийлээд барилгын ажлын оргил үедээ л 6000 хүртэл хүн ажиллуулж болох юм. Гэхдээ мэргэжилгүй ажилчдын дор хаяж тал хувийнх нь хийх ажил “хоёр сар”-аас илүүгүй хугацаанд үргэлжлэх магадлалтай⁵¹. Барилгын ажил дууссаны дараа хоёр дамжуулах хоолой нийлээд 700 хүн ажиллуулахаар тооцсон байна⁵².

Гэтэл ард иргэдийн хувьд аливаа төслийн өгөх ажил эрхлэлтийн үр өгөөжийн талаар илүү их бөгөөд буруу горьдлоготой байдаг. Эдгээр ажлын байр бий болохгүй бол компаниуд болон ард иргэдийн хооронд хурцадмал байдал үүсч эхэлдэг. Ажил олж хийж чадаагүй хүмүүс ажилд орсон цөөн хүмүүст дургүйцэх болсноор ард иргэдийн дунд хэрүүл маргаан ч өрнөдөг. Голдуу ямар нэг төслийн төлөө дэмжлэг авахыг хүссэн улс төрчид, заримдаа компанийн албан тушаалтнууд энэхүү худал хуурмаг горьдлогыг бий болгодог.

Мөн газрын тосны үйл ажиллагаа нь ард иргэдийн нийгмийн бүтэц, давхаргад сөргөөр нөлөөлж болно. Тухайн газар ирж ажиллаж байгаа гадны ажилчид урт удаан хугацаагаар гэр орноосоо хол байх болдог. Гадаадын компани, ажилчдыг дагасан их хэмжээний бэлэн мөнгө эдийн засагт орж ирснээр инфляци үүсгэж, нутгийн ард иргэд өмнө худалдан авч чадаад байсан бараа бүтээгдэхүүнээ өндөр үнээр авч чадахгүйд хүрдэг.

Ажилчдын хотхонд амьдарч буй эрчүүд согтууруулах ундаа, мансууруулах бодис, биеэ үнэлэгчдийн нөлөөнд автах явдал олонтаа. Энэ нь цаашлаад гэр бүлийн амьдрал, нийгмийн бүтцийг эвддэг. Олборлох салбараас нийтийн эрүүл мэндэд үзүүлэх сөрөг нөлөө, түүний дотор ДОХ өвчний тархалт, биеэ үнэлэлт, мансууруулах бодисын хэрэглээ зэрэгтэй холбоотой ихэнх судалгаа уул уурхайн ажиллагааг голлон авч үзсэн байдаг бол газрын тосны өрөмдлөгийн газруудад ч нөхцөл байдал ижил байх талтай. Өмнөд Африкийн уул уурхайн салбарын жишээнд гэхэд уурхайд ажиллагсдын дундах ДОХ өвчний тархалт нийт хүн амынхаас 20 хувь өндөр байв⁵³.

Газрын тосны өрөмдлөгийн газруудад ажиллаж буй ажилчдын эрүүл ахуй, аюулгүй байдлын нөхцөл ч аюултайд тооцогддог. Далай дээрх өрөмдлөгийн цамхагууд хүчтэй салхи шуурга, давалгаанд өртөх явдал бий. Газрын тос олборлолтын тавцан дээрх нөхцөл ч нойтон бөгөөд хальтиргаатай байдаг. Ажиллах ээлж урт бөгөөд бие махбодид ядаргаатай байдаг (ажилчид голдуу уртасгасан ээлжээр ажиллаж, дараа нь уртасгасан хугацаагаар амардаг). Өрөмдлөгийн цамхаг дээр ажиллаж буй машинууд хүнд бөгөөд ажиллах хурд өндөртэй байж болно. Өрөмдлөгийн толгойн хэсэгт хэт их даралт өгвөл тэсэрч

дэлбэрэх, гал гарах аюултай. Энэ бүх нөхцөл байдал ноцтой гэмтэл авахад хүргэж болно. 2002 онд АНУ-ын Аляскад үйл ажиллагаа явуулж байсан Британийн газрын тосны аварга компани БиПи ажилчидтай холбоотой хоёр том осол гаргасныхаа төлөө торгуулж байв. Энэ үеэр цооног дэлбэрснээс нэг ажилчин амь насаа алдаж, дамжуулах хоолой хагарснаас нэг ажилчин хүнд гэмтсэн байна⁵⁴.

Үнэн хэрэгтээ, газрын тосны салбарт ажиллана гэдэг бол хамгийн аюултай мэргэжлийн нэг байдаг. Хөдөлмөрийн аюулгүй байдлын харьцангуй чанга хуультай АНУ-д гэхэд газрын тос, байгалийн хий олборлолтын салбар дахь үйлдвэрлэлийн ослоор нас баралтын хэмжээ АНУ-ын бусад бүх салбарыг нэгтгэсэн дүнгээс ч өндөр байдаг байна⁵⁵. Газрын тос үйлдвэрлэгч хөгжиж байгаа орнуудад хөдөлмөрийн аюулгүй байдлын хууль байхгүй эсвэл муутай байдаг учраас магадгүй хөдөлмөрийн нөхцөл бүр ч тааруу байж болох юм. Мөн байгаа хуулиудын хэрэгжилт муу, ажил олгогч нар эрх бүхий этгээдийг хахуульдан шийтгэлээс бултах явдал олон байдаг. Бас үйлдвэрчний эвлэл сул бол ажилчдын хамгаалалт тааруу байна.

Газарт ч бай, далай дээр ч бай газрын тос олборлох газруудад ажиллаж буй ажилчид арсеник, цианид гэх мэт химийн аюултай бодист өртөж хордох боломжтой. Их хэмжээгээр хордох нь хүнд ноцтой гэмтэл, өвчлөлт үүсгэдэг бол бага багаар удаан хугацаанд хордох нь ажилчдын эрүүл мэндийг хохироож болно. Гэмтэл бэртлээс болж алдсан ажлын өдрүүд бусад салбарынхаас илүү олон байх хандлагатай байдаг⁵⁶.

Дүгнэлт

Газрын тосны салбар дэлхийн хэмжээгээр түлш шатахууны шинэ эх үүсвэр хайх ажлаа эрчимжүүлж байгаа учраас алс хязгаарын бөглүү газруудад хүртэл тус салбарын гар хүрч болох бөгөөд харин үйлдвэрлэл, боловсруулалт хэдийнээ хийгдэж эхлээд байгаа газруудад бүр ч их үйл ажиллагаа явагдаж болзошгүй байна. Түүний зэрэгцээ, газрын тосны үйлдвэрлэлийн үр дагавар, түүний дотор байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөө нь мөн адил эрчимжиж байгаа бөгөөд шатдаг түлшийг ийнхүү авлаж байгаагийн сөрөг үр дагаврыг маш нарийн нягтлан үзэх шаардлагатай байна. Газрын тосны эрчимтэй үйлдвэрлэлээс олох боломжит санхүүгийн үр шимийг нэгдүгээрт тухайн улсын ард иргэд, хоёрдугаарт дэлхий нийт хүн амд учрах байгаль орчин ба нийгэмд үзүүлэх хор хохирлын талаас нь авч үзэж болох ба ингэж авч үзэх ч ёстой. Эцсийн эцэст газрын тос зүгээр нэг үнэгүй урсч гараад байдаггүй билээ.

ЗӨВЛӨГӨӨНИЙ ХУУДАС

Хүний эрхийн тухай асуултууд

- ▶ Газрын тосны компаниуд нутгийн ард иргэдтэй хийх ямар ямар зөвшилцөлд оролцсон бэ? Эдгээр нь цөөн тооны хэсэг хүмүүсийн хүрээнээс давж гарсан уу? Нутгийн ард иргэдэд иж бүрэн мэдээллийг өөрсдийнх нь хэлээр гаргаж өгсөн үү?
- ▶ Газрын тосны компаниуд хувийн болон улсын аюулаас хамгаалах хүчнийхэнтэй аюулгүй байдлын ямар зохицуулалт хийсэн бэ? Энэ холбоо сүлбээний жинхэнэ мөн чанар юу вэ- гэрээний, ажил олгогч буюу ажил эрхлэгч, агентлаг уу? Компани аюулгүй байдлын зохицуулалтууд буюу гэрээнүүдээ (бичгээр гаргасан эсэх) ил болгосон уу? Компани хүний эрх ба түүнтэй холбоотой асуудлаар байгуулсан ямар нэг гэрээг нийтэд ил болгосон уу?
- ▶ Газрын тосны компаний хөрөнгө оруулж байгаа улс орон ба түүний аюулгүйн хүчнийхний олон нийтийн хүний эрхийг хамгаалах байдал ямар вэ? Тухайн компанид хүний эрхийн асуудлаар мэдэгдэл өгөх ямар онцлог анхааруулгууд байна вэ?
- ▶ Тухайн газрын тосны компани хөрөнгө оруулахаасаа өмнө аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээ хийсэн үү? Уг эрсдлийн үнэлгээний мөн чанар, агуулга юу вэ? Үүндээ хүний эрхийн зөрчил гарах боломжийг хөндөн авч үзсэн үү? Компани аюулгүй байдлын эрсдлийн үнэлгээгээ нийтэд ил болгосон уу?
- ▶ Тухайн газарт уг компани ямар байдлаар ажиллаж байна вэ? Компани хүний эрхийн зөрчлүүдийг хянах, урьдчилан сэргийлэх, хөндөн авч үзэх чадвар, чадавхитай юу? Газрын тосны эх компани ба тухайн газар нутаг дээр ажиллаж байгаа түүний салбар буюу охин компани хоёрын холбоо ямар шинж чанартай байна вэ?
- ▶ Тухайн компаний үйл ажиллагаатай танилцах зорилгоор сэтгүүлчид, хүний эрхийн бүлгүүд болон бусад хүмүүс ямар нэг хориглолт хязгаарлалтгүй,

хэн нэгнийг цаанаас нь дагалдуудахгүй, хэн нэгнээр хянуулахгүйгээр чөлөөтэй очиж үзэх боломж олгодог уу?

- ▶ Олборлолт, дамжуулах хоолой болон бусад үйл ажиллагаа явуулах зорилгоор нутгийн ард иргэдийг нүүлгэн шилжүүлсэн үү? Ямар нэг нөхөн төлбөр олгосон бол ямар төрлийн нөхөн төлбөр байсан бэ? Нүүлгэн шилжүүлэлтийн мөн чанар ямар байв, ямар нөхцөл байдалтайгаар нүүлгэн шилжүүлсэн бэ (өөрөөр хэлбэл, ямар нэг аюул занал учруулах, айлган сүрдүүлэх явдал гарсан уу)?
- ▶ Засгийн газар ба газрын тосны компаний хооронд тухайн компаний хөрөнгө оруулалтын нөхцлийг тохирсон хууль ёсны гэрээ болох Хүлээн Авагч Засгийн Газрын Гэрээ буюу түүнтэй адилтгах гэрээг тухайн улстай байгуулсан уу? Тухайн компани энэ гэрээг нийтэд ил тод болгосон уу? Эдгээр гэрээ нь засгийн газраас олон нийтийн ашиг сонирхлыг хамгаалах чадварыг хязгаарлаж байна уу? Эдгээр гэрээ нь албадан хураах, нөхөн төлбөр олгох асуудлыг зохих ёсоор авч үзэх нөхцлийг хангасан уу?

ҮЙЛ ЯВДЛЫН ЖИШЭЭ

Юнокал компани АНУ-аас гадуур хүний эрхийн зөрчил гаргасныхаа төлөө шүүхэд дуудагдсан АНУ-ын анхны компани болж байна

Марк Лавин

ЛОС АНЖЕЛЕС, 2003 оны 12 дугаар сарын 10 (Аженс Франс Пресс)- Мянмар гаригт газрын тосны аварга компани Юнокал хилийн чанадад хүний эрхийн зөрчил гаргасан хэргээр буруутгагдан АНУ-ын шүүхэд дуудагдсан анхны АНУ-ын компани боллоо. Энэ нь түүний Мянмар улсад хийн хоолой тавих ажлыг тойрсон хэрэг байв.

Мянмарын тосгоны иргэд Зүүн Өмнөд Азийн энэ орны харгис цэргийн хунтынханы үйлдсэн албадан хөдөлмөр, хүчирхийлэл, эрүүдэн шүүлт зэрэг хүний эрхийн зөрчил гарахад Калифорнид төвтэй уг газрын тосны аварга компани оролцсон гэж үзэн шүүхэд хандсан байна.

Хуучин Бирм хэмээн нэрлэдэг байсан уг улсад 62 километрийн (39 миль) урттай Яданагийн байгалийн хийн хоолой байгуулж байгаа асуудлаар тосгоны нэр нь тогтоогдоогүй 15 иргэн 2 удаа шүүхэд хандсаны дагуу Лос Анжелест шүүх хурал боллоо.

1990-ээд онд 1.2 тэрбум долларын өртөгтэй байгуулсан энэ дамжуулах хоолойг барьж байгуулах үеэр хунтын цэргүүд тосгоны иргэдийг алж, хүчиндэж, боолчилж, хүчээр ажиллуулж байхад Юнокал компани хараагүй царайлж байсан хэмээн долоон жил үргэлжилсэн энэхүү шүүхийн маргааныг үүсгэгч тосгоны иргэд заргалдаж байна.

“Бирмийн цэргүүд боолын хөдөлмөрийн систем бий болгож, Юнокалын нэрийн өмнөөс аймшигтай хүчирхийллийн үйлдлүүд хийсэн” хэмээн тосгоны зарим иргэдийг төлөөлж байгаа Олон Улсын Хөдөлмөрийн Эрхийн Сангийн гүйцэтгэх захирал Терри Коллингсворт хэлсэн юм.

Мянмарын засгийн газрын өмчийн энэхүү газарт шууд үйл ажиллагаа явуулаагүй Юнокал компани ямар нэг зөрчилд оролцсон гэдгийг хүчтэй эсэргүүцэн үгүйсгэж байна.

Уг хэрэг нь Юнокал компани Францын Тотал зэрэг өөрийн түншүүдтэй хамтран Мянмараас хөрш Тайланд улсад газрын тос тээвэрлэн хүргэх зорилгоор нилээд хэл амтай байгуулсан дамжуулах хоолойн эргэн тойронд төвлөрч байна.

Юнокал компани ийм зөрчил гаргаснаа хүлээн зөвшөөрөхгүй байгаа ч гэсэн Янгоны хунтын албадан хөдөлмөрлүүлэлт, цэргүүдийнх нь аллага, хүчингийн хэргийг ашиглан тус компани ашиг орлого олсон бөгөөд үүний улмаас бидэнд тодорхойгүй хэмжээний хохирол учруулсан хэмээн буруутгаж уг тосгоныхон шүүхэд хандаж байгаа ажээ.

Салбар компани нь өөрийн гэсэн тодорхой үнэ цэнэ бүхий хөрөнгөтэй байтал эх корпорациас нь мөнгө авахыг оролдож буй энэ нэхэмжлэгч нарт Калифорни мужийн “сайн найзын номлол” саад болж байна хэмээн Юнокалийн тэргүүлэх хуульч Даниел Петроцелли хэлжээ.

“Энэ хэрэг бүхэлдээ нэг асуудал дээр л гацаж байна. Хэрвээ салбар нь нэхэмжлэлийг төлж болох юм бол энэ хэрэг шийдэгдэнэ” хэмээн дүүрэн хүнтэй шүүх танхимд хэлсэн нээлтийн үгэндээ тэр онцолсон юм.

Харин тосгоныхны өмгөөлөгч нар Юнокал компани хариуцлагаас зугтахын тулд салбараа бамбай болгон ашиглаж байна гэж үзэж байна.

“Юнокал компанийн хийсэн нээлтийн мэдэгдэл нь корпорациуд ашгийн төлөө юу ч хийхээс буцахгүйг харуулж байна” гэж тосгоныхны өмгөөлөгч Дэн Стормер бидэнд хэлсэн юм.

Тэрээр “Эдгээр янз бүрийн аж ахуйн нэгж бие даасан байх эсэх нь хамаагүй” гэж хэлээд Юнокал компани энэ хэрэгт өөрийн нэгжийн гүйцэтгэсэн үүргийн төлөө шууд хариуцлага хүлээх ёстой, учир нь тэд бол зохиомол компаниуд гэлээ.

Харин Юнокал Мянмар Оффшор, Юнокал Интернэшнл Пайплайн, Юнокал Глобал Венчүрес компани зэрэг түүний нэгжүүд бол өөртөө хэдэн зуун сая долларын хөрөнгөтэй, өөрийн гэсэн корпорацийн бүтэцтэй компаниуд хэмээн Петроцелли мэдэгдлээ.

Мөн “Энэ компаниудын аль нь ч үүнийг төлөх чадвартай” гэж тэр хэлэв.

Энэ хэргийг АНУ-ын хуулийн дагуу шийдвэрлэхийн оронд ядаж нэг хэсгийг ч болов тус компанийн салбарууд байрладаг Мянмар эсвэл Бермудагийн хуулийн дагуу авч хэлэлцэх ёстой хэмээн 7 дугаар сард шүүгч Викториа Чэний уг маргааныг шүүхээс татгалзаж байжээ.

Хэрвээ эх компани бус, харин түүний салбарт шүүх ажиллагаа чиглэгдэх ёстой хэмээн Юнокал компани 20 орчим өдөр үргэлжлэх төлөвтэй байгаа эхний шатны шүүх хурал дээр

итгүүлэн гарч чадах юм бол дараагийн шатны шүүх хурал дээр зөрчлийн хохирлыг нөхөн төлөх асуудлыг шийдэж болох юм.

Мянмар дахь гадаадын хөрөнгө оруулалттай хамгийн том төсөл гэж нийтэд сурталчилсан энэхүү дамжуулах хоолойн байгууламжуудыг барьж байгуулах, замыг цэвэрлэхэд биднийг хүчээр ажиллуулсан хэмээн тосгоныхон гомдолдоо бичсэн байна.

Мянмарын хунт хариу арга хэмжээ авахаас эмээн нэхэмжлэл гаргагчдын нэр хаягийг нууцалсан байна.

Цэргийнхэн төсөл хэрэгжүүлэх газрын ойролцоо өөрсөддөө зориулсан зэр зэвсэг, хангамжийг зөөх болон бусад ажил эрхлэхэд тосгоныхныг хүчээр ажиллуулж байсныг Юнокалын гүйцэтгэх ажилтнууд хүлээн зөвшөөрсөн боловч дамжуулах хоолой бай-

гуулахтай холбоотой ямар нэг ажил хийлгэж байсныг үгүйсгэсэн байна.

Юнокал компани уг дамжуулах хоолойг хуучин ТоталФинаЭлф буюу одоогийн Тотал компани болон Тайланд, Мянмарын засгийн газруудтай хамтран эзэмшдэг. Тотал компани энэ асуудлаар Европт тусдаа шүүгдэж байна.



Франс Пресс Агентлагийн зөвшөөрлөөр хэвлэв.

Редакторын тэмдэглэл: 2005 оны 3 дугаар сарын байдлаар Юнокал компани энэ хэргийг шүүхээс гадуур шийдвэрлэхээр тохирсон байна. Ингэхдээ орон нутаг дахь амьдрах нөхцлийг сайжруулахад болон хохирогчдод мөнгөн нөхөн төлбөр олгоход зориулсан сан бий болгохоор болжээ.

Хавсралт

Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилга

Их Британийн Олон Улсын Хөгжлийн Департамент болон Дээхрийн Банкнаас тэргүүлэн санаачилсан ОСИТБС нь олборлох салбаруудаас олох орлого тогтвортой хөгжил болон ядуурлыг бууруулахад хувь нэмэр оруулах нөхцөлийг хангах зорилготой.

ОСИТБС-ын зарчмууд

1. Бид, байгалийн нөөц баялгийг ухаалгаар ашиглах нь тогтвортой хөгжил, ядуурлыг бууруулахад чухал хувь нэмэр оруулдаг эдийн засгийн тогтвортой өсөлтийн нэг чухал хөшүүрэг бөгөөд хэрэв үүнийг зохистой удирдахгүй бол нийгэм, эдийн засгийн сөрөг үр дагавар үүсгэж болно гэдэг итгэл үнэмшлийг хуваалцдаг.
2. Бид, аливаа улс орон байгалийн нөөц баялгаа ард иргэдийнхээ тусын тулд ашиглах асуудал нь үндэсний хөгжлийнхөө ашиг сонирхлыг гүйцэлдүүлэх гэсэн тусгаар улсын засгийн газруудын анхаарлын төвд байдаг гэдгийг баталж байна.

3. Бид, нөөц баялгийг олборлосны үр шим нь олон жилийн турш хуримтлагдах орлогын урсгалаар бий болох бөгөөд энэ нь үнээс өндөр хамааралтай байх болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна.
4. Бид, засгийн газрын орлого, зарцуулалтын талаар ард иргэд ямар нэг ойлголттой байх нь цаашдаа тогтвортой хөгжлийн зохистой бодит хувилбаруудын сонголтын талаар олон нийтийн хэлэлцүүлэг явуулах, мэдээлэл өгөхөд тустай байж болохыг ойлгож байна.
5. Бид, олборлох салбарт ажиллаж буй засгийн газар ба компаниудын ил тод байдлын ач холбогдол болон төрийн санхүүгийн удирдлага, хариуцлагатай байдлыг сайжруулах шаардлагыг онцлон тэмдэглэж байна.
6. Бид, илүү их ил тод байдлыг бий болгох явдал нь гэрээ хэлэлцээр, хууль тогтоомжуудыг хүндэтгэн үзэх байдлаар хийгдэх ёстой гэж ойлгож байна.
7. Бид, гадаад, дотоодын шууд хөрөнгө оруулалтын орчныг сайжруулах нь санхүүгийн ил тод байдлыг авчрах болно гэж үзэж байна.
8. Бид, улсын зардал, орлогын урсгалыг зохицуулах талаар засгийн газраас бүх ард түмнийхээ өмнө хүлээсэн хариуцлагын зарчмууд, үйл явцад итгэж байна.
9. Бид, олон нийтийн амьдрал, бизнес, засгийн газрын үйл ажиллагаанд ил тод байдал, хариуцлагын дээд зэргийн стандартыг дэмжин нэвтрүүлэхийн төлөө байна.
10. Бид, төлбөр болон орлогыг ил тод болгохын тулд өргөн хүрээтэй уялдаа холбоо бүхий, хэрэгжихүйц бөгөөд хэрэгжүүлэх, ашиглахад энгийн хялбар арга барил хэрэглэх шаардлагатай гэдэгт итгэдэг.
11. Бид, аливаа улс орон дахь төлбөр тооцоог ил тод болгоход тухайн оронд үйл ажиллагаагаа явуулж байгаа олборлох салбарын бүх компанийг хамруулах ёстой гэж үздэг.
12. Бид, бүх оролцогчид, түүний дотор засгийн газар, түүний агентлагууд, олборлох салбарын компаниуд, үйлчилгээний компаниуд, олон талт байгууллагууд, санхүүгийн байгууллагууд, хөрөнгө оруулагчид, ТББ-ууд аливаа шийдэл гаргахад тус тусын чухал хувь нэмэр оруулдаг гэдэгт итгэдэг.

ОСИТБС-ын шалгуурууд

1. Газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниудаас засгийн газарт төлж байгаа бүх материаллаг төлбөрүүд (“төлбөрүүд”), тэдгээрээс засгийн газрын хүлээн авсан бүх материаллаг орлогуудын (“орлогууд”) талаар өргөн олон нийтэд хүртээмжтэй, ойлгомжтой, цогц байдлаар тогтмол хэвлэн нийтэлж байх.
2. Хэрэв хөндлөнгийн хяналт байхгүй бол дээрх төлбөр болон орлогуудыг итгэмжлэгдсэн, хараат бус аудитаар олон улсын аудитын стандартууд хэрэглэн шалгуулдаг байх.
3. Төлбөр болон орлогыг итгэмжлэгдсэн, хараат бус захирагчаар олон улсын аудитын стандартууд хэрэглэн нэгтгэн дүгнүүлж, хэрэв ямар нэг зөрүүтэй байдал илэрсэн бол энэ талаарх тухайн захирагчийн дүгнэлтийг хэвлэн нийтэлдэг байх.
4. Энэ арга нь бүх компаниуд, түүний дотор төрийн өмчит үйлдвэрийн газруудад хамаатай байх.
5. Дээрх үйл явцыг зохион байгуулах, хяналт шинжилгээ, үнэлгээ хийхэд иргэний нийгэм идэвхтэй оролцогч байх бөгөөд олон нийтийн хэлэлцүүлэг өрнүүлэхэд хувь нэмрээ оруулах.
6. Санаачилгыг хэрэгжүүлж буй хүлээн авагч засгийн газар, шаардлагатай тохиолдолд олон улсын санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар, дээрх бүх үйл явцад зориулан санхүүгийн хувьд тогтвортой ажлын төлөвлөгөө гаргах бөгөөд энэхүү ажлын төлөвлөгөөнд хэмжиж болохуйц зорилтууд, хэрэгжүүлэх хугацаа, болзошгүй хүндрэл бэрхшээлийн үнэлгээ зэргийг багтаасан байх.

<http://www.eitransparency.org/principlesandcriteria.htm>

Төлснөө нийтэл

Төлснөө нийтэл кампанит ажил нь газрын тос, байгалийн хий, уул уурхайн компаниуд засгийн газрууд болон төрийн бусад байгууллагуудад төлж байгаа татвар, хураамж, нөөц ашигласны төлбөр болон бусад төлбөрүүдээ нийтэд заавал ил болгох шаардлагын төлөө кампанит ажил юм.

Компаниудыг “төлснөө нийтэл” хэмээн уриалж байгаа явдал бол олборлох салбарын компаниудаас нөөц баялаг ихтэй хөгжиж байгаа орнуудад төлж буй байгалийн баялгийн орлогын удирдлагыг илүү хариуцлагатай болгоход чиглэсэн зайлшгүй шаардлагатай анхны нэг алхам юм. Түүнчлэн засгийн газруудын хувьд “авснаа нийтлэх” шаардлага бий. Хэрэв компаниуд олсон орлогоосоо төлж байгаагаа, засгийн газрууд эдгээр орлогоос хүлээн авч байгаагаа ил болгох юм бол иргэний нийгмийн гишүүд тэдгээрийг хооронд нь харьцуулж, улмаар засгийн газрын орлогын удирдлагыг хариуцлагатай болгох юм. Мөн иргэний нийгмийн бүлгүүд байгалийн баялгийн орлогын ашиглалт, хуваарилалтын талаар ардчилсан мэтгэлцээн өрнүүлэх чиглэлээр ажиллахад тустай.

Орлогын ил тод байдал нь нөөц баялаг ихтэй боловч ядуу буурай хөгжиж байгаа олон орны жирийн иргэдэд нүүрлээд байгаа ядуурлыг бууруулахад чиглэсэн амин чухал нэг алхам мөн. Энэ нь Их 8-ын Авилгалтай Тэмцэх, Ил Тод Байдлыг Сайжруулах Төлөвлөгөө гэх мэт хариуцлагатай засгийн газар, авилгалаас урьдчилан сэргийлэлт, нөөц баялгийн орлогын удирдлагын ардчилсан мэтгэлцээн зэрэг олон улсаар хүлээн зөвшөөрөгдсөн зорилтуудтай тууштай нийцэж байгаа юм.

Энэ нь бас бизнесийнхэнд ч ашиг тустай. Ил тод байдал нь компаниудын нийгэмд оруулж буй эерэг хувь нэмрийг харуулах замаар тэдний “үйл ажиллагаа явуулах нийгмийн лиценз”-ийг бэхжүүлэхийн зэрэгцээ тэдний засгийн газруудад төлж байгаа орлого хий дэмий үрэгдэх буюу авилгалын замаар орж нийгмийн хагарал, төрийн хямрал, зөрчилдөөнд хүргэх биш, харин тогтвортой хөгжилд зарцуулагдан тогтвортой бизнесийн орчин бий болгох магадлалыг нэмэгдүүлж өгөх болно.

Түүнчлэн ил тод байдал нь авилгалч засгийн газрын зохисгүй практикуудад орооцолдох гэмт үйлдлээс компаниудыг хамгаалах бөгөөд үүнийг ойролцоогоор 7 триллион ам.долларын хөрөнгийг удирдан зарцуулж буй Хойд Америк, Еврол болон бусад орны хөрөнгө оруулагчдын саяханы нэгэн мэдэгдэлд хүлээн зөвшөөрсөн билээ. Бүх компаниудад төлснөө нийтлэх шаардлага тавигдсанаар бизнесийнхэн адил тэгш өрсөлдөөний нөхцлөөр хангагдах ач холбогдолтой. Ингэснээр дэвшилтэт компаниуд мэдээллээ сайн дураар нийтэлсний төлөө

авилгалч засгийн газрууд гэрээг нь цуцлах явдлаас хамгаалагдахаас гадна ил тод байдал муутай өрсөлдөгчид өмнүүр нь орох боломжгүй болох юм.

Одоо байгаа аж ахуйн нэгжийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн стандартууд, санхүүгийн институциуд ба банкуудын зээл олгох нөхцлүүд зэрэгт компаниуд ба засгийн газруудын орлогыг ил тод болгох шаардлага тавих байдлаар энгийн зохицуулалт хийх гэх мэт өргөн хүрээтэй, дэлхий нийтийг хамарсан аргууд хэрэглэн ил тод байдалд хүрч болно. Орлогыг ил тод болгохдоо нэгээс дээш компанийн нийт төлсөн дүнгээр бус, харин компани бүр үйл ажиллагаа явуулж буй орон бүрээрээ задлан гаргах ёстой гэж Төлснөө Нийтэл кампанит ажлынхан үздэг. Олборлох Салбарын Ил Тод Байдлын Санаачилгаас (ОСИТБС) илээр тайлагнах загвар байж болохуйц тайлангийн маягтын нэгэн загварыг боловсруулан гаргаад байна.

Үндэстэн дамнасан болон төрийн өмчит компаниуд засгийн газруудад төлж байгаа төлбөрөө ил болгох, мөн засгийн газрууд олборлох салбараас олж байгаа орлогоо ил болгох нөхцлийг хангах олон тооны зохицуулах механизм шаардлагатай байна. Төлснөө Нийтэл кампанит ажлаас эдгээр зайлшгүй биелүүлэх шаардлагатай механизмыг хэрэгжүүлэхийг уриалж байгаа гол зорилтот цэгүүд бол:

- Үнэт цаасны биржийн эрх бүхий газрууд
- Дэлхийн Банкны Групп (СБХОУБ, ОУХХ, ОТХОБГ, ОУСК)
- Олон Улсын Валютын Сан
- Бусад олон талт болон хоёрт талт зээлдүүлэгч байгууллагууд
- Экспортын зээл олгогч газрууд
- Үйлдвэрлэгч орны засгийн газрууд
- Хөгжингүй орнуудын засгийн газрууд
- Олон Улсын Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын Зөвлөл
- Нөөц баялагт тулгуурлан зээл олгодог хувийн, арилжааны болон жижиглэн худалдааны банкууд

Ил тод байдал бол улсын өмчийг системтэйгээр идэж ашиглан шамшигдуулах байдлаар ашиг хонжоо олж байдаг авилгалч дээдсээс бусад иргэд, компаниуд, хандивлагч засгийн газрууд, нийт олон улсын хамтын нийгэмлэг зэрэг бүх холбогдох талын ашиг сонирхолд бүрэн нийцнэ.

<http://www.publishwhatyoupay.org/english/objectives/index.shtml>

Тэмдэглэл

Бүлэг 1

¹ Дэлхийн Банкны тайлан *Дэлхийн Хөгжлийн Үзүүлэлтүүд 2004*-ийн дагуу 2002 оны нэг хүнд ноогдох ДНБ (1995 оны ам.доллараар) Нигерид 254.26\$, Индонезид 1060.24\$ байв.

² Дэлхийн Банк, *Дэлхийн Хөгжлийн Үзүүлэлтүүд 2004*.

³ Ялангуяа олборлолтын зардал ихтэй орнуудын хувьд олборлолтыг хойшлуулах нь хүсүүштэй байж болно. Технологи сайжрах эсвэл нефть бүтээгдэхүүний зах зээлийн үнэ өссөнөөр олборлолтын өртөг зардал буурч болно. Түүнчлэн түрээс буюу нефтийн үнэ ба олборлолтын зардлын зөрүү нь газрын тосны үнийн өсөлтийн хурдаас илүү хурдацтай өсөх болно.

⁴ Нидерланд улс Хойд мөсөн далайгаас байгалийн хийн орд газар нээсний дараа тус улсын валютын ханш өссөний сөрөг нөлөөний улмаас ийн нэрлэжээ.

⁵ Такахио Акита, Ёичи Накамура нарын редакторласан *Хятад, Индонези, Япон дахь ногоон ДНБ-ны тооцоо*. НҮБ-ын Байгаль орчин, Эдийн засгийн Бүртгэлийн Системийн хэрэгсэл (НҮБ-ын Их сургууль/НҮБИС/ОУНББС), Токмо, 2000 он. Бичээлийг үзнэ үү.

⁶ Глобал Витнесс, *Бүгд Ерөнхийлөгчийн хүмүүс (2002 оны 3 дугаар сар)*. <http://www.globalefficiency.org/reports/show.php?en06002.htm>

⁷ "Африк газрын тосны наймааны дансуудаа нээж байна", News24.com, 2004 оны 6 дугаар сарын 27, http://www.news24.com/News24/Africa/News/0,,2-11-1447_1549016,00.html

⁸ Ийм явдал АНУ-д ч бодитойгоор гардаг. Ж.Лайтзингер, Ж.Е. Штиглиц нарын бичсэн "Газрын тос, байгалийн хийн түрээс дэх мэдээллийн гадаад хүчин зүйлс", *Орчин цагийн эдийн засгийн бодлогын асуултууд* 5 (1984 оны 5 сар):44-57-г үзнэ үү.

⁹ Албертагийн хэрэглэсэн шатрын хөлгийн хэв маяг (үүнд тухайн газрыг олон тооны талбай болгон хувааж, талбай бүрийг анхнаас нь сөөлжүүлэн түрээслүүлдэг) нь энэ утгаараа мэдээллийн тэгш бус байдлын хүрээг багасгаж, улмаар засгийн газрын орлогыг нэмэгдүүлдэг. Ж.Е.Штиглиц, “Газрын тосны салбар дахь урт хугацааны хуваарилалтуудын зах зээлийн үнийн үр ашигтай байдал”, Г.Браннон, редактор, *Эрчим хүчний татаарын бодлогын судалгаа*. (Кэмбридж, Балличгер Паблшишинг, 1975): 55-99.

¹⁰ Засгийн газар энгийн нөхцлөөс илүү гарсан концесс өгөхөөс болгоомжлох ёстойн нэг шалтгаан бол энэ юм. Дараа дараагийн засгийн газрууд ийм концессийг хүчингүй болгох дарамт шахалтад орох болно. Газрын тосны компаниуд ч үүнийг мэдэж байгаа бөгөөд улмаар эдгээр концессийн үнэ цэнэ засгийн газрын авч байгаа үнэд зөвхөн хязгаарлагдмал хүрээнд тусгагдах болно.

¹¹ Урамшуулалт дуудлага худалдаанд хүртэл голдуу 16 хувийн нөөц ашигласны төлбөртэй байдаг.

¹² Паул Милгромын *Дуудлага худалдааны орлогыг хэрэгжүүлэх нь* (Кэмбридж, МА, Кэмбриджийн Их Сургуулийн Хэвлэл, 2004) бүтээлийг үзнэ үү.

¹³ Мөн л нягтлан бодох бүртгэлийн хүрээгээ өөрчлөх шаардлага гарч болно. ОУВС-ийн одоо хэрэглэж байгаа нягтлан бодох бүртгэлийн хүрээ нь улсын үйлдвэрийн газруудын зээллэгийг засгийн газрын бусад зээллэгтэй нэгтгэн гаргадаг. Иймээс, хэрэв засгийн газрын өмчийн газрын тосны компани хөрөнгө оруулалтын зээл авлаа гэхэд тухайн улс өөрийн дансандаа их хэмжээний холбогдох илүүдэл хөрөнгөтэй гарсан тохиолдолд л ОУВС-аас зэмлэл хүртэхээс зайлсхийх болно.

Бүлэг 2

¹ Роберт Баер, “Саудын ордны уналт”, *Атлантик Монтли*, 2003 оны 5 дугаар сар

² Терри Линн Карл, *Энбл: дэлхийн гэж рүүдэг Газрын тосны эрчим хүч ба Нэгдүгээр үеүүд* (Беркелий: Калифорнийн Их Сургуулийн Хэвлэл, 1997 он)

³ Торвалдур Жилфэсон, “Байгалийн баялаг, боловсрол ба эдийн засгийн хөгжил”, Эдийн засаг Судлалын Институт (2000 оны 9 дүгээр сар): 1.<http://www.ioes.hi.is/publications/wp/w0010.pdf>

⁴ НҮБ-ын Хөгжлийн Хөтөлбөр, *Ариус. Хүний Хөгжлийн Тайлан 2003*

⁵ Транспаренси Интернэшнл, *Америкийн сийлгөлтэй индекс 2004*. http://www.transparency.org/pressreleases_archive/2004/2004.10.20.cpi.en.html

Бүлэг 3

¹ Ерөнхийдөө биомассийг олон улсын эрчим хүчний ихэнх гол тооцооноос хассан байдаг нь гол төлөв одоогоор эдгээрийн нилээд хэсэг нь арилжааны зорилгоор худалдаалдаггүйтэй холбоотой. Гэвч энэ нь дэлхийн нийтийн эрчим хүчний нэг чухал эх үүсвэр хэвээр байна. Олон Улсын Эрчим Хүчний Агентлаг 2002 оны *Дэлхийн Эрчим Хүчний Төмөр-доо* арилжааны бус биомасс нь хөгжиж байгаа орнуудын эрчим хүчний нийт эрэлтийн дөрөвний нэг хувийг эзэлж байгаа бөгөөд хөгжилтэй орнуудын биомассын хэрэглээ 2000 онд 891 сая тнт байснаас 2030 онд 1019 сая тнт хэмжээнд хүрч өсөх төлөвтэй байна гэжээ.

Бүлэг 4

¹ ЭкссонМобил, *Жилийн тайлан 2003*.

² БиПи, *Жилийн тайлан 2003*.

³ Роял Датч/Шелл, *Жилийн тайлан 2003*.

⁴ Тотал, *Жилийн тайлан 2003*.

⁵ ЧевронТексако, *Жилийн тайлан 2003*.

⁶ <http://finance.yahoo.com/q/ks?s=COP> дээрээс олдсон мэдээллийг үзнэ үү.

⁷ КонокоФиллипс, *Жингийн тайлан 2003*.

⁸ "Саудын Араб: Саудын Арабын байгалийн хийн агуу санаачилгын мандан бууралт", *Ойрхи Дорнодын Эдийн Засагийн Эмхтгэл*, 2004 оны 6 дугаар сарын 27.

⁹ Хүний Эрхийн Манаа, "Зарим ил тод байдал ба хариуцлагагүй байдал: Ангол дахь газрын тосны орлогын ашиглалт ба түүний хүний эрхэд үзүүлэх нөлөө", *Хүний Эрхийн Мансаа Байгууллагын Тайлан*, боть 16, дугаар 1, (2004 оны 1 дүгээр сар)

¹⁰ ЧевронТексакогийн хэвлэлийн мэдээ, "Чеврон Нигериа Лимитед компани Форс Мажор буюу давагдашгүй хүчин зүйл зарлав", 2003 оны 3 сарын 20.

¹¹ *Орны шинжилгээний тавчсан: Алжир* (2004 оны 2 дугаар сар). <http://www.eia.doe.gov/emeu/cabs/algeria.html>

¹² <http://www.eia.doe.gov/cabs/venez.html> дээрээс олдсон мэдээллийг үзнэ үү.

¹³ Нигери улсад олон давтагдсан дамжуулах хоолойг эвдэн сүйтгэж, түүхий нефть хулгайлсан хэргүүдийн тухай дэлгэрэнгүй мэдээллийг <http://www.hrw.org/reports/2002/nigeria3/> хаягаар үзнэ үү.

¹⁴ <http://www.zietlow.com/docs/Fuel-Prices-2003.pdf> дээрээс олдсон мэдээллийг үзнэ үү.

¹⁵ http://www.shell.com/static/nigeria/downloads/pdfs/annualreport_2003.pdf дээрээс олдсон мэдээллийг үзнэ үү.

¹⁶ БиПи компани Индонези дахь үйл ажиллагааны тайланг дараахь холбоосоос үзнэ үү: [http://www.bp.com/subsection.do? categoryId=2011189&contentId=2016392](http://www.bp.com/subsection.do?categoryId=2011189&contentId=2016392)

¹⁷ НҮБ-ын Глобал Компакт хөтөлбөрийн үр нөлөөтэй байдлын тухай маргааныг тойрсон нийтлэлүүдийг Дэлхий нийтийн Бодлоогн Форум буюу Глобал Полиси Форумын дараахь вэб хуудсаар дамжуулан олж үзэж болно: <http://www.globalpolicy.org/reform/indxbiz.htm>

¹⁸ Гро Брунтланд, ред., *Бидний нийтлэг ирээдүй: Байгаль орчин, Логжлийн Дэлхийн Комисс*, (Оксфорд: Оксфордын Их Сургуулийн Хэвлэл, 1987)

¹⁹ ОСИТБС-ын тухай нэмэлт мэдээллийг, түүний дотор уг санаачилгатай холбоотой Орос хэл дээрх мэдээллийг <http://www.eitransparency.org/implementation.htm> хаягаар олж авч болно.

Бүлэг 5

¹ Глобал Витнесс, *Ил тод байдлын цаг үе: Газрын тос, байгалийн хий, үйл үрэхийн орлогосыг цээр гэрэх нь* (2004 оны 3 дугаар сар).

² Даниел Жонстон, *Олон Улсын Нефтийн Төсвийн Системүүд ба Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд* (ПеннВелл Бүүкс, 1994)

³ Женик Радон, "Хилийн чанад дахь хамтарсан үйлдвэрүүдийн хэлэлцээр ба санхүүжилт", Н.Лакассе, Л.Перрет нарын, ред., *Хилийн чанадад хамтарсан үйлдвэр байгуулах нь* (Уилсон энд Лафлоер Айтий, Канад, 1989).

⁴ Зүүн ба Дорнод Ази дахь Гео шинжлэх ухааны Хөтөлбөрийн Зохицуулах Хороо (ССОР)-н тухай <http://ccor.or.th> хаягаар үзнэ үү.

⁵ Газрын тосны компаниудын ангиллыг Иан Гари, Терри Линн Карл нарын бэррлэлийн ёррол: *Африкийн газрын тосны өргөл үе ба ядуус (Католик Релижер Сервисес, 2003)* номоос үзэж болно. Дэлхийн хамгийн том газрын тосны компаниудыг “супер томууд” гэх ба үүнд Роял Датч/Шелл, БиПи, Тотал, ЭкссонМобил, ШевронТексако компаниуд орно. Мөн “томууд” гэсэн түвшинд КонокоФиллипс, Оксидентал Петролеум, Юнокал зэрэг компаниуд орно. “Бие даагчид” гэсэн ангилалд уг бизнесийн үйлдвэрлэлийн дараахь хэсэгт ерөнхийдөө анхаардаг арай жижиг компаниуд болох Амерада Хесс, Марафон, Талисман зэрэг компани орно. Эцэст нь, Ойрхи Дорнодод болон Бразил (Петробрас), Малайз (Петронас) зэрэг бусад улсуудад үйлдвэрлэлийн ихэнхийг хяналтдаа авсан үндэснийг газрын тосны компаниуд (ҮГТК) чухал үүрэгтэй. Африкийн орнуудад ҮГТК-иуд дангаар үйл ажиллагаа явуулдаггүй, харин хөрөнгө, техникийн боломж, туршлагатай гадаадын компаниудтай түншлэн ажилладаг.

⁶ Ерөнхийдөө Кирстен Байндеманны “Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд: Эдийн засгийн шинжилгээ”, *Дэлхийн Нефтийн Зах Зээлийн Тайланг 25* (Эрчим хүч судлалын Оксфордын Институт, 1999 оны 10 дугаар сар) нийтлэлийг үзнэ үү.

⁷ Үнэн хэрэгтэй, Иран, Саудын Араб, Мексик, Венесуэл зэрэг орон газар болон байгалийн нөөц баялгийг төр өмчлөх тухай шаардлагыг үндсэн хуулиндаа оруулж баталсан байдаг.

⁸ Бүтээгдэхүүний ашиг (буюу газрын тосны ашиг) дахь төрийн мэдлийн хувийг үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний тогтмол хувиар эсвэл урьдчилан тодорхойлсон буурах шатлалын дагуу тодорхойлдог. Сүүлийн арга нь илүү их уян хатан байдлыг ялангуяа үнийн өөрчлөлтийн үед бий болгодог. Буурах шатлал ашиглан төлөх төлбөрийн тооцох хамгийн түгээмэл хоёр арга нь нэг бол өдөр тутмын үйлдвэрлэлийн дунджид (Индонезийн БХГ-нүүд шиг) эсвэл R-хүчин зүйлд тулгуурласан аргууд юм. R-хүчин зүйл гэдэг нь тухайн төслийн дагуу хуримтлагдсан орлого ба зардлыг харьцуулсан харьцаа юм. R-хүчин зүйлд тулгуурлан тооцоход засгийн газарт үлдэх бүтээгдэхүүний ашгийн хувь янз бүр байна. Байндеманны “Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд: Эдийн засгийн шинжилгээ”-г үзнэ үү.

⁹ Чакиб Келил, “Газрын тосны төсвийн системүүд: Засгийн газрын “авцаа” ба хайгуулын хөрөнгө оруулалтын төлөөх өрсөлдөөн”, *Хүнийн хөгжлийн үндэсний газрын бодлого* 46 (1995 оны 5 дугаар сар)

¹⁰ Филип Даниел/Дэлхийн Банк, *Нефтийн өрсөлийн удирдлага Тойм* (Дэлхийн Банк/ESMAP хөтөлбөр).

¹¹ Ричард А.Файнберг, “Авцааг баталгаажуулах нь: Аляска дахь нефтийн нэхэмжлэл”, Светлана Цалик, Каспийн газрын тосны олз ашиг: Хэн хожих вэ? (Нээлттэй Нийгэм Хүрээлэн, 2003).

¹² Азарбайджаны газрын тос, байгалийн хийн гол талбайнуудын БХГ-нүүдийг <http://www.caspiandevlopmentandexport.com> хаягаар олж үзэж болно.

¹³ Дэлхий дахинд буй нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмуудын ялгааг үнэлж, тайлбарлах оролдлого хийсэн нэг зохиогч “аливаа компанийн үйл ажиллагаа ба санхүүгийн байдлын талаар “үнэн зөв бөгөөд шударга үнэлгээ” хэрхэн өгөх тал дээр нягтлан бодогч нар нилээд эрх эдэлдэг” хэмээн онож хэлжээ. Уг зохиогчийн бодлоор, “эрх зүйн хүрээ, капиталын зах зээлийн шинж чанар ба үүрэг, улс төр эдийн засгийн нөлөөнүүд, бизнесийн харилцаанд нөлөөлдөг соёлын зан төрхүүд” гэх мэт “орчны” хүчин зүйлсээс болж нягтлан бодох бүртгэлийн жинхэнэ цаад утгын талаарх зөрүүтэй ойлголтууд үүсдэг ажээ. Венди Д.Ротенберг, “Өөр арга барилууд”, *СА Магазин* (1995 оны 4 дүгээр сар) нийтлэлийг <http://www.camagazine.com/multimedia/camagazine/Library/EN/1995/Apr/education.pdf> хаягаар авна уу.

¹⁴ Рёнвалдур Ханнессон, Нефтийн эдийн засаг: Газрын тос, байгалийн хийн үйлдвэрлэлийн асуудлууд ба стратегиуд (Кворум Бүүкс, 1998)

¹⁵ Индонезийн Зүүн Тимор муж болон Умард Австралийн хооронд буй газар дахь хамтын ажиллагааны бүс нутгийн тухай Австрали Улс ба Бүгд Найрамдах Индонези Улс хоорондын

гэрээ, Тиморын Тэнгис, 1989 оны 12 дугаар сарын 11, 1991 оны 2 дугаар сарын 9-нд хүчин төгөлдөр болсон. *Австралийн Гэрээний Цугаралууд 9* (1991)-г үзнэ үү.

¹⁶ Төрийн өмчит компаниуд болох Кувейтийн Кувейт Ойл компани, Саудын Арабын Сауди Арамко компаниуд нь тухайн улсдаа газрын тосны концессийн цорын ганц ашиг хүртэгчид нь юм. Гадаадын компаниуд төрийн өмчийн компанитай хамтарсан үйлдвэр байгуулах замаар боловсруулалт, маркетингийн үйл ажиллагаанд оролцож болно.

¹⁷ Иран улсын үндсэн хуульд нефть ашиглах эрхийг концессийн байдлаар олгохыг хориглодог. 1987 оны Нефтийн тухай хуулиар улсын компани НИОК (НИОС) ба хувийн компаниудын хооронд буцааж худалдан авах гэрээ байгуулахыг зөвшөөрсөн байна. Буцааж худалдан авах гэрээ гэдэг нь гэрээлэгч хөрөнгө оруулалтын бүх санхүүжилтээ олж үйл ажиллагаа явуулаад, бүтээгдэхүүний хуваарилсан ашгийн хэлбэрээр НИОК-оос нөхөн төлбөр авах бөгөөд дараа нь гэрээний хугацаа дуусмагц үйл ажиллагаа явуулж буй газраа буцааж НИОК-д шилжүүлдэг зохицуулалт юм.

¹⁸ Мексик улсын үндсэн хуулиар төрийн өмчит компани болох Пемекс компани л газрын тос, байгалийн хийн нөөцийг дангаар эзэмшиж болдог. Үйлдвэрлэлээ нэмэгдүүлэх зорилгоор Пемекс компани 2002 оны 6 дугаар сард Олон Талт Үйлчилгээний Гэрээ (ОТҮГ) хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн бөгөөд харьцангуй хязгаарлагдмал хэмжээнд оролцох боломжийг гадны компаниудад олгож байна.

Бүлэг 6

¹ Зарим заавар удирдамжийн хувьд дараахь эх сурвалжуудыг үзнэ үү: ОУВС-ын Төсвийн ил тод байдлын гарын авлага, 2001 оны 3 сарын 23: <http://www.imf.org/external/np/fad/trans/manual/>; Аудитын дүрмийн тухай заавруудын Лимагийн тунхаглал: http://www.intosai.org/Level2/2_LIMADe.html; ЭЗХАХБ-ын Төсвийн ил тод байдлын тэргүүн туршлагауд, 2001 оны 5 дугаар сарын 5: [http://www.oecd.org/olis/2000doc.nsf/4f7adc214b91a685c12569fa005d0ee7/c125692700623b74c1256a4d005c23be/\\$FILE/JT00107731.PDF](http://www.oecd.org/olis/2000doc.nsf/4f7adc214b91a685c12569fa005d0ee7/c125692700623b74c1256a4d005c23be/$FILE/JT00107731.PDF)

² Венесуэлийн Сангийн Яам, 2004 оны 4 дүгээр сар.

³ Аляскийн Байнгын Сангийн Корпораци, 2003 оны 12 дугаар сарын санхүүгийн тайлан.

⁴ Рэндалл Додд, “Үнэт цаасны цагаан толгой”, *Санхүүгийн Бодлогын Формула*, Вашингтон, Колумбын тойрог, 2002 он: <http://www.financialpolicy.org/dscprimer.htm> хаяг дээр байгаа. Мөн “Үнэт цаасны хэрэгсэлүүдийн цагаан толгой”, *Санхүүгийн Бодлогын Формула*, Вашингтон, КТ, 2004 он: <http://www.financialpolicy.org/dscprimer.htm> -г үзнэ үү.

⁵ Өмнөхтэй адилхан.

⁶ Богино заалттай байна гэдэг нь ямар нэг зүйл өгөх өртэй байхтай адилхан, харин урт заалттай байна гэдэг нь ямар нэг зүйл эзэмшиж байгаатай адилхан, иймээс эхнийх нь үнийн уналтаас ашиг олдог бол дараагийнх нь үнийн өсөлтөөс ашиг олдог байна.

⁷ Рэндалл Додд, “Лангуугаар худалдаалдаг үнэт цаасны зах зээлийн бүтэц”, *Финансжер*, боть 9, дугаар 1-4 (2002), <http://www.financialpolicy.org/dscprimer.htm> хаяг дээр байгаа.

⁸ Эргэлдүүлэх гэрээнд удахгүй хугацаа нь дуусах фючерсүүдийг худалдан аваад, дараагийн гэрээний хугацаанд ижил төстэй фючерсийг худалдан борлуулах ажил орно.

⁹ Австралийн Буудайн Зөвлөл 1990-ээд оны сүүлээр хувьчлагдсан.

¹⁰ Энэ сэдвийн хүрээнд сваф гэдэг нь форвардын цуврал гэрээтэй эдийн засгийн хувьд адил тэнцүү байна.

¹¹ Янз бүрийн үнэт цаасны хэрэгслийн тухай ярилцлага, тайлбаруудыг Доддын “Үнэт цаасны цагаан толгой” ба “үнэт цаасны хэрэгсэлүүдийн цагаан толгой” (дээр дурдсан тэмдэглэл 4) зэргийг үзнэ үү.

¹² Жеймс а.Даниел. “Засгийн газрыг газрын тосны үнийн эрсдлээс хамгаалах нь”, ОУВС-Зийн ажлын баримт бичиг (2001 оны 11 дүгээр сар).

Бүлэг 7

¹ Паул Эпштайн, Жессэ Зелбер нар, редакторууд, Газрын тос, түүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөний амьдралын мөчлөгийн шинжилгээ, (Харвардын Анагаахын Сургууль- Эрүүл мэнд, дэлхийн байгаль орчны төлөө төв, 2002 оны 3 дугаар сар):9.

² Өмнөхтэй адилхан.

³ АНУ-ын Байгаль Орчны Хамгаалах Газар, БОХГ-ын салбарын дотоо мөрдөлтийн зөвхөн тосны газар, Газрын тос ба байгалийн хий олборлох салбарын тайлан (2009 оны 10 дугаар сар):38, <http://www.epa.gov/compliance/resources/publications/assistance/sectors/notebooks/oil.html> хэлгээр 3546

⁴ Эми Б.Розенфелд, Дебра Гордон, Марианне Гюерин-МакМанус, “Цооногийг шинэчлэх нь: Халуун орны бүсэд газрын тос боловсруулан гаргахын байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөг багасгах аргууд” нийтлэл, Иан А.Боулес, Глен Т.Прикетт нарын редакторласан *Шинэчлэлт ба дагуу хөгжилт өсөлт: Байгалийн байгалийн үйлдвэрлэл, дэд бүтэц, биологийн гэрэл зүйлийн хамгаалалт* (Оксфордын Их Сургуулийн Хэвлэл:2001):57 номонд.

⁵ Өмнөхтэй адилхан.

⁶ Эпштайн Зелбер нар, 7.

⁷ Жоанна Бургер, Газрын тос алдалтууд (Нью Брунсвик, НЖ: Рутгерсийн Их Сургуулийн Хэвлэл, 1997):29.

⁸ Өмнөхтэй адилхан, 137.

⁹ Өмнөхтэй адилхан, 161.

¹⁰ Эпштайн Зелбер нар, 9.

¹¹ Өмнөхтэй адилхан, 12.

¹² Өмнөхтэй адилхан.

¹³ Дагмар Шмидт Эткин, Газрын тос алдалтын тухай бүх эх сурвалжаас авсан түүхэн тойм (1960-1999):7, Газрын тос алдалтын тухай 1999 оны олон улсын бага хурал дээр тавьсан илтгэл, http://www.environmental-research.com/publications/pdf/spill_costs/paper1.pdf хаягаар авав.

¹⁴ Амазоны Ажиглагч, Боливи: Энрон/Шелл Кюйбагийн байгалийн хий дамжуулах хоолой, www.amazonwatch.org/amazon/BO/cuiaba хаягаар авав.

¹⁵ Эпштайн Зелбер нар, 27.

¹⁶ Өмнөхтэй адилхан.

¹⁷ АНУ-ын Байгаль Орчны Хамгаалалтын Газар, 2001 Хорт бодис ялгаруулсан байдал (TRI), Нийтэд зориулан гаргасан тоон мэдээллийн тайлан (2001).

- ¹⁸ Өмнөхтэй адилхан.
- ¹⁹ Эткин, 2.
- ²⁰ Өмнөхтэй адилхан, 2.
- ²¹ Эпштайн Зелбер нар, 20.
- ²² Бургер, 97.
- ²³ Өмнөхтэй адилхан.
- ²⁴ Дагмар Шмидт Эткин, Газрын тос алдалтын цэвэрлэгээний зардлыг тооцох нь, Газрын тос алдалтын тухай 1999 оны олон улсын бага хурал, http://www.environmental-research.com/publications/pdf/spill_costs/paper6.pdf хаягаар авав.
- ²⁵ Экссон Валдезийн Газрын Тос Алдалтын Итгэмжлэгдсэн Зөвлөл, [http://www.evostc.state.a\[us\]/facts/qanda.html](http://www.evostc.state.a[us]/facts/qanda.html) хаягаар авав.
- ²⁶ Эпштайн Зелбер нар, 36.
- ²⁷ http://www.iea.org/dbtw-wpd/textbase/stats/electricitydata.asp?country=World&SummitA=Summit&COUNTRY_Long_Name=World хаягаар авсан Олон Улсын Эрчим Хүчний Агентлагийн тоо баримтад тулгуурлав.
- ²⁸ Шинжлэх Ухааны Үндэсний Академийн Гео шинжлэх ухаан, байгаль орчин, нөөц баялгийн комисс, Цаг уурын өөрчлөлтийн шинжлэх ухаан: Зарим гол асуултуудын шинжилгээ (2001)6
- ²⁹ Дэлхийн Нөөц Баялгийн Институт, Дэлхийн чиг хандлагууд, http://earthtrends.wri.org/pdf_library/country_profiles/Cli_cou_840.pdf хаягаар авав.
- ³⁰ Дэлхийн Банкнаас газрын тос болон бусад олборлох салбаруудад гүйцэтгэх үүргээ үнэлэх зорилгоор хийлгэсэн хараат бус дүгнэлт болох Олборлох Салбаруудын Үнэлэлт Дүгнэлтэд олборлох салбарын бүх төслүүдийг Дэлхийн Банкны А Ангилалд оруулахыг зөвлөмж болгожээ.
- ³¹ Хавер Сала-И-Мартин, Арвинд Субраманиан нар, "Байгалийн баялгийн хясланг авч үзэх нь: Нигерийн дүр зураг", Олон Улсын Валютын Сангийн ажлын бодлого бичиг 03/199 (2003 оны 7 дугаар сар):4.
- ³² Мартин, Субраманиан нар, "Байгалийн баялгийн хясланг авч үзэх нь: Нигерийн дүр зураг".
- ³³ Хүний Эрхийн Манаа, Газрын тосны үнэ (1999), <http://www.hrw.org/reports/1999/nigeria/Nigew991-01.htm> хаягаар авав.
- ³⁴ Өмнөхтэй адилхан.
- ³⁵ Өмнөхтэй адилхан.
- ³⁶ Өмнөхтэй адилхан.
- ³⁷ Ээрт Райтс Интернэшнл, Төтөлгөн үгүйсгэлт үргэлжилсээр (2000 оны 5 дугаар сар):62, <http://www.earthrights.org/pubs/TotalDenialContinues.pdf> хаягаар авав.
- ³⁸ Өмнөхтэй адилхан.

³⁹ “Газрын тосны компанийн газрын тухай асуудлаар Колумбийн Индианчууд цагдаагийнхантай мөргөлдөв”, *Нью Йорк Таймс*, 2000 оны 2 сарын 14.

⁴⁰ Хүний Эрхийн Манаа.

⁴¹ Өмнөхтэй адилхан. Мөн Ээрт Райтс Интернэшнл, *Виверо Де Чевринтожско г*, <http://www.earthrights.org/chevrinindex.shtml> хаягаар үзнэ үү.

⁴² Ээрт Райтс Интернэшнл, *Дие Де Юнокал-г*, <http://www.earthrights.org/unocal/index.shtml> хаягаар авав.

⁴³ Өмнөхтэй адилхан.

⁴⁴ Хүний Эрхийн Манаа.

⁴⁵ Амазон Аллайнс... гэх мэт, Олсон зүйлсийн дүн: *Комиссалийн тосолд хохирсон нутгийн уугуул иргэдийн байдлыг судлах 2003 оны 5 дугаар сарын голлохон динд тайлан*; Уорбамаба голлохон динд ба дээд хэлний, *Нару улс*, http://www.amazonwatch.org/amazon/PE/camisea/reports/020724_camisea.pdf хаягаар авав.

⁴⁶ Амазоны Ажиглагч, *Энрон Де Шатагийн барьсан Кютабы болон Боливи* Эрэмгийн даажууных хоолойн үр нөлөө, 2002 оны 11 дүгээр сарын 14, http://www.amazonwatch.org/amazon/BO/cuiaba/reports/bolivia_audit_0211.pdf хаягаар авав.

⁴⁷ Ээрт Райтс Интернэшнл, *Дие Де Юнокал*.

⁴⁸ Эпштайн Зелбер нар, 18.

⁴⁹ Эмнести Интернэшнл, *Хүний эрхийн эрэлт дээр: Бүх тбилис Цойбаты даажууных хоолойн тосол* (2003 оны 5 сар).

⁵⁰ Өмнөхтэй адилхан.

⁵¹ <http://www.caspiandevlopmentandexport.com> хаягаар авсан *Бүх нутгийн үр нөлөөт дүлэлт* Оманод Каспийн газрын тос ба байгалийн эхийн тосолдгийн эдийн засаг, тиймээ, байгали орчныг тайм (2003 оны 2 дугаар сар).

⁵² Өмнөхтэй адилхан.

⁵³ <http://www.worldbank.org/ogmc/wbminingaid.htm> хаягаар олдсон мэдээллийг үзнэ үү.

⁵⁴ Шейла МакНалти, “Аляскийнхан ажилчны үхэлд БиПи-г буруутган торгож байна”, *Вашингтон Таймс*, 2003 оны 5 сарын 27.

⁵⁵ Эпштайн Зелбер нар, 13.

⁵⁶ Өмнөхтэй адилхан.

Нэр томъёоны тайлбар

Хүчлийн бороо: Шатдаг түлшийг шатаах үед агаар мандалд ялгардаг азотын исэл болон хүхрийн ислээс голдуу бүрдсэн хор хөнөөлтэй хэмжээний азотын болон хүхрийн хүчил агуулсан хур тунадас. (Эх сурвалж: energytrends.pnl.gov/glosa_d.htm)

Хөрөнгө: Бэлэн мөнгө болгон хувиргаж болох эдийн засгийн үнэ цэнэ бүхий эд зүйл.

Битум: Халаахад шингэн хэлбэрт орж болох хатуу бөгөөд хагас хатуу хэлбэртэй нүүрс ус төрөгчийн аливаа бүлэг. Битумыг боловсруулж шатахуун, тосон түлш, асфальт зэрэг арилжааны бүтээгдэхүүн үйлдвэрлэж болно. (Эх сурвалж: Хоуфтон Миффлин: <http://www.college.hmco.com/geology/resources/geologylink/glossary/b.html>)

Бнт/ө: Нэг өдөрт ноогдох баррель нефтьтэй тэнцэх хэмжээ. Энэ нэр томъёог байгалийн хийн үйлдвэрлэлийн хэмжээг газрын тосны үйлдвэрлэлийнхтэй жишиж стандартчилахад хэрэглэдэг.

Шагнал: Аливаа компаниас газрын тос, байгалийн хий, ашигт малтмалын орд зэрэг байгалийн баялгийг боловсруулан гаргах эрхийн төлөө хүлээн авагч орны засгийн газарт төлдөг төлбөр. Шагналыг голдуу үе шаттайгаар, тухайлбал төслийн эхэнд болон боловсруулалтын янз бүрийн шатанд хүрэх үед төлдөг.

Бутан: Ихэвчлэн байгалийн хийн ордоос буюу боловсруулах үйлдвэрээс гарч буй хийн урсгалаас гаргаж авдаг хий хэлбэртэй нүүрс ус төрөгч. Үүнийг ахуйн хэрэглээний түлш, хөдөлгүүрийн хий, хөргөгчийн зориулалтаар ашигладаг. (Эх сурвалж: <http://www.pplweb.com/glossary.htm>)

Капиталын зардал: Нийтээр хүлээн зөвшөөрсөн нягтлан бодох бүртгэлийн зарчмын дагуу үйл ажиллагааны болон засвар үйлчилгээний зардалд ёсчлон тооцдоггүй үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийг шинээр худалдан авах, солих, шинэчлэх, өргөтгөхөд гарсан аливаа зардал. (Эх сурвалж: <http://www.ohca.state.ct.us/glossary.htm>)

Капиталын урсгал: Нэг улсаас нөгөөд гадаад валют шилжих хөдөлгөөн. Мөнгийг олон улсын хооронд шилжүүлэхэд ашигладаг энэ төрлийн гүйлгээнд зээл болон түүний буцаан төлөлт, бонд гаргалт ба түүний төлөлт, гадаадын шууд хөрөнгө оруулалт ба капиталыг эх орондоо татан авах, хувьцаа, бонд, үнэт цаас гэх мэт портфелийн хөрөнгө оруулалт орно. (Эх сурвалж: Currency Transaction Tax, Glossary of Financial Terms /Валютын гүйлгээний татвар, Санхүүгийн нэр томъёоны тайлбар/. <http://www.currencytax.org/glossary.php>)

Бэлэн мөнгөний урсгал: Аливаа компанийн санхүүгийн эрүүл саруул байдлын нэг хэмжүүр. Өгөгдсөн хугацаанд хүлээж авсан бэлэн мөнгөний орлогоос бэлэн мөнгөөр төлсөн зардлыг хассантай тэнцүү байна.

Бараа, түүхий эд: Алт болон бусад металл, нефть, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн зэрэг худалдаалж болох янз бүрийн эд зүйлсийн өргөн хүрээг хамарсан нэр томъёо.

Концесс: Ихэвчлэн гадаадад явуулж байгаа үйл ажиллагаанд хэрэглэдэг бөгөөд хүлээн авагч засгийн газраас тухайн үйл ажиллагааг явуулах компанид их хэмжээний талбайг тодорхой хугацаагаар, тодорхой нөхцөлтэйгээр олгож, тухайн компанид хайгуул хийх, үйлдвэрлэл явуулахыг зөвшөөрч байгааг хэлнэ. (Эх сурвалж: <http://www.gomr.mms.gov/homepg/lagniapp/glossary.html>)

Конденсац: Үйлдвэрлэлийн дараа шингэн хэлбэртэй хөнгөн нүүрс ус төрөгчийг түүхий нефтиэс ялган авч, тусд нь борлуулахад хэрэглэдэг нэр томъёо. (Эх сурвалж: Конокс Филлипсийн эрчим хүчний нэр томъёоны тайлбар. <http://www.conocophillips.com/utilities/glossary/glossary-c.asp>)

Консорциум: Газрын тос, байгалийн хийг олборлож арилжааны бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилгоор хүчээ нэгтгэн ажиллаж буй хоорондоо холбоогүй

компаниудын аливаа бүлэг. Ийм үед ихэвчлэн нэг компани үйл ажиллагааг удирдан явуулдаг.

Түүхий нефть: Газрын гүнээс олборлон гаргаж буй шингэн нефтийг ингэж нэрлэх бөгөөд үүгээрээ боловсруулах үйлдвэрээс нэрэн гаргаж буй нефтиэс ялгаатай. Түүнчлэн “криуд” буюу “түүхий” хэмээн товчлон нэрлэх явдал байдаг. (Эх сурвалж: <http://www.mme.state.va.us/DMR/DOCS/MinRes/OIL/glos.html>)

Элэгдэл хорогдол: Аливаа хөрөнгийн үнэ цэнэ түүний ашиглалтын болон цаг хугацааны явцад алдагдахыг хэлнэ.

Ноогдол ашиг: Компаниуд ашгийнхаа тодорхой хэсгийг хувьцаа эзэмшигчиддээ олгодог бөгөөд эдгээр ашгийг ноогдол ашиг гэж нэрлэдэг.

Үйлдвэрлэлийн дараахь үйл ажиллагаа: Газрын тосны салбарын энэхүү нэр томъёог түүхий нефтийг нэрж шатахуун үйлдвэрлэхээс эхлээд үйлдвэрлэсэн бүтээгдэхүүний түгээлт, маркетинг, тээвэрлэлт хүртэл бүхий л үйл ажиллагаанд хамруулан хэрэглэдэг.

Голланд өвчин: Аливаа улс үндэстэн ямар нэг байгалийн баялгийн орд газар нээх үед тухайн улсын үндэстний валютын ханш нэмэгдэж, дотооддоо үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүний олон улсад өрсөлдөх чадвар бууран, импорт нэмэгдэж, экспорт буурсны улмаас үндэстний аж үйлдвэржилт саарах үзэгдэл гардаг. Энэ нэр томъёо Голланд улс Хойд мөсөн далайгаас байгалийн хийн орд газар нээсний дараа үүссэн байна. (Эх сурвалж: <http://www.investorwords.com>)

Валютын ханш: Нэг улсын валютыг өөр нэг улсын валютаар илэрхийлсэн үнэ.

Онцгой татвар: Бараа, түүхий эдийн үйлдвэрлэлт, борлуулалт, хэрэглээнд ноогдуулдаг татвар, хураамж.

Шатдаг түлш: Газрын хөрсөн доорх үхсэн ургамал, амьтны үлдэгдлээс үүссэн нүүрс ус төрөгчийн болон нүүрс төрөгчийн түлш. Шатдаг түлш бий болохын тулд сая сая жил шаарддаг. Газрын тос, байгалийн хий, нүүрс зэрэг нь шатдаг түлш юм. Шатдаг түлш шатаах үед агаар мандалд нүүрс төрөгчийн давхар исэл ялгарч байгаа нь дэлхийн цаг уурын дулааралд голлох нөлөө үзүүлж байна хэмээн олон эрдэмтэд санаа зовдог.

Зайн түлш: Түлшний эх үүсвэрийг шатаахаасаа илүү цахилгаан химийн урвалаар дамжуулан химийн эрчим хүчийг цахилгаан эрчим хүч ба халуун ус болгон

хувиргадаг жижиг төхөөрөмж. (Эх сурвалж: <http://www.fuelingthefuture.org/contents/glossary.asp>)

Тосон түлш: Дунд буюу хүнд жинтэй нүүрс ус төрөгчийн хольцоос бүрдсэн шингэн түлш бөгөөд түүхий нефтийг боловсруулах замаар үйлдвэрлэдэг. Тосон түлшний арай хөнгөн төрлүүдэд дизель түлш, гэр ахуйн халаалтын тос, керосин, тийрэлтэт хөдөлгүүрийн тос ордог бол арай хүнд төрлүүдийг нь аж үйлдвэр, хөлөг онгоцонд болон эрчим хүч, дулаан үйлдвэрлэх зорилгоор цахилгаан станцид ашигладаг. (Эх сурвалж: <http://www.uwsp.edu/cnr/wcee/keep/Audit/glossary-f-g.htm>)

Шатахуун: Дотоод шаталтын хөдөлгүүртэй авто машиныг ажиллуулахад ашигладаг боловсруулсан нефтийн хэлбэр.

Дэлхийн цаг уурын дулаарал: Дэлхийн гадаргын температур аажим аажмаар улам бүр нэмэгдэх үйл явц бөгөөд энэ нь хүлэмжийн нөлөөгөөр үүсч, дэлхийн цаг уурын хэв шинж өөрчлөгдөхөд хүргэж байна гэж үздэг. Цаашлаад нүүрс төрөгчийн давхар ислийн хэмжээ (автомашин, цахилгаан станц, бусад хорт хий ялгаруулагчаас үүссэн) нэмэгдэж байгаа нь дэлхийн цаг уурын дулаарлыг улам нэмэгдүүлж байна гэж олон эрдэмтэд үздэг.

Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ): Аливаа орны эдийн засагт үйлдвэрлэсэн бүх бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийн нийлбэр дүн.

Нүүрс ус төрөгч: Зөвхөн нүүрстөрөгч, устөрөгч агуулсан органик нийлмэл бодис. Голдуу нефть, байгалийн хий, нүүрсэнд агуулагддаг. (Эх сурвалж: <http://www.envirotools.org/glossary.shtm>)

Дотоод шаталтын хөдөлгүүр: Эрчим хүч гаргахын тулд хөдөлгүүрийн цилиндрт түлш (бензин) шатаах замаар ажилладаг нэг төрлийн хөдөлгүүр. (Эх сурвалж: <http://www.learningonthemove.co.uk/gloss.html>)

Хамтарсан үйлдвэр: Компаниудын консорциумаас хамтран хийсэн хөрөнгө оруулалт, ихэвчлэн нэг гишүүн нь үйл ажиллагааг удирдан явуулдаг.

Өр төлбөр: Аливаа өрийг ирээдүйн тодорхой хугацаанд төлөх санхүүгийн үүрэг.

Лицензийн гэрээ: Тодорхой газар нутаг дээр газрын тос, байгалийн хийн хайгуул хийж, үйлдвэрлэл явуулах эрхийг засгийн газраас газрын тосны компанид олгодог гэрээ.

Дотоодын бүтцийн шаардлагууд: Аливаа бүтээгдэхүүний тодорхой хэсэг эсвэл

ажилчдын тодорхой хувийг дотоодын эх үүсвэрээс авах ёстойг заасан хууль тогтоомжууд.

Зах зээлийн капиталжилт: Аливаа компанийн хөрөнгийн зах зээлийн үнэ. Үүнийг тооцоходоо нийт үлдэгдэл хувьцааны тоог нэг хувьцааны зах зээлийн үнээр үржүүлж тооцно. (Эх сурвалж: <http://www.slb.com/ir/ar/glossary.html>)

Дунд нэрмэл: Нефть боловсруулах нэрэлтийн “дунд чаналтын түвшинд” байгаа нүүрс ус төрөгч. Үүний жишээнд халаалтын тос, дизель түлш, керосин орно. (Эх сурвалж: <http://www.thebullandbear.com/resource/RI-archive/gloss-oil.html>)

Зах зээлд эзлэх хувь: Аливаа компанийн борлуулалтыг нийт салбарын борлуулалтад эзлэх хувиар илэрхийлсэн хувь.

Шингэрүүлсэн байгалийн хий (ШБХ): Байгалийн хий үйлдвэрлэх явцад гаргаж авсан шингэнүүд, тухайлбал этан, пропан, бутан, конденсац гэх мэт. (Эх сурвалж: <http://www.careersinoilandgas.com/general/glossary.cfm>)

Цэвэр орлого: Нийт орлогоос татвар төлж, зардлыг хасч, зохих шимтгэл тооцсоны дараахь орлого.

Үйл ажиллагааны ашиг: Аливаа компанийн үйл ажиллагааныхаа явцад орлого олох чадварын нэг хэмжүүр. Хүүгийн төлбөр болон орлогын татварыг хасахын өмнөх орлоготой тэнцэнэ. (Эх сурвалж: http://www.investorwords.com/3464/operating_profit.html)

Пентани: Метан буюу парафины цувралын гурван метамер нүүр ус төрөгчийн аль нэг. Тэдгээр нь өнгөгүй, ууршимтгай шингэнүүд бөгөөд хоёр нь бензин шатахуунд агуулагддаг. Нэг молекулдаа нүүрстөрөгчийн таван атомтай учраас пентани гэж нэрлэжээ. *Уэбстерийн Шинэчилсэн Хураангуйлаагүй Толь Бичиг, © 1996*

Нэг хүнд ноогдох орлого: Нийт орлогыг нийт хүн амын тоонд хуваасантай тэнцэх буюу нэг хүнд ноогдох дундаж орлого.

Нефть: Түүхий нефть, шингэрүүлсэн байгалийн хий, байгалийн хий, тэдгээрийн бүтээгдэхүүний ерөнхий нэр. (Эх сурвалж: <http://www.conocophillips.com/utilities/glossary/glossary-p.asp>)

Мөчлөг дагасан капиталын урсгал: Цаг сайхан байх үед (жишээлбэл, байгалийн баялгийн олон улсын үнэ өндөр байх үед) ихэсдэг, цаг муугаар эргэхэд (жишээ нь, байгалийн баялгийн үнэ доогуур байх үед) буцааж нэхэгддэг зээлдүүлэг.

Мөчлөг дагасан төсвийн бодлого: Цаг сайхан байх үед (жишээлбэл, байгалийн баялгийн олон улсын үнэ өндөр байх үед) ихэсдэг, цаг тааруу байх үед (жишээ нь, байгалийн баялгийн үнэ доогуур байх үед) багасдаг засгийн газрын зарцуулалт.

Бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд (БХГ-үүд): Нефть эсвэл уул уурхайн төслийн хайгуул, үйлдвэрлэлийн зардал ба эрсдлийг тухайн компани даасны хариуд бүтээгдэхүүний тодорхой хувийг авах тухай эрчим хүчний хайгуулын компани ба хүлээн авагч засгийн газар хоёрын хооронд байгуулдаг гэрээ. Зарим тохиолдолд, эрчим хүчний компани оруулсан хөрөнгө оруулалтаа нөхөж авах хүртэл хүлээн авагч засгийн газар бүтээгдэхүүний маш бага хувийг авах буюу эсвэл огт авдаггүй байна.

Газрын тосны ашиг: Бүтээгдэхүүн хуваах гэрээний газрын тосны ашиг гэдэг нь аливаа компани эсвэл консорциум ба хүлээн авагч засгийн газрын хооронд хуваах ашигт оруулж тооцсон газрын тосыг хэлдэг. Компаниуд үйлдвэрлэсэн газрын тосны орлогоос урсгал зардлаа нөхөх болон уг газрын тосыг боловсруулан гаргахад зарцуулсан капиталын зардлын элэгдэл хорогдлоо тооцсоны дараа үлдэж буй ашгийг газрын тосны ашиг гэдэг.

Пропан: Атмосферийн хэвийн даралт болон температурт хий байдалд буй байгалийн нүүрс ус төрөгчийг хэлнэ. Гэхдээ пропаныг ихэвчлэн тээвэрлэлт, хадгалалтын зорилгоор даралтжуулан шингэрүүлдэг. Пропаныг голдуу хөдөө хээрийн нөхцөлд халаалга болон хоол унд хийхэд ашиглахын зэрэгцээ байгалийн хий дамжуулах гол шугам байхгүй газруудад хийн түлш болгож, мөн петро химийн эх үүсвэр болгон ашигладаг. (Эх сурвалж: <http://www.turtletrader.com/glossary.html>)

Болзошгүй нөөц: Газрын тос, байгалийн хийн тоо хэмжээний хувьд хараахан “батлагдаагүй” боловч бүхий л нотлох баримт, техник, эдийн засгийн хүчин зүйлсийг харгалзан үзвэл үйлдвэрлэн гаргах 50-иас дээш хувийн магадлалтай нөөцийг “болзошгүй нөөц” гэнэ. (Эх сурвалж: http://www.emeraldenergy.com/docs/ar_00/glossary.htm)

Батлагдсан нөөц: Одоогийн эдийн засаг, үйл ажиллагааны орчин нөхцөлд газрын тос, байгалийн хийн тодорхой нэг орд газраас гарган авч болно хэмээн геологийн болон инженерийн тоо баримтаар харуулсан нүүрс ус төрөгчийн тогтоосон тоо хэмжээг хэлнэ. (Эх сурвалж: <http://www.conocophillips.com/utilities/glossary/glossary-p.asp>)

Төлөөс нэхэх: Төрийн зарим бодлогын “тааламжтай” шийдвэрийн үр дүнд бүтээгдэхүүн, үйлчилгээг өөртөө шилжүүлэн авах зорилгоор нөөцийг зарцуулахыг хэлнэ. Төлөөс нэхэгч зан байдлын жишээнд хувь хүмүүс буюу бүлгүүд бусдыг золиослон өөрсдөө санхүүгийн ашиг хонжоо юмуу бусад онцгой давуу талууд хүртэх үүднээс татвар, зарцуулалт, зохицуулалтын бодлогын талаар засгийн газрыг лоббидох янз бүрийн арга зам ордог. (Эх сурвалж: Paul M. Jonson, “A Glossary of Political Economy Terms” / Пол М. Жонсон, “Улс төр эдийн засгийн нэр томъёоны тайлбар” / . <http://www.auburn.edu/~johnspm/gloss/>)

Хөрөнгийн өгөөж: Аливаа компанийн ашигт ажиллагааны нэг хэмжүүр. Санхүүгийн жилийн нийт орлогыг нийт хөрөнгийн дүнд хувааж, хувиар илэрхийлсэнтэй тэнцүү байна. (Эх сурвалж: http://www.investorwords.com/4246/Return_on_Assets.html)

Өөрийн хөрөнгийн өгөөж: Олсон орлогыг хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн дүнд хуваана. Энэ нь тухайн компанийн эзэд (буюу хувьцаа эзэмшигчид) оруулсан хөрөнгө оруулалтаараа хэр их орлого олж байгааг харуулах бөгөөд аливаа компанийн гүйцэтгэлийн нэг чухал хэмжүүр байдаг. (Эх сурвалж: <http://www.meredith.com/archive/investors/financial/glossary.htm>)

Нөөц ашигласны төлбөр: Газрын тос, байгалийн хий эсвэл байгалийн баялгийн орлогоос түүний эзэнд буюу ихэвчлэн засгийн газарт төлдөг хувь. Энэ хэмжээ нь ихэвчлэн уг баялгийг ашиглах явцад олсон орлогын хувь байдаг.

Утаа тортог: Хүний амьсгалын замын эмгэг үүсгэдэг хүхрийн давхар исэл, нүүрс төрөгчийн давхар исэл зэрэг хорт хийнүүд болон хөө, тортог их хэмжээгээр агуулсан өнгөгүй, өтгөн цацралттай манан. (Эх сурвалж: <http://www.nrdc.org/reference/glossary/s.asp>)

Тогтворжуулалтын сан: Бараа, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс хамгаалж засгийн газрын төсвийг тогтворжуулахад ашиглаж болох аливаа сан. Бараа, түүхий эдийн үнэ өндөр байх үед олсон илүүдэл орлогыг уг санд шилжүүлж болно. Улмаар бараа, түүхий эдийн үнэ буурах үед уг хөрөнгийг тогтворжуулалтын сангаас гаргаж засгийн газрын төсөвт буцаан шилжүүлж болдог.

Үндсэн бүтээгдэхүүний хамаарлын занга: Тодорхой нэг үндсэн бүтээгдэхүүний экспортоос улам бүр хамааралтай болох явдал.

Татвараас хасагдах зардал: Аливаа аж ахуйн үйл ажиллагааны татвар ногдох орлогоос хасч болох зардлууд.

Торт буюу Нөхөн төлбөрийн хууль: Энэ нь гэмтэж бэртсэн хүн түүнийг гэмтээж бэртээсэн хүнээс нөхөн төлбөр авах боломж олгодог хууль тогтоомжийг хэлнэ.

Үйлдвэрлэлийн өмнөх үйл ажиллагаа: Газрын тос, байгалийн хийн хайгуул, үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд хамаарах газрын тосны салбарын нэр томъёо.

Эх сурвалжууд

Бүлэг 2

Auti, Richard M. 1998. *Resource Abundance and Economic Development / Нөөц баялгийн элбэг байдал ба эдийн засгийн хөгжил/*. Helsinki: UNU World Institute for Development Economic Research.

Auti, Richard M. and Raymond Frech Mikesell. 1998. *Sustainable Development in Mineral Economies / Эрдэс баялгийн эдийн засагтай орнуудын тогтвортой хөгжил/*. Oxford: Clarendon Press.

Birdsall, Nancy, D.Ross, and R.Sabot. 1997. Education, Growth and Inequality / Боловсрол, өсөлт, тэгш бус байдал/, in N.Birdsall and F.Jasperson, eds. *Pathway to Growth: Comparing East Asia and Latin America / Өсөлтийн замууд: Зүүн Ази, Латин Америкийн харьцуулалт/*. Washington, DC: Inter American Development Bank; 93-127.

Chaudhry, Kiren Aziz. 1997. *The Price of Wealth: Economics and Institutions in the Middle East / Баялгийн үнэ: Ойрхи Дорнод дахь эдийн засаг ба институтууд/*. Ithaca: Cornell University Press.

Collier, Paul and Ann Hoeffler. 1998. On Economic Causes of Civil War, *Oxford Economic Papers* /Оксфордын эдийн засгийн илтгэлүүд/ 50; 563-573.

Glyfason, T. 2002. Lessons from the Dutch Disease: Causes, Treatment, and Cures /Голланд өвчнөөс авах сургамжууд: Шалтгаан, эмчилгээ, эмчлэх аргууд/, in *The Paradox of Plenty: The Management of Oil Wealth- Based on Terry Lynn Karl's The Paradox of Plenty* /Элбэг дэлбэгийн гэж үзэгдэл: Газрын тосны баялгийн удирдлага/. Oslo: Report 12/02 ECON, Centre for Economic Policy.

Isham, Jonathan, Michael Woolcock, Lant Pritchett, and Gwen Busby. 2003. The Varieties of Resource Experience: How Natural Resource Export Structures Affect the Political Economy of Economic Growth /Нөөц баялгийн туршилагын олон хувилбарууд: Байгалийн баялгийн экспортын бүтцүүд эдийн засгийн өсөлтийн улс төрийн эдийн засагт хэрхэн нөлөөлдөг вэ/. *Middlebury College Economics Discussion Paper* no.03-08.

Karl, Terry Lynn. 1997. *The Paradox of Plenty: Oil Booms and Petro-States* /Элбэг дэлбэгийн гэж үзэгдэл: Газрын тосны оргил үе ба нефро-улсууд/. Berkeley: University of California Press.

Karl, Terry Lynn. 2004. Oil Led Development: Social, Economic and Political Consequences /Газрын тосонд хөтлөгдсөн хөгжил: нийгэм, эдийн засаг, улс төрийн үр дагаврууд/. *Encyclopedia of Energy* /Эрчим хүчний нэвтэрхий толь/, Vol.IV. New York: Elsevier.

Leite, Carlos and Jens Weidmann. 1999. Does Mother Nature Corrupt? Natural Resources, Corruption and Economic Growth /Эх байгаль сүйрэв үү? Байгалийн баялаг, авилгал ба эдийн засгийн өсөлт/. *IMF Working paper WP99/85*. Washington, D.C.: International Monetary Fund.

Owens, T. and A.Wood. 1997. Export-Oriented Industrialization through Primary Processing? /Анхан шатны боловсруулалтаар дамжин экспортод тулгуурласан аж үйлдвэржилт/, *World Development* 25; 1453-73.

Ross, Michael. 2001. Does Oil Hinder Democracy? /Газрын тос ардчилалд саад болдог уу? /*World Politics* 53.

Sachs, Jeffrey D. and Andrew W.Warner. 1997. Natural Resources and Economic Growth /Байгалийн баялаг ба эдийн засгийн өсөлт (шинэчилсэн хувилбар)/ (revised version). *Harvard Institute for International Development Discussion Paper*. Cambridge: Harvard.

Sachs, Jeffrey D. and Andrew W. Warner. 2001. The Curse of Natural Resources / Байгалийн баялгийн хяслан/. *European Economic Review* 45; 827-838.

Wright, Gavin and Jesse Czelusta. 2002. Exorcising the Resource Curse: Minerals as a Knowledge Industry, Past and Present /Нөөц баялгийн хясланг зайлуулах нь: Эрдэс баялаг мэдлэгийн үйлдвэрлэл болох нь, өнгөрсөн ба одоо/, Unpublished.

Бүлэг 3

American Petroleum Institute /Америкийн Нефтийн Институт/: <http://api-es.api.org/frontpage.cfm>

BP Statistical Review of World Energy /Дэлхийн эрчим хүчний тухай БиПи-гийн статистикийн тойм/: <http://www.bp.com/subsection.do?categoryId=95&contentId=2003480>

International Energy Agency /Олон Улсын Эрчим Хүчний Агентлаг/: <http://www.iea.org/>

Kyoto Protocol /Киотогийн Протокол/: <http://www.unfccc.int/resource/convkp.html>

Organization of the Petroleum Exporting Countries /Нефть экспортлогч орнуудын байгууллага/: <http://www.opec.org/>

United Nations Framework Convention on Climate Change /Цаг уурын өөрчлөлтийн талаарх НҮБ-ын хүрээний конвенц/: http://www.unfccc.int/essential_background/convention/items/2627.php

United Nations Intergovernmental Panel on Climate Change /Цаг уурын өөрчлөлтийн талаарх НҮБ-ын Засгийн газар хоорондын зөвлөл/: <http://www.ipcc.ch>

United States Energy Information Administration /АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн удирдах газар/: <http://www.eia.doe.gov/>

United States Geological Survey /АНУ-ын Геологийн судалгааны газар/: <http://www.usgs.gov/>

Бүлэг 4

Alexander's Gas and Oil Connections /Александрын газрын тос ба байгалийн хийн холболтууд/: <http://www.gasandoil.com/goc/>

American Petroleum Institute /Америкийн Нефтийн институт/: <http://www.api.org>

Energy Intelligence /Эрчим хүчний тагнуул/: <http://www.energyintel.com>

Extractive Industries Transparency Initiative /Олборлох салбарын ил тод байдлын санаачилга/: <http://www.eitransparency.org>

Foumylinks: <http://www.freespace.virgin.net/alan.foum/>

Global Reporting Initiative /Дэлхий нийтийн тайлагналын санаачилга/: <http://www.globalreporting.org/>

International Association of Oil and Gas Producers /Газрын тос, байгалийн хий үйлдвэрлэгчдийн олон улсын холбоо/: <http://www.ogp.org.uk>

International Energy Agency /Олон улсын эрчим хүчний агентлаг/: <http://www.iea.org>

New York Mercantile Exchange /Нью Йоркийн Бараа, түүхий эдийн бирж/: <http://www.nymex.com>

Oil and Gas International /Газрын тос, байгалийн хийн олон улсын байгууллага/
<http://www.oilandgasinternational.com/>

Organization of Petroleum Exporting Countries /Нефть экспортлогч орнуудын байгууллага/: (ОПЕК): <http://www.opec.org>

Oxford Institute for Energy Studies /Эрчим хүч судлалын Оксфордын институт/
: <http://www.oxfordenergy.org/index.php>

Petroleum Argus /Петролеум Аргус/: <http://www.argusonline.com/>

PFC Energy /ПиЭфСи Энержи/: <http://www.pfcenergy.com/>

Platts /Платтс/: <http://www.platts.com>

Publish What You Pay Campaign /Төлснөө нийтэл кампанит ажил/: <http://www.publishwhatyoupay.org>

Schlumberger News Digest /Шлумбергерийн мэдээний эмхтгэл/: <http://www.slb.com/ba.cfm?baid=I>

Security and Exchange Commission's EDGAR database /Үнэт цаас, арилжааны комиссийн ЭДГАР өгөгдлийн сан/: <http://www.sec.gov/edgar/searchedgar/webusers.htm>

Society of Petroleum Engineers /Нефтийн инженерүүдийн нийгэмлэг/: <http://www.spe.org>

United Nations Global Compact /НҮБ-ын Глобал Компакт/: <http://www.unglobalcompact.org/Portal/Default.asp>

U.S. Energy Information Administration /АНУ-ын Эрчим хүчний мэдээллийн удирдах газар/: <http://www.iea.doe.gov> (үнийн тухай түүхэн мэдээлэл авахад сайн)

Voluntary Principles on Security and Human Rights /Аюулгүй байдал, хүний эрхийн сайн дурын зарчмууд/: <http://www.state.gov/g/drl/rls/2931.htm>

Yahoo Oil & Gas Operations Industry News /Яахүүгийн газрын тос, байгалийн хийн салбарын мэдээ/: <http://biz.yahoo.com/ic/n/oilprd.html>

Бүлэг 5

Azerbaijan Production Sharing Agreements /Азербайжаны бүтээгдэхүүн хуваах гэрээнүүд/: <http://www.caspiandevlopmentandexport.com>

Barrows Company /Барроус компани/: <http://www.barrowscompany.com>

Centre for Energy, Petroleum, & Mineral Law and Policy at the University of Dundee /Дүндээгийн Их сургуулийн Эрчим хүч, нефть, ашигт малтмалын хууль ба бодлогын төв/: <http://www.dundee.ac.uk/cepmlp/welcome.htm>

Бүлэг 6

Financial Policy Forum /Санхүүгийн бодлогын форум/: <http://www.financialpolicy.org>

UNCTAD-UN Conference on Trade and Development /НҮБ-ын Худалдаа, хөгжлийн бага хурал/: <http://www.unctad.org>

Publish What You Pay Campaign /Төлснөө нийтэл кампанит ажил/: <http://www.publishwhatyoupay.org>

New York Mercantile Exchange (oil, mineral and metal futures and options) /Нью Йоркийн Бараа, түүхий эдийн бирж (газрын тос, ашигт малтмал, металлийн фьючерс ба опционууд)/: <http://www.nymex.com>

New York Board of Trade (futures and options) /Нью Йоркийн Худалдааны зөвлөл (фьючерс ба опцион)/: <http://www.nybot.com>

World Bank, Treasury Department-Risk Management /Дэлхийн Банк, Сан хөмрөгийн хэлтэс- Эрсдлийн удирдлага/: <http://treasury.worldbank.org/index.html>

U.S. Department of Agriculture-Risk Management Agency /АНУ-ын Хөдөө аж ахуйн департамент- Эрсдлийн удирдлагын газар/: <http://www.rma.usda.gov>

Dodd, Randall. 2002a. Primer: Derivatives. *Financial Policy Forum* /Үнэт цаасны цагаан толгой, Санхүүгийн Бодлогын Форум/. Washington, D.C.: <http://www.financialpolicy.org/dscprimer.htm>

Dodd, Randall. 2004. Primer: Derivative Instruments. *Financial Policy Forum* /"Үнэт цаасны хэрэгсэлүүдийн цагаан толгой", Санхүүгийн Бодлогын Форум/. Washington, D.C. <http://www.financialpolicy.org/dscinstruments.htm>

Dodd, Randall. 2002b. The Structure of OTC Derivatives Markets /Лангуугаар худалдаалагдах барааны үнэт цаасны зах зээлүүдийн бүтэц/. *The Financier* Volume 9, no.1-4. <http://www.financialpolicy.org/dscprimer.htm>

Larson, Donald, Panos Varangis, and Nanae Yabuki. 1998. Commodity Risk Management and Development /Бараа, түүхий эдийн эрсдлийн удирдлага ба хөгжил/. *World Bank Working Paper*, no. 163. Washington, D.C.

Tsalik, Svetlana. 2003. Caspian Oil Windfalls; Who Will Benefit? /Каспийн газрын тосны олз: Хэн хожих вэ?/ Caspian Revenue Watch, Open Society Institute, New York, New York.

Wright, Brian D. and David M. Newbery. 1989. Commodity Bonds with Put Options for Consumption Smoothing by Commodity-Dependent Exporters /Бараа, түүхий эдээс

хамааралтай экспортлогчдын хэрэглээг тэгшитгэхэд зориулсан худалдах опцион бүхий барааны бондууд/. CUDARE Working Paper Series 519, University of California at Berkeley, Department of Agricultural and Resource Economics and Policy.

Бүлэг 7

U.S. Environmental Protection Agency. October 2000. *EPA Office of Compliance Sector Notebook Project, Profile of the Oil and Gas Extraction Industry: АНУ-ын Байгаль Орчныг Хамгаалах Газар, БОХГ-ын салбарын дагаж мөрдөлтийг хянах төслийн газар, Газрын тос ба байгалийн хий олборлох салбарын тайлан (2000 оны 10 дугаар сар):38, <http://www.epa.gov/compliance/resources/publications/assistance/sectors/notebooks/oil.html>*

Paul Epstein and Jesse Selber, eds., *A Life Cycle Analysis of its Health and Environmental Impacts/Газрын тос: түүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх нөлөөний амьдралын мөчлөгийн шинжилгээ/*. Harvard Medical School, Center for Health and the Global Environment /Харвардын Анагаахын Сургууль- Эрүүл мэнд, дэлхийн байгаль орчны төлөө төв/, 2002 оны 3 сар. <http://www.med.harvard.edu/chge/fullreport.pdf>

Burger, Joanna. 1997. *Oil Spills /Газрын тос алдалтууд/*. New Brunswick, N.J.: Rutgers University Press.

Human Rights Watch /Хүний эрхийн ажиглагч/.1999. *The Price of Oil /Газрын тосны үнэ/*. <http://www.hrw.org/reports/1999/nigeria/Nigew991-01.htm>

Earth Rights International /Дэлхийн эрхийн олон улсын байгууллага/. May 2000. *Total Denial Continues /Тоталын үгүйсгэлт үргэлжилсээр/*. <http://www.earthrights.org/pubs/TotalDenialContinues.pdf>

Зохиогчдын тухай

Рандаал Додд бол Вашингтон дахь Бараа, түүхий эдийн үнэт цаас судлалын төв болон Санхүүгийн бодлогын форумыг үүсгэн байгуулагч, захирал хүн юм. Тэрээр өмнө нь Бараа, түүхий эдийн фьючерс худалдааны комисст эдийн засагчаар болон комиссийн гишүүний тусгай зөвлөхөөр ажиллаж байв. БТЭФХК-д ажиллахаасаа өмнө АНУ-ын Конгресс дахь Эдийн засгийн хамтарсан хороо болон Ардчилсан судалгааны группт ахлах эдийн засагчаар, Конгрессийн Банкны Хороонд алба хашиж байсан конгрессийн гишүүн Жо Кеннедигийн хууль тогтоомж хариуцсан захирлаар ажиллаж байжээ. Мөн Вашингтон руу шилжихээсээ өмнө Додд Ситикорп Инвестмент Банкинд ажиллаж санхүүгийн зах зээлийн тайлан мэдээ гаргаж, урьдчилан таамаглах загваруудын эконометрик туршилтууд хийж байв. Тэрээр төр засгийн болон бизнесийн салбарт ажилласан туршлагаасаа гадна Колумбийн Их сургуулийн Бизнесийн Төгсөх Сургууль ба Колумбийн Коллеж (тэрээр энд Орчин цагийн иргэншил нэртэй үндсэн хөтөлбөрийн хичээл зааж байв), Жонн Хопкинсийн Их сургууль, Руттерсийн Их сургууль, Мэрилэндын Их Сургууль, Барухын Коллеж CUNY, Америкийн Их сургууль зэрэг газруудад эдийн засаг, санхүү, улс төрийн философийн хичээл зааж байв. Тэрээр Колумбийн Их сургуулиас эдийн засгийн ухааны Ph.D докторын зэрэг хүртсэн бөгөөд олон улсын худалдаа, санхүүгийн чиглэлээр мэргэшсэн байна.

Терри Линн Карл бол Латин Америк Судлалын Гилдред профессор, Стэнфордын Их сургуулийн Олон улс судлалын хүрээлэнгийн улс төрийн ухааны профессор, ахлах судлаачаар ажилладаг. Тэрээр өмнө нь Харвардын Их сургуулийн Засгийн газрын хэлтэст хичээл зааж байсан байна. Харьцуулсан улс төр ба олон улсын харилцааны асуудлаар олон бүтээл бичиж хэвлүүлсэн бөгөөд газрын тос экспортлогч орнуудын бодлого, харьцуулсан ардчилалын үйл явц, хүний эрх, орчин цагийн Латин Америкийн улс төрийн асуудлыг онцлон бичдэг байна. Эрчим хүчний асуудлуудтай холбоотой түүний бичсэн ном, монографуудын тоонд дараахь бүтээл орж байна: *The Paradox of Plenty: Oil Booms and Petro-States /Элбэг дэлбэгийн гаж үзэгдэл: Газрын тосны оргил үе ба петро-улсууд/ (University of California Press, 1998)* буюу Венесуэл, Алжир, Нигери, Индонези, Иран, Норвеги улсуудыг харьцуулсан судалгаа; *Bottom of the Barrel: Africa's Oil Boom and the Poor /Баррелийн ёроол: Африкийн газрын тосны оргил үе ба Ядуус/ (Иан Гаригийн хамт), The Limits of Competition /Өрсөлдөөний хязгаарууд/ (MIT Press, 1996)* буюу Лисбоны Групптэй хамтран бичсэн олон зохиогчтой боть (Европын Хамтын Нийгэмлэгийн “Арван хоёр одот байгаль орчны шагнал”-г хүртсэн бүтээл). Түүний хамгийн сүүлийн үед бичсэн нийтлэл бол Катлер Клийвландийн эмхтгэсэн *Encyclopedia of Energy /Эрчим хүчний нэвтэрхий толь/ (San Diego: Elsevier, 2004)*-д орсон “Газрын тосны нийгэм, улс төрийн үр дагаварууд” нэртэй бүтээл байлаа. Одоо тэрээр Мэри Каллдортой хамтран газрын тос, дайн хоёрын холбоо хамаарлыг судлах харьцуулсан төсөл дээр ажиллаж байна.

Женик Радон бол Колумбийн Их сургуулийн Олон улсын ба төрийн хэргийн сургуульд шадар туслах профессор, Энэтхэгийн Мумбай дахь Индра Гандийн нэрэмжит Хөгжлийн Судалгааны Хүрээлэнгийн (Энэтхэг улсын Резерв Банкны дэмжлэгээр ажилладаг бие даасан эдийн засгийн институт) зочин профессор, Радон & Ишизуми товчооны өмгөөлөгч юм. Олон улсын хэмжээнд хийсэн ажлуудынхаа явцад Радон 1980 онд Афганистанд Туслах Хороог үүсгэн байгуулалцаж, түүний Гүйцэтгэх хорооны гишүүн (1980-1995), АНУ-Польшийн Эдийн засгийн Зөвлөлийн дэд дарга (1987-1992), Эстонийн засгийн газар, түүний дотор шинэчлэлийн (өмч хувьчлалын), эдийн засаг, хууль зүйн яамдад зөвлөх (1988-1995), 1990 онд Эстони-Америкийн Худалдааны Танхимыг байгуулж, үүсгэн байгуулагч Америк даргаар (1990-1993) тус тус ажилласан байна. Тэрээр 1996 оноос хойш Гүржийн засгийн газрын зөвлөхөөр ажилласан бөгөөд стратегийн ач холбогдолтой олон тэрбум долларын өртөгтэй Баку-Тбилис-Цейханы нефть дамжуулах хоолой болон Баку-Тбилис-Ерзурумьн хий дамжуулах хоолойн гэрээ хэлэлцээрүүдэд Гүржийн талаас тэргүүлэн оролцсон байна. Тэрээр хүлээн авагч

засгийн газрын байр сууринаас бүтээгдэхүүн хуваалт, концесс-лиценз, хамтарсан үйлдвэрийн гэрээнүүд төдийгүй байгалийн хий худалдан авах гэрээнүүдийн асуудлаар хэлэлцээнд оролцож зөвлөгөө өгсөн байна. Радон Колумбийн Их сургуулийн дэргэдэх Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга хэмээх сэтгүүл зүйн боловсролын хөтөлбөрийнхөө нэг хэсэг болгож Ази, Африкийн орнуудад газрын тосны гэрээнүүд ба байгалийн баялгийн хөрөнгө оруулалтын сангуудын талаар лекц уншиж байна. Стэнфордын Хуулийн Сургуулийг төгссөн тэрээр Эстонийн Худалдааны Танхимын “Алдарын медаль” –аар (1990) шагнуулсны зэрэгцээ 2000 онд Гүрж улсын хамгийн том иргэний шагнал болох “Гүржийн гавъяаны одон”-оор шагнуулсан анхны гадаад хүн болжээ.

Жонн Робертс нь дэлхийн эрчим хүчний мэдээллийн тэргүүлэх эх сурвалж болох Платтсийн эрчим хүчний аюулгүй байдлын мэргэжилтэн юм. Түүний бичсэн номуудад *Visions & Mirage: The Middle East in a New Era /Алсын харгаа ба зэрэглээ: Шинэ эрин үеийн Ойрхи Дорнод/* (Mainstream, Edinbough), *Caspian Pipelines /Каспийн дамжуулах хоолойнууд/* (Royal Institute of International Affairs, London, 1996) орно. Тэрээр сүүлийн үед дараахь мэргэжлийн бүтээлүүд бичсэн байна: *Эрчим хүч Европын Холбооны аюулгүй байдлын асуудал болох нь*, Европын Холбооны Аюулгүй байдал Судлалын Институтын (ISS, Парис) судалгаа; *Газрын тос ба 2003 оны Иракийн дайн*, (Эрчим хүч ба Эдийн засгийн Хөгжлийн Олон Улсын Төв, Боулдер, КО, АНУ, 2003 оны 5 сар); *Афганы дамжуулах хоолойнууд* (Хар тэнгис ба Каспийн газрын тос, байгалийн хийн бага хуралд зориулсан илтгэл, Истанбул, 2003 оны 5 сар); *Газрын тосны үнэ, түүний Персийн булан ба Барууны аюулгүй байдалд үзүүлэх нөлөө* (Эрчим Хүчний Аюулгүй Байдлын Симпозиумд зориулсан илтгэл, Хатан Хааны Нэгдсэн Үйлчилгээний Институт, Лондон, 2002 оны 10 дугаар сар).

Катерин Стефан Нью Йоркт төвтэй эрчим хүчний мэдээллийн дэлхийн хамгийн том хангагч болох Платтсд газрын тосны зах зээлийн талаар мэдээлэл бичдэг. Түүний бичсэн мэдээ нийтлэл нь газрын тосны үнийн өөрчлөлтөд нөлөөлж буй үндэсний ба олон улсын хүчин зүйлст чиглэдэг. Тэрээр одоо долоо хоног тутмын бизнесийн хэвлэл Грэйний *Чикаго Бизнес* болон хөгжиж байгаа ба шилжилтийн эдийн засагтай орнуудад эдийн засгийн бодлогын хувилбарууд гаргаж өгдөг ашгийн бус байгууллага болох Бодлогын Хэлэлцүүлгийг Дэмжих Санаачилга байгууллагад чөлөөт сэтгүүлчээр ажилладаг. Үүний өмнө тэр Хонг Конг дахь *Far Eastern Economic Review* буюу Алс Дорнодын Эдийн Засгийн Тойм сэтгүүлд сэтгүүлчээр ажиллаж байжээ. Тэрээр Колумбийн Их сургуулийн Олон улсын ба төрийн хэргийн сургуульд магистрийн зэрэг хамгаалсан байна.

Жозеф Е. Штиглиц, Нью Йорк дахь Колумбийн Их сургуулийн профессор энэ хүн 2001 онд эдийн засгийн чиглэлээр Нобелийн шагнал хүртжээ. Тэрээр 1997-2000 онд Дэлхийн Банкны тэргүүлэх эдийн засагч болон ахлах дэд ерөнхийлөгчөөр ажиллаж байв. Түүний бичсэн *Даяаршил ба түүнд сэтгэл дундуур байдал* (Нортон, 2002) ном сая гаруй хувиар борлогдож, 30 гаруй хэлээр орчуулагджээ. Тэр 1993-1995 онд Клинтонь захиргааны үеэр Эдийн Засгийн Зөвлөхүүдийн Зөвлөлийн гишүүн, 1995-1997 онд ЭЗЗЗ-ийн даргаар ажиллаж байв. Тэр Амхерстийн Коллежийг төгсөөд 1967 онд MIT-гээс Ph.D докторын зэрэг хүртсэн, 1970 онд Иелийн Их сургуульд профессор болж, 1979 онд Америкийн Эдийн Засгийн Холбооноос тухайн чиглэлд хамгийн чухал хувь нэмэр оруулсан 40-өөс доош насны эдийн засагчид хоёр жил тутамд олгодог Жонн Бэтес Кларкын шагналаар шагнагджээ.

Дэвид Васкоу АНУ-ын Friends of the Earth буюу Дэлхийн Найз Нөхөд Олон Улсын Хөтөлбөрийн (ДНН) захирлаар ажилладаг бөгөөд уг байгууллага корпорацийн хариуцлагатай байдалд голлож анхаарахын зэрэгцээ олон улсын эдийн засгийн институциуд ба дэлхийн санхүүгийн байгаль орчин болон нийгэмд үзүүлэх нөлөөг онцлон авч үздэг. Өмнө нь тэрээр ДНН-д олон улсын эдийн засаг ба корпорацийн хариуцлагын янз бүрийн асуудлаар 4 жил ажилласан бөгөөд АНУ-ын Худалдааны Төлөөлөгчдийн Газрын Худалдаа ба Байгаль Орчны Бодлогын Зөвлөх Хороонд ДНН-ийг төлөөлөн ажиллаж байв. Васков Прицетоны Их сургуулийн Вүүдров Уилсоны нэрэмжит Төрийн ба олон улсын хэргийн сургуулийг төрийн хэргийн магистрийн зэрэгтэй төгсч, мөн Чикагогийн Их сургуулийг М.А зэрэгтэй төгсжээ.

Карол Уелч НҮБ-ын Мянгань Хөгжлийн Зорилтуудын Кампанит ажлын төлөөх АНУ-ын хүчин чармайлтыг удирдан зохицуулдаг. Энэ кампанит ажил нь Мянгань хөгжлийн зорилтуудын тухай олон нийтийн ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхийн зэрэгцээ эдгээр олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн зорилтуудыг хангахад иргэд, засгийн газруудын гүйцэтгэх үүргийг дэмжин сурталчлахыг эрмэлздэг. Уелч өмнө нь Дэлхийн Найз Нөхөд байгууллагад долоон жилийн турш ажилласан бөгөөд хамгийн сүүлд олон улсын санхүүгийн байгууллагууд, худалдаа, корпорацийн хариуцлагын асуудлаарх ДНН-ийн кампанит ажлыг хянан зохицуулах Олон Улсын Хөтөлбөрийн захирлаар ажиллаж байв. Мөн Юбилей 2000 АНУ-ын кампанит ажлын Гүйцэтгэх хороонд ажилласан байна. Уелч Жоржтауны Их сургуулийг гадаад албаны чиглэлээр бакалавр (B.S) зэрэгтэй, Флетчерийн Хууль ба Дипломат Албаны Сургуулийг магистрийн (M.A) зэрэгтэй төгссөн байна.